

**ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙ**



**АГШИН ЗУУР ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР  
ЗУРГААДУГААР БОТЬ**

ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙ

АГШИН ЗУУР  
ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР

Зургаадугаар боть

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэг

## АГУУЛГА

Намтрын өмнөх үг .....	4
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн товч намтар .....	5
Өмнөх үг .....	10
Бясалгал бол хайрын эх булаг мөн .....	11
Үйлийн үр, нүгэл хилэнцийг давах нууц арга.....	27
Жинхэнэ Богдосын ном цагаан лянхуа судар.....	44
Хайрын хүч ба ёс журам.....	70
Адислалын хүч .....	95
Жинхэнэ шүншиглэн аравнайлахуй.....	110
Бодьсадвагийн замаар замнахад заавал зовлон эдэлнэ.....	130
Арьяабалын аргаар бясалгахаас өмнөх бясалгалын арга.....	140
Өөрийн бүхнийг чадагч их хүчийг чадамгай ашигла.....	152
Их гуталт номын цогцос.....	168
Өөртөө найдах нь хамгийн дээд их хүчинд найдаж буй хэрэг.	192
Орчлон ертөнцөд бид ч бас багтаж байдаг.....	216
Үй түмэн хувилгаан бие .....	233
Дээд дэсийн самади - Төгс гэгээрсэн Их Багшийг хайж олохын чухал нь.....	246
Энх тайвныг өөрөөсөө эхлүүлцгээе.....	260
Веган хоолны ач тус .....	281
Эрүүл мэнд ба хоол хүнс .....	282
Экологи ба хүрээлэн буй орчин .....	286
Дэлхийн өлсгөлөн .....	287
Гэгээнтнүүд ба үйлс нэгтнүүд .....	289
Авшиг хүртэх- Арьяабалын номын ёс.....	292
Таван сахил .....	295
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн ном хэвлэлийн жагсаалт ..	296
Бидэнтэй хэрхэн холбогдох вэ? .....	301

## НАМТРЫН ӨМНӨХ ҮГ

Ихээр билиг нээгдсэн нэгэн Их Багшийн дэсийг эгэл хүний чадвар болон энэ ертөнцийн үг хэлээр илэрхийлэх боломжгүй байдаг. Түүний бүхий л амьдрал, үзэл санааг хичээнгүйлэн тодорхой дүрсэлсэн ч бүрэн гүйцэд өгүүлэх аргагүй. Эрт цагт Энэтхэгийн нэгэн бясалгагч Багшийнхаа намтар түүхийг бичихээр томилогджээ. Хэдэн сарын дараа бичиж дууссан эсэхийг түүнээс асуухад дуусаагүй гэв. Дахин хэсэг хугацаа өнгөрсний дараа мөн л асуухад: “Миний багш эгэл ертөнцөөс хэтийдсэн төрөлтөн болохоор түүний дэсэд хүрч байж л би Багшийнхаа дүрстэй, дүрсгүй ажлыг жинхэнээр нь ойлгож чадна. Тийм болохоор энэ ажлыг хэзээ ч дуусгах аргагүй юм” гэжээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай өөрийн урьдын амьдралын түүхээ дурдсан нь тун бага. Гэвч олон орны шавь нар нь Багшийнхаа намтрыг ихэд сонирхож, янз бүрийн асуултыг давтан тавьдаг учраас өөрийн түүхээ нээн өгүүлсэн билээ. Энэхүү товч намтарт Их Багшийн амьдралын замнал, түүхээс нь эмхэтгэн цуглуулж, найруулан бичсэн байна. Иймээс бүрэн гүйцэд биш байхыг үгүйсгэх аргагүй тул хүлцэл өчье.

## ТОВЧ ИЛГЭЭЛТ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай нь уран бүтээлч, оюун санааны агуу хөтчийн хувьд сүнслэг гоо сайхныг илэрхийлэх бүхий л хэлбэрт дуртай. Иймээс Тэрээр Вьетнамыг “Ау Лак”, Тайванийг “Формоса” гэж нэрлэдэг. “Ау Лак” нь Вьетнамын эртний нэр бөгөөд амар амгалан амьдрах гэсэн утгатай. Харин “Формоса” (үзэсгэлэнтэй сайхан) гэдэг нэр энэхүү эрдэнийн арал болоод ард түмнийх нь гоо сайхныг бүрэн дүүрэн илэрхийлнэ. Эдгээр нэрийг хэрэглэх нь тухайн нутаг орон, ард иргэдэд сүнслэг дэвшил, буян хишгийг авчирна гэж Их Багш үздэг юм.

## **ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН ТОВЧ НАМТАР**

### **ХАЙР ЭНЭРЛИЙН ЗАМ**

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай бол дэлхий дахинаа алдар суу нь түгсэн оюун санааны их удирдагч, уран бүтээлч, хүмүүнлэгийн үйлстэн юм. Их Багшийн хайр энэрэл хүн төрөлхтний соёл, ёс заншлын хил хязгаарыг давж, дэлхий даяар түгж байдаг билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Ау Лакын (Вьетнам) төв нутагт мэндэлж, Европт очиж суралцсан бөгөөд тэндээ Улаан загалмайн нийгэмлэгт ажилласан байна. Тэрээр энэ хугацаанд дэлхий дахин зовлон зүдүүрээр дүүрэн байгааг даруй олж мэдээд үүнээс ангижрах арга замыг эрэн хайхаар шийдсэн нь Түүний амьдралын эрхэм дээд зорилго болсон байна.

Тэрбээр тухайн үед герман эмчтэй гэр бүл болж, аз жаргалтай амьдарч байсан ч тус тусын зам мөрийг хөөх хэн хэндээ амаргүй шийдвэрийг гаргаж, нөхрийнхөө чин сэтгэлийн ерөөлийг өвөрлөн, өөрийн зорилгоо биелүүлэх аяндаа морджээ. Ийнхүү Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай үнэнийг эрэн хайж, сүнслэг гэгээрлийн зам мөрөөр замнаж эхэлсэн байна. Эцэст нь Энэтхэгийн Хималайн ууланд нэгэн Төгс Гэгээрсэн Их Багш түүнд дотоодын Гэрэл ба Аялгууг

ажих “Арьяабалын Бясалгалын Арга”-ыг уламжилжээ. Ийнхүү тэрбээр хэсэг хугацаанд хичээнгүйлэн бясалгасны эцэст Төгс Гэгээрэлд хүрчээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн гэгээрлийн сургаал номлолыг удирдлага болгосон Олон улсын нийгэмлэг 1980 онд байгуулагджээ. Хүмүүсийн чин сэтгэлийн хүсэлтээр Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Арьяабалын бясалгалын аргыг уламжилж, тэднийг өөрийн дотоод дахь бурханлаг чанараа нээн илрүүлэхэд нь дэмжин зоригжуулж эхэлсэн юм. Удалгүй Америк, Европ, Ази, Австрали, Африк зэрэг таван тив болон Нэгдсэн Үндэсний Байгууллагаас Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайг ном тайлуулахаар урин залах болжээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай энэрэн нигүүлсэх сэтгэлээрээ зовж зүдэрсэн олонд бүх талаар хайр энэрэл, тус дэмжлэг үзүүлдэг бөгөөд Түүний хүмүүнлэгийн ажил нь бүхий л хориг саадыг даван туулж, дэлхийн өнцөг булан бүрийн орон гэргүй ядуучууд, дорой буурай амьдралтай өндөр настнууд, шоронгийн хоригдлууд, хөгжлийн бэрхшээлтэй болон оюуны хомсдолтой иргэд, дүрвэгсэд, Америкийн ахмад дайчид зэрэг хүмүүст түгэн хүрчээ.

Дулаарлаас үүдэлтэй элдэв хямрал дэлхий дахинд нүүрлээд байгаа өнөө үед Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай өгөөмөр сэтгэлээр олон сая долларын хүмүүнлэгийн тусламжийг үзүүлдэг бөгөөд байгалийн элдэв гамшигт нэрвэгдэгсдэд туслуулахаар нийгэмлэгийнхээ гишүүдийг дэлхийн бүхий л оронд илгээж байна. Үүнээс гадна Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай энэ дэлхийд бидэнтэй зэрэгцэн оршигч эрхэм ариун амьтад болон хүрээлэн буй орчны асуудалд ихэд санаа тавьдаг билээ.

Их Багшийн энэрэл хайр, асрал нигүүлсэл олон сая хүмүүсийн сэтгэлийг хөдөлгөж, бусдын төлөөх харамгүй сайхан сэтгэл нь тэдний даган дуурайх үлгэр жишээ болж байна. Их Багш өөрийн уран зураг, дэнлүү чимэглэл,

хувцасны загвар, үнэт эрдэнийн гоёл зэрэг урлагийн бүтээлүүдийнхээ орлогоороо тусламж хэрэгтэй Эзэн Бурханы үр хүүхдүүдийг дэмжин тэтгэдэг билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сүүлийн жилүүдэд бичсэн “Шувууд миний амьдралд”, “Миний амьдрал дахь ноход”, “Эрхэм ариун амьтад” хэмээх гурван ном нь дэлхийн хамгийн их борлуулалттай номоор шалгарч, олон хэлээр орчуулагдаад байна. Их Багш телепат холбоо болон сүнслэг ажиглалтаараа эрхэм ариун амьтдын сэтгэл хөдлөл, бодол санааг гүн гүнзгий ойлгож, тэдний эрхэм дээд санаа зориг, хэзээ ч хариу үл нэхэх өгөөмөр хайрыг эдгээр бүтээлүүддээ тод томруун тусган харуулжээ.

Төгс Гэгээрсэн Их Багш хүмүүст үлгэр дуурайл болох зөв ёс зүйтэй сайн үйлсийг урамшуулан сайшааж 2006 оны 3 сард “Дэлхийн Гэрэлт манлайллын шагнал”-ыг, мөн удалгүй “Дэлхийн Гэрэлт Баатарын шагнал”, “Дэлхийн Гэрэлт Нигүүлсэнгүй үйлсийн шагнал”, “Дэлхийн Гэрэлт шударга үйлсийн шагнал”, “Дэлхийн Гэрэлт Зохион Бүтээгчийн шагнал” зэрэг олон цол шагналуудыг бий болгожээ. Эдгээр нэр төртэй шагналыг хувь хүн, албан байгууллага, улс орнуудад олгодог бөгөөд тэдний үлгэр дуурайлтай ажил үйлс нь манай гарагийг улам гоо үзэсгэлэнтэй, эв зохиролтой болгож, дэлхийн тогтвортой хөгжилд жинтэй хувь нэмэр оруулж байна. Тухайлбал: Словени Улсын хоёр дахь Ерөнхийлөгч доктор Жанез Дрновшек, АНУ-ын 45 дахь Дэд ерөнхийлөгч, 2007 оны Нобелийн Энх тайвны шагналт, НҮБ-ын Уур Амьсгалын Өөрчлөлтийн Засгийн Газар Хоорондын Мэргэжилтний Хороо (IPCC)-ны гишүүн Аль Гор, НҮБ-ийн Уур Амьсгалын Өөрчлөлтийн Засгийн Газар Хоорондын Мэргэжилтний Хороо /IPCC/-ны тэргүүн бөгөөд Энэтхэг улсын Эрчим Хүч, Эрдэс Баялгийн Хүрээлэн (TERI)-гийн тэргүүн, НҮБ-ын Хүний суурьшлын хөтөлбөрийн 2010 оны шагналт, доктор Ражендра К.Пачаури, АНУ-ын Сансар Судлалын Үндэсний Төвийн



(НАСА) тэргүүн, 2009 оны Карл Густаф Россби судалгааны шагналт, доктор Жэймс Е.Хансен, Английн нэрт доктор, бичний овгийн хөхтөн амьтан судлаач Жэйн Гуудал нарын олон хүн эдгээр шагналыг хүртсэн байна.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай амиа үл хайрлан аюул эрсдэлийг сөрж, бусдын амь насыг аварсан бидний эрхэм анд нөхөр амьтдын баатарлаг үйлсийг нь сайшаан “Дэлхийн Гэрэлт Баатарын шагнал”, “Дэлхийн Гэрэлт оюун ухааны шагнал”-ыг олгодог бөгөөд үүгээр амьтдын баатарлаг зориг, сэргэлэн ухаан, хайрын сэтгэлийг илчлэн харуулдаг билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн дэлхийн хөгжил дэвшилд оруулсан сүнслэг болон материаллаг асар их хувь нэмрийг олон улс орны төр засгийн газар, хувийн байгууллагууд өндрөөр үнэлэн шагнаж хүндэтгэлээ илэрхийлсэн байна. Тухайлбал: Гуси Энх Тайвны шагнал (2006 он), Телли-гийн 27 дахь жилийн шалгаруулалтын Мөнгөн Эрдэнийн тэргүүн шагнал (2006 он), Лос Анжелесын Хөгжмийн Долоо хоногийн Сайшаалын гэрчилгээ (2002 он), Дэлхийн Оюун Санааны Удирдагчийн шагнал (1994 он), Дэлхийн Хүний Эрхийг Дэмжигчийн Шагнал (1994) зэргийг дурдаж болно. Түүнчлэн АНУ-ын төр засгаас жил бүрийн 2 дугаар сарын 22 болон 10 дугаар сарын 25-ны өдрүүдийг “Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Өдөр” болгон тэмдэглэж байхаар зарласан юм. Их Багшийн дэлхийд өргөсөн тусламж, түүний бие сэтгэл харамгүй их үйлсийг олон орны төрийн тэргүүн, ард иргэд өндөр үнэлэн талархлаа илэрхийлсээр байдаг билээ.

Их Багш Чин Хай бол өөрийн билиг ухаан, баатар зоригоороо цаг уурын өөрчлөлтийн сэдвийг зоригтой хөндөж тавьсан өнөө үеийн хүрээлэн буй орчныг хамгаалагчдын манлайлагч юм. Үнэн хэрэгтээ хориод жилийн өмнөөс хүрээлэн буй орчныг хамгаалахыг уриалж байсан бөгөөд “Тайм амьдралыг сонгож болно”, “SOS-дэлхийн дулаарлыг

зогсоох нь” зэрэг үйл ажиллагааг санаачлан эхлүүлжээ.

Түүнчлэн дэлхийн цаг уурын өөрчлөлтийн хуралд зочин илтгэгчээр оролцож, дэлхий ертөнц дээр өнөө үед тасралтгүй гарсаар байгаа байгалийн гамшгийн үндсэн шалтгаан болон түүнийг шийдвэрлэх гол арга болох нигүүлсэнгүй веган амьдралын хэв маягийг сонгоход олны анхаарлыг хандуулж байна.

Олон нийтэд хэдийнээ танил болсон “Веган болж, энх тайвныг цогцлооё” хэмээх уриаг Их Багш Чин Хай дэвшүүлсэн билээ. Хоол хүнсний сонголт нь цаг уурын өөрчлөлтөд асар их нөлөөтэйг үндэслэн энэрэнгүй, тогтвортой амьдралын хэв маягийг сонгоход нь хүмүүст туслахын тулд “Loving Hut” веган хоолны сүлжээ ресторанууд Их Багш Чин Хайн урамшуулал дэмжлэгээр амжилттай өргөжин тэлсээр байна. Олны таашаалыг хүлээсэн энэ хоолны газрууд дэлхий даяар тархаж, олон төрлийн эрүүл тэжээллэг, хямд үнэтэй, амтлаг веган хоолоор үйлчилдэг. Гараг ертөнц, түүний оршин суугчид, зэрэгцэн оршигч төрөлтнүүд болоод бидний үр хойчийг дэлхийн дулаарлаас үүдсэн сүйтгэгч нөлөөнөөс аврахын тулд үүний эсрэг хамгийн үр дүнтэй арга болох эрүүл энэрэнгүй хоол хүнсийг дэлгэрүүлж байна.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хүн төрөлхтөнд хосгүй гайхамшигт энэ гараг дэлхийдээ гэрэлт ирээдүйгээ цогцлоох үйлсэд нь амь биеэ огоорон, эцэс цуцалтгүйгээр тусалсаар байгаа билээ.

## ӨМНӨХ ҮГ

Их Багш Чин Хай гүн утгатай, ойлгоход хэцүү үг хэллэг хэрэглэхээс ямагт зайлсхийж, хамгийн ойлгомжтой яриан хэлбэрээр ном тайлдаг. Түүний ном хэвлэлүүд нь уран яруу илэрхийллийг бус уншихад хялбар ойлгомжтой байхыг урьтал болгодог. Их Багшийн адислалын хүчийг бууруулахаас эмээж түүний шавь нар эгэл хүний ухаанаар номын агуулгыг өөрчилдөггүй.



## **БЯСАЛГАЛ БОЛ ХАЙРЫН ЭХ БУЛАГ**

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Формоса, Тайбэй хот Сун Ят сений дурсгалын цогцолбор  
1994 оны 4 дүгээр сарын 20  
(Эх нь хятад хэлээр)*

Ингэж алга ташиж байгаагийнхаа жинхэнэ утга учрыг та бүхэн ойлгож байгаа гэж найдаж байна. Та бүхэн ном айлдаж байгаа энэ хүнийг биш, харин өөрсдийнхөө билиг ухааныг алга ташин талархан угтаж байна. Өнөөдөр та нар цаг завгүй байдаг ажил амьдралаа зохицуулаад тогтсон үзэл бодол, дадал зуршлаа ялан дийлээд энд хүрэлцэн иржээ. Нилээд хэдэн цаг хүлээсний эцэст орж ирээд ном сонсож байна. Та бүхний тэсвэр тэвчээр, номч сэтгэлд үнэхээр их талархлаа. Чин сэтгэлд тань баярлан алга ташъя. Намайг үнэн ёсонд суралцаж байхад ч ийм бэрхшээл тохиолдож байгаагүй. Ном сонсохын тулд хэдэн цагаар хүлээх явдал Формосад л харин байна. Энэтхэгт бол ном айлдах хүн олдвол шууд л яваад очдог. Удаан хүлээхгүй. Гэхдээ бид олоход бэрх зүйлсийг зарим үед илүү их нандигнадаг. Тийм биз дээ. Хэрэв дэндүү амар хялбар олдвол эсрэгээрээ нэг их нандигнаад байдаггүй. Бидэнд ийм дутагдал үргэлж л байдаг. Эртнээс нааш Төгс Гэгээрсэн Их Багш нар шавиа сонгохдоо хатуу чандаар сорьж шалгаж, номоо ч тийм

амархан уламжилдаггүй байсан. Их Багш шавиа хатуу сорих нь нэг талаар тустай ч бас дуталдалтай тал ч бий. Учир нь тийм их сорилт шалгалтыг давах нь зарим хүний хувьд хүлээж авахын аргагүй байдаг. Тэгээд ч цаг хугацаа, нөхцөл байдлын хувьд олон сорилтыг хүлцэн тэвчих боломжгүй. Эсвэл удаан хүлээсний эцэст Их Багшаас суралцах завшаан олддог. Тиймээс эрт дээр үед бясалгах хүмүүс цөөн байжээ. Одоо нилээд олон болсон байна.

Ойрын үед манай дэлхий тун хурдан өөрчлөгдөж байна. Үүнийг бараг хүн бүхэн мэднэ! Тийм биз? Өөрчлөлт үнэхээр их, маш түргэн байна, тийм ээ? Яагаад тэр вэ? Яагаад гэнэт ийм их гэрэл гэгээтэй болов? Яагаад нөхцөл байдал ийм түргэн, тийм огцом, сүрхий их өөрчлөгдөв өө гэж та нар бодож үзсэн үү? Энэ талаар ер нь бодсон уу? Үнэндээ энэ бүхэн хүмүүсийн хичээнгүйлэн бясалгаснаас болсон юм. Нийтийн бясалгалын хүч бол сэтгэшгүй их байдаг. Хүн бүрийн дотоодод бурхан бий. Хэрвээ олон бурхад нэгдээд ижил хүсэл зорилгоор, ижил зүйлийг хийвэл тухайн ажил илүү хурдтай амжилтанд хүрдэг. Харин ганцаараа хүссэн, хийсэн зүйл заримдаа амжилттай, заримдаа амжилтгүй болдог. Манай шашинд ийм нэг уламжлал байдаг. Хэн нэг хүн нас барвал олуулаа суугаад хойдын буянд нь зориулж ном уншдаг. Тийм биз? Хамт уншиж буй хүмүүс чин сэтгэлтэй, бие, хэл, сэтгэл нь цэвэр ариун, дотоодын бурхан чанар нь өндөр төвшинд хүрсэн байвал түүнд зориулсан чин сэтгэлийн даатгал залбирал тухайн нас нөгчсөн хүний сүнсэнд маш их ач тустай. Нүүр царай нь гэрэлтээд ирдэг, тийм биз? Манай хятад хүмүүс ингэж ярьцгаадаг. тийм ээ? Царай нь улаа бутарч байвал маш сайн, сүнс нь дээш дэвшжээ гэдэг. Тийм биз? Хэрэв царай нь харлавал яахав? (тамд унана гэж хариулав). Там байдаг эсэхийг би мэдэхгүй! (Багш инээв) Гэхдээ царай нь харлавал сайнгүй гэж сонссон. Тийм учраас хамтын хүч үнэхээр ач тустай. Гэхдээ тухайн

бүлэг хүн нэгдмэл хүсэл, нэгдмэл санаа бодолтой эсэхээс хамаарна. Багшийнхаа санааг ойлгов уу? Хэрвээ нас барсан хүний хойтын буяныг ганц хүн уншаад тэр нь сэтгэлдээ мах, ногоо, загас бодож, өчигдөр нөхөртэйгээ хэрэлдсэн, эхнэр нь өчигдөр орхиод явсаныг бодож суувал тухайн сүнсэнд ямар ч ач тусгүй, харин ч улам шаналгана. Сүнс эсэргүүцлээ илэрхийлэн царайгаа барайлгах байх.

Царай нь яагаад харладаг гэхээр, бид уурлавал царай зүс барайж харлаад хөх ягаан, хар ногоон болдогтой адил, гэхдээ би нүүр нь ногоорсон хүнийг арай ч хараагүй. (Багш инээв) Тас хар гэж байгаа миний санаа бол царай нь хувираад цусгүй цайж, сайхан сэтгэлийн өчүүхэн ч галгүй болохыг хэлж байгаа юм. Хүн үхвэл яг ийм болдог. Саяхан нас барсан хүний сүнс, бие цосцос хавиараа эргэлдэж байдаг. Ихэнх хүний сүнс ийм байдалтай байдаг. Харин бясалгагч хүний сүнс явья л гэвэл явна. Нилээн хурдан. Зарим нэг маш хэрцгий, хүнд нүгэлтэй хүн, Эзэн Бурхан, Бурхан бодьсадваг хилэгнүүлж, харгис балмад нүгэл хилэнц их үйлдсэн хүн үхвэл чөтгөр ирж, сүнсийг нь даруй чирэн одох тул бие махбодоо харж, ойр хавиар нь эргэлдэж чадахгүй. Зарим сүнс өөрийн бие махбодын орчимд дөчин ес хоног байдаг. Нас барсан хүний сүнс бусдын бодлыг уншина, бид хэдэн бүлэг хүн шарилын дэргэд ном гүрэм уншиж байгааг хардаг.

Үхэл бол амьд байхаас ч илүү таатай төлөв байдал. Гэхдээ яарах хэрэггүй, яарах хэрэггүй, цаг нь болохоор бүгд явна. (Багш инээв) Бүх хүн мөнхрөхийг хүсдэг, харин би үхлийг сурталчилна. Үнэхээр хачин жигтэй номын багш байна даа! Гэвч ийм хачин жигтэй Багшийн номын айлдварыг хааяа хааяа сонсох хэрэгтэй. Эс бөгөөс амьдрал нэгэн хэвийн сонирхолгүй болно. Нас бармагц сүнс махан биеийн хүлээснээс ангижирч эрх чөлөөтэй болж, эрх дураараа явах тул бусдын бодол санааг хялбархан мэдэж,

хэнийг ч ажиглахад их дөхөм байдаг. Бидний сүнсэн бие хана нэвтлэн гэрийн дээврээр гадагшилна. Өөр орон зайд саадгүй хурдан шилжих тул хэн нэгнийг мөрдөж, нууцыг нь мэдье гэвэл өрөөнд нуугдаад цоожлон суусан ч тэдний нууцыг мэдчихнэ. Хэрвээ саяхан нас барсан сүнснүүд тэр даруйдаа диваажинд төрөх их буянгүй, тамд унах хүнд нүгэлгүй бол хэсэг хугацаанд бие цогцосынхоо орчим байж, тэнгэрийн элч ирж авахыг хүлээдэг. Эсвэл цаг нь болоход дахин умайд орж, хүний төрлийг авна. Тиймээс бид саяхан нас барсан сүнсэнд зориулж, хойдын буяныг унших үедээ чин сэтгэлээсээ хандаагүй бол тухайн сүнс жинхэнэ ач тусыг хүртэж чадахгүй, харин ч биднийг улам их хорсож занана. Ойлгож байна уу? Жишээ нь, бидний ном уншихдаа зүүрмэглэж буйг, эсвэл хажуугийн бүсгүйг ширтэж байгааг ч харж байдаг. Энэ нь жишээ татаж байгаа төдий зүйл шүү. Бас тийм муу хүн байна гэж үү? бодох хэрэггүй. Магадгүй тэр нас барсан сүнс уурласан учраас царай нь харласан байх. Ойлгов уу? Бид нас барсан хүний хойдын буянд зориулан ном уншвал царайны хувирлаас нь чин сэтгэлтэй эсэхээ харж болно. Иймээс та бүхэн нас барсан хүнд зориулж, ном уншвал болгоомжтой байгаарай. Чин сэтгэлгүйгээ хүмүүст харуулах хэрэггүй. (Багш инээв). Нас барсан хүний царай улам харлавал тэгээд л ойлгомжтой болох билээ.

Ау Лакт ийм нэгэн түүх бий. Зөвхөн ад чөтгөрт зориулж, идээ ундаа өргөн, сүр тавьдаг номын багш байжээ. Та нар сүр тавих гэдгийг ойлгох уу? Ад чөтгөрт өргөл өргөж, хооллох гэсэн үг. Жишээ нь, буддын шашинтан оройн уншлагын үеэр долоон ширхэг будаа авч, сүр тавих тарни, өөр бас олон тарнийг хагас цаг хэртэй уншвал олон болж арвижих бөгөөд үүгээр талийгчийн сүнсийг хооллодог. Тэр номын багшийг хүмүүс байнга залж, ном судар уншуулж, ад чөтгөрийг хооллуулна. Ялангуяа ад чөтгөрт өглөг өргөдөг долоон сард маш завгүй байдаг, тийм биз? Формосад ч

ийм, Ау Лакт ч бараг иймэрхүү. Учир нь түүнийг урьж сүр тавиулах хүн дэндүү олон. Тэр ядраад ой санамж нь муудсан байна. Нэгэн өдөр гэрээсээ гарахдаа түлхүүрээ мартжээ. Хаана тавьснаа ч санахгүй болов. Замын хагаст хүрээд сая санаж, замын дундаас хурлын газар хүртэл толгойд нь түлхүүр л бодогдож явав.

Тэгээд сүр тавьж, тарни уншихдаа түлхүүрээ л бодсоор байжээ. Ажлаа дуусаад гэртээ харивал өнөөх ад чөтгөрүүд орой ирж, гэрийн эзнийг татаж, чангааж гэнэ. Гэрийн эзэн ихэд гайхаж: “Өнөөдөр та нарт өргөл өргөж хооллосон. Юунд ирж дахин намайг үймүүлэв?” гэхэд ад чөтгөрүүд: “Үгүй ээ! Бид юу ч олж идээгүй шүү. Бидэнд ганц ганц түлхүүр оногдсоноос өөр юмгүй (Багш инээв). Бид олуулаа. Тэрэнд ганц түлхүүр л байсан. Хаалгыг нь нээгээд орсон ч бид тэнд амьдарч болохгүй” гэв. Учир нь талийгч сүнснүүд ач тус хүртээгүй тул гомдолжээ. Тиймээс бид бясалгал сайтай байж байж л бусдын хойдын буяны ном гүрэм унших хэрэгтэй.

Өөрийн бие, хэл, сэтгэлээ сайтар дасгалжуулаад хүссэн бүхнээ хийлгэдэг болох хэрэгтэй. Жишээ нь, уйл гэвэл уйлдаг, инээ гэвэл инээдэг, уурла гэвэл уурладаг, аядуу зөөлөн бай гэвэл аядуу зөөлөн болдог, эцэстээ бүх зүйл ямар ч хүчлэлгүй аяндаа болохын цагт бид бүрэн өөрийн эзэн болно. Тэр үед л бидний хийсэн бүхэн энэ дэлхийд ачтай тустай. Хэрвээ бид ийм дэсэд хүрье гэвэл тийм ч хэцүү биш, нам сууж бясалган дадуулвал хүрчихнэ.

Тайбэйн нийтийн бясалгалын үеэр нэгэн энэтхэг хувраг ирж, бидэнтэй хамт нийтийн бясалгалд суусан. Тэр миний шавь биш л дээ! Учир нь тэр энэтхэгээс ирсэн тул далимаар нь би түүнээс ном айлдахыг хүссэн. Хэн түүнийг урьж авчирсныг мэдэхгүй, лав л өөрөө ирээгүй. Тэр нь хамаагүй! Бид бас түүнийг талархан угтана. Шавь нарт бясалгалтай холбоотой зүйлс ярьж өгөхийг хүсэхэд тэр нилээд хэдэн түүх ярьсан



нь тун сонирхолтой байв. Гэвч түүний энэтхэг -англи хэл ойлгоход бэрх тул би тун их хичээж, анхааралтай сонсох хэрэгтэй болсон. Тэр нэг зүйл ярьсан бөгөөд нарны туяа угаасаа маш халуун, их илчтэй байдаг ч бид нарны туяагаар ганц ширхэг өвсийг ч шатааж чадахгүй. Тийм үү? Зөвхөн толь, томруулагч шил, эсвэл нүдний шилээр нарны туяаг нэг цэгт цуглуулж бөөгнөрүүлвэл цаас, өвснөөс гал гарч шатна. Би ч бас үүнийг урьд нь туршиж үзэхэд үр дүнтэй байсан.

Үүнтэй нэгэн адил бидний дотоодод орших хүч сэтгэгдэшгүй их, бүхнийг чадагч. Гэвч бид түүнийг нэгэн цэгт төвлөрүүлээд тэр цэгээр асуудлыг ойлгож, асуудлыг шийдэхгүй бол бид хэзээ ч ямар ч асуудлыг шийдэж чадахгүй. Нарны гэрэл хичнээн хурц ч өөрөө асаж, гал болохгүй шиг бидний хүч хэдий их ч түүнийг сарниулвал ямар ч ашиггүй. Энэ нь шинжлэх ухаантай бүрэн нийцнэ. Тийм биз? Үүнтэй яг ижил зарчим, яагаад бид дэлхийн асуудлуудыг шийдэх чадваргүй байна вэ? Учир нь ердөө л их хүчээ төвлөрүүлж, тулгамдсан асуудлуудыг шийддэг дадал бидэнд алга. Та бүхэн Арьяабалын аргаар бясалгахгүй байж болно. Хамаагүй. Бас Будда болохгүй байж болно. Гэхдээ та бүхэнд хэлэхэд хамгийн хялбар нэгэн аргаар бясалгавал та гэр бүлээ халамжилж, улс орондоо үйлчилж, дэлхий ертөнцөд тусалж чадна.

Миний шавь болох шаардлагагүй. Ургамал хоол идэх хэрэггүй. Гэхдээ боломжийн хэрээр ургамал хоол идвэл тун сайн. Та нар үйлийн үрд итгэх, итгэхгүй нь хамаагүй, аль болох ургамал хоол идэхийг хичээвэл амь хороосон хүнд үйлийн үрээ багасгана. Мах идвэл шингэц муудаж, бие хүндэрдэг. Харин ургамал хоол амархан шингэнэ. Шингэц сайтай хүнс хэрэглэвэл оюун ухаан хурдан сэтгэж, ажлын бүтээмж сайжирна. Бие хүндэрч нойрмоглохгүй. Иймээс аль болох ургамал хоол идэхийг хичээ! Би энэрэнгүй явдлыг яриагүй. Нигүүлсэнгүй үйлийг хийдэг хүн тун цөөн. Та нар

ядаж биеэ бод, өөрийгөө бүү зовоо. Оюун санаа хөнгөн бол өөртөө, гэр бүл, улс орондоо тусална. Жишээ нь, томоохон асуудал шийдэх хэрэг гарвал бид хөмсгөө зангидаж, бодлоо төвлөрүүлдэг, тийм биз? Төд удалгүй шийдэх арга нь тодорхой болно. Гэвч жирийн үед бодлоо төвлөрүүлж дадаагүй бол төвлөрөхөд хэцүү. Төвлөрөл муу бол үр дүн ч бага.

Хэрвээ бид гүнзгий сайн төвлөрлийг өдөр бүр дадуулвал сүүлдээ энэ нь дадал болж, хүссэн үедээ хурдан төвлөрдөг. Ингэж бид дотоодынхоо билиг ухааны хамгийн төв хэсэгт гүн нэвтэрвэл тэндээс ирсэн хариулт, үр дүн лавтай хамгийн оновчтой, хамгийн дээд дэсийн, хамгийн төгс төгөлдөр нь байна. Ойлгов уу?(бүгд алга ташив) Миний бодлоор өөртөө маш хурдан туслах хамгийн сайн арга бол бясалгал. Бясалгана гэдэг нь өөрийн бүх хүчийг төвлөрүүлж, юунд хэрэгтэй байна, түүнд ашиглахыг хэлнэ. Яг л нарны гэрлийг томруулагч шилээр нэг цэгт төвлөрүүлээд юуг ч шатааж болдог шиг, ойлгов уу? Зөвхөн ганц ширхэг тамхи, ганц ширхэг өвс, ганц хуудас цаасыг шатаахгүй, олон зүйлийг шатааж чадна. Үүний нэгэн адил бясалгалаар бид бүх анхаарлаа нэг цэгт төвлөрүүлээд аливаа асуудлыг тэр цэг дээр тавихад бүх зүйл маш хурдан шийдэгдэнэ. Бид асар их хүчтэй, гэвч түүнийг төвлөрүүлж, өдөр бүр ашигладаггүй тул хүчгүй мэт байдаг. Бүгдээрээ тэнэг мулгуу болжээ. Бид угаасаа Будда бөгөөд юуг ч хийж бүтээх, ямар ч шидийг үзүүлэх, ямар ч асуудлыг шийдэх их билиг ухааны эзэн байтал өөрийн энэ агуу чадварыг хөгжүүлээгүйгээс эцэст нь тэнэг мулгуу, зовж зүдэрсэн, юу ч хийсэн бүтэлгүйтэж, тэнгэр газар, хувь заяандаа гомдсон хүн болсон байна. Ойлгов уу? Ингэх нь буруу, дэндүү гунигтай, өөрийгөө буруутгасан хэрэг юм. Бид өөрийгөө өөрчлөхөд тун амархан. Өдөр бүр хагас цаг, нэг цаг бясалгаад үз. Амьдрал чинь өөрчлөгдөнө. Багшийн шавь нар яагаад Арьяабалын

бясалгалд дуртай байдаг вэ? Бүгд ач тусыг нь хүртсэн учраас тэр. Бясалгах тусам өөрөө өөрчлөгдөж, улам гэрэл гэгээтэй болж байгаагаа мэдэрнэ. Тэр ч байтугай гадаад дүр төрх ч өөрчлөгддөг. Би заримдаа тэдний өөрчлөгдсөнийг хараад их цочдог. Зарим шавь нар авшгийн өмнө болоод дараа хэдхэн минут, хэдхэн цагийн дотор даруй хувирч, би ч танихааргүй болдог. Яагаад ийм гоё болчихов оо гэж боддог. Гэтэл зарим нь гэртээ хариад залхууран бясалгахгүй бол царай зүс нь хувирч харлаад билиг ухаангүй, сэтгэлийн шаналалтай болно. Бид ийм хүнийг үйлийн үр ихтэй гэдэг.

Иймээс Багшид мухраар сүсэглэж, шүтээн болгон биширсэндээ бус, харин ач тусыг нь өөрийн биеэр хүртэж мэдэрсэн учраас миний шавь нар бясалгах дуртай. Шавь нар маань бүгд зургаатай, арван хоёртой хүүхдүүд биш, хэдийнээ үс нь бууралтчихсан настай хүмүүс ч бий. Өндөр албаны хүмүүс, цэргийн дарга, увш, эмч, профессор, сүсэгтэн гээд янз бүрийн хүн байдаг. Тэд бүгд тэнэг биш, надад тийм удаан мэхлэгдэхгүй. Ойлгов уу? Нэг, хоёр, гурван өдөр, гурван жил мэхлэгдэж болох ч үргэлж мэхлэгдэхгүй. Надаас авшиг хүртээд зургаа, долоон жил болсон хүмүүс ч бий. Зарим шавь намайг Формосад ирснээс хойш өнөөдрийг хүртэл зургаан жил дагажээ. Тэд Багшдаа, Арьяабалын бясалгалын аргад улам итгэлтэй болж, бясалгал нь ч сайжирч, ажил төрөл нь явах тутам бүтэмжтэй болсон. Улмаар улс орон, гараг дэлхийдээ ач тусаа өргөж, өөрийгөө улам их хайрлаж, бусдыг бүр ч их хайрлах болсон нь мэдээж. Хэрвээ бид өөрийгөө хайрлахгүй бол бусдыг ч хайрлахгүй.

Хэн нэгэн хүн танд: “Бид эхлээд бусдыг хайрлах ёстой. Бусдыг өөрөөсөө илүү хайрлах хэрэгтэй” гэвэл энэ нь боломжгүй зүйл. Чи өөрийгөө хайрлаагүй бол хэнийг ч хайрлахгүй. Уучлаарай! Энэ бол логикт нийцсэн энгийн зүйл. Энэ бол бидний төрөлх чанар учраас өөрчлөгдөхгүй. Тиймээс бид их хүчээ төвлөрүүлж, давуу тал, авьяас чадвар,

билиг ухаан, олноос хэтийдсэн авьяас билиг, хэр их хайр энэрэлтэйгээ эхлээд мэдэх хэрэгтэй. Ингэж өөрийн давуу талыг танин мэдвэл бусдыг хайрлана. Өдөржингөө ийм олон хүнийг харж ханддаг ч хайрын сэтгэл минь дундарч багассан мэдрэмж яагаад Багшид нь төрдөггүй вэ? Учир нь би өөрийгөө ихэд хайрлаж, хүндэлж, талархсанаас тэр.

Өөрийгөө дорд үзэх нь бидэнд маш муу. Үүнээс атаархах, эзэрхэх сэтгэл төрж, өрсөлдөн тэмцэлдэх уур амьсгал үүсдэг. Учир нь бусдыг өөрөөсөө илүү гарах вий, өөрийг нь хүндлэхгүй, хайрлахгүй байх вий гэж айна. Өөрөө мэддэг ч өрөөлд мэдүүлэхийг үл хүсэх, нууж далдалсан ямар нэг дутагдал бидэнд байдаг тул өөрийгөө хайрлан хүндлэх, өршөөн уучлах аргагүй байдаг.

Өөрийгөө голох сэтгэлээс болж олон муухай авир гаргана. Ингэж өөрийгөө ч өрөөлийг ч хорлож, орчин тойрныхоо хүмүүсийг тухгүй болгодог. Бясалгалаар давуу сайн талаа илрүүлж, оюуны чадвараа нээгээгүй бол өөрийгөө голох сэтгэлээс хагацахгүй. Ихэнх хүн их, бага ямар нэгэн хэмжээгээр өөрийгөө голж байдаг. Бардам зан ч гэсэн өөрийгөө дорд үзсэний илрэл. Яагаад вэ? Жишээлбэл, нэг хүн эрхэм дээд албан тушаал хашсанаасаа хойш захирагддаг хүмүүсээ доорд үзэх болжээ. Энэ нь нэг төрлийн өөрийгөө голсон хэлбэр. Тэр өөрийгөө эрхэм дээд албан тушаалтан гэж мэдэхээс цаашгүй.

Дахиад нэг жишээ авья. Сайд хүн өөрийгөө сайд гэхээс, Будда гэхгүй. Ойлгов уу? Тэр өөрийгөө гайхуулаад байх юмгүй, энэ ертөнцөд даргын алба хашсан төдий гэнэ. Тэр өөрийгөө төгс төгөлдөр төрөлтөн биш гэнэ. Өөрөөс нь дээш ерөнхийлөгч, эсвэл Шагжамуни Будда, Есүс Христ шиг дээд дэсийн төрөлтнүүд маш олон байдгийг мэднэ. Тиймээс Будда гэдгээ өөрөө мэдэхээс нааш түүний биеэ голох өвчинийг эмчлэх сайн эм байхгүй. Хэрвээ бид өөрийгөө голдог бол бусдад муугаар хандах нь тун элбэг.

Учир нь бидний санаа сэтгэл тайван бус тавгүй тул бусдын ажил төрөлд саад хийнэ, хүмүүст хүргэсэн жаахан тусынхаа хариуд ихийг хүлээнэ. Тиймээс мунхагийн өвчин, өөрийгөө голох өвчин, өөрөө Будда гэдгээ мэдэхгүй байх энэ бүх ноцтой өвчнүүдээс аврагдъя гэвэл бидэнд ганц л арга бий. Энэ бол бясалгал. Арьяабалын аргаар бясалга гэж байнга ярилгүй харин дэс төвшнийг чинь аль болох дээшлүүлж, улам таатай сайхан болгох эдгээр нууц жорыг би та бүхэнтэй хуваалцаж байна. Арьяабалын аргаар бясалгавал мэдээж хамгийн сайн, гэвч хүн бүхэн Багшийг даган бясалгахгүйг би мэднэ. Учир нь өөрөө эргэлзэж тээнэгэлзээгүй ч саад хийх хэн нэгэн хэзээд хажууд нь байдаг. Хэрэв эхнэр нь зөвшөөрвөл ээж нь гомдоллоно. Ээж нь зөвшөөрвөл аав нь саад хийнэ. Яасан ч их саад бэрхшээл вэ? Тэгээд ч сонгосон замаараа баттай явахаар шийддэг зоригтой хүн тун цөөн.

Шагжамуни Будда бол улсын хамгийн дээд эрх мэдэлтэй, эрх танхи ханхүү байсан. Тэрээр бясалгахын тулд хааны ордноос харанхуй шөнөөр сэм оргох замыг сонгосон нь ханхүүгийн намба төрхөнд нийцэхгүй хэдий ч ийм шийдэмгий, ийм чин сэтгэлтэй байгаагүй бол Тэр Будда болж чадахгүй байсан. Ойлгов уу? Хэрвээ хааны хүү харанхуй шөнөөр оргож болохгүй, бүхнийг заавал ил тод хийж, эцэг эх, эхнэр хүүхэд, ордны таван зуун сайхан бүсгүйдээ хэлэх ёстой гэх мэтээр бодоод бүх асуудал шийдэгдэхийг хүлээвэл хүч тамираа барж, явж чадахгүй болох байв. Тийм биш үү? (бүгд алга ташив) Нэг шавь маань надад Л.Толстойн түүхийг ярьсан. Тэр уг нь хар лам болохоор шийдсэн байжээ. Энэ нь католик шашинтны гэрээс гарч буй хэлбэр. Толстой удаан бодсон ч эхнэртээ хэлж зүрхлэсэнгүй. Хэтэрхий удаан бодсоноос зориг нь мохоод бодол төдий л болсон байна. Нэгэн өдөр тэр үлдсэн жаахан зоригоороо захидал бичив. Захиагаа ч дуусаж, зориг нь ч шавхагдаж. Ингээд л тэр гэрээс гарч чадаагүй юм. Ойлгов уу? Арьяабалын аргаар хүн

бүхэн бясалгаж чадахгүйг, хүн бүхэнд тэмцэх хангалттай зориг зүрх байхгүйг би мэднэ. Миний шавь нараас ч зарим нь маш их бэрхшээлтэй тулгарч байсан. Жишээ нь, нөхөр нь авшиг хүртээд гэртээ харихад эхнэр нь ургамал хоол хийж өгөхгүй, эхнэр, нөхөр тусдаа унтах, нөхөр нь салахаар сүрдүүлэх гэх мэт олон асуудал гарахад бидний бясалгах зориг санаа амархан ганхдаг. Хүмүүс заримдаа ургамал хоол идвэл бусадтай харилцах аргагүй болж, алба тушаал, найз нөхдөө алдана гэж айдаг. Учир нь ургамал хоолтон болвол өндөр дээд алба тушаалтай хүмүүсийг дайлж цайлах аргагүй болох тул ажил албанд нөлөөлж, байр суурь ганхана гэх мэт тун олон зүйл бясалгах зориг шийдвэрт чинь саад болдог. Иймээс бясалгах нь та нарын хувьд хэцүүг би ойлгоно. Би гадагш гарч ном дэлгэрүүлэх тусмаа бясалгадаг хүн үнэхээр олддошгүй ховор, уг мөн чанараа хайж олох жинхэнэ хүсэлтэй, эгэл ертөнцийг жинхэнэ огоорч чадах хүн үнэхээр цөөнөөс цөөн байдгийг улам илүү ойлгодог. Иймээс эртнээс нааш бясалгагч хүн үнэхээр эрдэнэ мэт үнэ цэнэтэй байжээ.

Шагжамуни Буддаг энэ дэлхийд заларч байхад тэр үеийн эзэн хаад, их түшмэд, өтгөс буурлууд Түүний шавь нарыг ихэд хүндэтгэн биширч байсан. Багшийг нь биш, шавь нарыг нь шүү дээ. Тэд Шагжамуни Буддагийн гэрээс гарсан шавь, их бясалгагч хүмүүсийг харвал хувцас хунараа бохирдохыг ч үл тоон даруй сөгдөж мөргөнө. Тэр ч байтугай эзэн хаан ч гэрээс гарсан хуврагуудад ёслол мөргөж хүндэтгэлээ илэрхийлнэ. Эзэн хаан, Шагжамуни Буддагийн шавь нарыг хармагцаа мөргөдөг байсан. Энд бид Шагжамуни Буддагийн гэрээс гарсан шавь нарын тухай ярьж байна. Энэ бол хааны үлдээсэн түүх. Гэрээс гараагүй хэдий ч бясалгалын дэс өндөртэй хүмүүс олон байсан бөгөөд бид тэднийг дорд үзэж болохгүй. Гэхдээ гэрээс гарсан хүн бүхнийг огоорсон учир гэрээс гараагүй бясалгагчаас дэсээр өндөр. Гэрээс гарагч болно гэдэг тун хэцүү! Багшийнх

нь шавь нарын дунд гэрээс гарсан хүмүүс ч бий, гэртээ бясалгагчид ч бий. Гэвч шуудхан хэлэхэд би гэрээс гарсан хүмүүсийг илүүд үзнэ. Учир нь тэдний зориг санаа өөр, би тэднийг бүх талаар сургаж болно. Гэрээс гараагүй хүнийг бол заримдаа би сургаж чаддаггүй. Нааш цааш яваад Багшийн дэргэд байнга байхгүй тул тэднийг шалгах цаг хомс, гүн нарийн ном зааж, гүнзгий сорьж, нарийн төвшний би гэх үзлийг нь илрүүлэх боломжгүй байдаг.

Тэдний огоорох хандлага нь ч нилээд өөр. Тэд огоорохыг хүсдэг ч нөхцөл байдлаас болж гэрээс гарагсдаас ялгаатай. Ойлгож байна уу? Чи огоорохыг хүсэвч энд ч хүлээстэй, тэнд ч баглаастай явсаар сүүлдээ тэр нь дадал болж, бие биендээ хүлэгдээд дуусдаг. Харин гэрээс гарагсад бол хэдийнээ бясалгахаар зориг шулуудаж сэтгэлд нь үнэн ёс л байна. Тэдний сэтгэлд Их Багш, Бурхан, ном, хуврагаас өөр юмгүй. Ийм зориг шийдвэр байгаа учраас бид их зүйлийг бүтээж, олон сорилтонд орж, өөрийн хамгийн их чадварыг хөгжүүлж чаддаг. Бясалгахад ч их хялбар дөхөм. (Алга ташаад яахав. Тэднийг хэлсэн юм. Та нарыг хэлээгүй) (бүгд инээлдэв)

Өмнө нь тэр хаан гэрээс гарсан хуврагууд дээр тусгайлан очиж, ёслон мөргөнө, тэднийг хармагцаа мөргөдөг байв. Энэ дэлхийд залран буй Буддад үл итгэдэг нэгэн их түшмэл байжээ. Тэр: “Та бол эзэн хаан, төрийн тэргүүн. Гэрээс гарсан хэн ч бай бүгд таны албат иргэд. Тэгээд ч тэд гуйлгачин шиг ноорхой хувцаслаж, өдөр бүр хоол гуйн бадарлаж явдаг. Тэд ямар сүрхий гэж та өдөр бүр эрхэм нандин тэргүүнээрээ мөргөж, хувцас хунараа бохирдуулна вэ?” гэж тэсгэлгүй асуув. Хаан эзэн түүнээс: “Миний толгой үнэ цэнэтэй юу?” гэхэд түшмэл: “Мэдээж шүү дээ. Таны толгойноос үнэтэй зүйл байхгүй” гэхэд хаан: “За одоо гэр лүүгээ буцъя” гэв. Ордон руу буцах замдаа тэр түшмэлийг явуулж гахайн толгой, нугасны толгой, үхрийн

толгой, загасны толгой бас нэг хүний толгой худалдан аваад тэдгээрийг зах дээр заруулахаар түшмэлийн туслахуудыг явуулжээ. Бүх толгой зарагдаж дуусаад ганцхан хүний толгой л үлдэж гэнэ. Зарагдаагүй толгойг хааны ордонд авчраад, хаанд: “Бүх толгой зарагдсан, ганцхан хүний толгой л зарагдаагүй үлдсэн, одоо бүр өмхийрчихлөө. яах ч аргагүй нь гэж илтгэв. Хаан, нөгөө түшмэлээс: “Хүний толгой яагаад зарагдсангүй вэ?” гэж асуухад, тэр түшмэл: “Хүний толгой ямар ч хэрэгцээгүй шүү дээ” гэв. Хаан: “Бусад толгой яагаад үнэ хүрэв вэ?” гэсэнд, түшмэл: “Гахайн толгойгоор шөл хийнэ. Гахайн толгой, үхрийн толгойг чанаад иднэ, арьсыг нь ашиглана. Харин хүний толгойг хаяхаас өөр ямар ч хэрэгцээгүй” гэв. Хаан: “Хүн бүрийн толгой хэрэгцээгүй гэж үү? гэхэд түшмэл: “Тийм, тийм” гэж хурдан хариулав. Хаан: “Миний толгой хүний толгой болохоор бас л хэрэгцээгүй юу” гэхэд түшмэл хариулж зүрхлээгүй ч хааныг шавдуулаад байхаар нь: “Тийм, тийм ” гэв. Эцэст нь аргагүйн эрхэнд: “Тиймээ, хаан эзний толгой ч үнэ хүрэхгүй” гэв. Хаан: “Чи тэгвэл зальхай түшмэл байна. Буян хийхэд минь саад болж, энэ хэрэгцээгүй толгойгоор эрхэм дээд хүсэл мөрөөдөлтэй гэрээс гарсан хувраг, нэр хүндтэй, хязгааргүй их ач буянтай хүмүүст мөргөхөд минь саад болсон чи зальхай түшмэл мөн. Толгойг чинь авна” гэсэнд түшмэл өвдөг сөгдөн аврал эржээ. Тэр хаан: “Тэр гэрээс гарагсад навсархай хувцастай, ядуу амьдарч, толгой хоргодох орон гэргүй яваа нь тэдний өөрийн сонголт юм. Тэднийг гаднаас нь харвал эгэл ертөнцийн эд зүйл хураагаагүй ч дотооддоо хэмжээлшгүй их дээд дэсийн ач буянтай. Үүнийг чи үл мэдэх тул намайг хоригложээ.

Хэрвээ тэд дотооддоо хичнээн их агуу хүчтэйг мэдсэн бол аль хэдийнэ чи тэдэнд мөргөх байсан” хэмээн сургамжлав. Тэр өдрөөс эхлэн их түшмэл ухааран ойлгож агшин зуур гэгээрээд хааныг дахин хориглож зүрхэлсэнгүй.



Нэгэн хаан үнэнийг бясалгавал дэргэдийн хүмүүс нь саад хийж зүрхэлж байхад эгэл жирийн чадал дорой биднийг бол яриад яахав. Биднийг хүлээслэх зүйл тун олон, найз нөхөд, үр хүүхэд ч саатуулна. “Ургамал хоол идэхийг хүү маань зөвшөөрөхгүй байна” гэж зарим ээж надад ярьсан. Зовж өсгөсөн үр хүүхэд нь ургамал хоол идэхийг нь хориглож, үгэнд нь ороод идэж зүрхлэхгүй, бас тэднээс үхтлээ айна. Тэгээд: “Бясалгамаар байгаа ч хүүхдүүд ургамал хоол идэхийг зөвшөөрөхгүй байна” гэж ярина. “Ай, хөөрхий, ертөнцийн явдал үнэхээр хөл толгой нь солигджээ. Гэвч үнэхээр ийм явдал бий бий. Та нарт ийм зүйл тохиолдож байсан уу? Лавтай тохиолдсон. За тийм! Яриад яахав. Ярьвал нүүрээ барахын нэмэр.

Хүний эцэг, эх байтал яагаад хүүхэддээ захирагдана вэ? Энэ арай дэндүү ах захаа алдсан хэрэг биш үү? Заримдаа “дараа төрсөн” нь “түрүүлж төрсөн”-өө захирч байна. Нэгэн хатагтай нөхрөө өөрөөсөө ахмад, өөрөөсөө ухаантай гэж ихэд хүндлээд “сиен шэн” (хятадаар эр нөхөр гэсэн үг. Бас түрүүлж төрсөн гэсэн утгатай) гэж дуудна. Надаас түрүүлж төрсөн, юмны учрыг илүү ойлгодог гэж бодоод түрүүлж төрсөн гэжээ. Түрүүлж төрсөн юм чинь биднээс сайн, биднээс агуу, бүхнийг ойлгоно. Гэвч энэ нь сонсголонтой нэрнээс цаашгүй, нэр нь нидэртээ нийцэхгүй болсон байна. Түрүүлж төрсөн хүн (эр нөхөр) нь яагаад эхнэртээ захирагдана вэ? Энэ чинь “дараа төрсөн”-дөө захирагдаж байгаа хэрэг мөн биз! Яаж ингэж дуудна вэ?

Энэ дэлхийн юм бүхэн хөл толгой нь солигдоод бүгд хоосон нэр төдий болжээ. Эхнэрүүд нөхрөө “түрүүлж төрсөн” гэж дуудах хэрэггүй. Харин “бяцхан хүү”, “бяцхан дүү” гэх мэт яаж ч нэрлэсэн яахав. Харин түүнийг “түрүүлж төрсөн” гэж дуудах хэрэггүй. Ойлгов уу? Жишээ нь, нэгэн ерөнхийлөгчийг бид “ерөнхийлөгч” гэж нэрлэсэн байтал ерөнхийлөгчийнх нь ажлыг хийлгэхгүй, эрх мэдлийг нь

өгөхгүй бол ерөнхийлөгч гээд яахав. Тийм үү? Үүний адил, та нарын эр нөхөр чинь “түрүүлж төрсөн” юм бол тэдэнд бодсоноо биелүүлэх боломжийг нь олгох хэрэгтэй. Мэдээж түүнийг дагаж ургамал хоол идэх албагүй ч түүнд сонголт хийх эрхийг нь өгөх ёстой. Чөлөөтэй шүтэж бишрэх эрх нь хуулиар баталгаажсан шүү дээ. Тийм биз? Тэр илүү ихийг хүсээгүй. Эхнэр хүн улсын хуулийг зөрчиж болох уу? Энэ бол муу эхнэр, муу иргэн. Тэгээд ч төрийн хуулиа хүндэтгэхгүй байгаа хэрэг. Хэрвээ та нар бишрэн шүтэх эрх чөлөөгүй улс оронд амьдардвал тухайн улс орны хууль дүрмийн дагуу эр нөхрөө өөр шашин шүтэж болохгүй гэж хэлэх шалтаг олох байв. Гэтэл бид эрх чөлөөтэй улсад амьдраад эхнэр, нөхрөө ургамал хоол идэж, бясалгал хийхийг нь хязгаарлан хоривол үнэхээр шившигтэй. Ийм байвал хүмүүс та нарыг хүндлэхгүй, атгаг сэтгэлтэй гэж бодно. Эхнэр, нөхрөө эрхшээлдээ байлгаж байгаа чинь өөрийгөө дорд үзсэн хэрэг! Үнэ цэнээ алдах нь тун тоогүй явдал. Энэ зуршлаа өөрчлөх хэрэгтэй. Та бүхэнд ёс журмыг ярьсанаас, намайг дагаж бясалга гээгүй. Энэ нь та нарын амьдрал тул ургамал хоол сонгоно уу, мах иднэ үү надад хамаагүй. Гэтлэх үү, гэтлэхгүй юу гэдэг нь та нарын хэрэг. Хэдийнээ гэтэлсэн болохоор надад ямар ч хүсэл шаардлага байхгүй. Бясалгахад түмэн бэрхшээл байдаг, хэн нэгнийг өөрийн бүхнийг чадагч их хүчээ хайж олоход маш их зүйл саад болдгийг Багш нь мэднэ. Иймээс хүн бүрийг Арьяабалын аргаар бясалга гэхгүй. Харин амьдралыг сайжруулж, амар тайван болгодог нэгэн нууц жор байдгийг та бүхэнд сануулсан хэрэг.



## ҮЙЛИЙН ҮР, НҮГЭЛ ХИЛЭНЦИЙГ ДАВАХ НУУЦ АРГА

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Формоса, Миаоли, Шиху ашрам  
1991 оны 7 дугаар сарын 14  
(Эх нь хятад хэлээр)*

Бидний үйлийн үр тийм ч сүртэй юм биш, нүгэл хилэнц ч бас өөрчилж болшгүй зүйл биш. Тийм биш бол бид бясалгах ч хэрэггүй, ёс суртахуунтай сайн үйл хийх бүр ч шаардлагагүй, Төгс Гэгээрсэн Их Багшийн хэрэгцээ ч байхгүй байхсан.

Үйлийн үр, нүгэл хилэнц гэж юу вэ? Энэ бүхэн заавал бидний муу сэтгэлээс үүсдэггүй тул заримдаа тун утгагүй санагддаг. Багшийнхаа санааг ойлгож байна уу? Жишээ нь, чамд аль нэг газар, хэн нэг хүн ихэд таалагддаг. Үүнийг бид тухайн хүнтэй барилдлагатай, тэр газартай ерөөлтэй гэдэг. Гэвч та нар энэ ерөөл барилдлагын сайн, мууг мэдэхгүй. Бидний дэс тийм ч өндөр биш бол муу ерөөл барилдлагад татагддаг. Харин дэс маань өндөр төвшинд хүрвэл тэр муу нөхцөл байдалд нөлөөлөгдөхгүй болно. Ойлгов уу?

Яг л усны төвшин гүехэн, гүнзгий байдаг шиг. Усны ёроолд хүрвэл даралт ихсэж, нийт жингээрээ дарна. Харин усны гадаргад ойртвол даралт багасаж амьсгалах

боломжтой болно. Эрэгт хүрвэл усанд живэхгүй. Үүний адил бясалгадаг хүн үйлийн үр, нүгэл хилэнцийн нөлөөллөөс мултарч дарамтгүй хөнгөн болдог. Тиймээс бясалгах тусам амьдрал баяр баясгалантай, ажил үйлс бүтэмжтэй болдог. Учир нь бид хэдийнээ үйл үрийн явцаас мултарч, тэр бидэнд дахин ойртохгүй болсон байна. Бид түүнээс илүү өндөрт гарч чаджээ. Жишээ нь, баранд хөөгдөхөд хурдан шалмаг бол дээд давхарт гарна, модонд авирна, тэгвэл бар яаж ч чадахгүй. Тэгээд ч өлсөх тул хүлээж чадалгүй орхиод явна. Ойлгов уу? Ахин нэг жишээ авъя. Хэн нэг хүнд дурлаад гэрлэхийг, найзлахыг хүсвэл хянуур болгоомжтой байгаарай. Тэр хүн олон төрөлдөө дотны итгэлт хүн чинь байсан байж магадгүй. Зарим хүн бясалгаад тодорхой төвшинд, тухайлбал хоёрдугаар ертөнцөд хүрвэл өнгөрсөн төрлүүдэд тохиолдсон зүйлсээ хардаг, үүнийг та нар мэдэх үү? Яагаад одоо ийм байдалд байгаагаа, яагаад зарим хүмүүстэй барилдлагатай болсноо мэдчихнэ.

Америкт ийм нэг бодит явдал болжээ. Нэг эмэгтэй хэдэн мянган жил, хэдэн сая жилийн өмнөх урд төрлийн амьдарлаа тодорхой хардаг. Дэлхий үүссэн тэр цагаас өнөөг хүртэлх бүх зүйлсийг хардаг. Тэр нэг эрэгтэй хүнтэй танилцаад хэдхэн долоо хоногийн дараа гэрлэсэн байна. Гэрлэсний дараа тийм ч сайхан амьдарч чадахгүй, түүний боол, ажилчин мэт хамаг хүчээ шавхан ажиллажээ. Хожим нь тэр үйлийн үрийн барилдлагаа олж харсан байна. Нөхөр нь урьд түүний эзэн, өөрөө боол нь байжээ. Тэр нилээд царайлаг боол байсан тул түүнийг хулгайлаад өөр боолуудтай хамт байлгасан аж. Тэр, боол худалдаж авах мөнгөгүй тул бусдын боол хулгайлдаг байж. Тэгээд тэднийг элсэн цөлд хүргэж, өөрийн өмнөөс олон янзын ажил хийлгэдэг, тун хэрцгий эзэн байжээ.

Эмэгтэй энэ төрөлдөө дахин түүнтэй гэрлэж, өдөр бүр өнөөх элсэн цөлд чармайн ажиллана. Хэдэн мянган

жилийн өмнө хулгайлагдан боол болоод хамтдаа хулгайлсан тэмээгээр ачаа тээш зөөнө. Харин энэ төрөлдөө тэмээгээр биш, том ачааны машинаар зөөх болжээ. (Багш инээв) Энэ ч бас нэг төрлийн “төмөр” тэмээ. Тийм биш үү? Тэд машинаар сүү зөөх мэтийн элдэв янзын ажил чармайн хийдэг ч элсэн цөлийн ажлаасаа мултарч чадахгүй байлаа.

Бясалгах болсноосоо хойш нөхрөөсөө хоромхон зуур төвөггүй салсан байна. Нэг удаа нөхөртөө салах тухай хэлэхэд тэр ямар ч саадгүй дороо зөвшөөрчээ. Нөхөр нь урд төрөлдөө түүний эзэн байсан тул түүний хэлсэн сайн, муу бүхнийг дагана. Хожим нь эмэгтэй нэгэн Төгс Гэгээрсэн Их Багштай уулзаж бясалгах болов. Би яагаад заавал энэ хүнтэй хамт байх учиртай юм бол гэж нэг өдөр өөрөөсөө асуужээ. Учир нь хүссэн хүн нь тэр биш, тэгээд ч таарч тохирохгүй тул ямар нэг шалтгаангүй ч гэнэт явахаар шийдэв. Тэгээд нөхрөөсөө ямар ч асуудалгүй салж гэнэ. Учир нь бясалгаад урьдын үйлийн үрийн хүлээснээс мултарч, нөхөртэйгөө цаашид хамт амьдрах шаардлагагүй болсноо мэдсэн аж.

Түүнийг бясалгаад удаагүй байхад нь нэгэн үл үзэгдэх төрөлтөн ирж гурав хоног дараалан зовоожээ. Зарим үед та нарт бас ийм явдал тохиолддог. Хэвтэж байхад дээрээс хүн дарах шиг санагддаг ч харагдахгүй. Хашгирч болохгүй, яаж ч хичээгээд салахгүй, чадал тэнхээ барагдаж ямар ч аргагүй болдог. Тийм биз? Тэр эмэгтэй ийм байдалд ороод ихэд дургүйцэж, давж гарах арга хайжээ. Дахин ийм байдал тохиолдоход тэрээр Багшийгаа тасралтгүй бодож, хэсэг зуур зовсоны эцэст энэ байдлаас гарч чадсан байна.

Үл үзэгдэх төрөлтөн ирж зовооход бүх гэрлээ асаасан ч тэр байсаар байх тул унтахгүй байхаар шийдэж, Багшийнхаа сургаал номлолыг сэтгэл төвлөрөн уншиж, хуулан бичиж, эх ноорог гарган Багшийн зааснаар хийсээр байв. Багшийн ажлыг сэтгэл төвлөрөн хийж байхад үл үзэгдэх төрөлтөн хажууд байсан ч зовоож чадахгүй байжээ.

Гэвч жаахан анхаарал сарниж, сэрэмж алдвал үл үзэгдэх амьтан даруй ирж зовооно. Энэ нь яг л том уут углавал амьсгалж болохгүй, хөдөлж ч чадахгүй болох мэт. Харин Багшийн ажлыг сэтгэл төвлөрөн хийвэл асуудалгүй, харин хоромхон зуур анхаарал сарнивал дүрсгүй төрөлтний нөлөөнд орж буй нь дорхноо мэдэгдэх аж.

Эмэгтэй ийм байдлаар гурав хоног тэмцээд огтхон ч унтсангүй. Анхаарлаа сарниулалгүй, өдөржин, шөнөжин зөвхөн Багшийгаа бодож, даалгасан ажлыг нь хийж, хуурцаг сонсож, оюун ухаанаа цаг ямагт бясалгал дээр төвлөрүүлсэн тул дахин энэ явдал болсонгүй гэнэ. Ингээд гурав хоногийн дотор түүний дэс даруй дээшилжээ. Гурав хоногийн турш Багшийгаа бодож, Багшийнхаа ажлыг өчүүхэн ч сарнилгүй сайтар төвлөрөн хийвэл дэс чинь заавал дээшилдэг болохыг та сайн бодоорой.

Та нар заримдаа долоо хоногийн, нэг хоногийн, хоёр хоногийн даяанд суугаад дэсээ дээшилснийг мэддэг. Тийм биз? Бид даяаны үер дэсээ дээшлэхэд төвлөрдөг тул үйлийн үр ард хоцорч, аяндаа нөлөөлөхгүй болно. Бид голын эрэгт хүрчихвэл хорохгүй болдог шиг. Жишээ нь, урьд нь харгис муу явдал үйлдэж байсан бол хилсээр амиа алдах, гамшигт өртөж үхэх явдал тохиолдох магадлалтай.

Өмнө нь ийм байдлаар нэг л удаа нас барвал эргэж төрөл авсан ч энэ байдал давтагдах гээд байдаг нь далд ухамсарт бичигдсэнтэй холбоотой юм. Далд ухамсар нь юу бичнэ, түүнийг гаргадаг компьютертэй адилхан гэж би та нарт ярьсан. Жишээ нь, урд төрлийнхтэй яг ижил зүйл тохиолдох буюу ижил товчлуур дарагдвал далд ухамсар яг тийм үйлдлийг гаргаж ирнэ. Далд ухамсар сайн, мууг ялгахгүй, ямар товчлуур дарагдана, тийм л мэдээллийг гаргаж ирнэ. Хэн дарахаас үл хамаарна, товчлуур дарагдсан л бол тохирох хариу нь гарч ирнэ.

Зарим нэг газраар явахад тун дарамттай санагддаг.

Эсвэл авто осол, гай гамшиг, ямар нэг юм болох гэж байгааг зургаа дахь мэдрэхүй урьдчилан мэдэрдэг. Тийм биз? Бид энэ бүхнийг мэдэрсэн ч нөхцөл байдлыг хянаж чадахгүй тул болох юм болдгоороо л болно. Жишээ нь, шинэ байшин үзэхээр очсон хүн шатаар буухдаа зүгээр байсан ч, бүдрэхээ мэдэрснээс дараагийн алхамд үнэхээр хий гишгээд биеэ гэмтээв. Өмнө нь түүнийг нэг хүн байшин дээрээс түлхэж амийг нь хороосныг хожим нь олж харжээ. Заримдаа бид урьд нь тохиолдож байсантай ижил нөхцөлд орвол товчлуур дарагдсан мэт хэдийнэ бичигдсэн зүйлийг далд ухамсар давтан гаргадаг. Жишээлбэл, камераар бичсэн бүжгийн үдэшлэгийн бичлэгийг зурагтын дэлгэцээр үзье гэвэл тохирох товчийг дарахад тэр бичлэг гарна. Багшийнхаа санааг ойлгов уу? Эсвэл бид санамсаргүйгээр тэр товчлуурийг дарвал тэр бичлэг л гарна. Хүүхэд, хараагүй хүн санамсаргүйгээр тэр товчийг дарсан ч бас яг ижил агуулгыг гаргана.

Үйлийн үр, нүгэл хилэнцээс үүдсэн нөхцөл байдлаас бясалгалын хүчээр л давна. Ямар ч ач буян хийсэн ялгаагүй. Буян бол буян, нүгэл бол нүгэл. Эгэл хүмүүс бидэнд ач буян, нүгэл хилэнц гэж хоёр зүйл байдаг. Харин бясалгавал буянтай, буянгүй бүгд туулан ангижирч, дээд төвшинд хүрнэ. Энэ нь шинжлэх ухаанч, бас учир зүйд бүрэн нийцэх зүйл. Тиймээс бид бурханд мөргөж судар уншихад л болчихно гэж үздэг мухар сүсгээр бясалгаж болохгүй. Үр дүн нь та нарын чин сэтгэлээс, төвлөрлийн хүчээс шалтгаалдаг. Хэрвээ судар уншингаа бизнес наймаа бодвол ямар ч тусгүй. Багш нь яагаад ном судар унших, бурханд мөргөх нь ихэнх хүнд ач тусаа өгөхгүй гэдэг вэ? Хэдийгээр бидэнтэй адил бурханд мөргөж байгаа ч арга нь төгс биш, хангалттай төвлөрлөлгүй зэргээс болж хүмүүсийн хүртэх ач тус нь өөр өөр байдаг.

Гурван өдөр дүрс үгүй төрөлтнөөс болж зовсон тэр эмэгтэй шиг нэгэн сэтгэлээр бясалгавал лавтай хурдан дэвшинэ. Тэр үед өөрийн амь насны төлөө бууж өгөхгүйгээр

шийдэж, аргагүйн эрхэнд хүчээр төвлөрөөд гурав хоногийн дараа дэс нь дээшилсэн тул тэр дүрс үгүй төрөлтөн нөлөөлж чадахгүй болжээ. Дүрс үгүй төрөлтөн гэгч нь хэн байв? Үнэндээ тэр хоёр тийм ч муу барилдлагагүй. Дүрс үгүй төрөлтөн өмнө нь буддын бус өөр нэгэн шашны гэрээс гарсан хувраг байсан бөгөөд тэр эмэгтэй: “Төрөл төрөлдөө таныг дагаж гэрээс гарна, сүм хийд барихад чинь тусална” гэж ам тангараг өргөөд хожим нь түүнийгээ биелүүлж чадаагүй байна. Өнөөх эмэгтэй энэ төрөлдөө хүн болсон ба нөгөө хувраг асури болсон тул эмэгтэйг асуурийн орондоо аваачиж, өөрийн төлөө ажиллуулахыг хүссэн байна. Учир нь төрөл төрөлдөө түүнийг дагаж, “Та хаана явна, би тэнд байна” гэж амалсан аж! Ай хөөрхий, болгоомжтой л байгаарай! Хамаагүй ам тангараг өргөж болохгүй шүү. Хэнтэй хамт байна гэсэн ч бүгд л тун төвөгтэй явдал!

Хэрвээ цаад төрөлтний дэс нь доогуур бол өөрийн дэс рүү биднийг чангаана. Учир нь бид нэгэнт ам алдсан билээ. Гэхдээ та нар зарим хүнд, эсвэл бусдыг хүлээслэх дуртай шашны ямар нэгэн бүлэгт жинхэнэсээ ам тангараг өргөсөн байсан ч хамаагүй. Арьяабалын аргаар сайн бясалгавал уг үйлийн үрээ арилгаж чадна. Яг л бид модонд авирчихвал дор байгаа бар яаж ч чадахгүй шүлсээ гоожуулан үлдэх шиг. Үнэндээ үйлийн үр, нүгэл хилэнц байсан ч хамаагүй. Өдөр бүр оюун ухаанаа их билиг ухаан дээр төвлөрлүүлээд хичээнгүй сайн бясалгавал бид ямар ч нөхцөл байдлыг даван туулж, ямар ч нүгэл хилэнцийг ардаа орхиж, дороо үлдээнэ. Бясалгах нь ашиг тустай, энэ нь өөртөө найд гэсэн санаа юм. Багшийнхаа хэлснийг ойлгов уу? Бясалгаж эхлэхэд чинь Багш нь эдгээр ёс журмыг заагаагүй бол та нар яаж ийм ихийг мэдэх вэ? Зарим зүйлийг та нар сайн ойлгохгүй, эсвэл буруу арга сонгож бясалгахаас чинь сэргийлж, Төгс Гэгээрсэн Их Багштай байх нь нэн чухал гэдэг юм. Гэхдээ Их Багш та нарын өмнөөс юм бүхнийг бясалгахгүй, харин



хажуугаас нь заан сургаж, удирдан чиглүүлнэ.

Арьяабалын аргаар бясалгадаггүй боловч Их Багшийг өдөр бүр дурсан санадаг хүмүүс ямар ач тус хүртэх вэ? гэж та нар надаас асууж магадгүй. Тэд бас яагаад гэтэлж чаддаг вэ? Учир нь бид санан дурссан зүйлийнхээ нөлөөг хүртдэг жам ёсоор дотоодын билиг ухаан багахан ч гэсэн ундрэн гардаг. Багшийнх нь сая ярьсан ёс журамтай адил, ямар нэгэн газраар явж өнгөрөхдөө урдынхтай ижил нөхцөл байдлыг олж харвал далд ухамсар үүнтэй яг ижил дурсамжийг гаргаж ирнэ. Зарим үед бид хэн нэгнийг дурсан санавал нөгөө хүн бас мэдэрнэ. Учир нь түүний сүнс биднээс цацарсан долгионыг хүлээж авдаг.

Эх, үрийн хүйн холбооны тухай та нар сонссон. Гэртээ байгаа ээжид нь ямар нэг зүйл тохиолдвол хол яваа хүүгийнх нь гэдэс өвддөг. Тийм биз? Учир нь эх, үрийн хүйн холбоо маш гүн байдаг. Ийм зүйл байдаггүй бол хоёр өөр газарт амьдарч байгаа дурлалт хос уулзаагүй ч бие биенээ яаж тийм хүчтэй санах вэ? Жишээ нь, төрөл төрөлдөө эхнэр, нөхөр байсан, эхнэр, нөхрийн барилдлагатай байгаад нас барахдаа бие биенээ ихэд хайрлаж байсан бол бие махбод нь үгүй болсон ч сэтгэл нь хэвээр байж, төрөл төрөлдөө дотоод харилцаагаа хадгалан бие биенээ дагаж төрөөд байдаг. Иймээс ”барилдлагатай бол мянган бээрийн холоос ч уулзана, барилдлагагүй бол нүүр тулсан ч учрахгүй” гэдэг. Тиймээс та нар хар л даа, Лиан Шаньбо, Жу Иньтай хоёр яагаад ийм их алдартай болсон бэ? Миний сонссоноор, тэр хоёр долоон төрөлдөө эхнэр, нөхөр болох гээд чадалгүй, хожим эрвээхэй болж төрөөд эрх чөлөөтэйгээр хамт амьдарчээ. Ингэтлээ санавал арай хэтэрсэн явдал биш үү. (бүгд инээлдэв) Дэс нь унана. Иймээс энэ ертөнцийн хайр сэтгэлийг их л болгоомжтой зохицуулахгүй бол тун төвөгтэй. Бид хэн нэгэнд дурлаж болно. Асуудалгүй. Бие биенээ хайрлан дурлаж, энэ хайр дурлалын холбоогоор харилцан

тусалж, бие биенээ зоригжуулж, бясалгаж гэгээрэх зориг тэмүүллээ тэтгэж, хамтдаа дэвших нь үнэхээр сайн хэрэг биш гэж үү?

Гэвч хичнээн үзэсгэлэнтэй, хичнээн сайн хүн байсан ч ганцхан түүний төлөө сансрын хүрдэнд хамтдаа төрөл, төрөлдөө эргэлдэж, зовлонгийн далайд живэх дуртай байх нь үнэхээр утгагүй хэрэг. Иймээс хайр сэтгэл сайн ч талтай, саар ч талтай гэдэг нь ийм учиртай. Юм бүхэн сайн, муу хоёр талтай. Чи алийг нь сонгосноос болоод чамд сайн, эсвэл муу байна. Хооллох ч бас үүнтэй адил ёс. Хэтрүүлбэл цаггалдаж үхнэ. Үүний нэгэн адил тамир тэнхээ тэтгэх эмийг ч ихдүүлж болохгүй. Багшийнхаа санааг ойлгов уу? Яг л цахилгаан гүйдэлд дураараа хүрвэл тогонд цохиулж, амиа алддаг шиг. Харин цахилгааныг сайтар тусгаарлавал юунд ч ашиглаж болох бөгөөд олон хүнд тустай.

Бид бодсон бүх зүйлдээ нөлөөлөгдөж байдаг гэж Багш нь дөнгөж сая хэлсэн. Энэ бол үнэн бодитой хэрэг. Тиймээс Багш нь та нарыг ертөнцийг бүү бод, Бурхныг л бод гэж сургадаг. Учир нь энэ дэлхийд олон зүйлийг сурах боломжгүй тул Багш нь та нарыг унтаж байхад байнга дээш аваачин сургадаг. Өндөр төвшний ертөнцөд хүрч байж л жинхэнэ ёсоор суралцана. Энэ нь яг л та нар сургуульд явбал багшаас их зүйл сурч чаддагтай адил. Гэртээ байвал яаж сурах вэ? Гэрээрээ суралцахад амаргүй тул заавал сургуульд явах хэрэгтэй. Эсвэл багштайгаа захидлаар харилцаад суралцаж болно. Ганцаараа бол суралцахад тун бэрх. Тиймээс та нарын унтах чинь ч бас унтаж байгаа биш. Минийх ч бас жинхэнэ унтлага биш. Зарим үед Багш нь унтсан, унтаагүй ийм л байдаг. Хийх ажил өчнөөн байна. Гэвч заримдаа жаахан ч гэсэн унтвал миний биенд ч сайн, ажилд ч тустай. Тэр эмэгтэй Их Багшийнхаа ажлаас ганц хором л сатаарвал дүрс үгүй төрөлтөн даруй ирж, түүнийг дарж авдаг гэж Багш нь сая ярьсан. Гурав хоногийн турш

хичээн тэмцээний эцэст уг саадыг давжээ. Гуравхан хоног бясалгах төдийд тийм өндөр дэсэд хүрч, асурийн төвшнийг давсан нь үнэхээр боломжийн байна шүү. Учир нь асурийн төвшнээс салж, түүнийг давна гэдэг тун хэцүү. Эгэл ертөнцийн тогтсон үзэл, бие биендээ хүлэгдсэн сэтгэл, бусдад өгсөн сайн, муу элдэв амлалт, одоо тэр амлалтууддаа гэмшиж, сэтгэл хүлэгдээд түүнээсээ салж чадахгүй бол тэд ирж үймүүлнэ. Харин бид энэ дэсээс салвал урд төрлийн өр төлөөстэй тэр хүмүүс биднийг яаж ч чадахгүй. Учир нь соронзон талбай нийлэхгүй болсон. Ижил зүйлс харилцан таталцдаг. Тиймээс та нарт атаархал, асурийн хайр сэтгэл, шунал, хилэн, мунхаг зэрэг дүрстэй, дүрсгүй саад тотгор учирвал илүү сайн бясалга. Өөр ямар ч аргагүй. Багшийнхаа ном сургаалыг ахиухан уншиж, дууны хуурцгийг байнга сонсож, илүү их бясалгаж, аялгууны бясалгалаа сайн хийх хэрэгтэй. Илүү их хичээж, үнэн ёсонд нэгэн сэтгэлээр төвлөр. Хаана ч нуугдсан аюултай. Харин Үнэн ёсонд нуугдвал аюулгүй.

Бид дүрстэй төрөлтнөөс зайлж чадна, харин дүрс үгүй төрөлтнөөс зайлахад хэцүү. Хаашаа ч явсан гэд биднийг олно. Тэрхүү биегүй төрөлтнүүд бодмогц л гараад ирдэг. Бид юу бодно, тэр бүхэн бидэнд нөлөөлж байдаг. Тиймээс Арьяабалын бясалгал хийдэггүй хүмүүс ч Их Багшийг дурсан санавал нөлөөлөх хүчийг бас мэдэрнэ. Ямар ч хүн Их Багшийг дурсан санасан Түүний нөлөөг мэдэрдэгийг хүмүүс мэддэг. Үүнийг бид санаанаасаа зохиогоогүй, бүгд нотолгоотой. Хэнд, ямар нөлөө мэдрэгдсэн, гай гамшгаас хэрхэн яаж мултарсан, өвчний зовуурь арилсан гэх мэт нь бүгд л та нарын надад ярьсан зүйл. Их Багш жаахан билиг ухаан дамжуулсан учраас түүний нүгэл хилэнц нь угаагдаад дэс нь дээшилжээ.

Энэ нь Их Багшийг мэдээж нилээд зүдрээдэг. Жишээ нь, нөхөр, хүүхдүүд чинь чамайг хаа ч явсан байнга дурсан

санаад байвал чи тэсэхийн аргагүй болно. Тийм биз дээ. Тэр ч байтугай гэдэс, толгой чинь өвдөж, сэтгэл санаа тавгүйрхэж, зорьсон газраа хүрэлгүй буцмаар санагдана. Зарим үед хоёр муурын зулзага, нэг гөлөг байсан ч гадагш гарвал сэтгэл зовоод байдаг нь тэд таныг дурсан санаснаас болдог. Хэрвээ итгэхгүй бол хариад хоёр, гурван хүнийг дуудаад өөрийн нэрийг өдөр бүхэн хэлүүлж дуудуулаарай. Тэгээд өөрийгөө яахыг хар. (бүгд инээлдэв) Зөвхөн нэр унших төдий биш. Гай гамшиг тохиолдох, үхэл хагацал ирэх, сэтгэлээр унах, ухаан санаа самуурах үедээ сэтгэлийн гүнээс гуйн залбирвал тэр хүчийг мэдрэнэ. Үй түмэн хүн хамтдаа уншвал тэр үед чи ойлгоно. Хэрвээ бясалгалын тогтсон хүч хангалтгүй бол тун амаргүй. Заримдаа та нар Багшийгаа гэнэт өвдөх юмуу, ухаан алдан унаад даруй сэрэхийг хардаг. Багш нь ихэнх нүгэл хилэнцийг агшин зуурт шатаадаг. Удах шаардлагагүй. Гэсэн ч заримдаа хэдэн цаг, хэд хоног, хэдэн сар, түүнээс ч удаан хугацаа орох нь бас бий.

Бид өөрсдийн амьдралаа өөрчилье гэвэл бидэнд сайн зүйлсийг дурсаж, бидэнд ач тустай зүйлсийг бодох хэрэгтэй. Тэгэхгүй бол урд төрөлдөө тохиолдож байсан байдалд байнга эргэж орох гээд байдаг. Хэрвээ нэг хүн урд төрөлдөө амиа хорлож байсан бол эргэж төрөөд бас л амиа егүүтгэхийг санаархана. Хичнээн урт хугацааны дараа хүний төрлийг олсон ч өөрийгөө егүүтгэх бодол агуулсаар байх бөгөөд ахин амиа хорлож болзошгүй. Авто машины осолд орох, эсвэл үхэхээс өөр аргагүй байдалд орж амиа алдана. Үнэндээ муу үйлийн үр тийм ч аймшигтай биш. Зарим тохиолдолд санаатайгаар боловсордоггүй, харин тэр давтагддаг байдал нь үүсэхэд түүнтэй тэмцэж, уг саадыг даван гарахыг хичээгүйгээс эргэж төрөөд ахиад нөгөө үйлдлээ давтдаг юм.

Нүгэл хилэнц сүртэй зүйл биш, түүнийг угааж болно. Арьяабалын аргаар бясалгавал ямар ч нүгэл угаагдана.

Үүнийг Багш нь батална. (бүгд алга ташив) Бид заримдаа ямар дутагдалтайгаа таньж мэдэх хэрэгтэй. Хэрвээ бид хэтэрхий үхээнц дорой бол үргэлж урд төрлийнхөө нөлөөлөлд автаад яаж түүнийг давах талаар бодож сэтгэхгүй, бясалгаж чадахгүй, дээш дэвших аргагүй болдог. Хүмүүс биднийг далайд шидвэл заавал живэх албагүй, дээш сэлэн гарч болно шүү дээ. Эсвэл хөвж байгаа модыг олж бариад сэлүүрдэнгээ тусламж гуйн хашгирвал эрэг дээр гарах боломж олдоно. Ойлгов уу? Тэнд тэр чигээрээ живэх шаардлага ерөөсөө байхгүй.

Үйлийн үр нь үргэлж нүгэлт сэтгэлээс үүсдэггүй. Оюун санаа биднийг байнга мэхэлж, урдын төрлүүдэд тохиолдсонтой ижилхэн байдалд оруулдаг. Тэр ижил төстэй зүйл харвал ижил товчлууур дарж, ижил үзэгдлийг гаргаж ирээд адилхан үйлдэл хийлгэдэг. Хэрвээ бидэнд ямар нэгэн золгүй явдал, гай гамшиг тохиолдвол тэдгээрийн нөлөөнд авталгүй, дадал зуршилдаа хүлэгдэлгүй заавал даван гарах хэрэгтэй. Үүнийг бид тодорхой сайн мэддэг байх ёстой.

Багш нь энэ бүх учир явдлыг ярьж байгаа нь бясалгал амьдралыг чинь илүү урагштай, гоё сайхан болгож, алийг нь зохицуулах, алийг нь мартаг, юуг илүү их анхаарч, юунаас болгоомжлохыг та нарт ойлгуулахад оршино. Тийм биз? Иймээс Багш нь та нарт ямар ч үед Бурхан дээр төвлөрч, дотоодын Багшаасаа аврал эрж байх хэрэгтэй гэж сургадаг. Бид модноос зуураад байвал доор байгаа бар биднийг барьж идэхгүй. Харин загатнасан газраа маажих гээд модноос барьсан гараа тавиад уначихсан бол баранд гомдох хэрэггүй. Багшийнхаа санааг ойлгов уу? Бар биднийг идэх гээд хүлээж байгаа тул болгоомжтой байх хэрэгтэй. Аюулгүй болсны дараа л тайвширч болно. Жишээлбэл, та нар асурийн төвшнийг хэдийнээ давсан бол урьд төрлийн өр төлөөстэй хүмүүс бидэнд ойртохгүй болдог. Та нар ч гэсэн зовж зүдрэхгүй, дарамт багатай тайван амьдарна. Миний

саяын ярьсан тэр эмэгтэй гурван өдрийн турш тэмцэхдээ хором бүр Багшийгаа санагалзаж, Багшийнхаа даалгасан ажлыг хийж, Багшийнхаа заасан аргаар бясалгажээ. Гурав хоногийн дараанаас эхлэн өдөр бүр ингэх шаардлагагүй болж, унтаж амрах боломжтой болсон байна. Харин гурав хоногийн хугацаанд тэрээр унтаж ч зүрхлэхгүй, тасралтгүй тэмцжээ. Унтах, анхаарал болгоомж алдахад дүрс үгүй төрөлтөн тэр дороо ирж дарах тул гурван өдөр, гурван шөнө Багшийнхаа ном сургаалыг хуулж бичих зэргээр тасралтгүй ажиллаад өчүүхэн ч зүүрмэглэж зүрхлээгүй аж. Харин тэр дэсийг давснаар ингэж зүдрэх шаардлагагүй болжээ. Яг л та нарын шалгалт өгөхтэй адил. Шалгалт дуусах, эсвэл сургуулиа төгсчихвөл амарч зугаалах завтай болдог шиг.

Бүгд хичээнгүй байж, саад бэрхшээлтэй тулгарвал улам чармайх хэрэгтэй. Хичээнгүйлэн бясалгасны дараа хариулт нь маш тодорхой болно. Бид өөрсдийн урд төрлийн үйлийн үрээ чин сэтгэлээсээ давах хэрэгтэй. Би нүгэл хилэнц гэдэг хоёр үгийг ярих дургүй. Харин “дадал зуршил” гэвэл дээр. Тэгвэл арай зөөлөн, логиктой, шинжлэх ухаанч сонсогдох төдийгүй үйлийн үрийг өөрчилж болно гэсэн санааг агуулна. Хэрэв үйлийн үр гэж яриад байвал тэндээ гацаж, үйлийн үр бол ад чөтгөр, сэтгэшгүй, өөрчлөхийн аргагүй аймшигтай зүйл гэж бодно. Үнэндээ энэ нь юу ч биш, дадал зуршил төдий зүйл. Тийм биш бол бид яаж өөрчлөх вэ? Ярга бой хийдэг тэр хүмүүс Бурхан Буддаг шүтэн дагаад үйлийн үргүй болдог шиг. Учир нь одоо тэр урдын дадал зуршлын дагуу хийж болохгүй гэдгээ ухаарчээ. Үнэн зөв хандлагатай бол хийсэн бүхэн зөвдөнө. Хандлага нь буруу бол сайн үйл хийсэн ч адын үйл болно. Хуврагийн хувцас өмссөн ч адынх, эгэл хүний хувцас өмсвөл бүр адынх болж, харилцан бие биедээ ад бололцоод дуусахаас цаашгүй. (Багш инээв) Тиймээс та нар хянуур болгоомжтой байгаарай.

Бид өөрсдийн дадал зуршлаа ямар ч аргаар хамаагүй ялан дийлэх хэрэгтэй. Жишээлбэл, төрлөөс төрөлдөө атаач, бусдыг дайрч доромжилдог, шүүмжилдэг, муу үйлэнд авьяастай, хорсомтгой байсан нь дадал зуршил болжээ. Энэ бүх учир утгагүй юмыг одоо дахин бүү үйлд! Аль хэдийнээ төрөл тутамдаа үйлдсээр ирсэн байна. Одоо өөрчилж, өөр зүйл хий! Төрөл авах болгондоо нэг л зүйлийг хийгээд байвал дэндүү уйтгартай. Иймээс Багш нь та бүхэнд шинэ зүйл, шинэ санаа, шинэ хандлага, амьдралын шинэ хэв маягийг зааж байна. Өдөржингөө хүн шүүмжлэх, бусдыг гоочлохыг л хийж суудаг бол үүнийг хэн ч хийж чадна. Тэгэхээр одоо бид өөр зүйл хийвэл сонирхолтой бөгөөд мундаг. Тэгээд ч илүү эерэг, илүү гэгээн саруул, илүү эрхэмсэг зүйл хийвэл тун сайн. Өдөржингөө хов ярьж, дэмий чалчихыг ямар ажил гэх вэ? Нэг насыг ингэж бараад дахин ирж, нөгөө л зүйлээ давтаад дадал зуршилдаа баригдаж, ухаан санаандаа мэхлэгдээд дахиад л сурсан юмгүй ганзага хоосон буцна. Яагаад ихэнх хүний хийсэн бүхэн нь бүтэлгүйтээд байдгийг мэдэх үү? Учир нь бүрэн төвлөрч чадахгүйгээс болдог. Бүрэн төвлөрвөл тусгай мэргэжлийн ажлыг ч сайн хийнэ. Төвлөрлийг дадуулж дадал болгосон учраас бизнес хийх, инженерийн ажлыг хийхэд улам хялбар болно. Зарим эмч, уран барилгачин бусдаасаа илүү чадварлаг байдаг нь тэдний төвлөрөх чадвар, цэцэн ухааны төвшин адилгүйгээс болдог.

Нэгэн Төгс Гэгээрсэн Их Багш яагаад бүхнийг хийж чаддагийг та нар мэдэх үү? Учир нь Тэр байнгын төвлөрөлтэй байдаг бөгөөд юу ч хийсэн тухайн зүйл дээр бие, хэл, сэтгэлээ бүрэн төвлөрүүлдэг. Мөн үй түмээр хувилж чадна. Учир нь Түүний сэтгэл үүрд сарнихгүй. Яг л нар шиг, хорвоо ертөнцийг даяар нь гийгүүлэх боловч түүнээс нь юу ч хорогдохгүй. Харин лаа бол хэсэгхэн газрыг түр зуур гэрэлтүүлнэ. Дахиад гэрэлтүүлж чадахгүй. Ойлгов уу? Бясалгадаг, бясалгадаггүй хүний ялгаа энд л бий.

Бясалгадаг хүмүүс бясалгах тусмаа дэс нь дээшилж, мэргэжилгүй ч аливааг мэргэжилтэй хүнээс ч илүү сайн хийнэ. Учир нь сэтгэлээ билиг ухаандаа төвлөрүүлэх тул ямар ч ажлыг чадамгай хийнэ. Ялгаа нь энд л байгаа юм. Иймээс юуг ч хийж чадна. Билиг ухаандаа нэвтэрсний дараа бид юм бүхнийг хийж чадна. Билиг ухаан бүхий л орчлон ертөнцийг бүтээдэг байтлаа бусад зүйлийг ч яагаад сайн хийж чадахгүй байх вэ? Тэрээр хэрэгцээ шаардлага байвал хийнэ, хэрэгцээгүй бол хийхгүй.

Бид хоёр зүйлийн нөхцөл байдлаас болоод юмыг сайн хийж чаддаггүй. Нэгт, сэтгэл төвлөрөөгүйгээс, Хоёрт, самадид орж махан биеэ орхисноос. Зарим үед бясалгаж самадид орсны дараа гурван ертөнцийг харж, мэдэж байх ч өөрийн биеийн эд эрхтэнийг эрхшээхэд хэцүү болдог. Учир нь бидний сүнс махан биеэсээ гарах тийм төвшинд дадаагүй, алсаас махан биетэйгээ холбогдож сураагүй байдаг. Энэ нь хүүхэлдэй тоглуулж сурч буй хүн анх эвээ олохгүй сандраад хөлийг нь татах гээд гарыг нь татдагтай адил. Анх машин барихад дадаагүйгээс тоормослох гээд хаазаа гишгэдэг, зүүн тийш эргэх гээд баруун тийш эргэдэг шиг.

Самадид удвал явах, суух, хэвтэх бүгд даяан болох тул Багшид нь юу ч хийсэн ялгаагүй. Гэвч заримдаа маш их нүгэл хилэнцтэй хүмүүсийг гэтэлгэх, эсвэл зарим нэгэн зохицуулах шаардлагатай ажил бие махбодод нөлөөлдөг ч үйл ажиллагаанд нөлөөлж чадахгүй. Учир нь би самадид байхдаа ажиллаад дадчихсан. Сүнс заавал бие махбоддоо байх албагүй. Хэрэв түүнийг бие махбодод нь авчраад эгэл ертөнцийн ажлыг хийлгэвэл дадаагүй тул зовсондоо дэлбэрч мэднэ. Ойлгов уу? Зарим ажлыг хийхэд түүнийг биед нь оруулж, зовлон амсуулах хэрэгтэй болдог. Тэр үед үнэхээр их зовдог ч Түүний үй түмэн хувилгаан биеийн ажил, хаа ч орших чадварт нөлөөлөхгүй. Маш их нүгэлтэй хүнийг гэтэлгэхэд л ийм байдал үүсдэг. Бусад үед бол тийм



их зовохгүй. Хэдий чинээ олон хүнийг гэтэлгэнэ, хүнд үйл нүгэлтэй нөхцөл байдал тохиолдох нь төдий чинээ ихсэнэ. Харин цөөн хүн гэтэлгэвэл тийм асуудал байхгүй. Ихэнх бясалгалтан, Төгс Гэгээрсэн хүмүүс ихэвчлэн ил гаралгүй, бусдаар болон шавь нараараа дамжуулах зэрэг адил бус аргаар хүмүүсийг чимээгүй аварч байдаг. Учир нь олны өмнө ил гарвал яршиг төвөг ихсэж, ад чөтгөрийн саад тотгор олширч, эвдэн сүйтгэх хүч маш их болно. Энэ бүхэн нь Төгс Гэгээрсэн Их Багш нарыг сорьж буй хэрэг юм.

Та нар түүх сөхөөд үз. Эртнээс нааш амар тайван амьдарсан Төгс Гэгээрсэн Их Багш байсан уу? Хорлохгүй бол гүтгэнэ, гүтгэхгүй бол хөнөөнө, хөнөөхгүй бол зодно, зодохгүй бол шийтгэж шоронд хорино гэхчлэн олон янзаар айлган сүрдүүлдэг байсан. Багшийнхаа санааг ойлгов уу? Айдаггүй Төгс Гэгээрсэн Их Багш байхгүй ч заавал хийх хэрэгтэй. Үүнийг л баатар зориг гэдэг юм. Айгаагүй үедээ хийсэн юм бол юу ч биш. Салж түвдэхгүй зүйлээ бусдад өгөх хэцүү. Харин хэрэггүй зүйлээ өгсөн бол энэ нь юу ч биш.

Шагжамуни Будда ч айж байсан, айхгүй хүн байна уу? Тэр бол хамгийн баатар зоригтон. Учир нь Тэр бүхэл бүтэн улс орон, хайртай хатан, хаан суудал, элбэг баян амьдралаа орхиж чадсан. Гэвч Тэрээр хамаг амьтдыг хараад айсан. Эсэрваа тэнгэр буун ирж, Шагжамуни Буддаг гурван удаа залжээ. Гурвантаа залсан тул татгалзаж чадалгүй зөвшөөрсөн. Түүнээс илүү зоригтон байна уу? Байхгүй. Би ч бас маш их айж байсан. Гэвч хийе гэсэн бол хийх л хэрэгтэй. Айгаад сэтгэл түгшиж байсан ч хийж чадвал харин ч зугаатай. Багш нь “айхгүй” гэж байгаа нь өөрийн айдсын хязгаар, айх сэтгэл, хулчгар зангаа давж чадахыг хэлж байна. Гэсэн ч хийгээд л байх хэрэгтэй. Яг л та нарын эцэг, эх өдөр бүр ажилдаа явах сонирхолгүйтэй адил. Заримдаа бие нь өвдөнө, эрт гэрээс гарна, их ядарна. Дөнгөж босоод тав,

зургаан цагт ажилдаа явах нь үнэндээ хүсмээр зүйл биш. Заримдаа хар салхи салхилж, аадар бороо орж байсан ч явах хэрэгтэй. Дуртайдаа ч биш, гэр бүлээ тэжээхийн төлөө явах хэрэгтэй.

Төгс Гэгээрсэн Их Багш ч мөн адил. Тэд олон хүнтэй нөхөрлөхийг хүсэхгүй. Та нар бясалгаж эхлээд л хүмүүстэй холилдохгүй, авшигтнуудтай хүртэл яриа өрнүүлэх дургүй болж, утсаар бага ярьж, сонин хэвлэл уншихаа больдог. Тэгээд ч өндөр дэстэй Төгс Гэгээрсэн Их Багш өглөөнөөс орой болтол олон хүн ирж шуугилдахад яаж дуртай байх вэ? Мэдээж дургүй. Ингэх нь учир зүйд бүрэн нийцнэ.

Бясалгадаггүй хүмүүс ойлгохгүй байж магадгүй. Харин Арьяабалын аргаар бясалгадаг хүн Багшийнхаа юу яриад байгааг сайн ойлгоно. Бид бясалгах тусмаа олон хүнтэй холилдох дургүй болдог. Тийм биз? Тэгэхээр Багшийнх нь хувьд бүр ч ойлгомжтой. Дуртайдаа биш, харин та нарын чин сэтгэл, Багшийгаа дэмжих санааг чинь хараад хатуурхаж чадахгүй тул энэ бүхнийг хийж байдаг.

Заримдаа та нар намайг ном айлдуулахаар урьдаг. Тэгээд аль болох их зар тарааж, сурталчилгаа сайн хийвал маш олон хүн ач тусыг нь хүртдэг. Хамтран ажиллах тусмаа бид улам их ачлах, хайрлах сэтгэлтэй болдог болохоор Багш нь тэтгэвэртээ гарч зүрхэлдэггүй юм.

Зарим үед надад хүч дутсанаас ажил хийхэд хүндрэлтэй байдаг. Багшийнх нь дэргэд мэргэжлийн хүн ажиллаагүй ч бидний хэвлэсэн ном хэвлэл үргэлж мэргэжлийн төвшнийхөөс ч илүү чанартай болдог нь Багш нь үүнд сэтгэл зүрхээ харамгүй зориулж, тааруухан хэсэг байвал тэр бүхнийг засаж болохыг нь засаж янзлаад уншихад амар, төгс болгохыг чармайдагт байгаа юм.

Тухай бүрдээ би хүний ертөнцийн нөхцөл байдалд уусаж, зэрэг дэсэд нь зохицох хэрэгтэй бөгөөд ингэж энэ ертөнцийн хэрэг явдлыг шийддэг. Энэ бүхэн нь бясалгалын учир явдал

биш, харин хүний ертөнцийн хэрэг явдлууд. Бие махбодтой байгаа учраас Багш нь энэ бүхнийг хийх боломжтой байна. Махан биед байх нь үнэхээр зовлонтой. Өөрөө чармайн тэмцэж, ухаан санаагаа ашиглах хэрэгтэй болно. Энэ бүхэн Багшийнх нь хувьд дэндүү ядраасан, дэндүү доогуур, дарамт ихтэй байдаг ч гэсэн хийх ёстой. За, бүгдээрээ хооллохоор явья! Хожим та нар юу ч хийсэн сэтгэлээ сайн төвлөрүүлээрэй. Сайтар бясалгавал хийсэн бүхэн чинь аяндаа бүтнэ. Бясалгахгүй бол хичнээн сайнаараа хийе гэж хичээсэн ч эсрэгээрээ эвдэн сүйтгэнэ.



## **ЖИНХЭНЭ БОГДОСЫН НОМ ЦАГААН ЛЯНХУА СУДАР**

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Формоса, Тайбэй хот, Ваньхуа  
1987 оны 3 дугаар сарын 9  
(Эх нь хятад хэлээр)*

Ном айлдахад сонсоод ойлговол сая хэрэг нь гарна. Чулуу хүртэл сонсоод ойлгож байхад бид ойлгохгүй байж болох уу? Гэвч зарим хүн чулуунаас дор. Багш нь түүнийг хэдэн сар сургасан ч ойлгоогүй л байдаг. Дахин дахин ярьсан ч ойлгоогүй хэвээрээ. Эрт дээр үед Даошэн гэдэг нэгэн номын багш ууланд очиж хад чулуунд ном айлддаг байсан гэж сонссон. Учир нь түүнийг айлдсан номийг хүмүүс ойлгохгүй, чулуу харин сайшаан толгой дохидог байсан гэнэ. Багшийг нь ном тайлах үед бас зарим нэгэн хүн ингэж толгой дохин суудаг (зүүрмэглэсэн маягтай толгой дохив). Тиймээс хичнээн дахин ном айлдсан ч тэд бас ойлгоогүй л байдаг. Миний бодлоор Даошэн номын багш Багшаас нь илүү ухаантай байна. Эсвэл Багш шиг нь ийм “азтай” байгаагүй байх. Ном сонсоод ойлгодог хүн бас байна аа! Гэвч бясалгал хийх хүн яагаад ийм цөөн байна вэ? Бид “Үнэн ёсыг заахад амаргүй, хайхад хэцүү. Учир нь Их Багш нар юуг ч олонд нээлттэй ил заадаггүй. Маш нууцлаг

байж бусдад мэдүүлдэггүй” гэж ярихыг үргэлж сонсдог. Ингэж ярих нь зөв үү? Буруу! Үнэхээр буруу! Үүнд итгэж огт болохгүй. Үнэндээ төрөл тутамд ихэд гэгээрсэн номын багш нар, тэдний гарамгай шавь нар ном уламжилж, ном айлдаж, Үнэн ёс гэж юу болох, түүнийг хэрхэн яаж хайхыг заан сургасаар ирсэн. “Дао”-(үнэн ёс)-г хайх нь үнэндээ маш хялбар. Гэсэн ч бид ээдрээ төвөгтэй зүйлд дадаж, ээдрээ төвөгтэй амьдралаар амьдарч хэвшсэн тул аль нэг бясалгалын аргыг тун хялбархан гэж сонсвол даруй толгой сэгсэрч: “Үнэн ёсыг хайх тийм амархан байж болох уу?”

Бясалгагч хүн өөрийгөө бүрэн эзэмдэж, хатуу бясалгал хийж, наран сүлжээгээ ажих, хамраа ажих, толгойгоо ажих, хувхай яс ажих, амьсгалаа ажих гэх мэт олон зүйлийг бясалгадаг гэж сонссон. Энэ Их Багшийн уламжилж буй Арьяабалын бясалгалын арга нь яагаад ийм хялбар байна вэ?” гэж бодно. Тиймээс маш олон хүн итгэхийг хүсдэггүй.

Арьяабалын бясалгалын арга бол хамгийн хялбар, хамгийн энгийн, хамгийн жам ёсны арга мөн. Учир нь бясалгалыг “Дао”-гаар хийдэг. Эгэл хүний бие махбод, бодлыг ашиглахгүй. Эгэл хүний бие, хэл, сэтгэл байвал энэ бүхнээ огоорох хэрэгтэй. Ихэнх хүний оюун санаа ээдрээтэй зүйлд дассан учраас Арьяабалын аргаар бясалгаж чадах хүн тун цөөн байдаг. Өчигдөр зуун жар гаруй хүүхэд бидэнтэй хамт бясалгаад бүгдээрээ Буддагийн гэрлийг харжээ. Хэдийгээр түрхэн зуур ч гэсэн бүгд гэрэл харсан. Энэ бол бидний ярьдаг “Агшин зуурын гэгээрэл” мөн. Яагаад ийм хялбар байна вэ? Учир нь угаасаа л боломжтой! Угаасаа “Дао” (Үнэн ёс)-г олоход ийм хялбар. Заавал төвөгтэй аргаар бясалгах шаардлагагүй. Хүүхэд маш цэвэр ариун байдаг. Тэдэнд юу ч хэлсэн шууд итгэнэ. Тиймээс тэд үнэн ёстой тийм хурдан холбогдсон байна.

Томчуудын оюун санаа нь эд юмс дүүртэл нь хураасан

байшин сав шиг элдэв зүйлээр дүүрсэн тул сайн зүйл орох зайгүй болсон байна. Жишээ нь, энэ танхим ном сонсохоор ирсэн хүмүүсээр дүүрэн тул шинэ хүн ирвэл багтах зайгүй байх нь тодорхой. Ямар ч чухал хүн ирсэн ялгаагүй, нэгэнт суудалгүй болсон тул яах ч аргагүй. Томчуудын толгой яг үүн шиг зайгүй болтлоо дүүрсэн байдаг нь үнэхээр харамсалтай! Би ер нь хүүхдэд заах нь хамгийн зөв юм байна. Томчууд төвөг ихтэй, залхмаар байдаг. Хүч тамираа барж хичнээн сургасан ч ямар ч тус нэмэргүй. Харин ч өчнөөн төвөг бэрхшээл, дэл сул яриа, гүтгэлэг шүүмжлэл гаргана. Хичнээн их ажилласан ч үр өгөөж нь өчүүхэн бага. Ном уламжлах үед ижил дэстэй байсан том хүн, хүүхэд хоёр адил хугацаанд чармайн бясалгавал хүүхдийн дэвшил илүү хурдан байдаг. Гэвч хүүхэд хянамгай бус, юуны төлөө бясалгаж байгаагаа ойлгохгүй зэрэг сул талтай болохоор тэднийг бас сайн гэж болохгүй. Хэрвээ том хүн хүүхэдтэй адил хянамгай бус, оюун санаа нь будлиантай, хичээл зүтгэл муутай бол хүүхдээс ч дор байх нь ойлгомжтой. Тиймээс дэвшил нь ч тийм хурдан биш. Гэрээс гараагүй хүний хувьд амьдралын нөхцөл байдлаасаа болоод бясалгахад хэцүү байдаг. Гэхдээ энэ нь гэрээс гараагүй хүмүүс бүгдээрээ бясалгаж чадахгүй гэсэн үг биш. Заримынх нь ар гэр асуудал багатай тул цаг заваа зохицуулж болно. Заримынх нь амьдрал дэндүү ээдрээтэй, цаг заваар хомс, саад тотгор ихтэйгээс болоод бясалгахад тун хэцүү.

Сайн сүмд сууж чадаагүй бол гэрээс гарсан хувраг хүн ч бас элдэв хэрэгтэй хэрэггүй ажилтай зууралдаад завгүй болдог. Өдөржингөө хурал хурж, ном уншин сударт мөргөөд чөлөө завгүй бужигнана. Үнэн ёсыг ийм хөөр хөгжөөнтэй байдлаар бясалгадаг гэж би ямар ч ном судраас уншаагүй. Эртнээс нааш аль ч шашны ном сударт бясалгагч хүн хэрхэн нам сэлүүн сууж, хичээнгүйлэн бясалгахыг л заасан байдаг. “Дао”-г хараахан олж чадаагүй юмуу, эсвэл

энэ “Дао”-г алдсанаас хойш ийм хөл хөгжөөнтэй болжээ. Учир нь бүгд өнгөн талын зүйлсийг бясалгах болсон байна. Өнгөн талын зүйлсийг хэдий чинээ их бясалгана, нисваанис төдий чинээ арвидаж, бардам зан, би гэх үзэл ихсэнэ. Учир нь тэд өөрийгөө бид бол бясалгагч, бясалгаж байгаа маань хэдийнээ хангалттай гэж боддог.

Тэдний бодлоор, дуусашгүй нисваанисаас салах арга үгүй тул яаж энэ цаглашгүй дээд бясалгалын аргыг сурч чадах вэ? “Хязгааргүй их төрөлтөнийг гэтэлгэх тангараг” гэдэг нь хамаг төрөлтнийг гэтэлгэхийн тулд өдөр бүр ном гүрэм үйлдэх явдал ажээ. Нэгэн билиг ухаантай амьд хүнийг сургаж чадахгүй байхад үхсэн хүнийг яаж сургах вэ? Талийгаач нүгэл хилэнц ихтэй бол даруйдаа тамд унана. Нүгэл хилэнц багатай ч оюун санаа нь самуурсан тул юу ч ойлгохгүй. Нүгэлгүй ч амьд сэрүүндээ ном судар уншиж, бурханд мөргөж, сургаал номлол сонсоогүй, билиг ухаан нь нээгдээгүй бол үхэхийн цагтаа бусдын уншсан бага сага номыг сонсоод түүний билиг ухаан яаж тэр даруйдаа нээгдэхэв дээ?

Амьд ахуйдаа гэгээрээгүй бол ном уншсан ч ойлгохгүй, маани, тарни уншсан ч ойлгохгүй, ном судар үзээд ч утгыг нь ойлгохгүй. Үхэл ирэхийн цагт бие цогцос ч хэрэгцээгүй болж, билиг ухаан нь ч ад чөтгөрт түйвээгдээд хийсэн нүгэлдээ татагдаж, элдэв бэрхшээлтэй нүүр тулна. Ийм үедээ юу ойлгох вэ? Тэдэнд ном гүрэм үйлдэх хэрэг байна уу? Эртний хүмүүс ийм үймээн бужигнаан дунд бясалгадаг байсан гэж би ер сонсоогүй.

Мял богд (Миларайба) бол түвд хүн. Тэр ийм хөөр хөгжөөнтэй зүйлсийг бясалгаж байсан уу? Үгүй. Тэр ганцаараа уулын агуйд чимээгүй бясалгаж байв. Багшийгаа даган бясалгаж байхдаа ч тийм чимээ шуугиантай байгаагүй. Багш нь Түүнд өдөр бүр ном судар унших, бурханд мөргөхийг зааж байсан гэж дуулаагүй. Мөн

тийм ном уншиж, хурал хурдаг бясалгалын аргыг түүнд уламжилсан, эсвэл Түүгээр бурханд мөргөх, судар унших үймээн ихтэй явдлуудыг хийлгэж байсныг бас дуулаагүй. Харин Тэрээр Мял богдоор байшин бариулж, барьсан байшинг нь нураалгаж ахин дахин бариулж байсан. Барьж дуусмагц нь Багш нь: “Болоогүй байна! Дахиад барь” гэнэ. Барьж, нураасаар олон жилийг өнгөрөөсөн. Ийм аргаар Багш нь түүний хийсэн нүгэл хилэнцийг цайруулсан ажээ. Яагаад Түүний нүглийг арилгах хэрэгтэй болсон вэ? Мял богд өөрийн багш, жинхэнэ Төгс Гэгээрсэн Их Багштай учрахаас өмнө маш их нүгэл үйлдсэн байжээ. Тэрээр өөрөө хүсээгүй ч энэ бүхнийг эхийнхээ ятгалга, шахалтаар хийсэн байна. Түүний аав, ээж нь чинээлэг хүмүүс байсан ч эцэг нь нас барахдаа өв хөрөнгөө авга ах, авга эгчид нь захирах эрхтэй үлдээжээ. Тэд их шуналтай хүмүүс байсан тул өв хөрөнгийг нь өөрийн болгоод гэр бүлийг нь зовлонд унагаж, ахынхаа гэрээсийг биелүүлээгүй юм. Навсгар муу байшинд амьдруулж, зарц мэт дээрэнгүй харилцана. Миларайбын ээж ихэд уурлаж, хүүгээ хар шид сургахаар явуулжээ.

Ингээд хар шидийн хүчээр авга ах, авга эгчийнхээ нь гэр бүлийг бүгдийг нь хороож, ганцхан авга эгчийгээ үлдээжээ. Бараг гучаад хүнийг хороосон гэдэг. Миларайба угаасаа ийм хорсох сэтгэлтэй байгаагүй ч ээж нь шаардсан тул ачийг нь хариулахын тулд аргагүй эрхэнд хийсэн хэрэг. Үүнээс үзэхэд эцэг, эхээ буруу ачилвал бас л буруудана. Тийм биш үү? Хэрэв эцэг, эх маань буруудсан байвал тэднийг ачлахын төлөө буруу зүйл хийвэл өөртөө ч лай хурааж, эцэг, эхийгээ ч нүгэлд унагана. Хожим нь Миларайба бясалгах сэтгэлийг жинхэнэ ёсоор үүсгээгүй бол, жинхэнэ Төгс Гэгээрсэн Их Багштай учраагүй бол аав, ээжийнхээ хамт бүгд тамаас мултрах аргагүй болох байсан.

Өнөөдөр бид “Яавал жинхэнэ ачлал болох вэ? Яавал гэр бүлдээ жинхэнэ тус хүргэх вэ?” гэдэг талаар ярилцъя.



Бид тэдний хүссэнийг хийдэг. Мах идэж, архи уу гэвэл мах идэж архи ууна. Хор уу гэвэл хор ууна. Үүнийг ачлал гэх үү? Мэдээж үгүй. Иймээс гэртээ бясалгах нь тун хэцүү, хялбар биш болохоор хүмүүс гэрээс гардаг, эсвэл гэрээ орхиж явдаг гэж сонссон. Аав, ээж, ах, дүү нар хангалттай билиг ухаангүй, дээдийн номыг бидэнд зааж чадахгүй, зөвхөн идэж уух, өмсөж зүүх, сургууль соёлд явах төдийхнийг л заадаг. Би та нарт шууд хэлье. Хоол хүнсгүй бол ганц төрөлдөө үхэх төдий. Харин ёс суртахуунгүй, өөрийн Эзэн Бурхныг эрж олоогүй бол төрөл төрөлдөө үхэж, сансрын хүрдэнд эргэлдсээр байх болно.

Сургуульд сураагүй бол сайндаа л эрдэм номгүй хүн болно. Тариачин болж бас болно шүү дээ! Дээр үед Шэньнун гэдэг их хаан байжээ. Тэр ямар эрдэм ном сурсныг би мэдэхгүй. Тэр үед сургууль бараг байгаагүй байх. Тэр хаан хүн хэдий ч ногоо тарьдаг байв. Тийм байсан, үнэн биз? Тэрээр ард олондоо үлгэр дуурайлал больё гэсэндээ тариа ногооны ажил хийсэн байж магадгүй. Өвгө дээдэс маань ийм байдалтай байжээ. Бид эрдэм ном сураагүй, сайн үйл хийж чадахгүй бол тариа ногоо, будаа гурил тариад байж чадалгүй яахав. Харин өндөр дээд ёс суртхууныг эзэмшээгүй, өөрийн их хүчээ олж аваагүй, эрхэм дээд хүн байж чадаагүй бол жинхэнэ хэрэгцээгүй, хэн ч биш болно. Олон хүн эрдэм номтой, эд мөнгөтэй ч ёс суртахуунгүйгээс маш их алдаа гаргадаг. Тэд заримдаа гэр бүл, эх орноо, тэр ч байтугай бусад улс гүрэн, ард олныг ч мөхөөн сөнөөдөг. Энэ бүхэн цөм тэдний ёс суртахуунгүйтэй холбоотой. Иймээс ёс суртахуунтай байх, боловсролтой байх хоёрын аль нь чухал вэ гэдгийг харьцуулах хэрэгтэй. Ёс суртахуунтай байх нь чухал. Тийм биз? Тийм бол гэрээс гарах нь тун зөв. Гэрээс гарч ёс суртахуунаа дадуулах хэрэгтэй. Учир нь заримдаа гэртээ бясалгах ямар ч боломжгүй. Тэр өдөр соронзон талбайн тухай ярьсныг санаж байна уу? Гэрээс гараагүй

хүний соронзон талбай ямар байдгийг мэдэх үү? Цөөн ам бүлтэй бол цаг заваа зохицуулаад бясалгаж болно. Хэрвээ олуулаа тухайлбал, эхнэр, нөхөр, хадмууд, хүүхэд, авга ах эгч, аав, ээж бүгд хамт амьдардаг бол нөхцөл байдал тун төвөгтэй. Харин гэр бүлээрээ бясалгадаг бол саад тотгор харьцангуй бага. Бүгдээрээ бясалгадаггүй бол үнэхээр төвөгтэй. Ийм байдлыг би сайн ойлгоно. Хүн бүхэн өөр өөр зүйл хийх гэнэ. Зурагт үзнэ, дагшаа жааз хөгжим сонсоно, төгөлдөр хуур тоглоно, хөгжим сонсонгоо бүжиглэнэ, хов ярина, өөр хөгжим тоглоно гэх мэт. Хүүхдүүд нааш цааш гүйлдэж, энэ тэрийг байцааж, нэг бол хоол иднэ, нэг бол сүү ууна гэнэ, бас энэ тэрийг шалгаана. Ийм нөхцөлд яаж бясалгах вэ? Бүхэл өдөржингөө ажиллаж ядараад орой бясалгахад сэтгэл тогтохгүй. Өглөө босоод бясалгахад бас л ядарсан мэт санагдана. Хүүхэд нь зургаан цагт гэрээсээ явах тул таван цагт босож, хоол ундыг нь бэлдэнэ. Гэрийн ажил мундахгүй, оройн арван нэг, арван хоёр цагт ч завгүй л байдаг. Гэрийн эзэгтэй өдөр бүр ажлаасаа ирээд угааж индүүдэх, цэвэрлэх цэгцлэх, хоол хийж, аяга таваг угаагаад тун завгүй. Бүгдийг хийж дуусахад хэдийнээ унтах цаг болно. Бясалгасан ч юмгүй, нойронд дийлдэнэ. Олигтой ч унтаж амжилгүй, эртлэн босч, гэрийнхэндээ цай унд бэлдэнэ.

Бие эрүүл бол өдөрт дөрвөн цаг унтахад л хангалттай. Тэгвэл хэдийд босох хэрэгтэй вэ? Дөрвөн цагт уу? Дөрвөн цагт бослоо гэж бодоход ганцхан цаг бясалгаад таван цагт унд цай бэлдээд хүүхдээ хооллон сургуульд нь хүргэнэ. Сургууль нь хол бол бүр ч эрт босох хэрэгтэй. Яарч сандран аяга таваг, бусад зүйлийг угааж цэгцлээд ажилдаа явна. Амьжиргааны зардал нь хүрэлцэхгүйгээс одоо ихэнх гэрийн эзэгтэй гадуур ажил хийх болсон. Ийм байхад бид яаж бясалгах вэ? Хэдийд нь бясалгах вэ? Өдөржингөө ажиллаж, орой ирээд ажиллана, өглөө босоод ажиллана. Харамсалтай

бөгөөд өрөвдөлтэй амьдрал? Энэ биеийн төлөө, өдрийн гурван хоол, өмсөх хэдэн хувцасны төлөө ажиллаад өдөр бүр өчүүхэн ч зав чөлөөгүй.

“Хүмүүс яагаад гэрээс гардаг юм бол? Гэртээ ч бас бясалгаж болно шүү дээ” гэж та нар бүү бод. Тийм биш! Гэртээ бясалгахад дэвшил маш удаан, олигтой бясалгаж чадахгүй, жаахан бясалгал нь хаана ч хүрэхгүй, тэгээд яаж хамаг амьтныг гэтэлгэх вэ? Хэдий ийм ч тэд бас бясалгалтайд тооцогдоно л доо. Харин одоо явж явж ямар ч бясалгалгүй хүмүүс хамаг амьтныг гэтэлгэж байгаа нь үнэхээр “сайшаамаар” явдал болоод байна. Бид хамаг амьтныг гэтэлгэнэ гэж тэд ярьдаг. Өглөө, оройн уншлага цээжлээд л хамаг амьтныг гэтэлгэхээр гарч өгнө. Хүн нас барсан гэж сонсвол тэр даруй гэтэлгэхээр очно. Авид Бурханы тарнийг цээжилчихвэл хүн гэтэлгэж болно. Өглөө, оройн уншлага, их нигүүлсэнгүй тарнийг цээжилчихвэл мөн л хүн гэтэлгэж болно гэнэ. Үнэхээр инээдтэй шүү. Гэвч Багш нь: “Ном судар, маани тарни уншаад хамаг амьтныг гэтэлгэж чадахгүй” гэвэл тэд: “Та яагаад биднээр бусдыг гэтэлгүүлэхгүй байна? Энэ багш гадаад номтон юм байна” гэнэ. Юугаа гэтэлгэх вэ? Өөрийгөө ч гэтэлгэж чадаагүй байж юун гэтэлгэх? Хэнийг гэтэлгэх гэж? Амьд хүнийг гэтэлгэж чадахгүй байж үхсэн цогцосыг гэтэлгээд юу хийх вэ? Билиг ухаантай, бие цогцостой, эрүүл саруул хүн ч бясалгаж чадахгүй байхад үхсэн хүн юу хийж чадах вэ? Цагийн гарз л болно. Өөрөө ч хангалттай хүчгүй байж бусдыг гэтэлгэх үү? Хэрвээ бид мөнгөгүй бол яаж өглөг өгөх вэ? Тийм биз дээ? Мөнгөтэй хүн л өглөг үйлдэнэ. Энэ “Дао”-тай хамт байж, “Дао” болж, чи өөрийгөө “Дао” болгон хувиргасан цагт хамаг амьтанд тусалж чадна. Тэгээгүй цагт өөрөө өөрийгөө баясгасан жүжиг тоглохоос цаашгүй. Өөрийгөө “Би хамаг амьтныг гэтэлгэдэг, Би тун нигүүлсэнгүй” гэж бодно. Өөрөө өдөр бүр мах иднэ, дараа нь бусдын үхсэн цогцосыг

гэтэлгэхээр явна. Энд нэг “үхсэн цосцос”-ыг идэж бараад дахин явж, өөр нэгэн үхсэн цогцост ном гүрэм, маани тарни уншиж сонсоод гэтэлгэнэ гэнэ. Энэ чинь юу хийгээд байгаа хэрэг вэ? Үнэхээр инээдэмтэй явдал.

Гэрээс гарсан хүн ч сайн багш, сайн хийд, сайн хуврагууд, сайн хуврагийн чуулган байхгүй бол бас л бясалгаж чадахгүй. Юу ч бясалгасан бүгд цагийн гарз болно. Учир нь энэ “Дао”-тай холбогдоогүй л бол юу ч бясалгасан бодлоор л бясалгах төдий. “Би өөрийгөө бясалгаж байна гэж төсөөлнө” гэх мэтчилэн. Үнэндээ энэ бол жинхэнэ бясалгал огт биш. Иймээс гэрээс гараагүйд нь гэрээс гараагүйн зовлон, гэрээс гарсанд нь гэрээс гарсны асуудал байна. Асуудлын гол нь бид өөрсдөө чухам яаж бясалгахаа мэдэхгүй, мөн өөрийн бэрхшээлээ давж гарах хангалттай хүчгүйд байгаа юм. Иймээс энэ асуудлууд маш их төвөг болж хувирдаг. Гэрээс гараагүй хүн олон зүйлд татагддаг. Гэр орондоо байх тул дүрэм журам гэхээр юмгүй! Өөрийн тогтоосон дүрмийг сахин биелүүлнэ гэдэг үнэндээ боломжгүй. Жишээ нь, бид утсаар ярих дургүй ч найз нөхөд залгавал яриад бүтэн цаг өнгөрснийг ч анзаарахгүй.

Бид зурагт үзэх дургүй ч заримдаа, өнөөдрийн хөтөлбөр тун сонирхолтой байна. “Жаахан үзэхэд яахав. Тавхан минут л харья. Юу гарахыг нь хараад л болчихно” гэнэ. Гэвч хэдийнээ мартаад хоёр, гурван цаг өнгөрснийг ч анзаарахгүй. Зурагт үзэх дуртай хүн байхгүй бол яагаад ийм олон зурагт борлогддог хэрэг вэ? Учир нь хүмүүсийн сонирхлыг их татдагаас тэр. Зурагт нь бидний бүхий л мэдрэхүйн эрхтнийг гадагш хандуулж, анхаарлыг татдаг. Энэ анхаарах хүч бол бидний эзэн билээ. Хэрвээ энэ анхаарлын хүч байхгүй бол бидний бие махбод ямар ч хэрэгцээгүй. Нас барсан хүний бие цогцос нь байвч анхаарлын хүч, эзэн нь явчихсан тул бие нь өчүүхэн ч хөдөлж чадахгүй болдог. Хэрвээ бид энэ анхаарлын хүчээ нэг цэгт төвлөрүүлбэл асар

их хүчтэй. Заримдаа их өргөн, их хүчтэй голын урсгалыг нэг газарт төвлөрүүлвэл маш их хүч болон хувирч, түүгээр цахилгаан гаргадаг. Үүний нэгэн адил, бидэнд асар хүч их байдаг боловч түүнийгээ бид өдөр бүр бүхий л мэдрэхүйн эрхтэнүүдээрээ дамжуулан гадагш сарниулдаг. Нүдээр ертөнцийг харж, чихээр ертөнцийг сонсож, амаар ертөнцийн сайн мууг хэлэлцэж, сэтгэлээр ертөнцийн зүйлсийг боддог тул бид хүчгүй болдог байна.

Өдөр бүр ажлаасаа ирээд маш их ядарснаа мэднэ. Энэ нь хамаг хүч тамираа гадагш алдаад хоосон уут шиг болсон хэрэг. Яг л бидний мөнгөтэй адил. Эндээс (халаасаа заав) банк, хоолны газар, нарийн боовны дэлгүүр, хувцасны дэлгүүр, цахилгаан барааны дэлгүүр лүү урсана. Мөнгөө үрж дуусаад гэртээ харихад юу ч үгүй болсон байдаг. Иймээс бид өдөр бүр ажлаа дуусаад гэртээ харихад тун ядарсан мэт санагддаг. Жаахан унтвал сэргэнэ. Хэрвээ хоёр, гурав хоног унтахгүй бол бараг үхэж, төрөл арилжих дөхнө. Яагаад тэр вэ? Учир нь хэдийнээ хүч тамиргүй болсон ч өөрийгөө хүчлэн ажилласнаас болжээ. Яг л шатахуун нь дууссан, шатахуун нь хүрэлцэхгүй байгаа машиныг хүчээр хөдөлгөөд ч нэмэргүй шиг. Хэрвээ шатахуун нэмэхгүй бол машин хөдлөхгүй. Бидний бие махбод, оюун санаа ч мөн адил. Түүнийг амраахгүй бол сульдаж доройтно.

Унтах нь бас нэг төрлийн бясалгал. Мэдээж анхан шатны дэсэд хамаарна. Хэрвээ бид түүнийг хөгжүүлж, яаж унтах аргаа мэдвэл унталт маань жинхэнэ ашиг тустай унталт болно. Ихэнх хүн яг л үхсэн хүн шиг унтдаг. Хэдий ийм боловч унтаагүйгээс дээр. Унтаад сэрэхэд яагаад сайхан байдаг вэ? Учир нь унтаж байхад нүд харахгүй, чих сонсохгүй, ам ярихгүй, сэтгэл элдэв юм бодохгүй. Ядахдаа л зориудаар ямар нэгэн юм бодохгүй, эсвэл түүний бодсон зүйлийг бид мэдэхгүй. Ингэж л бидэнд амин эрчим, эрч хүчээ сэлбэх боломж гардаг. Сэрсний дараа сэтгэл санаа,

тамир тэнхээ арай дээр болсноо мэдэрнэ.

Бясалгах, бясалгаж суух нь унтахаас ч сайн. Учир нь бясалгал бол нэг төрлийн ухамсар сэргэг унтлага юм. Ихэнх хүн унтахдаа ухамсраа хаашаа явсныг мэддэггүй. Бид ч бас мэдэхгүй. Тиймээс бид заримдаа хар дарсан элдэв янзын зүүд зүүдлээд сэрмэгц аймшигтай санагдаж, хар хөлс цутгаж, их айснаас дахин унтаж гэсэн ч чадахгүй болдог. Сэрээд тун их ядарснаа мэднэ. Учир нь бид унтаж байхдаа өөрийн эзэн буюу хүмүүсийн хэлдгээр сүнс сүлдээ удирдаж чаддаггүйгээс түүнийг хаа сайгүй явуулдаг. Асурийн ертөнц, эрлэг там, ад чөтгөрийн орноор яваад ирвэл муу хэлбэлзлээс болж ихэд тамирддаг. Тэндхийн доогуур хэлбэлзлэлийн нөлөөгөөр бидний сөрөг энерги ихсэж, нилээд ядарсан санагдана.

Бясалган суух нь нэг төрлийн маш сэргэг унтлага юм. Бид унтдаг ч бас унтдаггүй. Бие махбод тэнд байгаа ч бидний билиг ухаан тун сэргэг байдаг. Хаана ч очсон бүгдийг мэднэ. Хэзээ буцаж ирэхээ ч мэднэ. Явья гэвэл явж, ирье гэвэл ирнэ. Бид явах үедээ энэ биеэ хоосон байшин шиг үлдээнэ. Бид дээшилж, дээд дэсийн төрөлтнүүд, өндөр хэлбэлзлийн давтамжтай хамт байж, дахин цэнэглэгдэн сайн эрчмээр хүчээ нөхнө. Тиймээс эргэж ирэхэд ямар ч асуудалгүй.

Энэ орчлон ертөнц яг л хулс мод шиг өндөр, намтай. Хэрвээ бид өндөрлөг газарт очвол агаар нь нилээд сайхан. Нам доор газрын агаар нь бохир, чимээ шуугиан ихтэй. Иймээс бид ууланд гарах дуртай байдаг. Тэндхийн агаар сайхан учир сэтгэл санаа сэргэж, бие эрүүлжинэ. Үүн шиг, хэрвээ бид бясалгавал яг л хулсанд авиран гарсантай ижил. Бясалгахгүй бол дор үлдэнэ. Хүний төвшин энэ орчлон хорвоо хэмээх хулсны тэг дундаас арай доогуур хэсэгт байдаг. Хулс модыг хоёр хувааж дээд хэсгээр нь сайн, доод хэсгээр нь муу талыг төлөөлүүлье. Хэдий чинээ дээшилнэ,

төдий чинээ сайн. Хамгийн дээд хэсэг нь хамгийн сайн газар мөн. Дэлхийн хүмүүс бид дунд хэсэгт нь байгаа ч энэ нь муу хэсэгт харьяалагдана. Тийм ч сайн хэсэгт орохгүй. Гэхдээ яахав дунд хэсэгт л орох юм даа. Учир нь доогуур илүү муу муухай газар байдаг. Хэрвээ бид тамд очвол тэр хамгийн доод төвшинд унасан гэсэн үг.

Бид чөлөөтэй сонгох боломжтой. Тамд унахыг хүсэхгүй байж мэдээж болно. Бид дээшилж болно. Биднийг дээш, доош чөлөөтэй явуулах шат байна. Сонголт хийх билиг ухаан байна. Тэгэхээр дээшилье гэвэл дээшилнэ. Яагаад заавал доошлох ёстой гэж? Учир нь мэдэхгүйгээ болж л доошилдог. Зарим хүн мэддэг хэрнээ өөрөө дээшлэх хүсэлгүй. Эсвэл залхуу учраас авирах хүсэлгүй, тэгэхээр доошоо унахаас аргагүй. “Тамд унана” гэдэг нь ийм юм. Хэрвээ бид хулсны доод хэсэгт байгаад дээд хэсэгт хүрье гэвэл бидний эгэл хүний чадвар хангалтгүй тул эгэл бус чадварыг ашиглах хэрэгтэй болно. Үнэндээ тэр эгэл бус чадвар нь бас биднийх бөгөөд их энгийн зүйл.

“Аливаа бүхэн сэтгэлээс үүдэлтэй” гэхийг бид сонссон. “Бид бол Эзэн Бурхан, Эзэн Бурханы үр сад, Бурхадын хүүхэд” гэлцэхийг ч бас сонссон. Үнэхээр тийм бол яагаад Эзэн Бурханы хүүхэд, Бурхадын хүүхэд ийм ядуу зүдүү байна вэ? Яагаад ийм сул дорой байна вэ? Яагаад ингэж зовж зүдэрч байна вэ? Бид эд баялагаа ашиглаагүйгээс зовж байна. Түүнээс зориуд бидэнд саад учруулж, шийтгэж, бурууг хийвэл гэсгээдэг, зөвийг үйлдвэл шагнадаг тийм нэгэн муу Эзэн Бурхан байгаа юм биш. Тийм биш! Бүхнийг бид өөрсдөө хийдэг. Бидний билиг ухаанд юм бүхэн бий. Шүүх цагдаа, Эзэн Бурхан, Бурхан бодьсадва, ад чөтгөр, Эрлэг номунхан гээд юм бүхэнтэй.

Бид муу хэрэг хийвэл Эрлэг номун хаан тэр даруй тэмдэглэж авна, сайн хэрэг хийвэл Бурхан бодьсадва тэмдэглэж авна. Хүн бүхэнд өөрийн гэсэн ажил бий.

Хариуцах ажил нь өөр, мөн зан чанар нь ч өөр байдаг төдий. Яагаад вэ? Жишээ нь, бид ажил хийж, мөнгө олоод алт авбал түүнийг алт хадгалдаг газар хадгалах нь мэдээж. Хэрэв маш их үнэт эрдэнэс худалдаж авбал эрдэнэсийн санд хадгална. Харин чулуу авбал чулууны газар л хадгална. Зориулалт нь өөр өөр хэдий ч бүгдээрээ л бидний хөрөнгө. Алт, үнэт эрдэнэсийг биеэ гоёж, сайхан харагдахын тулд хэрэглэнэ. Харин чулуугаар зам дэвсээд цементээр өнгөлнө. Чулуу өөрийн гэсэн зориулалттай, цемент ч мөн адил. Хүмүүс тэдгээрийг зам тавихад ашигладаг. Үнэт эрдэнэсийг сайн зүйлд, эсвэл бурхны хөрөг өнгөлөхөд хэрэглэнэ. Бид сайн ойлгоогүйгээс болж, арвин их чулуу худалдаж, авбал гоёмсог сайхан байшингаа чулуугаар дүүргэнэ. Мөнгөөрөө алт, бусад үнэт зүйл авч болохыг мартаад хямдыг нь харж, нэг, хоёр мянгаар машин дүүрэн чулуу авдаг. Харин ийм мөнгөөр ганц мөхлөг сувд ч авахгүй. Багахан хэмжээний алт л авна. Алт, эрдэнэс хэтэрхий үнэтэй учир бүгд л чулуу авдаг. Эцэстээ байшингаа ямар ч хэрэгцээгүй чулуугаар дүүргэнэ.

Бясалгал ч адил. Бид хэдийгээр сонгож болдог ч сайн үйл хийх нь муу үйл хийхээс хэцүү. Бясалгал хийхгүй нь арай амар. Мах идэж, архи уух нь нилээд баяр хөөртэй. Олны дунд явна. Элдвийг ярилцах нөхөдтэй байна. Харин бясалгал хийвэл бүрэнхий газарт заавал ганцаараа суух тул ихэд ганцаардана, заримдаа ад чөтгөрөөс айна. Учир нь тэнд ганцаархнаа суудаг. Тиймээс бясалгах нь бясалгахгүйгээс хэцүү. Бид өөрсдийн дадлаас салаагүй байна. Ам элдвийг ярих дадалтай, чих ертөнцийн явдлыг сонсох дуртай, нүд гадны зүйлсийг харах дуртай. Энэ бүх дадлаа өөрчилье гэвэл сэтгэлээ дотогш хандуулж, ганцаар сууж, өөрийн уг чанарыг хайх хэрэгтэй. Энэ тун амаргүй. Учир нь дадал бол дадал! Өөрчлөхөд их хэцүү.

Тамхинаас гарах амаргүй байдгийг тамхи татдаг



хүн сайн мэднэ. Тамхи татах зуршлаасаа салж чадсан бол үнэхээр зоригтой хүн байж таарна. Гэхдээ тийм их зориг бас биш. Багшийн хүч тусалсан учраас тийм хурдан өөрчлөгджээ. Дан ганц өөрийн хүчээр тамхинаас гарна гэдэг амаргүй. Европ болон Америк тивийн улс орнуудад хүмүүсийг тамхинаас гарахад нь тусалж, маш их мөнгө зарцуулдаг. Тэднийг тамхинаас гаргах газарт тусгаарлаад өдөр бүр хиймэл тамхи, модон тамхи татуулна. Өдөр өдөрт багасгасаар тамхи татах ямар ч сонирхолгүй болгож, сүүлдээ ядраад шулуухан татахаа болино. Тусгай эм тариа хэрэглэж, мэргэжлийн зөвлөгчийг урьсан байж ч магадгүй. Тэднийг дагуулан өдөр бүр дасгал хөдөлгөөн хийнэ. Мөн өөр бусад ажил ч хийлгэнэ. Бохь, шоколад мэтийн орлуулах зүйл өгнө. Учир нь угийн тамхичин байсан тул гэнэт татахгүй болох нь тэдэнд уйтгартай санагддаг. Хэдэн сарын дараа энэ тамхи татах зуршлаа өөрчилж магадгүй. Гэвч санаа зориг мохоо, өөрөө өөрчлөгдөх тийм их хүсэлгүй, билиг ухаанаар өөрчлөөгүй, бурхны хүч туслаагүй бол гэртээ хариад найз нөхдөө харж, тэсэлгүй татна. “Ганцыг татахад яахав! Маргааш л татахгүй байя” гэж бодно. Гэтэл маргааш нь хоёр ширхэг, гурван ширхэг болон нэмэгдсээр тун удалгүй гурван хайрцаг болно. Хожуу сурсан тамхи татаж, архи уух зуршлыг өөрчлөхөд ийм хэцүү байхад хар багаасаа дадуулсан харах дуртай, сонсох дуртай, бодох дуртай дадлуудыг яаж тийм хурдан өөрчилж чадах вэ? Үнэндээ хэцүү. Тиймээс ном судар унших хүн олон. Маани, тарни уншвал дуу ихтэй. Бурханд мөргөх хүмүүс хаа сайгүй. Ямар ч бясалгалын газар ч очиход бурханд мөргөхөөр ирж буй хүмүүсийг л харна. Харин нам гүм сууж, бясалгах хүн тун цөөн, ер нь хайгаад ч олдохгүй. Суусан ч сэтгэл нь төвлөрөхгүй. Тэнд суугаад амаа хамхиж, нүдээ аньсан ч сэтгэлээ хурааж чадахгүй. Бодол сэтгэлээ хураах хамгийн хэцүү. Хэрвээ бид бодол сэтгэлээ түр зуур ч гэсэн үнэхээр

хурааж чадвал тэр дороо самади агуулж, самадийн ахуй ойлголттой болно. Гэхдээ энэ нь маш хэцүү. Иймээс бид өдөр бүр сайтар дадуулах хэрэгтэй байдаг. Сууж чадахгүй байсан ч суу. Сэтгэл самуурч, бодол ихтэй байсан ч суу. Ингэж суусаар суусаар хэсэг хугацаа өнгөрөхөд бидний жинхэнэ эзэн энэ бие махбодоос гэнэт сална. Тэр үед л бид амжилтанд хүрнэ. Тиймээс бид хичээнгүйлэн дадуулах хэрэгтэй. Үүний зэрэгцээ бас маш сайн аргатай байж байж л дадуулна. Энийг ч, тэрийг ч турших хэрэггүй, Ингэх нь ямар ч тус нэмэргүй. Бидний оюун санааг эрхшээж чадах хамгийн сайн нэг арга бий. Тэр бол “Арьяабалын бясалгалын арга” юм.

Бид хар багаасаа л гадны зүйлсийг анхаардаг дадалтай. Өнөөдөр Багштай нь уулзахаар ирсэн гурван сартай нялх хүүхэд хүртэл аль хэдийн ярих тун дуртай болсон байна. Яриа нь ойлгогдохгүй ч түүнд хүнтэй ярих сонирхол маш их байна. Тод өнгийн хувцас өмссөн хүн рүү нүдээ бүлтийлгэн харна. Жингэнэсэн дуу хөгжим сонсох дуртай. Уйлвал жаахан чимээ гаргахад уйлахаа болино. Буга бас лимбэний дуу сонсвол хүрч ирээд лимбэн дээр толгойгоо тавиад сонсдог гэнэ. Тэр үед анчид түүнийг ямар ч төвөггүй барьж авдаг байна. Ертөнцийн дуу аялгуу бидний анхаарлыг татдаг. Татах хүч нь их. Яагаад тэр вэ? Учир нь бид төрөх үедээ тэр жинхэнэ хүч, угийн дуу аялгуунаас тасарсан тул юу ч сонссон “өнөөх аялгуу маань байж магадгүй” хэмээн горьддог. Гэрэл цацарсан зүйл харвал энэ бол Буддагийн гэрэл гэж бодоод харах дуртай байдаг. Учир нь бид угийн жинхэнэ дуу, жинхэнэ аялгуугаа эрээд олохгүй болсон тул хуурамч дуу аялгуунд дурлах болсон.

Өндөр төвшний ертөнцөд хүрвэл бидэнд нүдний хэрэгцээ байхгүй. “Эрдэнийн мандалт” сударт: “Гаднаа дүрсээс салвал даяан хэмээмүй, дотроо сэтгэл самуурахгүй бол самади хэмээмүй” гэжээ. Бид бясалгахад их зовлонтой

байдаг нь анхаарлын хүчээ дотогш төвлөрүүлж, гаднах байдлаас салж, дотоод сэтгэлээ тогтоох гэж их зовдогоос болдог. Тиймээс ямар ч бясалгалын арга байсан бидэнд анхаарлын хүчээ дотогш хандуулахад тусалж чадахгүй бол муу арга, тааруухан арга гэсэн үг. Тиймээс Арьяабалын бясалгалын арга бол хамгийн сайн арга мөн. Учир нь энэ аргаар бясалгахад нүд, чих, бодол, бие алийг нь ч хэрэглэхгүй. Бүх ном хоосон чанартай, төрөхгүй, устахгүй, хиртэхгүй, ариусахгүй, нүдгүй, чихгүй, хамаргүй, хэлгүй, биегүй, бодолгүй. Юуг ч хэрэглэхгүй. Тэр үед л жинхэнэ уг чанар илрэн гарна. Тиймээс “Мөн чанараа үзэж Бурхан болно” гэдэг юм.

Бидний махан чихний цаана жинхэнэ чих, махан нүдний цаана нь, дотор нь жинхэнэ нүд бий. Энэ хамарны дотор нь, ард нь жинхэнэ хамар бий. Энэ бүх жинхэнэ чих, жинхэнэ нүд, жинхэнэ хэл, жинхэнэ хамрыг заавал нээх хэрэгтэй. Тэгвэл бид төгс төгөлдөр болно. Нээхгүй бол одоогийн энэ тааруухан хэсгүүдийг ашиглахаас цаашгүй. Жишээ нь, бидний хувцас гаднаасаа гоё харагдах хэдий ч дотор талд нь олон юм байх тул тийм ч сайхан харагдахгүй. Гэсэн ч хувцас л юм даа! Хэрвээ бид мэдэхгүйгээсээ болоод хувцсаа буруу харуулж өмсвөл муухай харагдана. Би сая гэрээс гарахдаа малгайгаа буруу харуулаад өмсчихжээ. Энд ирээд толинд хартал тун муухай харагдаж байгааг мэдэв. Тэгээд зөв харуулж өмслөө. Бидний бясалгал ч мөн адил. Төгс Гэгээрсэн Их Багшийг хайж олвол Тэр бидэнд зөв арга зам зааж өгнө. Жишээ нь, энэ аягыг дээш нь харуулж тавьсан бол ус аягалж болно. Хэрвээ аягыг хөмөрвөл ус нь асгарна. Зарчим нь ижил. Газар бүхэн цаглашгүй гэрэлтэй. Учир нь тэр цаглашгүй, хэмжээлшгүй! Гэвч бид яг л хөмөрсөн аяга шиг тул түүнийг хүлээн авч чадахгүй! Бид жинхэнэ нүдээ аньж, жинхэнэ чихээ бөглөжээ. Тиймээс энэ цаглашгүй гэрэл, цаглашгүй аялгууг мэдэрч чадахгүй байна.

Гэрэл ч бас аялгуу, аялгуу ч бас гэрэл. Зөвхөн хэлбэлзлийн давтамжаараа ялгаатай. Багш нь гэрлийн тухай яривал энэ нь бас аялгууны тухай ярьж буй хэрэг. Цаглашгүй гэрэл нь бас цаглашгүй аялгуу мөн.

Тэр нууцлаг дотоодын аялгууг эгэл хүний махан чихээр сонсохгүй. Бидний бясалгал өндөр төвшинд хүрвэл дотоод, гадаад нүдээ ээлжилж солбин ашиглана. Чихийг ч адил. Дотоод гадаад чихээ ээлжлэн ашиглана. Тийм учраас бид махан нүдээрээ Буддагийн орон, диваажингийн орныг ч харна. Махан чихээрээ гүн нууцлаг аялгуу, Буддагийн аялгууг сонсоно.

“Богдосын ном цагаан лянхуа судар”-ын номын багшийн эрдмийн зүйлд: “Жинхэнэ “Богдосын ном цагаан лянхуа судар”-ыг айлддаг номын багш бол махан нүдээрээ диваажин, там, өөр олон төвшнийг харна. Махан чихээрээ дотоод аялгуу, гаднах дуу аялгуу, ер нь ямар ч аялгууг сонсоно” гэжээ. Учир нь тэр багш бас Арьяабалын аргаар бясалгадаг хэрэг. Түүний дотоод нүд, гадаад нүд нь бүгд нээгдсэн тул эгэл нүдээ яг дотоод мэлмий шиг ашиглана. Учир нь хоёулаа нээгдсэн байна! Мэдээж хоёуланг нь ямар ч асуудалгүй ашиглаж болно. Түүний чихний эрхтэн, хэлний эрхтэн, бодлын эрхтэн ч бүгд гадна, дотногүй нээгдсэн тул сольж ашиглана. Тэр үед түүний бие махбод нь ч өөрчлөгдөөд дээд төвшний хэлбэлзлийн давтамжтай ижил болсон байдаг. Одоо “Богдосын ном цагаан лянхуа судар”-ыг тайлах дуртай хүн олон болсон байна. Учир нь тэд “Богдосын ном цагаан лянхуа судар”-ыг хүмүүст тайлж өгвөл энэ нь хамгийн дээд ач буян бөгөөд маш их буян хишигтэй болно гэж боддог. Тиймээс хүн бүхэн “Богдосын ном цагаан лянхуа судар”-ыг тайлж, ном хурж, цан хэнгэрэг дэлдэн хөл хөгжөөн болох дуртай.

“Богдосын ном цагаан лянхуа судар”-ыг тайлья гэвэл “Богдосын ном цагаан лянхуа”-н ахуй ойлголтыг ярих

хэрэгтэй. “Богдосын ном цагаан лянхуа судар”-ын дэстэй байх хэрэгтэй. Ийм нөхцөлд би бол “Богдсын ном цагаан лянхуа судар”-ын номын багш гэж хэлж болно. Хэрвээ нүдний эрхтэн нь гүн нарийн нууцлаг зүйлсийг харахгүй, Буддагийн гэрэлтэй холбогдохгүй, чихний эрхтэн нь Буддагийн аялгууг сонсохгүй бол жинхэнэ номын багш биш. Учир нь түүнд ийм номын багшийн ач буян хараахан байхгүй гэсэн үг. Тийм ахуй ойлголтгүй, тийм дэсэд хүрээгүй бол “Богдосын ном цагаан лянхуа судар”-ыг тайлаад ямар ач тустай байх вэ? Хэрвээ бид жигнэмэг сурталчилъя гэвэл өөрөө хэзээ ч жигнэмэг идэж үзээгүй, хүнд амсуулах жигнэмэггүй бол жигнэмэгийн тухай ярих хэрэг байна уу?

Үнэндээ хүмүүсийн сайн мэддэг тэр нэг зузаанаас зузаан судар бол жинхэнэ “Богдосын ном цагаан лянхуа судар” биш. Жинхэнэ “Богдосын ном цагаан лянхуа судар” бол өөр нэг зүйл болно. Тэр “Богдосын ном цагаан лянхуа судар” хэмээх сударт Шагжамуни Будда олон үлгэр түүх, арвин их зүйрлэл, олон төвшнийг ярьсан нь жинхэнэ “Богдосын ном цагаан лянхуа судар”-ыг магтан сайшаахын төлөө байсан. Харин жинхэнэ “Богдосын ном цагаан лянхуа судар” нь үүнээс өөр. Жишээ нь, Багш нь энэ дөрөв, тав хоног Арьяабалын бясалгалын аргыг тасралтгүй магтан сайшааж, олон зүйрлэл, олон төвшин, олон үлгэр түүх ярьсан нь бүгд энэ Арьяабалын бясалгалын арга хичнээн сайныг, түүгээр бясалгахын гайхамшигийг, цаглашгүй ач буяныг өгүүлсэн хэрэг. Та эдгээрийг сонсоод Арьяабалын бясалгалын аргыг хэдийнэ сурчихлаа гэсэн үг үү? Үгүй. Сураагүй. Авшигтнуудаас бусад бүх шинэ хүмүүс Арьяабалын бясалгалын аргыг хараахан сураагүй байна, жинхэнэ “Богдосын ном цагаан лянхуа судар”-ыг хүртээгүй байна.

Би дөрөв, тав хоногийн турш нэгэн судрыг магтсан бөгөөд тэр судар бол жинхэнэ “Очир огтлогч судар” юм.

Хэрвээ та нар тэр судрыг харсан, тэр судрыг олж авсан бол энэ чинь жинхэнэ “Богдосын ном цагаан лянхуа судар”, жинхэнэ “Очир огтлогч судар” байна гэж мэднэ. Ном уламжлах үедээ би та бүхэнд жинхэнэ “Очроор огтлогч судар”-ыг тайлж сонсгоно. Гэвч “Очир огтлогч судар”-ыг тайлах нь “Очир огтлогч ном”-ыг уламжилсан хэрэг биш. “Очир огтлогч ном”-ыг уламжлахад үг хэлний хэрэггүй. Гэсэн ч та нар тэр номыг хүртэж чадна. Тиймээс “Очир огтлогч судар”-ыг магтан сайшааж байгаа нь жинхэнэ “Очир огтлогч ном”-ыг магтан сайшааж байгаа хэрэг. “Очир огтлогч ном”-ыг уламжлахын тухайд бол энэ нь тусдаа өөр нэг зүйл. Иймээс та бүхэн “Богдосын ном цагаан лянхуа судар”-ыг аялгуулан унших, “Богдосын ном цагаан лянхуа судар”-ыг унших, “Богдосын ном цагаан лянхуа судар”-ыг судлах нь жинхэнэ “Богдосын ном цагаан лянхуа судар”-ыг магтан сайшаасан зүйл төдий. Жигнэмэгийг магтан сайшаах нэг хэрэг, харин жинхэнэ жигнэмэгийг олж идэх бол өөр нэг хэрэг юм. Зурагтаар жигнэмэг сурталчлах нь эхний явдал, худалдаж авах нь удаах явдал, жигнэмэг идэх нь гуравдугаар хэрэг. Жинхэнэ жигнэмэг олж идсэн нь харин хамгийн сайхан явдал. Гэхдээ эхлээд заавал жигнэмэгийг худалдан авах хэрэгтэй. Тэгвэл л идэж чадна! Тиймээс тэр “Богдосын ном цагаан лянхуа судар” хэмээгч нь “Богдосын ном цагаан лянхуа судар” биш. Тэр “Очир огтлогч судар” хэмээгч нь “Очир огтлогч судар” биш. “Эрдэнийн мандалт судар” хэмээгч нь “Эрдэнийн мандалт судар” биш юм. Эдгээр сударт ямар ч аргыг дурдаагүй, харин нэг цаглашгүй, дүрс үгүй бясалгалын аргыг магтан сайшаасан төдий. Судар бидэнд яаж бясалгахыг заахгүй. Мөн яавал гаднаа дүрсээс салж, дотроо сэтгэлээ тогтоож самуурахгүй болохыг ч заахгүй. Бид өөрийн хүчээр гаднаа дүрсээс салж, дотроо сэтгэлээ тогтоож дийлэхгүй. Заавал нэг бясалгалын аргатай байвал энэ бүхнийг хийж чадна. Харин тэр арга нь жинхэнэ

“Эрдэнийн мандалт судар”-т бий. Жинхэнэ “Очир огтлогч судар”-т бий. Жинхэнэ “Богдосын ном цагаан лянхуа судар”-т бий. Энэ бол өөр учир явдал.

Шагжамуни Будда “Богдсын ном цагаан лянхуа судар”-т ямар нэгэн бясалгалын аргыг яриагүй! Тэр зөвхөн олон үлгэр түүх өгүүлж, зүйрлэл хэлж, олон хэрэг явдлыг л ярьсан. Бурхад, бодьсадва нарыг танилцуулж, тэднийг магтан сайшаасан. Үнэндээ бол Будда ч танилцуулаагүй. Түүний шавь нар өндөр төвшинд очиж ирээд тэмдэглэсэн ахуй ойлголт, тэднийг бясалгаж байхад нь Шагжамуни Будда хувилгаан биеэрээ өндөр төвшинд дагуулан аваачих үед үзсэн ахуй ойлголтоо бичжээ. Хожим нь тэд ахуй ойлголтоо бичихдээ: “Шагжамуни Будда ингэж айлдав, тэгж айлдав” гэсэн байдаг. Тиймээс Шагжамуни Будда айлдсан гэх нь бас буруугүй. Гэхдээ энэ бүхэн өндөр төвшний ертөнцөд яригдсан бөгөөд тэдний бясалгалын ахуй ойлголт гэдгийг мэдэх хэрэгтэй. Дээд төвшинд очиход нь Шагжамуни Будда тэднийг Гайхамшигт аялгуут бодьсадва, Арьяабал бодьсадватай танилцуулжээ. Тэд буцаж ирээд ахуй ойлголтоо тэмдэглэн үлдээсэн нь өнөөдрийн “Богдосын ном цагаан лянхуа судар” болсон байна.

Энэ магтан сайшаасан судар бол жинхэнэ “Богдосын ном цагаан лянхуа судар” огт биш. Жинхэнэ “Богдосын ном цагаан лянхуа судар” нь “Богдосын ном цагаан лянхуа бясалгалын арга”-ыг заадаг. Харин энэ “Богдосын ном цагаан лянхуа бясалгалын арга” бол даруй Арьяабалын бясалгалын арга мөн. Хэрвээ “Богдосын ном цагаан лянхуа судар”-ыг ойлгоё гэвэл эхлээд заавал Арьяабалын аргаар бясалгах хэрэгтэй. Тэгвэл та нар дараа Багшийгаа ном тайлах үед ойлгоно. Тиймээс долоо хоногийн даяаны үеэр Багшийнх нь айлдах номын агуулга нь жирийн үеийнхтэй адилгүй. Учир нь шавь нарт зориулж айлддаг болохоор тэд бүгд ойлгоно. Би олны өмнө онцгой зүйл бараг ярьдаггүй.

Учир нь ярьсны дараа ойлгох хүн байх эсэхийг би мэдэхгүй. Ахуй ойлголтгүй бол яаж ойлгох вэ? Ойлгохгүй бол үнэхээр харамсалтай. Дахин нэг жишээ авч та нарт ойлгуулахыг хичээе. Жишээ нь, Шагжамуни Будда “Богдосын ном цагаан лянхуа судар”-ын хотол зохилдогч зүйлд Арьяабал бодьсадваг магтаж, Баршгүй саналт бодьсадвад хандан: “Энэ бол Арьяабал бодьсадва. Тэр гучин хоёр лагшин төгс хувилгаан биетэй. Тэр олон газар хүрч, тоолшгүй төрөлтнийг аварсан” гэж айлдсан.

Та нар бодоод үз, Баршгүй саналт бодьсадва Арьяабал бодьсадватай энэ ертөнцөд уулзах боломжтой юу? Боломжгүй шүү дээ! Арьяабал бодьсадватай уулзъя гэвэл бясалгалаараа Багштайгаа хамт бодьсадвагийн төвшинд хүрэх хэрэгтэй. Тэгвэл л түүнтэй уулзаж чадна.

Тэр үед дотоодын Их Багш нь чамайг Түүнтэй танилцуулна. Нэгэн Төгс Гэгээрсэн Их Багш, эсвэл Их Багш зөвхөн энэ ертөнцөд хамаг амьтныг сургах төдийгүй диваажингийн оронд, илүү өндөр төвшний диваажинд, Бурхны оронд ч бас хамаг төрөлтнийг сургаж байдаг. Тиймээс Тэр чамайг хаана хүрнэ, тэр газарт чинь сургана. Чиний төвшин хаа хүрнэ, Тэр чамайг тэнд сургаж байдаг.

Баршгүй саналт бодьсадваг бясалгах үеэр сүнсэн бие нь бодьсадвагийн төвшинд хүрч, тэнд Шагжамуни Буддатай уулзжээ. Баршгүй саналт бодьсадватай адил дэстэй бусад шавь нар ч хамт очсон нь мэдээж. Тэр үед Шагжамуни Буддагийн бие махбод хаана байсан нь нэг их хамаагүй. Магадгүй тэдний бие махбод Бугын цэцэрлэг хэмээх газарт бусад шавь нарын хамт бясалгаж суусан байх. Шагжамуни Будда тэнд бясалгаж, Баршгүй саналт бодьсадва энд бясалгаж байсан нь ер хамаагүй. Олон хүмүүстэй хамт бясалгаж байхдаа Шагжамуни Будда, Баршгүй саналт бодьсадвагийн сүнсэн бие нь дээш одож, Модгалъяна болон бусад бодьсадва нар ч бас дээш одож, дээдийн номонд



суралцахаар явжээ.

Тэр үед Тэд Арьяабал бодьсадва илрэн гарахыг харсан нь бид их сургуульд сурч байхад нэр алдартай профессорыг урьж тусгай лекц уншуулдаг шиг. Тэр үед Шагжамуни Будда олонд хандан: “Энэ бол Арьяабал бодьсадва, Тэр өнөөдөр манай энд хүрэлцэн иржээ. Арьяабал бодьсадва Биндэрьяа болор ертөнцөд байдаг. Тэр тийм тийм ач буянтай, тийм тийм хүч чадалтай, тийм тийм аргаар бясалгаж, энэ мөрийн хутгийг олоод төдийд, өдийд Будда болсон” хэмээн танилцуулна. Энэ бүхнийг хүний хорвоод биш, харин өөр нэгэн дээд төвшний ертөнцөд айлджээ. Арьяабал бодьсадва бол өндөр дэсийн бодьсадва бөгөөд тухайн үед бие махбодгүй байсан.

Баршгүй саналт бодьсадва буцаж ирээд: “Би төдийд, өдийд Арьяабал бодьсадватай уулзав. Арьяабал бодьсадва тийм, тийм ач буянтай, тийм, тийм буян хишигтэй. Түүнтэй уулзах, эсвэл алдрыг нь сонсвол ийм, тийм буян хишигтэй гэж Шагжамуни Будда айлдав” хэмээн тэмдэглэн үлдээсэн байна. Учир нь Баршгүй саналт бодьсадва хэдийнээ маш өндөр дэсэд хүрсэн тул тийм их буян хишигтэй байх нь тодорхой юм. Харин манай тоост ертөнцийн төрөлтнүүд Арьяабал бодьсадвагийн алдрыг сонсоод тийм их буян хишигтэй болж чадах уу?

Баршгүй саналт бодьсадва дээд дэсийн сургуульд жинхэнэ Арьяабал бодьсадватай уулзсан нь үнэхээр ханьцашгүй их дээд буянтай гэсэн үг! Яагаад буянгүй байх билээ. Тэрээр тийм өндөр дэс хүртэл бясалгаж чадсан, мөн жинхэнэ бодьсадва ирж, түүнд ном заахыг үзсэн, яаж буянгүй байх билээ? Тухайн үед Түүний дэс хэдийнэ маш өндөр, маш өндөр төвшинд хүрсэн тул цаглашгүй хэмжээлшгүй их дээд буянтай байх нь тодорхой. Тэнд хүрч, Арьяабал бодьсадвад мөргөсөн нь Түүний цаглашгүй их дээд буянтайг илтгэнэ. Эгэл хүмүүс бид бодьсадватай уулзаж чадахгүй тул яаж

мөргөх вэ? Модон бурханд мөргөөд хэрэг байна уу? Модон бурхан бидэнд ханьцашгүй их дээд буяныг өгөх үү?

“Хотол зохилдогч зүйл”-д: “Эсэрваагийн эгшиг, далайн түрлэгийн чимээ, чанагуух ертөнцийн ялгуулсан аялгууг тасралтгүй сонсож чадваас эргэлзээ хэзээд үл төрнө” гэжээ. Гэнэт яагаад эсэрваагийн эгшиг, далайн түрлэгийн чимээг дурдах болов? Уг нь Арьяабал бодьсатва хичнээн сайн, хичнээн их гэрэл гэгээтэй, хичнээн их хүч чадалтайг магтан сайшааж байсан бус уу, гэтэл яагаад ингэж ярив? Харахад нэг л авцалдаагүй, холбоогүй байна, тийм үү? Баршгүй саналт бодьсатвагийн бичгийн чадвар муу, мэдлэг боловсрол тааруугаас болов уу? Бидний бичсэн өгүүллэгийн үг өгүүлбэрийн уялдаа холбоо сайн бол утга санаа нь тодорч, сонссон хүнд ойлгомжтой. Харин судрын энэ хэсэг яагаад ингэж бичигдэв? Хоорондоо жаахан зөрүүтэй байна. Тийм үү? Яагаад ийм болсныг та нар мэдэж байна уу?

Хэрвээ та нар Арьяабалын аргаар бясалгадаг бол учрыг нь сайн мэднэ. Арьяабалын бясалгалын арга нь дотроо ажиглах бясалгал, сонсох бясалгал гэсэн хоёр хэсэгтэй. Баршгүй саналт бодьсатва эхлээд “харсан”, дараа нь “сонссон” ахуй ойлголтоо бичжээ. Та нар ч бас бясалгалын өдрийн тэмдэглэл хөтлөхдөө харсан ахуй ойлголт, сонссон ахуй ойлголтоо тус тусад нь бичдэг. Долоо хоногийн даяаны үеэр та нар ийм тэмдэглэл хөтөлж, юу харсан, юу сонссоноо бичдэг. Тийм биз? Тэмдэглэлийг өөртөө зориулж бичих тул харсан, сонссон зүйлээ онцгойлон дурдахгүйгээр зүгээр л үргэлжлүүлэн бичдэг. Өөрөө ойлгож, өөрөө мэдвэл болчихно.

Бясалгалын өдрийн тэмдэглэл хөтлөхийн гол зорилго нь хэр дэвшсэнээ мэдэх, үзсэн, сонссон нь өдрөөс өдөрт сайжирч буй эсэхийг шинжих, мөн өөртөө болон Багшид үзүүлэхийн төлөө бөгөөд энэ талаар Багштайгаа ярилцахад ч хялбар болно. Тиймээс үг найруулгыг онцгой анхаарахгүй

нь тодорхой! Тухайн үед Баршгүй саналт бодьсадвагийн бичсэн өдрийн тэмдэглэл хожим “Хотол зохилдогч зүйл” болсон юм. Үнэн хэрэгтээ та нарын ахуй ойлголт ч гэсэн бас нэгэн боть “Хотол зохилдогч судар” болж болно. Ном судрын доторх Хотол зохилдогчоос огт ялгаагүй.

Өчигдөр бясалгалын төв дээр ирсэн хүүхдүүдийн зарим нь Арьяабал бодьсадваг харжээ. Гэвч би тэдэнд номыг бүтнээр нь бус багахан хэсгийг нь уламжилж, тэдний билгийг жаахан нээж, Арьяабал бодьсадваг харуулсан төдий. Тиймээс тэд “Хотол зохилдогч зүйл”-ийг бичиж чадахгүй. Талыг нь л бичиж магадгүй! “Эсэрваагийн эгшиг, далайн түрлэгийн чимээ”-ний тухайд тэд бичиж чадахгүй. Учир нь би тэдэнд Арьяабалын бясалгалын аргыг уламжлаагүй болохоор тэд огт юм сонсоогүй. Харин миний шавь нар бол “Хотол зохилдогч зүйл”-ийг лавтай бичиж чадна. Одоо ойлгов уу? Хэрвээ гадны хүн ойлгохгүй байлаа ч шавь та нар заавал ойлгоно! Та нар “Хотол зохилдогч зүйл” –ийг бичиж чадах төдийгүй “Олонх бурханы судар”, “Очир огтлогч судар” гээд судар бүхнийг бичиж чадна.

Энэ нь та бүхэн бясалгалынхаа ахуй ойлголтоо л бичиж байгаа хэрэг. Бусдад уншуулахын тулд биш. Бидний ахуй ойлголт урьдын хүмүүсийнхтэй ижилхэн байтал яагаад заавал тэдний ахуй ойлголтыг унших хэрэгтэй гэж? Бид өөрсдөө жигнэмэгтэй байтал хөршийн жигнэмэгийн сайхныг магтах хэрэг байна уу? Тэдний жигнэмэг биднийхтэй адил болохоор өөрийн жигнэмэгээ идэхэд л хангалттай. Иймээс та нар миний шавь нарыг ном судар уншиж, маани, тарни хөгжөөж, Бурханд мөргөж, гэм нүглээ наманчилж, мөргөл даатгал үйлдэж, хөөр хөгжөөн болж байхыг хараагүй. Гэвч тэдний энэ “Дао”- зам мөр тун тодорхой, төөрч будилсан зүйл өчүүхэн ч үгүй. Тэд “Хотол зохилдогч зүйл” болоод “Богдосын ном цагаан лянхуа судар”-ын ач буяны талаар ярилцахыг сонсоогүй, ямар нэгэн номын хурал хийхийг ч

хараагүй. Харин тэд өөрсдөө “Хотол зохилдогч зүйл”-ыг бичиж чадна, “Богдосын ном цагаан лянхуа судар”-ыг ч бичиж чадна.

Тэдний ахуй ойлголт нь “Хотол зохилдогч зүйл”-ийн ахуй ойлголттой ижилхэн. Бүр илүү ч байж мэднэ. Учир нь Баршгүй саналт бодьсатва бясалгалын ахуй ойлголттоо бичих үедээ дөнгөж бясалгаж эхэлж байсан юм! Шагжамуни Будда ном уламжилж байхдаа “Богдосын ном цагаан лянхуа судар”-ыг айлджээ. Тэрээр ном айлдах, ном уламжлах үедээ бүх хүний ахуй ойлголтыг бичүүлдэг байсан нь одоо та бидний уншиж буй эртний судар ном болон үлджээ. Судар ном унших нь мэдээж буруугүй! Өөрийн ахуй ойлголтыг урьдын хүмүүсийнхтэй харьцуулснаар сурсан бясалгалын аргаа зөв ном уу, буруу ном уу гэдгийг мэдэх боломжтой. Хэрвээ бидний ахуй ойлголт “Хотол зохилдогч зүйл”-тэй адил бол зөв зам. “Баатар явагч их хөлгөн судар”-ын хорин таван бодьсатвагийн ахуй ойлголттой ойролцоо бол зөв зам. Эргэлзмээр юм юу байх вэ? Гэвч зарим хүн алт авалгүй, дэндүү их чулуу авчээ. Авсан нь бүгд чулуу. Хэрвээ алт хадгалах зай гаргая гэвэл чулуугаа зайлуулах хэрэгтэй. Гэвч чулуу нь хэтэрхий олон, их хүнд болохоор зөөхөд хэцүү. Учир нь түүний чулуу хэтэрхий ихэссэн байна. Оюун ухаанаа алтаар биш, чулуугаар дүүргэсэн хүнийг бид их нүгэлтэй гэдэг. Иймээс та нар Багшийг нь хүмүүс буруутгаж байвал бүү тоо. Учир нь тэд буруудчихаад байна. Андуураад хэт их чулуу авснаас одоо түүнийгээ зөөж зайлуулах чадалгүй болжээ. Гэсэн ч Багш нь тэдэнд тусалж, чулуунуудыг нь алгуурхан алгуурхан зөөж зайлуулна. Хэдийгээр ажил нь хэцүү ч чулууг зайлуулвал алт хадгалах зайтай болно. Та нар тэдэнд уурлах хэрэггүй! Багш нь тэдэнд тусалж, чулууг нь алгуурхан нэг нэгээр зөөж дуусвал тэд өөрийн уг чанараа харах юм. Тэр үед харин түүнд алт өгч болно.



## ХАЙРЫН ХҮЧ БА ЁС ЖУРАМ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Формоса, Каошюн хотын Ажилчны цэцэрлэгт хүрээлэн  
1988 оны 5 дугаар сарын 10  
(Эх нь хятад хэлээр)*

Энд ирж ном айлдахаас өмнө миний толгой элдэв санал бодлоор дүүрэн байсан. Одоо та нарыг хараад баярлаад бүгдийг мартжээ. Манай авшигтан сая үнэхээр тодорхой сайхан ярьсан болохоор Арьяабалын бясалгалын аргыг та бүхэн маш сайн ойлгосон байх. тийм үү? Ийм тодорхой яриаг ойлгохгүй бол Арьяабалын аргаар бясалгаагүй, гэгээрээгүйгээс болж байгаа юм. Гэгээрвэл маш хурдан ойлгоно. Гэгээрээгүй бол хичнээн их судар уншсан ч эртний даяанчдын айлдварын утгыг ойлгохгүй.

Зарим хүн: “Өчигдөр би хүчит салхины дууг сонсоод гэгээрэв” гэнэ. Энэ нь юу болохыг ойлгохгүй тул ихэд гайхаж, далайн хар салхины дууг сонссон бид яагаад гэгээрсэнгүй вэ? гэж бодно. Зарим хүн: “Өчигдөр би аянгын дуу сонсох тэр агшинд гэгээрэв” гэнэ. Бид яагаадыг бас л ойлгохгүй тул аянгын дуу яаж хүнийг гэгээрүүлнэ гэж? гэж гайхна. Бид өөрсдөө ахуй ойлголтгүй тул ойлгохгүй байх нь аргагүй. Зарим нь: “Өчигдөр би зүүдэндээ галав юүлж, тэнгэр газар нурахыг үзэв” гэнэ. Түүнийг гэгээрэхэд яагаад заавал галав

юүлж, тэнгэр газар нурсаныг бид ойлгохгүй. Энэ нь бас ямар нөхцөл байдал вэ?

Хэрэв галав юүлж, тэнгэр газар нурж байвал цөвүүн цагийн ёр бус уу? Биш! Энэ нь нэг зүйлийн дотоодын ахуй ойлголт. Үүнийг үг хэлээр зүйрлэх аргагүй. Хэрэв бид галав юүлээд тэнгэр, газар бүгд нурав гэвэл яагаад ийм хачирхалтай ахуй ойлголттой байна вэ? Ийм ахуй ойлголт хэнд хэрэгтэй вэ? гэж хүмүүс бодно. Тэнгэр, газар нуран галав юүлж байгаа нь үзэгдэл үгүй, бодит юмгүй болсон төвшин бөгөөд бүх юм эвдрэн устсан тул бидний сэтгэл атгаггүй болж, хоосон гэж үгүй, буй гэж үгүй болно. Гэвч бясалгалын ахуй ойлголтгүй бол энэ ямар учиртай вэ?, ямар тустай вэ? гэж өөрөөсөө асууна.

Үнэндээ бол маш их ач тустай. Өнөөдөр би тун их баяртай байна. Яагаад гэвэл, Арьяабалын аргаар бясалгаад хичнээн хүн “Баяр жаргал”-ыг олж, авшиг хүртээд хичнээн хүн эрх чөлөөт болж, Багшид нь шавилаад хичнээн олон хүн сансрын хүрднээс ангижирч, гэгээрлийн хутагийг олж, маш олон дээд төвшинд хүрч, баяр баясгалантай ертөнцөд жаргаж байгааг бодохоор сэтгэл туйлын их баяртай байна. Хамаг төрөлтнийг баярлуулж байвал би өөрөө тамд унасан ч яахав. (бүгд алга ташив). Та нар яагаад алга ташив? Намайг тамд унаг гэж үү? Багшийгаа тамд унана гэж сонсоод баярлав уу? (бүгд инээлдэв)

Одоо надад энэрэн нигүүлсэх сэтгэл гэж үгүй. Түүнийг эрээд олохгүй болсон. Энэрэн нигүүлсэх сэтгэл гэж чухам юу болохыг ч мэдэхгүй болсон. Бүх зүйл зүгээр л ая зөнгөөрөө байх болов. Энэрэн нигүүлсэх сэтгэлээс болж хийхгүй болжээ. Хэрвээ бид энэ энэрэн нигүүлсэх сэтгэлээр хорвоогийн хэрэг явдлыг шийднэ гэвэл тун их ядарна. Учир нь энэ энэрэх сэтгэл тун “хүнд”. Тэр бусдын үйлийн үрд хөндлөнгөөс оролцох дуртай. Жинхэнэ ёс суртахуунт амьдралыг хүмүүст хүчээр заана. Маш олон ёс суртахуун,

ёс учрыг тэдэнд тайлбарлана. Заримдаа сонсох дургүй байсан ч энэрэх нигүүлсэх сэтгэлийн улмаас хүчээр ярина. Тиймээс би тэр энэрэх нигүүлсэх сэтгэлийг долоон уулын цаагуур чулуудчихсан. Одоо надад энэрэх нигүүлсэх сэтгэл гэж үгүй болсон. Бүх зүйл аясаараа, жамаараа байх болов.

Та нар, Багш минь нигүүлсэнгүй сэтгэлтэй гэхэд би ихэд ичнэ. Энэрэх нигүүлсэх сэтгэл гэж чухам юу болохыг мэдэхээ больж, энэрэн нигүүлсэх сэтгэл минь үгүй болов. Багш нь юу ч хийсэн бүгд аяндаа болж, ямар нэг зорилгоор, эсвэл энэрэх сэтгэлийн үүднээс хийхгүй болсон. Өлсвөл иднэ, ядарвал унтана. Унтах хэрэгтэй. Нүдээ тэвхэдсэн ч унтах хэрэгтэй. Өлсвөл идэх хэрэгтэй. Идэх юм байвал ид. Аливаа юм аяндаа, ая зөнгөөрөө болно. Бясалгасан ч бас энэрэн нисүүлсэх сэтгэл байсаар байвал тун яршигтай. Өдөр бүр уйлна. Диваажингийн төрөлтөн тамд унаж байгааг хараад уйлна. Диваажингийн хүмүүс цаг нь болоход доогуур төвшин лүү угаасаа л унадаг.

Энэтхэгт нэгэн Их Багш шавь нарынхаа хамт газар сайгүй явж сургаал номоо дэлгэрүүлдэг байжээ. Нэгэн өдөр Тэр замын хажууд байгаа чийгийн улаан хорхойг заагаад: “Энэ хорхой дөнгөж сая Тушита тэнгэрээс унаж иржээ” гэж шавь нартаа хэлжээ. Энэ бол тун аймаар хэрэг. Цаг нь болоход энэ ертөнцийн хүмүүс ч мөн тамд унана, эсвэл диваажин луу явна. Даанч талаас илүү нь там руу явдаг. Тун аймаар. Гэвч жирийн хүмүүс үүнд ер итгэхгүй. Тиймээс бид энэрэн нигүүлсэх сэтгэлтэй бол уйлаад салахгүй. Учир нь бид бясалгадаггүй байхдаа нүдтэй ч нүдгүй мэт байсан. Сайндаа л эндээс тэр хүртэлх ойр зуурыг харна. Тэнгэрийн нүдгүй, Бурханы нүдгүй бол диваажинг харахгүй, тамын орныг харахгүй, наян дөрвөн мянган төрөлтний зовлон зүдгүүрийг харахгүй. Тиймээс бид тийм ч их зовлон шаналалгүй байдаг. Энэ ертөнц хэдийнээ дэндүү их зовлонтойг харж байхад тамын орныг хараад бас яах билээ?

Харин бид бясалгал хийх болсноор маш олон зүйлийг харах чадвартай том нүдтэй болов. Хэрвээ тэр үед энэрэн нигүүлсэх сэтгэлийн дэсээ даваагүй бол өдөр бүр үхтлээ уйлна, нулимсаа ширгэтэл уйлна. Тиймээс олон хүн нилээд их бясалгавал баяр баясгалангүй, уур уцаартай, бухимдал зовнилтой болдог. Бид тэднийг бухимдал зовнилтой Будда гэж нэрлэнэ. Учир нь тэр өөртөө туслах арга байхгүй. Тамын орныг харахаас цаашгүй байдаг.

Газрын зүрхэн бодьсадва төгс гэгээрэхээсээ өмнө тамын төрөлтнүүдийн зовлон шаналалыг үргэлж үзсэнээс энэрэн нигүүлсэх сэтгэл нь хөдөлжээ. Тэгээд төрлөөс төрөлд тамд байж, тамын амьтдыг гэтэлгэнэ хэмээн тангарагласан байна. Би тамд очиж түүнтэй уулзаагүй болохоор одоо түүндээ гэмшиж буй эсэхийг мэдэхгүй. Зарим хүн тамын орноор зугаалж үзсэн, зарим нь тэнд шүүгч мэтийн ажил хийдэг болохоор тэд л Түүний гэмшсэн эсэхийг сайн мэдэх байх. Хүмүүсийн хахууль тасрахгүй тул Эрлэг тамын шүүгч ашигтай ажил. (хүмүүс инээлдэв) Учир нь ихэнх хүн тамд унахаас айдаг тул хэн тамын оронд шүүгч хийж байгааг мэдвэл даруй очиж хахууль өгнө.

Би ч бас тамд очиж шүүгчийн ажил хиймээр байна. Тэгвэл олон хүнээс хахууль ирэх тул өгсөн зүйлийг нь идээд барахгүй, хэрэглээд дуусахгүй. Миний бодлоор тамын шүүгчийн ажил хамгийн сайн ажил. Та нар юу гэж бодож байна? (Тийм биш гэж нэг нь хариулав) Яагаад биш гэж? Хүмүүс бүгд л тамын орны шүүгчээс айж, амьд байхаасаа л хахууль өгч эхэлдэг. Үхээгүй ч үхлээс айж өдөр бүр мөргөнө, түүнээс тусламж гуйн дургүйг нь хүргэх зүйл хийхгүй. Өдөр болгон үхсэн хүний өмнөөс цаасан мөнгө шатааж хахууль өгнө. Тиймээс тамын орны шүүгч хийх нь тун зугаатай гэж бодлоо. Эрлэг номун хааны ажлыг ч бас Бурхан бодьсадва хийдэг. Тэр тийм ч амар тайван ажил биш. Бурхан бодьсадва нарын ихэнх нь өөрийн ажил албаа нууцалдаг. Яагаад вэ?



Хүмүүс ирж хахуульдахаас айдаг хэрэг.

Ер нь тамын шүүгч тун сайн ажил гэж би бодлоо. Хэрвээ би ийм ажилтай болоод та нарт хэлбэл бүгд ирж, хахууль өгнө. (Багш инээв) Би тун хурдан ашрамаа барих юм байна. Багш нь одоо хүртэл ашрамгүй тул газар сайгүй нүүж, майхан барьж, голын эргээр амьдарсаар байна. Бид бадар барьдаггүй, барихыг ч хүсдэггүй. Мөнгөгүй болвол гар урлалын зүйл хийж зарна. Тэгэхээр тэр ашрам их удаан хугацааны дараа л баригдах байх. Тиймээс Багштайгаа хамт бясалгая гэвэл заавал хэрмэл амьдралд дадах хэрэгтэй.

Нэгэн эмэгтэй урьд нь Багшийг нь дагаж гэрээс гараад сахил хүртсэн юм. Харин одоо нутагтаа буцаж, гэртээ бясалгах болсон. Өнөөдөр тэр хүүдээ хандан: “Багш энд тэндгүй хэрэн явж байгаа болохоор би их ядарч байна. Ашрамтай болж арай тав тухтай болсон үед нь Багш дээрээ очьё. Одоо тогтсон газаргүй тул над шиг настай хүн тэсэхэд бэрх байна” гэжээ. Шавьтай хэдий ч тэднийг харж хандах чадалгүй байгаадаа миний санаа ихэд зовж, түүнийг гэрт нь бясалгуулахаар буцаасан юм. Тэгээд ч тэр гэртээ маш сайн бясалгаж байгаа. Энэ хамаагүй.

Багш нь тамын эзэн болчихвол нилээд амар юм байна. Тиймээс тамд очиж, энэ хүсэлтээ гаргадаг юм билүү гэж өнөөдөр бодлоо. Гэсэн ч бүгд л тамын эзэн болох дуртай тул надад бараг боломж олдохгүй байх. Тамын эзэн төрөл тутамдаа тамд байдаг гэж сонссон. Тэрээр энэ ажилдаа бүр хүлэгдээд, огоорч чадахгүй, салж түвдэхгүй болсон биз. Тиймээс бид өнө үүрдийн тамын эзэнтэй болжээ. Миний бодоход би түүнтэй өрсөлдөх аргагүй, учир нь түүний сэтгэл Багшийнх нь сэтгэлтэй адилгүй байх. Хэрвээ бид ямар нэгэн ажил хайвал уг ажилдаа таарч тохирох сэтгэлтэй, таарч тохирох ур чадвартай байх хэрэгтэй. Тийм биз?

Бодоод байхад миний чадвар тохирохгүй бололтой. Учир нь Эрлэг номун хаан тун хатуу сэтгэлтэй, зөвхөн

хууль цааз, үйлийн үр, эрүү шүүлт, ёс журмыг л мэдэхээс, хайрын хүчийг мэдэхгүй. Ёс журам маш сайн. Гэхдээ хайрын хүч хамгийн сайн нь. Хэрвээ би тамын эзэн болбол там хоосорно. Учир нь энэ ёс журам миний хувьд маш олон талтай. Ёс журам үргэлж ёс журмаараа байдаггүй. Жишээ нь энэ дэлхийд хулгай, дээрмийг хамгийн муу хэрэг гэж үзнэ. Дээр үед хаан нь хулгай, дээрэм хийсэн хүний гарыг цавчдаг байжээ. Одоо ч зарим нэгэн оронд ийм шийтгэл байсаар байгаа бололтой. Миний хувьд хулгай хийх нь олон шалтгаантай, хулгай хийсэн хүн заавал муу хүн байх ёсгүй. Бид түүний ар гэр, аж амьдрал, бусад шалтгаан нөхцөлийг бодолцох хэрэгтэй. Миний хувьд хүн бүхэн ялгүй. Тиймээс хэрвээ би ганц хоног тамын орны эзэн байвал тэр дороо ажилгүй болно байх гэж бодож байна. Учир нь би ёс журмыг хамгаалахгүй, зөвхөн хайрын хүчийг илүү ихээр дээдэлнэ. Миний хувьд муу үйлийн үр гэж угаас байхгүй, бүх хүн Будда болохоор Буддаг шийтгэх хатуу сэтгэл надаас яаж гарах вэ?

Хүмүүс бүгдээрээ ирээдүйн Будда. Ирээдүйн Будда ч бас Будда. Тийм биз? Жишээ нь, дөнгөж төрсөн хааны хүү үнээний сүү ууж, угж хөхөх ч бид түүнийг ирээдүйн хаан гэж мэдэх тул түүнийг хүндэтгэхгүй байж зүрхлэхгүй. Харин ч түүнийг хамгаалж, хайрлаж, харж хандах ёстой. Учир нь тэр бол ирээдүй хаан. Зарим үед ханхүүгийн нас бага ч хаан суудал залгамжилдаг. Хаан суудалд залгамжлахад бид түүнд сөгдөн мөргөдөг. Учир нь бид өмнө нь Эзэн хаан бол тэнгэрийн хүү, тэнгэрийг төлөөлөн төр барьдаг гэж сонссон. Тиймээс одооны энэ хэрэгтэн хүн бол хараахан Будда болоогүй тул бид түүнийг шийтгэж болно гэж ярьж болохгүй. Миний бодлоор, би тамын эзэн болно гэдэг огт бүтэхгүй юм байна. Учир нь энэ хайрын хүчээс болоод бусдаас хахууль авахгүй, тэгээд ажил ч үгүй болох юм байна. Хүн бүхэн өөрийн зан араншинтай, өөрийн сонголттой.

Зарим үед бид ёс журмыг сонгоно. Зарим үед хайрын сэтгэлийг сонгоно.

Бид ёс журмыг сонговол бусдыг амархан шүүмжилж, гүтгэж, хэн нь сайн, хэн нь муу, хэн нь ёс суртахуунтай, хэн нь ёс суртахуунгүй, аль шашин нь сайн, аль шашин нь муу хэмээн шүүн дүгнэнэ. Хэрвээ бид хайраар харилцаж, хайраар хандвал бүгдэд нь тустай, өчүүхэн ч асуудалгүй болгоно. Жишээ нь, өнөөдөр бид нэгэн хүн бусдын мөнгийг хулгайлж байхыг харав. Энэ бол тун жигшмээр хэрэг гэж бид үздэг. Гэтэл мөнгөө хулгайд алдсан тэр хүн урд насандаа уг хулгайлсан хүнд өглөгтэй байсан ч юм билүү, хэн мэдэх билээ. Тиймээс бид хэн нэгнийг шүүмжлэх нь тийм ч амархан хэрэг биш. Өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагийнх нь үйлийн үрийн холбоо, барилдлагыг нь ойлгож мэдсэний үндсэн дээр л магадлан тогтооно. Иймээс ёс журам заримдаа оновчгүй байдаг. Тийм биш үү? Заримдаа хүн алаагүй хүн хилсээр шийтгүүлдэг.

Эрт дээр үеэс өнөөг хүртэл ийм шударга бус хилс хэрэг маш олон гарсныг бид мэднэ. Энэ дэлхийд үнэхээр шудрага шүүгч тун ховор тул хэн нь сайн, хэн нь мууг тогтооход хэцүү. Энэ түүхийг өмнө нь би ярьсан, өнөөдөр ч бас дахиад ярья гэж бодлоо.

Энэтхэгт нэгэн их бясалгагч байжээ. Тун сайхан царай зүстэй. Одоо тэр хэдийнээ ангижирсан. Нэгэн өдөр Түүнийг тэргэнд суугаад ном дэлгэрүүлэхээр явах замд нь олон согтуу хүн таарч гэнэ. Согтуу хүмүүсийн нэг нь тэр Их Багшийг хараад туйлын их хүндэтгэн биширч, маш их, бүр маш ихээр хайрлаж, яагаад ингэснээ өөрөө ч ойлгосонгүй. Тэгээд шадар туслахаасаа: Энэ юун хүн бэ? гэж асуухад: “Хүмүүс түүнийг Эзэн Бурхан гэгцгээж байна” гэж шоолонгуй хариулжээ.

Тэгж асуусан хүн уг нь дээрэмчдийн ахлагч бөгөөд бид түүнийг толгойлогч гэж нэрлэдэг. Толгойлогч доод хүмүүстээ

хандан: “Нээрээ Түүнийг харахад яг л Эзэн Бурхан шиг үнэхээр сүр хүчтэй, сүрлэг жавхаатай, тун их хайрлам хүн байна. Би заавал араас нь явж, түүнээс нүгэл хилэнцийг минь өршөөж аврахыг гуйна” гэлээ. Учир нь тэр маш их хулгай хийсэн, заримдаа хүн зодож, хүн алж байсан тул тун хүнд нүгэлтэй гэдгээ өөрөө сайн мэддэг, их айдаг байжээ. Тэгээд өнөөх Багшийн араас явж, гэрт нь очжээ. Түүний хөлнөөс нь зуурч сөгдөн мөргөөд: “Та бол Эзэн Бурхан мөн. Та миний нүгэл хилэнцийг заавал өршөөж хайрла” хэмээн гуйжээ.

Тэр Их Багш: “Ингэж бусдыг албадаж, өөрийн нүгэл хилэнцээсээ хэлтрэх нь зохимжгүй. Та ингэх хэрэггүй” гэв. Дээрэмчний толгойлогч: “Та намайг өршөөхгүй бол би эндээс босохгүй” гэхэд тэр Их Багш: “Би жирийн нэгэн эгэл хүн. Та намайг Эзэн Бурхан гэж бүү бод. Би таны юуг ч уучлан өршөөж чадахгүй” гэхэд дээрэмчдийн толгойлогч: “Та бол Эзэн Бурхан лавтай мөн. Таныг харваас яг л Эзэн Бурхан шиг байна. Би Таны хүчинд итгэнэ. Яавал би нүгэл хилэнцээ арилгаж чадахыг заавал надад зааж өг, учир нь миний нүгэл дэндүү хүнд” гэжээ.

Энэ үед тэр Их Багш аргагүйдэж, инээмсэглээд түүнд хандан: “Хүний хөлнөөс зуураад тавихгүй, нүгэл хилэнцээ угааж өгөхийг шаарддаг, ийм аргаар нүгэл хилэнцээ арилгадаг хүнийг би ер үзээгүй. Та ингэж болохгүй, үйл лайг чинь би цэвэрлэж чадахгүй” гэв. Дараа нь түүнд хандан: “За босоод ир, ямар ямар нүгэл хийснээ надад эхлээд ярь! Яагаад нүглээ цайруулахыг хүсэв” гэж асуув. Дээрэмчдийн толгойлогч өөрийн амьдралын түүхийг Төгс Гэгээрсэн Их Багшид ярьж: “Би уг нь цэрэгт явж эх орноо хамгаалахыг хүссэн юм. Нэг удаа гадуур явж байгаад манай тосгоны ядуу хөгшнийг нэгэн цагдаа зодож байхыг харав. Түүнийг зодоод бараг алах гэж байхыг хараад тэсэлгүй цагдааг зодсон. Уг нь настай хүнийг аврах гэсэн боловч цагдааг зодоод алчихсан.

Тэгээд нуугдах хэрэгтэй болж, цэрэгт явж чадаагүй дээ. Хүмүүс мөрдөж байсан тул нуугдахаас өөр аргагүй байсан. Ямар ч ажил хийх боломжгүй. Тэгээд хожим нь дээрэмчдийн толгойлогч болсон. Хэдий тийм ч би тийм муухай сэтгэлтэй, муу хүн биш. Цэрэг болж, эх орноо хамгаалахыг хүссэн ч золгүй явдлаас болж ийм байдалд орсон” гэж яриу. Миний өвгө Багш түүний ярихыг сонсоод сэтгэл нь ихэд хөдөлж: “За тэгвэл та үнэхээр чин сэтгэлтэй бол би танд яаж бясалгахыг зааж өгье. Нүгэл хилэнцээ арилгахад чинь туслая. Харин та таван сахил сайн сахина гэж амлах хэрэгтэй. Нэгт, амь хөнөөхгүй. Чадах уу?” гэхэд тэрээр: “Чадна. Одооноос эхлээд амь нас огт хөнөөхгүй ээ” гэв. Хоёрт, хулгай дээрэм хийхгүй гэхэд: “Хулгай дээрэм хийхгүй бол би яаж амьдрах вэ? Учир нь би сурсан эрдэмгүй, хулгай хийх нь миний мэргэжил. Одоо намайг битгий хулгай хий гэвэл мөнгө яаж олох вэ?” гэж тэр хариулав. Төгс Гэгээрсэн Их Багш: “Та үнэхээр юу ч хийж чадахгүй юу?” гэхэд “Чадахгүй. Одоо цэрэг ч болж чадахгүй” гэхэд Төгс Гэгээрсэн Их Багш яах ч аргагүй болж инээмсэглээд: “За за, тэгвэл хэрэгцээнээсээ илүүг хулгайлахгүй гэж амла ”гэлээ. Тэрээр: “Тэгье ,тэгье, Хэзээ ч илүү зүйл хулгайлахгүй, илүү шунахгүй” гэв.

Тэгэхэд нь Төгс Гэгээрсэн Их Багш: “Садар самуун явж болохгүй” гэхэд: “Надад эхнэр байхгүй. Эр, эмийн явдлыг хүсдэг ч үгүй” гэсэнд Багш: “Та худлаа ярьж болохгүй” гэхэд: “За за, би угаасаа худлаа ярьдаггүй. Юу байна, түүнийгээ л хэлнэ” гэв. Их Багш хамгийн сүүлд: “Архи ууж болохгүй” гэсэнд дээрэмчдийн толгойлогч: “Үүнийг чинь харин барахгүй байх” гэв. Их Багш: “Яагаад барахгүй гэж? Нүгэл хилэнцээ цайруулья гэхихээд ямар ч сахил сахихгүй, хулгай хийнэ, архи ууна гэнэ ээ” гэхэд тэрээр: “Үүнийг үнэхээр барахгүй. Намайг толгойлогч болохоор миний цэргүүд архи уухыг шаардана. Хэрвээ уухгүй бол зориг зүрхгүй, эхнэр хүүхэд шиг гэж шоолно”

ГЭВ.

Тэр Багш: “Та заавал засрах ёстой” гэхэд тэр: “Би архи уух дуртайдаа ингэж байгаа биш. Гэвч тийм хурдан засарч чадахгүй” гэв. Түүний Багш: “За тийм бол Багшийнхаа нүдэн дээр архи уухгүй гэж надад амла” гэв. Тэр: “Тэгэлгүй яахав. Таны дэргэд би огт уухгүй” гэв. Багш нь: “За сайн! Маргааш танд авшиг хүртээнэ” гэлээ.

Тэрээр Их Багшдаа итгэж, туулан гэтэлж, нүгэл хилэнцээ арилгахыг үнэхээр их хүссэн, гэгээрлийг чин сэтгэлээсээ хайсан болохоор маргааш нь түүнд авшиг хүртээхэд маш сайн ахуй ойлголттой болжээ. Тэр өөрийн хийсэн алдаанд тун их гэмшсэн эгэл даруу хүн байлаа. Тэр хорон муу санаагаар хүн алаагүй, жаргаж цэнгэхийн төлөө хулгай хийгээгүй, харин гарцаагүй нөхцөл байдлаас болжээ. Дээрэмчдийн толгойлогч гэртээ хариад дагалдагч хүмүүстээ: “Миний өнөөдрийн уулзсан богд хүн намайг аварлаа. Одоо би бясалгана. Өдөр бүр хоёр цаг хагас бясалгал хийнэ. Амь хөнөөхгүй, хулгай хийхгүй, архи уухгүй, садар самуун явахгүй, худлаа ярихгүй” гэв. Тэд: “Тэгж болохгүй, Өнөөдөр хүлээн авалт хийж таныг дайлна. Өнөөдөр та Их Багштайгаа учирсан болохоор хамтдаа тэмдэглэе” гэв( Багш болоод хүмүүс инээв)

Дээрмийн толгойлогч: “Би уухгүй” гэсэн ч дагалдагсад нь түүнийг заавал уулгана гээд: “Таныг архи уухгүй байхыг бид ер үзээгүй. Нэг л юм боллоо доо. Таныг чийгийн улаан хорхой шиг сул дорой амьтан болгомооргүй байна. Заавал уулгана” гээд дөрвөн хүн түүнийг бариад ам руу нь хүчээр архи цутгажээ. Дээрэмчдийн толгойлогч аргагүйн эрхэнд: “Та нар битгий намайг албад. Би ууя” гэлээ. Тэр хундагатай архийг уух гэтэл Багшийнх нь хувилгаан бие гэнэт тодрон гарахад тэрээр үхтлээ цочив (бүгд инээв). Учир нь Багшийнхаа нүдэн дээр архи уухгүй гэж амалсан болохоор одоо тэр уух аргагүй болов.

Тэр ихэд уурлаж буугаа гаргаад нөгөөдүүлдээ: “Та нар миний бууны эрдмийг мэднэ. Хэн ч намайг дийлэхгүй. Би Багшдаа хэдийнээ амалсан тул энэ архийг чинь уухгүй. Үүнийг та нар сайн ойлгож ав. Багш хувилгаан биеэрээ залрахад та нар харж чадаагүй. Би өөрөө мэдсэн л бол болно. Энэ та нарт хамаагүй (бүгд инээв). Өнөөдрөөс эхлээд огт хулгай хийхгүй болсныг минь мэдэж ав. Энэ түлхүүрээр бидний сан хөмрөгийг онгойлгоод доторх мөнгийг нь тэнцүү хувааж аваарай. Тэгээд та нар гэр гэртээ харьж, ажил төрөл олж хийцгээ. Өнөөдрөөс эхлэн би хулгай хийхгүй учраас та нарын толгойлогч биш болсон. Хүссэн үедээ хувилж чаддаг тийм сайн Бурхантай, тийм сайн бодьсадватай учирсан болохоор яаж би түүний үгэнд орохгүй байх билээ? Та нар намайг албадах хэрэггүй. Албадвал буудна шүү” гэв.

Тэр тун тодорхой хэлээд түлхүүрээ өгч: “Би цагдаа дээр очиж, өөрийгөө илчлэх тул та нар одооноос эхлээд надтай холбоотой байх хэрэггүй. Эс бөгөөс миний хамсаатан болно. Одоо та нар эртхэн харьж сайхан ажил олж хийцгээ, сайн хүн болцгоо” гэж хэлээд орхин явжээ. Тэр үеэс эхлэн хулгай хийхээ больж, үлдсэн жаахан мөнгөө хүргэж ядан амьдарч байсан ч хэзээ ч муу хэрэг хийсэнгүй.

Нэгэн өдөр түүний дүү охин хуримлах болов. Энэтхэгт эмэгтэй хүн гэрлэхдээ нөхрийн талд их мөнгө өгдөг. Хятадад ямар заншилтайг би мэдэхгүй. (Яг үүний эсрэг. Эрэгтэйн тал нь эмэгтэйн талдаа мөнгө өгдөг гэж нэг хүн хариулав). Тун харамсалтай. Тэгвэл эрчүүд Энэтхэгт очиж гэрлэвэл мөнгөтэй болох юм байна. (бүгд инээв). Энэтхэгт эмэгтэйн тал нь эрэгтэйн талдаа их мөнгө өгдөг болохоор охин дүү нь мөнгө хүрэлцэхгүй байгаагаа хэлж, туслахыг гуйхад тэр мөнгөгүй тул жаахан юм хулгайлахад сүртэй юм болохгүй гэж бодов. Тэр тун сэргэлэн юу ч хулгайлж чадна. Тэр, мөнгө хадгалдаг нууц авдрыг онгойлгомогц хаалга нь эргэж түгжигдээд онгойх ямар ч аргагүй болов

гэнэ. Уг нь түүний хувьд мөнгөний нууц авдар онгойлгох нь алга урвуулахын төдий амархан боловч энэ удаа яасныг бүү мэд, огт онгойсонгүй. Тэр, их мөнгө атгасан гараа татаж авах гэтэл хаалга нь хаагдсан тул “За баларлаа. Одоо гарах аргагүй болсон. Багшийн үгэнд ороогүйгээс боллоо” гэж бодоод уйлав.

Тэрээр: “Би хулгай хийхгүй гэж шийдсэн ч эцэстээ ийм байдалд орлоо. Хулгай хийгээгүй тун удсан. Ганц удаа хулгайлаад л бүтэлгүйтэж баригдах нь” гэж бодов. Энэ үед Багшийнх нь хувилгаан бие хүрч ирээд: “Илүү битгий шунаарай гэж хэлсэн биш шүү (Багш болоод хүмүүс инээв). Одоо босоод хаалгаа даруй онгойлгож, ганц ч мөнгө үлдээлгүй бүгдийг нь буцааж тавиад хурдан яв” гэлээ.

Тэр үеэс эхлэн үнэхээр дахин хулгай хийсэнгүй. Хашаа хороо шүүрдэж, бие засах газар цэвэрлэж, бусдад зарцлагдан зүдэрч байж хэдэн зоос олох болов. Тэрээр нэг өдөр цагдаад очиж, өөрийгөө илчлээд шоронд хоригдож үхлээ хүлээжээ. Энэтхэгт тэр үед хүн алах юмуу, хулгай дээрэм хийсэн бол алах ялаар шийтгэдэг байв. Тэр айсангүй, харин ч баяртай байлаа. Алагдахаас нь өмнө Багш нь ирж: “Гурав хоногийн дараа чи ангижирна” гэжээ. Тэр тун баяртайгаар тэр мөчийг хүлээж, өдөр бүр бясалгаж, даалгасан ажлыг сайн хийж байсан тул тэндхийн цагдаа нар түүнд тун сайн хандана.

Ялын тогтоол хараахан ирээгүй байхад тэр хэдийнэ мэдчихээд гурав хоногийн дараагаар ял гүйцэтгэх гэж байна уу гэж цагдаагаас асуухад: “Тийм ээ. Гэвч энэ бол нууц. Чи яаж мэдэв?” гэхэд Тэр: “Нууц юу байх вэ дээ? Миний Багш бүхнийг мэддэг. Тэр надад хэлсэн. Би айхгүй, харин ч баяртай байна. Энэ хугацаанд санаа тавьж байсан та бүхэнд баярлалаа” гэв.

“Учир нь би та нарт тун их баярласан болохоор та нарыг нэгэн газарт очоорой гэж захъя. Та нар миний багштай



нэг л уулзвал Тэр таны бүх амьдралыг өөрчилнө. Та нар Түүнийг хармагцаа л хувирна. Тэр бол энэ дэлхийн хамгийн агуу бодьсадва мөн. Та нар хурдан очиж, Түүнтэй уулзаарай. Би та нарт маш их баярласан учраас хэллээ. Би амьдралдаа сэтгэл хангалуун аз жаргалтай байна. Одоо явах гэж байгаа ч бас баяр жаргалтай байна. Би та нарт танилцуулахгүй байж тэссэнгүй. Та нар даруйхан очиж, миний Багшаас суралцаарай” гэв.

Хожим нь нөгөө цагдаа нар түүний Багштай уулзсан бөгөөд мөн түүний Багшийн бусад шавь нарт энэ тухай ярьсан тул бүгд энэ явдлыг мэддэг болж улмаар ихэд алдаршжээ. Энэ түүхээс үзвэл ялгаагүй хулгай боловч нөхцөл байдал адилгүй болохыг харж болно. Библид ч бас: “Хулгай дээрэм хийдэг бол муу хүн гэж эртний хуулинд заасан байдаг” гэж тэмдэглэсэн байна. Гэвч Есүс Христ: “Хоолгүй болоод өлбөрч үхэхгүйн тулд хулгай хийсэн бол ялгүй” гэжээ. Түүний хэлсэн нь Багшийнх нь саяын ярьсан зүйлтэй яг ижил. Иймээс Арьяабалын аргаар бясалгавал бид бүгд Будда болно. Наад зах нь сансрын хүрднээс ангижирч, Бурхан бодьсадвад ойртоно. Тиймээс бид өөрсдийгөө муу хүн, их нүгэл хилэнцтэй хүн гэж бодох хэрэггүй.

Өчигдөр нэг хүн архи уух талаар асуусан. Багшид нь нэгэн зүйлийн архи бий. Энэ ертөнцийн архинаас илүү сайн. Манай буддын шашинд рашаан ус, аялгууны урсгал гэдэг. Хүнийг төөрөгдүүлж, оюун санааг мунхруулдаг хямд үнэтэй ямар ч муухай архийг энэ архи орлож чадна.

Энэ ертөнцийн гэм нүгэл бүхэн биднийг сургах хичээл байдаг. Энэ дэлхийн шунал, хилэн, мунхаг нь бид жинхэнэ эрдэнээ олж чадаагүйгээс болдог. Бид жинхэнэ эрдэнээ олохыг маш их хүсэмжлэх тул гээсэн зүйлээ хайж байгаа шиг энд тэндгүй явж, газар сайгүй эрнэ. Түүнийгээ нэг л өдөр олно хэмээн найдна. Иймээс уур хилэн, шунал тачаал, харанхуй мунхаг бол бодь чанар мөн, нисваанис ч

гэсэн бодь чанар мөн. Уур хилэн, шунал тачаал, харанхуй мунхаг нь бас нэг зүйлийн буян хишиг юм. Зарим үед бид зовж зүдэрч, өвдөж шаналан, саад тотгортой учирдаг. Үүнийгээ нүгэл хилэнц гэж бодно. Гэвч энэ нь буян хишиг байдгийг бид ойлгох хэрэгтэй. Хэрвээ зовлон зүдгүүр, өвчин тахал, үйлийн үр байдаггүй бол бид бохир муухай хэсгээ цэвэрлэж чадахгүй. Зарим үед өвчин эдгэсний дараа билиг ухаан бага ч атугай нээгдэж, үзэл бодол урьдынхтай адилгүй болсон санагддаг. Ааш зан аядуу зөөлөн болж, хамаг төрөлтнийг илүү их хайрлан, ойр дотны хүмүүстээ илүү тэвчээртэй, илүү элгэмсүү хандана. Тийм биз? (бүгд алга ташив)

Иймээс бид энэ ертөнцийн аливаа байдалд нэг их гомдоллох хэрэггүй. Арьяабалын аргаар бясалгавал юм бүхний учрыг ойлгоно. Яагаад нисваанис нь бодь чанар, өвчин зовлон нь буян хишиг байдгийг ойлгож, гомдоллохоо болино. Харин ч улам эрх чөлөөтэй, улам талархалтай болж, өөрсдийнхөө азтайг илүү их мэдэрнэ. Учир нь энэ ертөнцийн мөнгө хөрөнгө, гоо үзэсгэлэн, алдар нэр, ашиг хонжоо цөм мөнх бус. Иймэрхүү баяр цэнгэл биднийг нэгэн өдөр цэнгүүлэх ч нөгөө өдөр нь огт өөр болгоно. Жишээ нь, өнөөдөр найз бүсгүйтэй байсан бол маргааш хаяад явсан байж тун магадгүй.

Гэтэл биднийг хэзээ ч орхидоггүй, үүрд бидэнд чин үнэнч нэгэн найз бий. Тэр бол бидний өөрийн эзэн, бидний уг дүр, бидний будда чанар, бидний Эзэн бурхан, бидний хамгийн их Дао (зам мөр) юм. Буддын шашин нь их зам мөр, бага зам мөр гэж хоёр хуваагддагийг бид байнга сонсдог. Өөрөөр хэлбэл нэг нь их хөлгөн, нөгөө нь бага хөлгөн. Их хөлгөн, бага хөлгөн гэдэг нь их зам мөр, бага зам мөр гэсэн үг. Яагаад их зам мөр гэсэн вэ? Дао-г олсон (үнэнийг олсон) гэсэн үг. Энэ үнэний дотор бясалгаж, үнэнтэй нэвтрэлцэж, үнэний хүчээр хамгаалуулж, үнэнийг хэрэглэж чаддаг,

үнэнтэй хамт байдаг бол их хөлгөн мөн.

Нөгөө нэг нь эртний хүмүүсийн бясалгалын ахуй ойлголтыг уншиж, бусдын бичсэн ном судрыг судалдаг бөгөөд тэр бол бага хөлгөн юм. Гэвч буддын шашинтны ихэнх нь их хөлгөн, бага хөлгөний ялгааг ойлгодоггүй. Тэд Хятадын буддын шашин бол их хөлгөн, Тайландын буддын шашин бол бага хөлгөн гэнэ. Үнэн хэрэгтээ ингэж хуваадаггүй. Их хөлгөн гэдэг нь аль хэдийнээ их зам мөрийг олсон. Бага хөлгөн гэдэг нь Их зам мөрийг хараахан олоогүй гэсэн үг. Одоо ойлгов уу?

Бид Арьяабалын аргаар бясалгаж байгаа нь их зам мөр, их хөлгөнийг бясалгаж байгаа хэрэг. Бид Арьяабалын бясалгалын арга гэж ярихгүй байж болно. Арьяабалын бясалгалын арга гэхээр нэрэнд хүлэгдэнэ. Гэвч бид их зам мөртэй жинхэнэ ёсоор холбогдоогүй, дотоодын гэрлээ хараагүй, дотоодын ахуй ойлголттой болоогүй, Буддатай уулзаагүй, аялгууны урсгалд умбаагүй бол бид бага хөлгөнийх л байна. Аль ч шашинд итгэсэн, ямар ч аргаар бясалгасан, ямар ч Их Багшийг шүтэн дагасан бүгд бага хөлгөнийх байна.

Шүтэн дагахын утга учрыг тодорхой сайн ойлгох хэрэгтэй. Шүтэн дагая гэвэл энэ ертөнцөд заларч буй Төгс Гэгээрсэн Их Багшийг хайж олох хэрэгтэй. Тэр өөрөө хэдийнээ үхэж төрөхөөс ангижирсан бол Түүнийг бид шүтэн дагаж болно. Хэрвээ тэр сансрын хүрднээс гэтлээгүй бол бид түүнийг шүтэн дагасан ч хамтдаа сансрын хүрдэнд эргэлдэж, хүний тоо нэмэхээс цаашгүй. Ойлгов уу? Уг нь тэр ганцаараа явсан бол амар байсан. Гэтэл та нар тав, зургаан зуун дагалдагсад нэмэгдээд түүнийг даган үхэж төрөхийн хүрдэнд эргэлдвэл ядарч үхнэ. Хэзээ туулан ангижрахаа ч мэдэхгүй болно. Энэ үнэндээ тун төвөгтэй. Тийм биш үү? Өөрөө гэтлээгүй, бас бусдад төвөг удна. Иймээс шүтэн дагана гэдэг тун осолтой явдал. Шагжамуни

Буддаг энэ дэлхийд заларч байхад бид сая жинхэнэ ёсоор Буддаг шүтэн дагалаа гэж болно. Зургадугаар үеийн Их Багш Хүй Нэн энэ ертөнцөд заларч байхад бид шүтэн дагаж чадна. Бид албан ёсоор шүтэн дагаагүй ч сэтгэлээрээ дагаж болно. Бид Тэр хүн бол Будда гэж итгэж, Тэр туулан ангижруулах хүчтэй гэдэгт итгэж, Түүнийг чимээгүй шүтэн дагаад дотоод сэтгэлдээ: “Итгэлт Багш минь ээ, Би танд үнэхээр их итгэнэ. Та надад туслаач. Үхэх үед минь намайг дагуулахаа бүү мартаарай” хэмээн залбирч болно.

Энэ бол жинхэнэ шүтэн дагаж байгаа хэрэг. Харин заавал тэнд хоёр цаг хагас сөгдөн мөргөх, эсвэл улаан ногооныг түрхээд олон сайхан зүйл ярих биш. Учир нь зарим зүйл ярихад сайхан ч ач тусаар бага. Амьд цэцэг сайхан. Гэтэл зарим цэцгийг хуванцараар хийдэг ч тэд бас сайхан гэгцгээнэ. Тийм биз? Энэ нь хүмүүсийн таашаалын асуудал. Зарим нь хуванцар цэцэгт дургүй, олонхи нь амьд цэцэгт дуртай. Ямар ч мэдрэмжгүй хүн л хуванцар цэцэг авна. Хуванцар цэцэг ямар ч хэрэгцээгүй тул авахгүй байх нь хамгийн зөв.

Уучлаарай, заримдаа Багш нь тийм сайн ярихгүй. Зарим хүн хуванцар цэцэг зарж, амь зуух тул Багш нь бас ингэж хэлж болохгүй. Хуванцар цэцэг давгүй л дээ. Гэвч Багш нь жинхэнэ үнэнийг яривал та нар айх хэрэггүй. Худал хуурмаг зүйлд дуртай хүмүүс хэзээд байдаг. Үнэнийг хэлсэн ч тэд сонсохгүй. Үнэн ёсонд дуртай хүн бол чиний хэлсэн ганц өгүүлбэрийг ч санана. Худал ёсонд дуртай хүнд чи хагас жил ярьсан ч тэр мэдэх ч үгүй, ойлгох ч үгүй.

Өнөөдөр нэг хүн Багшид нь захидал илгээжээ. Багшийг дагаж гэрээс гармаар байна гэж бичжээ. Тэр эрэгтэй хүн. Түүний хэлснээр таван жилийн өмнө Багштай уулзсан бөгөөд нэгэн номын хуримд Багшийн хамт оролцож, дараа нь Багшийг хүргэж өгсөн гэнэ. Гэвч тэр үед намайг хэн болохыг мэдээгүй гэнэ. Одоо харин мэдээд таван жилийг

талаар үрсэндээ маш их харамсжээ. Тиймээс одоо хурдхан нөхнө, гэртээ бясалгах хүсэлгүй. Хурдхан гэрээс гарч, Багштай хамт бясалган амжиж нөхөхийг хүсжээ. Багшид огт дургүй биш, Багшийг бас маш их хайрладаг байсан, гэвч тэр үед түүний цаг нь болоогүй байсан гэж ярьсан. Дэлхий дээр ийм олон хүн байхад бид яагаад нэг л хүнийг онцгой их хайрладаг вэ? Яагаад хайрласнаа бас мэдэхгүй, таван жилийн дараа сая мэдээд даруй гэрээс гарахаар шийдсэн байна.

Олон эрчүүд Багшийг нь дагаж гэрээс гаръя гэдэг, Би тэдэнд: “Багш нь эмэгтэй хүн шүү” гэдэг юм (бүгд инээв). Та нар яагаад инээлдэв? Би эмэгтэй хүн биш үү? Харахад эр хүн шиг байна уу, аан? Та нар алдас хийлээ! Хэрвээ та нар Багшийнхаа энд ирж, гэрээс гарвал Хятадын буддын шашинтны нийгэмлэг та нарт сахил хүртээхгүй байх шүү.

Яг үнэндээ сахил бол өөр зүйл. Шагжамуни Будда Бурханы хутагт хүрээд удаагүй байхдаа таван гэлэнтэй таарсан байна. Тэгээд тэдэнд ном уламжилжээ. Тэр үед сахил байгаагүй. Хожим нь олон хүн ирж, Түүнээс суралцах болсон үед ч бас сахил гэх юмгүй байсан. Учир нь янз бүрийн хүмүүс олноор ирэх болсон тул сүүлд сахил тогтоосон аж. Яагаад тэр вэ? Учир нь эртнээс нааш энэтхэгийн хуврагууд ямар ч шашны урсгалд харьяалагдсан ялгаагүй бүгд сахилтай байжээ. Шагжамуни Будда тэдэнд нийцүүлэх хэрэгтэй болсон, нийцүүлэхгүй байхын ч аргагүй байв. Тэр өөрөө бас хувраг байв. Хэрвээ тэдэнд нийцүүлэхгүй бол тэд Түүнийг хүндэтгэхгүй. Хүндэтгэхгүй бол тэдэнд ном уламжлах аргагүй болж, Түүний үг үнэгүйдэх байлаа. Тиймээс Тэрээр золиос гаргах хэрэгтэй болсон. Зарим үед тэр сахилууд ямар ч хэрэггүй, бясалгалд ч бас ач тусгүйг Тэр мэдэж байсан ч уялдуулах хэрэгтэй болсон юм.

Тэр сахилуудыг уншвал та нар ойлгоно. Би яриад ч хэрэггүй. Яривал зарим нь гомдоно. Гэвч миний хувьд

тэр сахилууд нь одоо огт хэрэгцээгүй болсон. Зөвхөн зарим нь тухайлбал, амь хороохгүй, хулгай хийхгүй, архи уухгүй, садар самуун явахгүй, худлаа хэлэхгүй байх зэрэг нь хэрэгтэй. Архи уухгүй байх нь билиг ухаанаа хамгаалахын төлөө. Архи бидний мэдрэлийн эсийг хордуулж, ихдүүлвэл тэнэг мангар болгоно. Ли Бай шиг цэцэн мэргэн, нэрд гарсан яруу найрагч архи ууснаас л тийм тэнэг болж, усанд туссан сарны дүрсийг уг нь тоохгүй баймаар атал ус руу үсэрч, түүнийг барих гэсэн нь юуных вэ? Ийм үйлдлийг ухаантай хүн байтугай жирийн хүн ч хийхгүй. Архи их ууснаас тийм харамсалтай явдал болсон.

Жирийн үед ч олон хүн архинаас болж, нэр нүүр, ажил алба, гэр орон, байр суурь, эрх мэдлээ алдахыг бид хардаг. Улсын хаан ч архинаас болж эх орон, хаан суудлаа алддаг. Нэр хүндтэй, өндөр алба тушаалтай хүмүүс архинаас болж, элдэв муу хэрэг үйлддэг. Архинаас болж, олон арван дайн гарсан. Тиймээс хувраг хүн архи ууж болохгүй нь мэдээжийн хэрэг.

Амь хөнөөхийн тухайд бол бүр ярихын ч хэрэггүй. Хувраг гэдэг нь энх тайван, эрхэм дээд гэсэн санаа бөгөөд эрхэмсэг амар амгалан амьдралыг төлөөлнө. Тэгэхээр бусдыг яаж алж хороож болох вэ? Амьтны амийг хөнөөдөг хүнийг алуурчин гэхээс эрхэм хүмүүн гэхгүй. Тиймээс бид ийм хэргийг үйлдэж болохгүй. Бусад сахилын тухайд гэвэл бүгд л тухайн улс орны уламжлал, зан заншил төдий. Жишээ нь, Төвөдөд хоол идэхдээ ногооны дээр будаа тавьдаггүй сахил бий. Үүний утга нь ногоо ахиуханыг аваад үүнийгээ хүмүүст мэдэгдэхгүйн тулд будаагаар халхалж болохгүй гэсэн санаа.

Яагаад ийм сахил байдаг вэ? Учир нь Төвөдөд ногоо тарихад тохиромжгүй тул хүнсний ногоо тун хомс. Хималайн нуруунд цаг агаар хүйтэн, цас байнга ордог болохоор олон төрлийн ногоо тарих боломжгүй. Ногоо ховор болохоор лам

нар дуртай ногоо нь байвал ахиухан авдаг тул үүнийгээ бусдад мэдэгдэхээс айж жаахан будаагаар далдалдаг. Энэ сахил Хятад хүнд ямар ч хэрэггүй. Учир нь хятадад ногоо цагаа элбэг болохоор будаагаа ногоогоор халхалсан нь ч бараг илүү. Тийм биш үү?

Учир нь онцгой зан заншил, ёс уламжлалууд сахил болон хувирсан тул сахил бүхэн заавал бясалгалтай холбоотой биш. Ойлгов уу? Түүнээс гадна, мөнгөгүй бол одоогийн лам нар ийш тийш явж чадахгүй. Учир нь орчин үед агаарын бохирдол ихэссэн болохоор явган явах нь хүний биед муу болжээ. Урьдын цагт бол замд явахад хаа сайгүй хөдөөгийн байдал хөвөрч, сайндаа л морин тэрэг, явган яваа хүнтэй л таарах төдий. Одоогийнх шиг бензиний бохирдол байсангүй. Тиймээс энэ цагийн хувраг хүн жаахан мөнгөтэй явахад гэмгүй.

Дээр үед Энэтхэгт хувраг хүн өдөр бүр явган явж, бадар барьдаг байжээ. Хэрвээ биедээ их мөнгөтэй яваа бол хаанаа хадгалах вэ? Хаана ч явсан хангир жингэр дуугараад өдөржингөө мөнгөндөө санаа тавих хэрэгтэй болно. Тэр үеийн мөнгө одоогийнхтой адилгүй, биедээ авч явбал дуу чимээ ихтэй. Хэрвээ биедээ алт, үнэт эрдэнэс авч явбал хүмүүс амархан мэдчих тул бидний амийг хөнөөж магадгүй. Бясалгагч хүн өөрийн амь насыг хамгаалахын төлөө байж, өөрийн биеийг аюул ослын бай болгох хэрэггүй. Тиймээс үнэт эдлэл, эрдэнийн чулуу, мөнгө төгрөг авч явж мэдээж болохгүй.

Ихэнх сахил бүгд л иймэрхүү. Маш олон сахил одоо бидэнд онцын хэрэггүй болсон. Цаг үе бүхэнд бясалгах нөхцөл байдал өөр өөр байдгийг ойлгох хэрэгтэй. Энэ цаг үед бясалгал хийхэд ийм хувцас өмсөх шаардлагагүй. (Их Багш өөрийн орхимжоо заав) Өмсвөл нилээд хоцрогдсон мэт харагдана. Харин ном тайлахдаа жийнсэн өмдтэй очвол цаг үетэйгээ нилээд нийцнэ. (бүгд инээлдэж, алга ташив)

Гэвч Багш нь энэ нэг хуврагийн хувцасыг л өмсөнө. Учир нь аль хэдийн худалдан авсан болохоор өмсөх хэрэгтэй. Сольж өөрчилсөн ч ялгаа байхгүй. Төд удалгүй жийнсэн өмд хоцрогдоход бас л солих хэрэгтэй болно. Энэ нь их төвөгтэй. Иймээс юу байгаагаа өмсвөл мөн сүр жавхаатай, бүх биеийг далдлах тул бидний “Уг дүр”-ийг хэн ч харахгүй.

Жийнсэн өмд өмсөх нь хэдийгээр гоёмсог, биед эвтэйхэн ч хүний нүдэнд тийм ч сүр жавхаатай харагдахгүй. Жишээ нь, эмэгтэйчүүд заримдаа бараг л нүцгэн шахуу явах болсон. Одоо үед бөс даавуу элбэг болсон ч хүүхнүүд даавуунд тун дургүй болжээ. Яг л даавуу ч олддоггүй ядуу хүн шиг л байх юм. Бүсгүйчүүдийн хөнгөн нимгэн хувцаслалт нь эрчүүдэд тун их яршиг төвөг уддаг. Хуврагийн ийм нэгэн хувцас өмсөх нь надад маш сайхан, сүр жавхаатай, төв эрхэмсэг санагддаг юм. Тиймээс бид өмссөөр л байх болно.

Гэхдээ ийм хувцас өмсвөл Будда болчихно гэсэн хэрэг огт биш. Гудамжинд дэлгүүрийн шилэн хоргон дахь гоёмсог хувцастай, будаж шунхадсан, халзан толгойтой загварын хүнийг харсан уу? (хүмүүс инээлдэв) Удалгүй халзан толгой ч бас моод болж магадгүй. Багштайгаа та нар өрсөлдөж амжихгүй. Удалгүй үсчний газрууд хүнээ дийлэхээ болих тул та нар сүмд очиж хусуулбал арай түргэн, тэгээд ч цус гарахгүй. Учир нь тэд хувраг хүний үсийг тусгайлан хусдаг болохоор тун хурдан, тавхан минутанд хусаад дуусгана. Удалгүй бүх Формосачууд халзан толгойтой болж магадгүй шүү.

Гэвч миний бодоход загвар хөөцөлдөхгүй байсан нь дээр, эс бөгөөс бид ядарна. Хувраг хүмүүс бид мөнгөгүй тул та нартай өрсөлдөж чадахгүй. Тиймээс миний бодлоор гэрээс гарагчийн хувцсаа л өмссөн нь дээр юм байна. Ийм нэг иж бүрэн хувцастай бол хаана ч өмсч болно. Үзэмжтэй, мөнгө үрэхгүй, угаахад хялбар, тун зүгээр санагддаг.



Японд бүр амар болжээ. Хуврагийн хувцас өмссөн ч эгэл хүнээс ялгарах юмгүй болж. Яг л адилхан мах идэж, гэрлэж, хүүхэд төрүүлж байна. Дэндүү задгайрчээ. Японд хувраг байх ийм хялбархан атал хүмүүс яагаад хувраг болохыг хүсэхгүй байгааг би ойлгохгүй байна. Тийм биш үү? Харин хятадад хувраг байх тун хэцүү. Ургамал хоол идэх хэрэгтэй. Авид Бурханы тарни унших ёстой. Заавал өглөө, оройн уншлага хийнэ. Гэрлэж болохгүй гэх мэт төвөгтэй зүйл тун их.

Японд хувраг байх ийм хялбар байтал яагаад хувраг хүн ийм цөөн байна вэ? Та нар мэдэж байна уу? (ертөнцийн жаргал цэнгэлд шунаад жинхэнэ ёсоор бясалгах сонирхол байхгүй гэж нэг хүн хариулав) Гэтэл тэндхийн хуваргууд эхнэр авч, архи ууж, мах идэж, ертөнцийн элдэв таашаалыг эдэлж л байдаг. Би яагаад гэдгийг мэдэхгүй болохоор та нараас асуусан юм. Та нар ийм олуулаа байж учрыг нь олохгүй байхад ганцаараа би яаж ойлгох вэ? (Багш болоод бүх хүн инээлдэв)

За, за тэднийг орхиё. Надад зүгээр л л хачирхалтай санагдсан юм. Түвдийн лам нар ч бас мах иддэг. Тэр ч байтугай зарим урсгалынхан тухайлбал, улаан, хар урсгалынхан гэрлэдэг. Шарын шашныхан гэрлэхгүй. Төвөд лам нар мах идэхэд асуудалгүй байна. Гэтэл яагаад бүгд бясалгахгүй байна вэ? Энэ нь тун сонирхолтой асуудал. Энэ бүхнийг би үнэхээр ойлгохгүй байна. Бид хариад энэ сэдвээр ном хаялцъя, болох уу? (бүгд инээлдэв). Яагаад гэдгийг би мэдмээр байна.

Гэвч ийм асуудлын төлөө бид тархиа гашилгах хэрэггүй. Учир нь бидний тайлбарлаж чадахгүй маш олон зүйл бий. Уламжлал зан заншлаас болсон нь нилээд их. Ганц хоёр хүн ямар нэгэн санал гаргавал бусад нь аялдан дагана. Хүмүүсийн ихэнх нь удирдагч болох дургүй, бусдыг дагах сонирхолтой байдаг. Тиймээс маш хүчирхэг, өвөрмөц зан

чанартай ганц хоёр хүн л ямар нэгэн хэв загварыг бүтээж бусад нь дагадаг. Дээр үед ойлгомжгүй зүйл маш их байсан. Жишээ нь, эмэгтэйчүүдийн хөлийг боох явдал. Формосад ч гэсэн хэдэн арван жилийн өмнө эмэгтэй хүний хөлийг шувууны хөл шиг болтол нь боож хатаадаг байв. Ингэхээр юу нь гоё болдгийг би ойлгоогүй. Энэ заншил хүнийг их зовоодог. Хар багаас нь боодог болохоор хөл нь байнга өвдөж, яг л гал шатах мэт болдог тул өвдсөндөө уйлж, идэж ууж, унтаж амарч чаддаггүй. Наад зах нь хоёр жилийн турш боодог тул өдөр бүр энэ зовлонг тэсвэрлэх хэрэгтэй болно. Ээж нь охиноо хүчээр боодог тул тэд энэ зан заншлаас салж чадахгүй, хүлээн зөвшөөрдөг байжээ.

Энэ бол тун өрөвдөлтэй явдал. Их бага түшмэдийн эхнэрээс эхлээд тариачны гэргий, настай хөгшид хүртэл хятад даяараа бүгд л ийм байжээ. Өдөр бүр уйлж байгаад хөлөө бооно. Хөл боодог даавууг байнга угаахгүй бол өмхийрдөг ч тэд завгүй тул арван дөрөв хоногт ганц удаа угаадаг гэж би сонссон. Тэр ч байтугай заримд нь өмхий тусмаа сайхан санагддаг гэнэ. Яагаад ингэдэг байсныг нь одоогийн бид ойлгодоггүй. Хэн нэгэн хүн жишээ нь, хаан эзэн нь дуртай байснаас татвар эм нь хөлөө боож, хожим нь үүнийг бүгдээрээ дуурайх болсон байх. Хичнээн их зовиуртай ч боосоор иржээ. Эмэгтэй хүн хөлөө боогоогүй бол гэрлэхэд хэцүү. Тийм биз? Хэдхэн жилийн гэрлэлтийн төлөө тийм их зовлонг амсах дуртай мөртлөө үхэж төрөхөөс ангижирч мөнхийн баяр баясгаланг олохын төлөө өдөр бүр хоёр цаг хагас яагаад бясалгаж чадахгүй байна вэ? Үүнийг би үнэхээр ойлгохгүй байна. Надад энэ нь саяхан та нараас асуусан тэр япон ном хаялцаанаас ч илүү ойлгомжгүй байгаа юм.

Номд бичсэнээр хөл боох нь үнэхээр зовлонтой, хоёр цаг хагас ч биш, бүхэл өдөржингөө өвдөнө. Одоо Багш нь та нарт Арьяабалын аргыг зааж өгвөл зарим хүн: “Өдөр бүр

хоёр цаг хагас бясалгаж чадахгүй. Завилж сууж чадахгүй” гэнэ. Би та нарыг заавал завилж суу гээгүй. Завилахгүй, сандал дээр суугаад хэвтээд бясалгаж болно. Ургамал хоол идэхэд л хангалттай. Гэрлэхийн төлөө, нөхрөө баярлуулахын төлөө боолгосон хөлөө өвдөхийг хорин дөрвөн цагийн турш гэсвэрлэдэг мөртлөө Будда бодьсадваг баярлуулахад хоёр цаг хагасыг зориулж чадахгүй байгааг хараад үнэхээр гайхдаг. Эндээс бид өөрсдийнхөө хэр их номч сэтгэлтэйг мэдэж болно. Өдрийн хорин дөрвөн цагийн арван хэдийг нь өөртөө болоод гэр бүлдээ зориулдаг атлаа Бурхан бодьсадвагийн төлөө, өөрийнхөө төлөө хоёр цаг хагасыг гаргаж чаддаггүйд нь үнэхээр эргэлзмээр, бас бухимдмаар байдаг.

Дээр үед ганц хөл боох ч биш өөр олон асуудал байсан. Бид жаахан эд юм, эсвэл наймаа арилжаандаа бага сага ашиг олох, амьдралаа тав тухтай болгохын төлөө ямар ч нөхцөл байдалд юу ч амсахад бэлэн байдгийг өнгөрсөн үеийн олон үйл явдал харуулдаг. Гэвч өнөд туулан гэтлэхийн төлөө хоёр цаг хагасыг гаргах дургүй байна. Хэрвээ бид сансрын хүрдэнд гарцаагүй эргэлдэх болбол энэ нь бидний өөрийн сонголт л байдаг. Хэн ч биднийг шийтгээгүй, Эзэн Бурхан шудрага бус хандаагүй. Эрлэг номуун хаан тийм ч харгис хэрцгий нэгэн биш.

Багш нь өнөөдрийн яриагаа ингээд дуусгая. Багш нь юу ч ярьсан бүгд тустай. Заавал ямар нэг их ёс журам, Бурхан бодьсадва, баруун зүгийн Төгс баясгалант орныг ярихгүй. Зүгээр энд ирээд А,Б,В - г хоёр цаг уншсан ч ач тустай. Учир нь би ном айлдаж байхдаа ч чимээгүйгээр ном уламжилж байдаг. Номыг үг хэлээр уламжилдаггүй юм. Яриад байгаа маань зөвхөн та нарын анхаарлыг татахын төлөө. Харин Багш нь өөр нэг зүйлийг уламжилж байдаг юм.



## АДИСЛАЛЫН ХҮЧ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Формоса, Тайбэй хот, Ванхуа  
1986 оны 10 дугаар сарын 1  
(Эх нь хятад хэлээр)*

Төгс Гэгээрсэн Их Багшийн адислалын хүчийг халаасандаа хадгалаад өөрөө л хэрэглэ! Асгаж үрэгдүүлэлгүй, хав дарж хадгалалгүй, өөртөө шингээх хэрэгтэй! Хэрэв олонд ярьж яваа бол энэ их хүчийг шингээж чадахгүй байгааг илтгэнэ. Ахуй ойлголтоо яривал тун Их Маяагийн саад үүснэ. Сайн ахуй ойлголтой бол түүнийгээ бичиж болно. Бүр шингээж чадахгүй бол Багшдаа ярьж болно. Эсвэл зурвас бичээд Багшдаа илгээж болно. Харин гагцхүү бусдад ярьж л болохгүй. Тэд ойлгохгүй тул хаа хамаагүй дур зоргоороо ярина.

Зарим нэгэн хүнд Багшийн адислах хүчийг дэндүү их өгвөл хүлээн авч чадахгүй тул доорх гурван зүйлийн байдал үүсдэг. Нэгт: адислалын хүчийг асгаж үрэгдүүлнэ, хоёрт: энэ хүчийг дураараа хэрэглэнэ, гуравт: маш их сандарч бачимдана. Өөрөө бясалгадаггүй бол адислалын хүч ирэхэд бачимдаж тэвдээд яахаа мэдэхгүй болдог. Тэгээд хүн амьтан ашиглан загнаж, зодож хэрэлдэнэ. Тиймээс өдөр бүр бясалгах хэрэгтэй. Багшаасаа тусламж гуйн адислал хүсвэл Багш нь хүч өгсөн ч бясалгахгүй бол хэрэглэж чадахгүй.

Ахуй ойлголттой болмогцоо гүйж гараад газар сайгүй ярьж, сурталчилна. Энэ их хүчийг яаж хэрэглэхээ мэдэхгүй тул их уур уцаартай болдог. Авшигтай хүн заримдаа өвчин тусдаг. Энэ нь Их Багшийн хүч түүнийг илүү сайн бясалга, дур зоргоороо бүү яв, гадаад ертөнц рүү сэтгэлээ бага хандуул, хэтэрхий их алдар нэр бүү хүс, хөрөнгө мөнгө, нэр төрийн төлөө хамаг сэтгэл зүрхээ зориулах хэрэггүй хэмээн сануулж байгаа хэрэг юм. Гэсэн ч бид үүнийг нь ухаарч ойлгож чадахгүй, алдар нэр, ашиг хонжоо хөөцөлдөж яваад эцэст нь өвчин тусаж, улмаар Багшаасаа тусламж гуйж ирдэг. Энэ үед нь Багш нь бас туслах хэрэгтэй болно.

Адислалын их хүч ирэхэд яахаа мэдэхгүй амархан уурлаж бухимдана. Учир нь бясалгалаа хийхгүй бол энэ их хүчийг шингээж чадахгүй. Энэ их хүч бие махбод, оюун ухаантай нийцэхгүй бол бид өөрийгөө хянах чадваргүй болно. Зөвхөн аврал тусламж гуйгаад огт бясалгахгүй бол бид явах тусам улам уур бухимдалтай болно. Мөн тэр их хүчийг дураараа ашиглах тул Багш нь туслаад ч нэмэргүй. Тиймээс бид үргэлж Багшдаа даатгаж тусламж гуйгаад байх биш, өөрөө хичээнгүйлэн сайн бясалгах хэрэгтэй. Эс бөгөөс Багш нь тусалсан ч та нар тэр их хүчийг дааж чадахгүй, шингээж дийлэхгүй.

Манай аргатай ойролцоо аргаар бясалгадаг нэг Америк хүн байдаг. Багш нь нэг өдөр түүнд улаан цэцэг өгч гэнэ. Энэ нь жирийн нэг гоё цэцэг биш, харин адислагдсан бэлэг мэт асар их адислалын хүчтэй цэцэг байжээ. Зарим адислалын хүчийг бид зөвхөн өөрөө хэрэглэх ёстой. Заримыг нь болдоггүй. Энэ улаан цэцгийг зөвхөн түүнд өгөөгүй, цааш нь олон хүнд дамжуулах ёстой байжээ.

Нэгэн өдөр түүнийг автобусаар явж байтал хүүхэд дагуулсан настай хүн эсрэг талд нь сууж байж. Тэр хүүхэд улаан цэцгийг ихэд сониучирхан харсан тул түүнд бэлэглэжээ. Уг нь тэр хүү эмээтэйгээ их л томоотой сууж

байсан атал улаан цэцгийг авмагцаа огцом өөрчлөгдөж ямар ч шалтгаангүйгээр энд тэнд үсэрч, зогсоо зайгүй хашгиран үймүүлсэн байна.

Яагаад ингэх болсныг та нар ойлгож байна уу? Учир нь Их Багшийн хүч дэндүү их. Бид түүнийг Буддагийн хүч, Эзэн Бурханы хүч гэсэн ч болно. Их Багшийн хүч үнэхээр гайхалтай. Тэр хүч хүнээр, эд юмсаар, тэр ч байтугай жирийн нэгэн улаан цэцгээр ч дамжиж болно.

Их Багшийн адислалын хүчийг авсан хүний үйлийн үр маш хурдан, бүр дэндүү хурдан өөрчлөгдөх тул зарим хүн үнэхээр тэсэхгүй. Бид Их Багштай, түүний их хүчтэй учирсан бол яагаад ч урдынх шигээ байхгүй. Энэ үнэхээр боломжгүй. Амьдрал чинь лавтай өөрчлөгдөнө, үйлийн үр чинь ч өөрчлөгдөнө. Бүхий л амьдралын хэв маяг чинь ямар нэг хэмжээгээр өөрчлөгдөнө. Жирийн хүнтэй адил байх боломжгүй болж, урдынхаасаа өөрчлөгдөнө. Гэвч ч хүмүүсийн ихэнх нь энэ өөрчлөлтийг ойлгодоггүй.

Нэг энэтхэг тариачин байжээ. Тэрээр тариан талбайдаа ажиллаж байтал нэгэн Төгс Гэгээрсэн Их Багш түүний талбайн хажуугаар тэргэнд суугаад өнгөрч гэнэ. Их Багш тэрэгний цонхоор гадагш харах тэр агшинд тариачин ч түүнтэй харц тулгаран холбогджээ. Удалгүй тариачин эр нас барав. Нас барахын өмнөхөн Төгс Гэгээрсэн Их Багш ирж, түүнийг диваажин луу, баруун зүгийн Төгс баясгалант орон луу авч явахыг хараад өөрийн ах дүүдээ хандан: “Энэ сүрлэг сайхан хүнтэй хэдэн өдрийн өмнө би уулзсан юм. Тэр өнөөдөр намайг диваажин луу авч явна” гэжээ.

Түүний хөрш айлд тэр Төгс Гэгээрсэн Их Багшийн зураг байв. Дээш дагуулан явсан хүний дүр төрхийг дүрслэн ярихад хөрш нь түүнд нэгэн зураг үзүүлээд: “Энэ хүн мөн үү?” гэхэд тэрээр: “Мөн, мөн” гэжээ. Энэ үеэс эхлэн тэд тэр Төгс Гэгээрсэн Их Багшийг мэдэх болсон байна.

Түүний нүд рүү нь ганц хараад л аврагдаж байхад

Түүнээс авшиг хүртсэн та нарын тухайд үнэхээр ярих юм алга. Хэдий тийм ч өөрөө бясалгахгүй Төгс Гэгээрсэн Их Багшийн хүчинд бүх юмаа даатгах нь учир дутагдалтай бөгөөд шудрага биш. Зөвхөн өөрийн сайн сайхны төлөө биш, хамаг амьтны төлөө, энэ дэлхийн төлөө бясалгаж, бясалгалын хүчээ бусадтай хуваалцах хэрэгтэй. Зөвхөн өөртөө, халаасандаа хадгалаад байх биш. Жишээ нь, баян хүн бидэнд мөнгө өгвөл зарж үрэлгүй бизнес хийж, улам арвижуулна. Багшийгаа дагаж суралцаад энэ нэг төрөлдөө Будда болох хэрэгтэй. Энэ нэг төрөлдөө сансрын хүрднээс ангижрах хэрэгтэй. Энэ нэг төрөлдөө төрөл төрлийнхөө үйлийн үр, тогтсон үйлийн үрээ цэвэрлэх хэрэгтэй гэж би та нарт хэлдэг.

Намайг даган суралцвал маш хурдан өөрчлөгдөнө. Тиймээс та нарт тэсэхэд хүнд. Гэхдээ л энэ бүхэн зайлшгүй, бид төрөл төрлийнхөө үйлийн үр, тогтсон үйлийн үр, бас өдөр бүр шинээр үйлдсэн үйлийн үр гээд угаах зүйл тун ихтэй тул удаж яаж болох вэ? Иймээс зарим хүн надтай хамт байх, эсвэл намайг дагаж гэрээс гараад Багшаараа муу үйлийн үрээ цэвэрлүүлэхдээ тэсэхгүй, унаж босож, янз бүр болно. Гэсэн ч хэсэг хугацаанд тэсчихвэл асуудалгүй болох юм.

Энэ төрөлдөө Будда болохоор шийдсэн бол нялх хүүхэд шиг байлгүй хурдан өсөж томрох хэрэгтэй. Хүн болгон л хурдхан Будда болохыг хүсдэг. Үйлийн үрээ шалавхан угаахыг хүснэ. Тогтсон үйлийн үр маань намайг их зовоож байна. Та яагаад хурдхан угааж туслахгүй байна вэ? Тогтсон үйлийн үрийг маань өөрчлөөд өгөөч гэж олон хүн надаас асуудаг. Тогтсон үйлийн үр, төрөл төрлийн үйлийн үр, шинээр үйлдсэн үйлийн үрээ ч бас өөрчлөхийг хүснэ. Хурдхан Будда болохыг хүснэ, билиг ухаанаа ихээр нээж, гэгээрэхийг хүснэ. Их ид шидтэй болохыг хүснэ. Ахуй ойлголт сайтай байхыг хүснэ. Юм бүхнийг хүснэ. Тэгсэн

атлаа Багшаар үйлийн үрээ угаалгах тун дургүй. Угаах үед өвдөхөөс нь айна.

Багш нь хамаг төрөлтнийг олон янзын номоор гэтэлгэдэг. Өдөр бүр чихэр жимс өгдөг бол сайн багш биш. Ойлгов уу? Чамайг ирэхэд тун эелдэгээр: “Та сайн уу, тавтай морил! Өнөөдөр та маш сайхан хувцаслажээ. Энэ жигнэмэгийг идээрэй. Та үнэхээр сайн хүн тул өдөрт таван минут бясалгахад болно, бясалгахгүй байсан ч болно” гэхгүй. Багш хүн ийм байж болохгүй. Ийм байя гэвэл бас болно л доо. Ядах юмгүй. Гэвч бясалгал чинь дэвшихгүй, Бурханы хутагт үтэр түргэн хүрэхгүй, бие даасан хүн болж чадахгүй. Багш нь үргэлж сайхан ааштай байвал та нар юм бүхэн дээр Буддагийн хүч, Их Багшийн хүчинд дулдуйдаад улам сул дорой болно. Эсвэл сүмд очиж модон Бурханд мөргөнө. Эсвэл уул ус, хад чулуунд мөргөнө. Энэ бүхэнд мөргөөд ямар тустай вэ?

Харин бид бясалгаж, өөрөө Будда болох хэрэгтэй. Уул усанд, модон Бурханд, чулуун Бурханд мөргөөд бидэнд юу өгөх вэ? Яагаад бид өөрсдөө бясалгахгүй байна вэ? Уул усанд мөргөх тэр цаг заваа ашиглаад бясалгаж, дотоод руугаа хандан асуудлаа шийдэж, өөрийн мунхаг харанхуйгаас салах хэрэгтэй. Сүмд очиж бурхан сахиусанд мөргөж байснаас өөрийн муу муухай нүгэл хилэнцээ угаан ариусга! Гэртээ нам суун бясалгаж, өөрийн Буддаг хайж, мөн чанартаа ойртохыг хичээ! Ингэвэл хурдан Будда болно. Эсвэл Багштайгаа гурав, долоо хоногийн даяан хийх, надтай хамт бясалгах, хагас бүтэн сайн, баярын амралтын өдрүүдээр Багштайгаа ирж уулзан адислалын хүчийг ахиухан хүртэж болно. Гэвч энд ирэхээр л болчихно гэсэн хэрэг биш. Заавал өөрөө бясалгах хэрэгтэй. Өөрөө бясалгаж урагшлана. Үүний зэрэгцээ Багш нь та нарыг дагуулбал дэвшил чинь арай хурдан. Яг л бясалгаж эхлэхийн өмнөх үе шигээ юу ч хийхгүй байж болохгүй. Хэрвээ та нар Бурханд



мөргөхийг хүсвэл Багш нь мөргүүлнэ. Маани, тарни уншъя гэвэл уншуулна. Ингэвэл та нар их баярлаж, Багш маань их өршөөнгүй шүү, биднийг юу ч хийсэн зөвшөөрдөг гэж бодож магадгүй. Гэсэн ч энэ нь та нарт муу.

Зарим хүн авшиг хүртсэнийхээ дараа алга болчихдог. Учир нь Багш түүнээс бясалгахыг, өөрийнхөө хүчинд тулгуурлан бясалгаж, бие даасан хүн болохыг шаардахаас айна. Тэр үед Арьяабал бодьсадвад даатгаж болохгүй, сүм хийдэд мөргөж болохгүй, мэргэ төлөг хийлгэж, зурхай зуруулж ирээдүйд, маргааш юу болохыг асууж болохгүй.

Сүм хийдийн бодьсадва нар юу гэж хариулдагийг би мэдэхгүй ч их билиг ухаанаас ирэх хариулт бүхэн бидний дотоодод байх тул хэн нэгнээс, гаднаас асуух шаардлагагүй. Хэрвээ бид дотоодоосоо хариулт олвол бусдад сайрхан ярих хэрэггүй. Өөрийн ахуй ойлголтыг замбараагүй ярих нь тун осолтой. Сонсож буй хүний дэс нь тухайн төвшинд хүрээгүй бол ойлгохгүй, тэгээд: “Энэ чинь ямар утгатай вэ? Чи арай хэтрүүлж байна. Би үүнд чинь итгэхгүй” гэнэ. Зарим хүн авшиг хүртмэгцээ гэгээрдэг. Гэвч өөрөө үүнийгээ мэдэхгүй. Гэгээрснийхээ дараа л Багш дээрээ очно гэж ярина. Ихэнх хүний бодол санаа их будлиантай. Харин Багш нь тун энгийн хүн. Зөв бол зөвийг нь, буруу бол бурууг нь шууд хэлнэ. Энэ чинь тун энгийн хариу үйлдэл. Даяан гэдэг нь гэгээрэл, Будда чанарыг хэлж байна. Тэрнээс ойлгохын аргагүй, авиршгүй өндөр, хүршгүй холын хэцүү зүйл огт биш.

Гэгээрэх нь үнэндээ тун амархан явдал. Гэвч хүмүүс дэндүү их ном судар, даяаны түүх уншсан байдаг. Даяаны түүхүүд нь олон ээдрээтэй хэрэг, ном хаялцааны тухай өгүүлдэг болохоор Багштайгаа уулзах үедээ тэд надаар оньсого мэт ном хаялцааныг тайлуулахыг хүсдэг. Би үнэндээ тун шулуухан, илэн далангүй хүн. Гэвч тэд ойлгохгүй. Ном уламжлахыг хүсэхэд нь за маргааш ирээрэй гэвэл уурлаж,

Багш биднийг мэхэлж байна гэнэ. Маргааш ном уламжлах учраас л тэднийг маргааш ир гэсэн хэрэг. Би хэнийг ч мэхлээгүй. Би ер нь элдэв маяггүй энгийн хүн. Хэлмээр юм байвал хэлнэ. Гэвч хүмүүс сэтгэл дотроо юу боддогийг би мэдэхгүй. Би хар, цагааныг хэлвэл тэд дөвийлгөөд нэг том зохиол болгоно. Бодол санаа нь будлиантай болохоор замаа олохгүй, нисваанис нь ихсээд өөртөө улам их асуудал үүсгэнэ.

Би угаасаа маш энгийн хүн. Надад ямар ч нууцлаг зүйл байхгүй. Гэгээрсэн хүн ядарвал унтана, өлсвөл иднэ, юу хэрэгтэй байна, түүнийгээ л хийдэг. Чөлөөтэй, эрх тааваараа, энгийн амьдралаар амьдарна. Ямар ч нууц далд гайхамшигтай, ээдрээ төвөгтэй хэцүү зүйлгүй. Та нар надаас суралцахаар ирэхдээ Багш ямар нэгэн гүн нууцлаг далд зүйл ярина гэж бүү хүс. Багш нь гурав юмуу, долоо хоногийн даяаны үеэр л нилээн гүн гүнзгий нарийн учир ёсыг тайлбарладаг. Тэр үед ярих шаардлага байдаг юм. Гүн нарийн учир ёс заавал ойлгоход хэцүү байх албагүй. Утга нь гүн хэдий ч тун ойлгомжтой байдаг. Хүний хэлсэн ганц өгүүлбэрийг долоо, найм болгон боддог эгэл хүмүүс шиг биш. Миний хувьд нэг нь нэг, хоёр нь хоёр. Харин тэд бол нэгийг гурав болгоно. Их хэцүү.

Бясалгагч хүн ч ялгаагүй. Хурдан Будда болж, Их Багшийн дэстэй больё гэвэл заавал Багшаараа цэгцлүүлж, өнгөлүүлж, зүлгүүлнэ. Ингэж байж л Багштайгаа адил болно. Зарим хүн өндөр дэстэй, төгс төгөлдөр хүн болох дуртай ч Багшаараа үйлийн үрээ угаалгаж, цэвэрлүүлж, арчуулж зүлгүүлэх тун дургүй. Иймээс тэд Багштай хамт байхдаа Түүний зааж сургах аргыг тэсвэрлэдэггүй. Дутагдлаа, сэтгэлийнхээ харыг, бохир муухайгаа Багшдаа харуулах дургүй. Цэвэрлүүлэх сонирхолгүй байдаг. Угаалганд хувцас өгөхдөө бид хир толботой бохир хэсгийг тодорхой сайн зааж хэлэх хэрэгтэй. Бас хувцас нь бүрэн бүтэн байх хэрэгтэй.

Хамгийн бохир, хамгийн муухай хэсгийг нь харахгүй байж магадгүй тул хаанаа их хиртэйг заавал хэлнэ. Тэгвэл тусгай саван хэрэглэнэ. Ингээд нэг угаагаад арилахгүй бол хоёр, гурав дахин угаана. Уг нь ингэх нь хамгийн зөв, гэвч зарим хүн Багшийг даган суралцахаар ирснийхээ дараа Багш нь түүнийг угаан цэвэрлэхэд дургүйцэж, нуугдаад, хар бараан, бохир муухай талаа Багшид харуулахыг хүсэхгүй байдаг. Харин Багшид бүгдийг мэддэг, сайхан сэтгэлтэй, гэгээрсэн нэгэн төгс төгөлдөр хүн гэдгээ л мэдэгдэхийг хүснэ. Тийм бол Багшид шавилах хэрэг байна уу? Эсвэл тань шиг төгс төгөлдөр хүнд би ёсолж багшаа болгох уу? Багш нь та нарт ном зааж зүрхлэх үү? Будда болоход тун амархан. Харин Багшдаа, өөртөө чин үнэнч байж, бие махбод, би гэх үзлээ үл хайхран бүр нэр нүүргүй болохоос ч айхгүй зоригтой байж, Их Багшаар өөрийгөө бүрэн цэвэрлүүлэх хэрэгтэй. Айгаад байвал цэвэр ариун хүн болж чадахгүй. Өөрийгөө хурдан өөрчилж чадахгүй. Бид өөрийгөө өөрчлөх боломжгүй учраас төрөл төрөлдөө энэ л хэвээр байдаг.

Дадал зуршлаа өөрчилж чадахгүй учраас бид үхэж төрөхийн хүрдэнд эргэлдсээр байдаг. Жишээ нь, урдын төрөлдөө нохой байсан бөгөөд ховдог, идэмхий, өдөржингөө хуцаж, хүмүүсийг амар тайван байлгадаггүй байжээ. Энэ төрөлдөө хүн болон төрсөн ч ховдог зан нь хэвээрээ, засаж чадахгүй тул бас л баяр баясгалангүй. Дадал зуршлаа өөрчилж чадаагүй болохоор дараагийн төрөлдөө дахин нохой болон төрж тун магадгүй. Эсвэл өмнө нь маш харгис хэрцгий, омог бардам, найрсаг бус хүн байсан бол энэ удаа дахин хүн болж төрсөн ч дадал нь хэвээр тул Будда, Богд хүн, Бодьсатва болж чадахгүй. Учир нь ижил чанарууд харилцан таталцдаг. Та нар хар л даа, гахай гахайтайгаа амьдарч, хамт хооллож, хамт унтдаг. Хүн хүнтэйгээ гэрлэж, хамт хооллож, амарч, ярьж хөөрнө. Тийм үү? Сэтгэл маань ямар байна, бид тийм болж хувирдаг. Үйлийн үрийн хууль

нь тун шудрага. Тэр бидний авахыг хүссэн зүйлийг л өгнө. Тиймээс бид шийтгүүлээд байгаа юм огт байхгүй.

Бид хүн болохоор байнга алдаа гаргадаг. Харин алдаагаа ойлгоод дахин давтахгүй байвал сайн. Ямар ч алдаа гаргадаггүй, аливааг маш их нигүүлсэл, билиг ухаанаар төгс төгөлдөр хийдэг хамгийн сайн хүн ч үхэж төрөхийн хүрдэнд эргэлдэнэ. Учир нь Их Багш нартай уулзаж, тэд тусалж, их энэрэнгүй, их нигүүлсэнгүй хүчтэй биднийг холбож өгөөгүй бол хийсэн бүхэн маань ямар ч ач тусгүй. Хамгийн цэцэн сэргэлэн, хамгийн энэрэл нигүүлсэлтэй, хамгийн түгээмэл хайртай сайн хүн байгаад ч нэмэргүй, Маяагийн гар хөл болохоос цаашгүй. Энэ үнэхээр хачирхалтай хэрэг.

Нэгэн Төгс Гэгээрсэн Их Багштай учраагүй л бол бидний хийсэн бүхэн ямар ч үнэ цэнэгүй байдаг нь Маяагийн ертөнцийн хатуу чанга хууль юм. Харин Төгс Гэгээрсэн Их Багш биднийг орчлонгийн хамгийн дээд их энэрэл нигүүлслийн хүчтэй холбовол бид гурван ертөнцийг давж, сансрын хүрднээс ангижирна. Тиймээс та нар алдаа гаргасан ч хамаагүй, аажмаар залруулж болно. Харин алдаагаа давтахгүй байх нь хамгийн чухал. Би зөвхөн та нарт л хэлье. Та нар өөрөө өөрчилж чадахгүй учраас Багшийн хүч та нарт тусалж, чамайг хүчээр өөрчилдөг. Ингэж үйлийн үрээ төлөх явц чинь хурдасдаг. Зарим үед тэсэхийн аргагүй болдог ч зүгээр, тэвчих хэрэгтэй. Хэдийгээр бид алдаа гаргасан ч хожим диваажин луу буцаж чадна. Учир нь бид өөрөө өөрчлөгдөхийг хүссэн. Бас Их Багшийн хүч тусалж байна. Бусад хүмүүс хэдийгээр сайхан сэтгэлтэй, ач буян үйлдэж, өглөг өргөж, сахил сахиж, хүлцэл тэвчээрийг дадуулж байдаг ч Арьяабалын аргаар бясалгадаг хүн тэдэнтэй харьцуулахын аргагүй үнэ цэнэтэй. Тиймээс урам хугарч болохгүй!. Энэ бол тун сайхан мэдээ. Учир нь энэ хүчний хувьд бидний хийсэн муу үйлүүд урьд нь үйлдсэн үү, одоо үйлдсэн үү гэдэг нь хамаагүй бөгөөд бид муу үйл

хиймэгц тэр дор нь угаан цэвэрлэдэг. Харин угаан цэвэрлэх явцад нь бид нилээн тавгүйрхэнэ.

Иймээс хамгийн сайн нь бид өөрийгөө гэмтэж сэвтэхээс хамгаалж, шинэ үйлийн үр үүсгэхгүй бол бие махбод болоод аж амьдрал маань тавтай сайхан байна. Энэ хүч бидний сайн мууг үл харгалзан бүх зүйлээ угаан цэвэрлэхэд маань тусалдаг. Учир нь Тэр бол их нигүүлсэнгүй, их энэрэнгүй хүч. Тэрээр ямар ч үйлийн үрийг угааж цэвэрлэнэ. Энэ бол бид бүхний хамгийн дээд, хамгийн чухал хүсэл эрмэлзлэл мөн. Хэрвээ юу ч цэвэрлэгддэггүй, дадал зуршлаа ч өөрчлөх боломжгүй, урьд төрлүүдийн нөлөөллөөс ангижрах аргагүй байдаг бол хэзээ бид Бурханы хутагт хүрэх вэ? Хэзээ бид сансрын хүрднээс гэтлэх вэ? Их энэрэнгүй, их нигүүлсэнгүй хүч байхгүй бол энэ бүхнээс бид салж чадахгүй. Бид төрж өсөөд томрох явцдаа ер нь хийсэн бүхий л зүйлдээ урьд төрлийнхөө үйлийн үрийн нөлөөг мэдсэн ч мэдээгүй ч үргэлж амсаж явдаг.

Бид хүний төрлийг авах бүртээ хийсэн бүхэн, хийсэн хамгийн сайн үйл байсан ч тэр бүхэн үнэндээ юу ч биш байдаг. Хичнээн том буян ч гурван ертөнцийн доторх буянаас цаашгүй. Хүн болон тэнгэрийн төрөлтөн болсон ч сансрын хүрдэнд эргэлдсээр л байна. Энэ их энэрэнгүй, их нигүүлсэнгүй хүчтэй учраагүй бол бид гурван ертөнцөөс ангижрах ямар ч аргагүй. Харин энэ их энэрэнгүй, их нигүүлсэнгүй хүч биднийг бүрэн төгс аварч, бидэнд бүрэн дүүрэн тусална. Бидний үнэхээр сул доройг, өөрөө өөрийгөө өөрчилж чадахгүйг, гурван ертөнцийг давж хүчрэхгүйг маань энэ хүч сайн мэднэ. Тиймээс энэ хүчийг чин үнэн сэтгэлээсээ шүтэн дагаж, дээш татахыг Түүнд зөвшөөрвөл Тэр бидний ямар шийдвэр гаргаснаас үл хамааран дуртайяа хийдэг. Их Багш нар бол өөрсдөө даруй энэ их хүч бөгөөд гадны өөр нэгэн хүч биш. Энэ хүч бол Тэр, Тэр бол энэ хүч. Тиймээс бид Их Багшийг даган суралцвал тэр их хүчтэй

холбогдсон гэсэн үг. Учир нь энэ их хүч нь баригдахгүй, тэмтрэгдэхгүй тул бидэнд түшиг болохын тулд заавал нэгэн дүрсэд хувирах хэрэгтэй. Эс бөгөөс энэ хүчинд бид яаж итгэх билээ? Бид өөрсдөө энэ хүчтэй холбогдох боломжгүй, Их Багш нартай л холбогдоогүй бол, бусдаар бид хэнтэй ч холбогдсон Маяагийн хүчтэй л холбогдоно, жинхэнэ Бурханы хүчтэй, жинхэнэ хамгийн дээд хүчтэй холбогдохгүй.

Бид хүн болж төрснийхөө дараа урд төрөлдөө ямар хүн байсан, юу юу хийж явснаа мэддэггүй нь бидний хувьд жинхэнэ буян хишиг юм. Үүнийг ихэнх хүн ойлгодоггүй. Жирийн хүн өөрийн өнгөрсөн, ирээдүйг мэдэх дуртай. Бясалгагч хүний хувьд өнгөрснөө харж болох ч ирээдүйгээ харах боломжгүй. Жирийн хүний хувьд бол ирээдүйгээ харж болно. Учир нь Бясалгагч хүн ирээдүйгээ өөрчилж байдаг. Бид бясалгалын хүчээр ирээдүйгээ, тогтсон үйлийн үрээ өөрчилдөг. Жишээ нь, үхэж төрөхийн хүрдэнд дахин нэг эргэлдэж нохой, бар болох байсан бол азаар ном уламжлах Их Багштай учирч, түүнийг даган бясалгаад сансрын хүрднээс гэтэлсэн тул дахин нохой, бар болж төрөхгүй болжээ. Иймээс жирийн хүний ирээдүйг харж болно. Харин бясалгагч хүний ирээдүйг харж чадахгүй.

Олон хүн Багшийнх нь заяа төөргийг харахыг хүсдэг. Даанч бүгд буруу байдаг. Багшийн юу нь өвдөж байгаа бол гэхэд ямар ч өвчингүй байна. Ирээдүйд Багшид юу тохиолдох бол гэхэд юу ч гарч ирэхгүй. Багшийг нь энэ дэлхийд мэргэлэх боломжгүй, тэгэхээр миний ирээдүй харагдахгүй юм. Тэгээд ч мэргэ төлөг буулгаж байгаа хүн Багшийнх нь оюун бодол, сэтгэл зүрх хаана байгааг мэдэхгүй. Олон бясалгагчид ийм явдал тохиолдсон юм. Тэд бусдын дэс, ахуй ойлголтыг харж чаддаг ч Багшийнхийг нь яагаад ч харж чадахгүй, энэ бол боломжгүй. Учир нь Багшийнх нь заяа төөргийг энэ дэлхийд мэргэлж чадахгүй.

Хэдийнээ гурван ертөнцөөс гэтэлсэн нэгний дэсийг хэн ч харж чадахгүй бөгөөд түүний зүрх сэтгэл хаана байгааг, юу бодож байгааг, ирээдүй нь яаж өөрчлөгдөхийг ч мэргэлж чадахгүй.

Бясалгагч хүний хувьд яг адил. Та бүхэн авшиг хүртмэгцээ олон ертөнцийг давсан тул жирийн мэргэ-төлөгч юу ч харахгүй. Дэсийн хувьд чамаас өндөр бол хувь заяаг чинь мэргэлж чадна. Та нар авшиг хүртсэн тэр даруйдаа л жирийн хүмүүсээс маш өндөрт гардаг. Тэгэхээр хэдэн арван жил өнгөрсний дараа та нартай адил байх боломжгүй. Та нар Багшдаа, өөртөө итгэлтэй байж үргэлжлүүлэн сайтар бясалгавал хожим нь өөрийнхөө өнгөрсөн, одоо, ирээдүйг харна. Одоо хараад ямар ч нэмэргүй. Жирийн хүн харсан ч хэрэггүй. Төрөл авах бүртээ бид өнгөрсөн төрлүүдээ харах аргагүй байдаг. Өнгөрснөө харж сэтгэл санаа үймрэхгүй болсон нь бидний буян хишиг, бүтээгчийн нигүүлсэл юм. Бид өнгөрсөн төрлийнхөө талаар мэдэхгүй байтал хэдийнээ ийм их зовлон бэрхшээлтэй, олон зүйлд нөлөөлөгдөж, энэ амьдралтайгаа эвлэрч зохирч чадахгүй, ажилдаа түүртэж, амьдралын элдэв асуудлаа шийдэж барахгүй явдаг. Дээрээс нь өнгөрсөн амьдарлаа харвал ямар их зовлонтой болох билээ? Тэр үед тэсэхэд бэрх болж, амьдрал самуурна. Тийм болохоор урд төрлүүдээ харж чаддаггүй нь үнэндээ жинхэнэ буян хишиг. Энэ бол бидний төлөө хийсэн бүтээгчийн хамгийн төгс зохицуулалт болохыг бид сайн ойлгох хэрэгтэй. Учир нь бидэнд нэгэн шинэ билгүүн ухаан, шинэ эхлэл өгч байгаа бөгөөд хэрвээ бид урьд төрлүүдийн амьдралдаа зууралдан хүлэгдэж, жишээ нь, өмнө нь барын төрөл авч байснаа мэдвэл энэ удаа маш их харгис хэрцгий хүн болж, тийм ч сайн сайхан ирээдүй хүлээгээгүй гэж бодоод хүсэл мөрөөдөлгүй, өөрийгөө дорд үзсэн, сайхан ирээдүйг төсөөлж ч үл чадах нэгэн болно. Ойлгов уу? Иймээс өнгөрсөн үеэ харж чаддаггүй нь бидний хувьд

хамгийн сайн хэрэг.

Энэ амьдрал маань бидний хувьд хамгийн эрхэм нандин болохоор бид боломж бололцоогоо бүрэн дүүрэн ашиглаад сайтар бясалган баттай эргэж төрөл авахгүй болох хэрэгтэй. Урьдын төрлүүдийг анхаарах хэрэггүй. Шагжамуни Будда өмнөх төрлүүддээ маш их сайн үйл хийж, өглөг их өргөж, сахил сайн сахиж, хүлцэл тэвчээрийг дадуулж байсныг бид Бурханы шашны ном судраас уншсан. Тэр бол их өглөгийн эзэн байсан. Маш их өглөгийн үйл хийдэг байсан ч бас төрөл төрөлдөө сансрын хүрдэнд эргэлдсээр байсан бөгөөд сүүлийн төрөлдөө ямар ч өргөл өргөлгүй, сахил сахилгүй, өглөөнөөс орой болтол хамгийн сайхан ордонд заларч, эцэг, эхдээ эрхлэхийн дээдээр эрхэлж, юу хүссэнээ эдлэн хамгийн үзэсгэлэнтэй эмэгтэйг хатнаа болгож, олон сайхан бүсгүйчүүдээр хүрээлүүлж, өдөр бүр ертөнцийн жаргалыг эдэлж байсан. Гэтэл тэр яагаад хамгийн сүүлийн төрөлдөө Бурханы хутагт хүрсэн бэ? Учир нь тэр хамгийн сүүлийн төрөлдөө үнэн ёсыг жинхэнээсээ хайсан юм. Үнэнийг хайхын тулд юу хийх ёстойг жинхэнээсээ ухаарсан бөгөөд маш сайн багштай учирч, өөрөө чин сэтгэлээсээ бясалгасан учраас амжилтанд хүрч чадсан. Эндээс бид өглөг өгөөд бурхан болохгүйг, бурханд мөргөөд сахиусанд мөргөөд Шагжамуни Буддагийн урьдын төрлүүддээ хийж байсантай яг адил зүйлсийг хийгээд үнэндээ ямар ч тус нэмэргүйг ойлгож болно. Гэвч бид одоо Бурхан Багшаас суралцахдаа бүгдийг мартаж, өглөг өгвөл Бурхан болж чадна, ач буянтай өөр ямар нэгэн зүйл хийвэл Бурхан болж чадна гэж бодох болжээ.

Зургадугаар үеийн их багш Хүй Нэн хийсэн гавьтай юмгүй ч үтэр түргэн Будда болсон бөгөөд ямар ч судар ном уншаагүй, ямар ч Бурханд мөргөөгүй, ямар нэгэн нарийн төвөгтэй аргаар бясалгаагүй, ямар нэгэн гарын мутарлагаар ер бусын нууцлаг зүйлс хийгээгүй. Гэвч тэр даруйдаа



билиг нь нээгдэж Будда болсон. Яагаад вэ? Учир нь үнэн ёс гэдэг тийм энгийн. Эзэн Бурханы хүч, Буддагийн хүч Хималайн ууланд бус та бидэнд өөрт маань байгаа. Гагцхүү бид харахгүй, мэдэхгүй байна. Түүнээс биш энд ч бий, тэнд ч бий. Заавал холын газраас Бурханыг хайж, Хималайн уулнаас Эзэн Бурханыг эрж, их өглөг өргөж, буян хийж, Бурханыг хахуульдахыг санаархах хэрэггүй. Энэ бүхэн бүгд боломжгүй зүйлс. Будда болох нэг нь шуудхан Будда болдог. Энэ нь бидний хийсэн буян хишигтэй ямар ч холбоогүй. Тиймээс Их Багш нар энэ дэлхийд залрахдаа биднийг энэрэл нигүүлсэл ихтэй өглөгийн эзэн болохыг, Их номын багш болохыг, их эрдэмтэн болж, аварга том сүм дуган барьж, өдөр бүр бурханд мянга мөргөж, тарни түм унших хэрэгтэй гэж заагаагүй. Үнэндээ тийм биш. Их Багш Хүй Нэн тарни уншиж, бурханд мөргөж, гарын мутарлага хийж байсан гэж би ер сонсоогүй. Энэ бүхэн бол гадна талын өнгөц явдлууд. Дотоодын бурхан чанартай ямар ч холбоогүй. Ийм чухал зүйлийг та нар заавал ойлгох ёстой.



## **ЖИНХЭНЭ ШҮНШИГЛЭН АРАВНАЙЛАХУЙ**

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Формоса, Тайнан хотын Мадөү-д  
1988 оны 2 дугаар сарын 13  
(Эх нь хятад хэлээр)*

Багш нь та нарыг ахуй ойлголтоо ярихыг хориглодог. Учир нь хүмүүс та нарыг гүтгэж муулахаас, өөрийн чинь бардам зан хөдлөхөөс эмээдэг. Ер бусын гайхамшигт ертөнц, Бурхад бодьсадва, гэрэл зэрэг энэ дэлхийн байдалтай огт адилгүй зүйлсийг яривал бясалгалын дотоод ахуй ойлголтгүй хүмүүс юу ч ойлгохгүй тул та нарыг этгээд гаж бодол сэтгэлтэй гэж бодно. Бодьдармаа багш ч бас ахуй ойлголтоо ярихгүй байхыг хүмүүст сануулж байсан. Тэрээр Дарма –Судал залгамжлалын онол судартаа энэ талаар маш тодорхой өгүүлж: “Нарны гэрлээс хэтийдсэн их гэрлийг олж үзэх үед урьдын дадал даруй устана. Тэр үед мөн чанараа үзэж гэгээрнэ. Ийм ахуй ойлголттой болсон бол өөрөө л мэдэхээс бусдад бүү өгүүл” гэжээ. (эх зохиолд: Харсан гэрэл тань нарнаас давсан байх аваас урьдын дадал үтэр арилж номын ертөнцөөс чанараа олж үзнэ. Хэрэв ийм явдал болбоос энэ нь Бурханы хутагт хүрснийг илтгэх ба зөвхөн өөрөө мэдэхээс бусдад өгүүлж үл болно.)

Нарнаас ч илүү их гэрэлтэй төвшнийг харах төдийгүй манай ертөнцөөс огт өөр олон төвшин байдгийг мэдэх болно. Хэрвээ энэ бүхнийг энэ ертөнцийн хэлээр яривал хүмүүс биднийг буруугаар ойлгож, гүтгэн буруушааж, яршиг төвөг удаж, маш их саад тотгор учруулна. Үүнээс гадна бас дүрс үгүй төрөлтнүүдийн атаархал бидэнд ад четгөрийн саадыг бий болгоно. Тиймээс бясалгалын ахуй ойлголтоо бусдад ярьж болохгүй. Харин: “Нададахуй ойлголт бий. Арьяабалын аргаар бясалгадаг бусад хүмүүс ч бас ахуй ойлголттой” гэж болно. Энэ нь бусдад урам зориг өгөхийн төлөө юм. Харин: “Би ийм тийм зүйлс харсан, Миний дэс ийм тийм төвшинд хүрсэн” гэх мэтээр нарийн ширийн зүйлээ яриад хэрэггүй. Багш л зөвшөөрөөгүй бол өөрийн дотоод ахуй ойлголтыг бусдад ярьж мэдүүлэхгүй байх нь хамгийн зөв.

Заримдаа бид ахуй ойлголттой байгаагаа мэддэггүй. Та нар Арьяабалын аргаар бясалгаад ийм байдалд орж байсан уу? Заримдаа унтаж байхад эхнэр, нөхөр хэн нэг нь гэнэт дуудан сэрээх тэр агшинд ямар нэг төвшнийг алдсан мэт, өндөр дэсээс унасан мэт ахуй ойлголт байсан уу? (байсан гэж маш олон хүн хариулав) Олон хүн толгой дохив. Надад ч гэсэн тохиолдож байсан. Эхнэр, нөхөр биш харин гаднын дуу авианд цочин сэрээд ийм байдалд орсон. Гүн самадид орж маш өндөр төвшинд хүрэх үед бидний оюун санаанд юу ч хадгалагдахгүй. Тэр бол зөвхөн гурван ертөнцийн доторх ахуй ойлголтыг л бичиж буулгана, харин гурван ертөнцийн гаднах ахуй ойлголтыг бичиж буулгаж чадахгүй. Жишээ нь, нэгэн цэргийн дарга хүн тусгай жолоочтой. Жолооч нь түүнийг ерөнхийлөгчийн ордонд хуралд хүргэж өгдөг. Харин даргатайгаа хамт ордонд орж болохгүй. Түүний үүрэг бол зөвхөн даргыгаа ордонд хүргэх. Дарга нь бусад дарга нартай хамт улс орны хэрэг явдлыг хэлэлцэхэд хамт орж болохгүй гэдгээ тэр сайн мэднэ. Тийм болохоор дарга нь ямар хуралд суусан, юу хэлэлцсэнийг огт мэдэхгүй.

Дарга нь ч түүнд хэлэхгүй. Та нар бясалгалын жаахан ахуй ойлголттой болмогцоо даруй бусдад ярьдаг. Энэ нь тун доогуур дэсийн ойлголт байвал бясалгал өндөртэй хүнд инээдтэй сонсогдоно. Тэд “Олигтой ч бясалгаж амжилгүй жаахан ахуй ойлголтоо өндөр дуугаар ярьж яваа нь хэтэрхий бардам зантайн шинж гэнэ. Бясалгадаггүй, эсвэл бясалгалын дэс доогуур хүн сонсвол дотоодын иймэрхүү ахуй ойлголт тэдэнд огт ойлгомжгүй тул хачин жигтэй яриатай хүн гэж чамайг тохуурхана. Тиймээс ахуй ойлголтоо ярих хэрэггүй. Та аль хэдийн Бурханы хутагт хүрсэн бол өөрийгөө “Түүнчлэн ирсэн” гэж болно.

Шагжамуни Будда өөрийгөө “Түүнчлэн ирсэн” гэж хэлсэн нь бардамнасан явдал бус, харин жинхэнэ бодит үнэнийг хэлжээ. Сургуулиа төгссөн бол төгсчихлөө гэнэ. Жишээ нь, бид анагаах ухааны их сургуулийг төгсвөл эмч болно. Харин сахил хүртэж, гэрээс гарвал гэлэн, гэлэнмаа болно. Гэртээ байгаа хүн бодьсадвагийн сахил хүртсэн бол би хэдийнээ бодьсадвагийн сахил хүртсэн тул гэрээс гараагүй бодьсадва болов гэж болно. Ингэж дуудах нь үнэндээ тун энгийн явдал. Гэтэл яагаад өөрийгөө Будда гэж хэлж зүрхлэх хүн байхгүй байна вэ? Учир нь тэд Бурханы хутагт хараахан хүрээгүй байна. Хүрсэн бол тийм хүн тун цөөн маш ховор.

Хэрвээ хэн нэгэн хүн өөрийгөө Будда боллоо гэвэл бид тун их цочиж, ад чөтгөр л биш бол хэн ч өөрийгөө Будда гэж зүрхлэхгүй гэж бодно. Энэ нь бид Будда болж чадаагүй байхад та яагаад болчихов? Яагаад биднийг хүлээж хамтдаа Будда болсонгүй вэ? гэсэн санаа. Гэтэл хамаг төрөлтний дэс өөр өөр, нэгэн зэрэг Будда болох боломжгүй юм. Учир нь зарим нь хурдан, зарим нь удаан суралцдаг тул яаж хүлээх вэ? Зарим хүний Будда болохыг хүлээвэл бусад төрөлтнийг гэтэлгэж чадахгүйд хүрнэ. Тэд биднийг хурдан ирж авраасай хэмээн хүсэн хүлээж байдаг.

Тиймээс Бурханы хутагийг бүтээе гэвэл хурдхан бүтээ. Хэнийг ч хүлээх хэрэггүй. Хэрвээ бусдыг хүлээвэл амжихгүй. Будда болсныхоо дараа хэнийг ч гэтэлгэж болно. Үнэн ёсыг хараахан олж чадаагүй байгаа тэр хүмүүсийг ч гэтэлгэнэ. Будда болох нь Энэтхэгт нилээд жирийн хэрэг байдаг. Магадгүй Энэтхэг нь үеийн үед бясалгалын ариун дагшин газар байсан, мөн тэндхийн хүмүүс Бярманы шашны нөлөөгөөр багаасаа ургамал хоол идэж, сахиус, гэгээнтнүүд, урьдын Төгс Гэгээрсэн Их Багш нарт мөргөж байдаг. Тийм болохоор тэндхийн байдал тун сайхан эерүү зөөлөн. Үүнээс гадна энэтхэгт хадгалагдаж үлдсэн бясалгалын уламжлал нилээд их. Одоо ч тэд маш олон янзын аргаар бясалгадаг. Эдгээр аргуудын тухай Ау Лак, эх газрын Хятад, Формоса, Япон, Солонгост урьд өмнө нь огт сонсоогүй. Энэтхэг, Төвөдөд урьдын уламжлалаа хадгалан үлдэхэд нилээн сайн анхаардаг болохоор бясалгалын эртний аргуудын дамжилга тасралгүй өнөөг хүртэл уламжлагдсаар иржээ. Хэрвээ бид үүнийг нь ойлгоогүй бол тэднийг буруу номоор бясалгаж байна гэнэ.

Гадаад номтон гэж юу вэ? Үнэн ёсыг эрж олохоос өмнө бүгд гадна талд, хажуугийн хаалганд, үүдний гадна байж, дотогш нэвтэрч чадаагүй байдаг. Энэ номын аймагт ороогүй, аялгууны урсгалд нэгдээгүй, гэрэл үзэж амжаагүй, дээд дэсийн ертөнцийн ахуй ойлголтгүй бол гадаад номтон юм. Гэхдээ гадаад номтон гэдэг нь ямар нэгэн муу хүн биш. Үнэн ёсыг олж чадаагүй, энэ үүдээр ороогүй байхдаа би ч бас гадаад номтон байсан. Эхээс төрөөд л гадаад номтон байв. Төрөлхийн гадаад номтон. Тиймээс одоо хэн нэгэн хүн намайг гадаад номтон гэвэл, би түүнд: “Тийм ээ, зөв. Угаасаа л гадаад номтон” гэж хэлнэ. Одоо жаахан гэгээрэлд хүрсэн ч түүнийгээ паспортон дээрээ бичээгүй, ямар нэгэн нэр шошго хадаагүй болохоор энэ хүн одоо дотоод номтон болсныг тэд ойлгохгүй. Би төрөлхийн гадаад номтон. Тэр ч

байтугай би гучин нас хүртлээ гадаад номтон байсан. Махан биенд байгаа бол гадаад номтон. Диваажинд, ариун оронд очиж чадсан нь дотоод номтон болно.

Өчигдөр Багш нь шүншиглэн аравнайлах тухай ярьсан. Харин өнөөдөр энэ шүншиглэн аравнайлах ёс заншил яагаад бий болсныг тайлбарлая. Та нар сонсмоор байна уу?(сонсьё гэж бүгдээрээ хариулав ) Эрт цагт энэтхэг оронд Төгс Гэгээрсэн Их Багшид шавилан суралцвал, суралцаж дууссаны нь дараа Багш нь шавь нарын дундаас нэгийг нь залгамжлагчаар сонгодог. Гэвч залгамжлагч сонгох нь тун хэцүү явдал. Хатуу чанга шалгалтанд олон удаа орох ёстой бөгөөд тухайн хүнийг тэсч тэсвэрлэхийн аргагүй болтол сорино. Тэр үед л ямар шавь залгамжлагчаар сонгогдохыг мэдэж болно. Тэрээр маш өндөр дотоодын ахуй ойлголттой ч гадаад намба төрх, итгэл бишрэлийнхээ бат бэхийг олон янзаар шалгуулна. Ингэвэл хожим гадагш гарахын цагт зүйл бүрийн үймээн самууныг тэсвэрлэж, бусдын гүтгэн гүжирдэх, дайсагнан хорлохыг хүлцэн тэсэж, хүлээн авч чадна. Тиймээс бат тууштай, эр зоригтой, тэсвэр тэвчээртэй байх хэрэгтэй.

Зөвхөн юу ч хийсэн түүнийгээ бүрэн гүйцэд хийхийг тэсвэр тэвчээр гэхгүй. Зөвхөн ийм санаа биш. Хэн ч юу ч гэж гүтгэж муулсан хамаагүй үргэлжлүүлэн номоо дэлгэрүүлсээр байх нь жинхэнэ тэсвэр тэвчээр мөн. Гүтгүүлж буруутгагдсан ч эмзэглэн нуугдахгүй. Гадаад номтон гэж хэлүүлсэн ч үтэр түргэн далдлан нуугдахгүй. Хүмүүс ингэж ярих нь надад ичмээр байна. Одоо би явж ном тайлж зүрхлэхгүй гэх биш. Магтан сайшаах, гүтгэн муулах хоёр үнэндээ яг ижил. Магтсан ч үргэлжлүүлэн номоо дэлгэрүүлнэ . Муулвал бүр сайн дэлгэрүүлэх хэрэгтэй.

Учир нь тэр гүтгэн буруутгагч хүмүүс ч бас Бурхан бодьсатва юм. Тэдний зүгээс учруулж байгаа саад тотгор тус нэмэр ихтэй байдаг. Яагаад вэ? Учир нь ном хүртэх ёсгүй

хүмүүсийг холхон байлгадаг юм. Ойлгов уу? Тэр, тэр гадаад номтон гэж хүмүүсийн шүүмжлэх ярихыг сонсоод итгэдэг хүнд ном зааж ерөөсөө болохгүй. Тийм хүмүүст ном заавал яршиг төвөг маш ихтэй. Тэд хүний хэлсэн ганц үгэнд шууд итгэдэг. Тэдэнд үнэн худлыг дэнслэх билиг ухаан байхгүй. Ийм хүмүүсийн ирэх зам гадна талд хаагдах нь тодорхой. Тэр, тэр бол гадаад номтон гэж зарлан сурталчилж явдаг болохоор дэл сул үг сонсох дуртай хүмүүс үгэнд нь даруй үнэмшээд аяндаа ирж ном сонсохгүй, ном сурах хүсэлгүй болдог. Тиймээс гүтгэн муулагчдыг ийм ажил хийдэг тул муу хүн гэж бас хэлэхийн аргагүй, тэдний тус нэмэр их. Харин ч эсрэгээрээ тэдэнд талархах хэрэгтэй. Нүүрэн дээр ил тод гүтгэн муулаагүй тул тэдэнд талархах завшаан надад олдсонгүй. Хэрвээ тэдэнтэй таарвал та бүхэн Багшийнхаа өмнөөс талархаарай.

Хамаг амьтныг гэтэлгэнэ гэдэг үнэхээр амаргүй ажил. Тэдний уг язгуур адилгүй тул түүнд нь тохируулан заах хэрэгтэй. Шагжамуни Будда энэ ертөнцөд заларч байхдаа (Богдосын ном цагаан лянхуа судар)-ын номын хурал хийжээ. Тэр үед таван мянган хүн Түүний номын хурлыг орхин явсан гэдэг. Энэтхэг бол бясалгалын ариун дагшин газар. Маш олон хүн багаасаа ургамал хоолтон болдог. Гэвч номын хурлыг орхин явсан тэр гэлэн, гэлэнмаа нар Шагжамуни Буддаг гүтгэн буруутгасан юм. 2500 жилийн өмнө Энэтхэгт хүртэл байдал ийм байжээ. Тэгэхээр одоо энэ цаг үе ч аргагүй юм даа. Тиймээс гүтгэн муулагч бол их бодьсдва юм. Та нар тэдэнтэй сөргөлдөх хэрэггүй. Харин ч Багш маань та нарт тун их талархаж, шинэ жилийн мэнд зүйргэж байна гэж хэлээрэй.

За одоо Энэтхэгийн талаар ярилцъя. Төгс Гэгээрсэн Их Багшийн залгамжлагч болохын өмнө Багш нь түүнийг маш хэцүү, хатуу олон аргаар сорино. Би өөрийн туулсан зүйлээ ярихгүй ээ. Яривал та нарын цагийг үрнэ. Үнэндээ

бас сорилт шалгалт гэмээр юмгүй. Тухайн үедээ шалгагдаж байгаагаа ч мэдэхгүй. Хийх ёстойгоо зүгээр л хийнэ. Шалгуулж байгаагаа мэдвэл: “За тэснэ шүү. Маргааш гэхэд л бүхэн юм дуусна” гэж бодно. Шалгагдаж байхдаа огт мэдэхгүй. Мэдвэл ямар ч шалгалт үгүй болно.

Тун олон шалгалт сорилтыг заавал давж, залгамжлагч болдог. Гэвч шалгалтанд тэнцсэний дараа Төгс Гэгээрсэн Их Багш хуврагуудыг цуглуулаад: Энэ залгамжлагчийг та нар зөвшөөрөх үү? Түүний ахуй ойлголт, ёс суртахуун, тэсвэр тэвчээр, даруу зан зэргийг танилцуулаад дотоод сэтгэл нь хоосорч, би гэх үзэлгүй болсон тул түүнийг сонгосон гэдгээ тайлбарлана. Залгамжлагч болж буй тэр шавь нь хэдийнээ Төгс Гэгээрсэн Их Багштайгаа адил дэстэй, адил ахуй ойлголттой болсон эсэхийг хатуу чанд хянан тогтоосны дараа залгамжлагчаар сонгоно.

Энэтхэгт зандан модыг нэгэн зүйлийн нунтагтай холиод будаг гаргаж авдаг. Энэтхэгт шар, улаан өнгөтэй онцгой төрлийн будаг бий. Энэтхэгийн бясаллагч хуврагууд ийм тусгай будгаар хувцсаа буддаг. Тэд будсан даавуу худалдаж авахгүй. Хятад даавуутай адил энгийн цагаан даавууг аваад өөрөө будаад өмсөнө. Залгамжлагч сонгох үед ийм будгийг зандан модны нунтагтай холиод билгийн мэлмийд нь түрхдэг. Ингээд түүнийг залгамжлагч болохыг хүлээн зөвшөөрнө. Энэ бол эртний энэтхэгийн залгамжлагч сонгох ёслол бөгөөд бараг гурван зуун жилийн дараа ч хадгалагдсаар байсан. Одоо нэгэнт үгүй болжээ. Одоо бол нүд рүү нь хараад яриад л болно. Үүнийг би нэгэн түүхээс олж уншсан юм.

Энэ ёслолоор түүнийг Будда болсон гэдгийг хүн бүхэн харж, мэдэж авдаг. Будда гэдэг нь Төгс Гэгээрсэн Их Багш гэсэн утгатай. Хойшид Тэрээр Багшийгаа төлөөлөн үргэлжлүүлэн ном дэлгэрүүлнэ. Нэгэн Төгс Гэгээрсэн Их Багшийн шавь нарын дунд гарамгай сайн шавь олон



байдаг ч зөвхөн нэг л шавийг залгамжлагчаар сонгоно. Тэгээд түүнийг Будда буюу Төгс Гэгээрсэн Их Багш хэмээн өргөмжилнө. Тэр Төгс Гэгээрсэн Их Багш ном дэлгэрүүлнэ. Түүний мэтгэлцэх чадвар онцгой сайн, үг хэл нь хурц тод, ярьсан учир ёс хэнд ч ойлгомжтой байх ёстой. Ерөнхийдөө түүнээс харьцангуй олон сайн чанаруудыг шаарддаг. Бусад шавь нарын дотоодын ахуй ойлголт нь түүнтэй ижил хэдий ч биеэ авч явах байдал бүрэн төлөвшөөгүй, мэтгэлцэх чадвар тааруу, хэл ярианы баялаг муу, ёс учрыг нэвтэрхий сайн тайлбарлаж чадахгүй гэх мэтээр дутуу.

Тиймээс Төгс Гэгээрсэн Их Багшийг бид төгс төгөлдөр хэмээн магтан сайшаадаг. Учир нь хамгийн төгс төгөлдөр хүн л сонгогддоогоос тэр. Тиймээс Шагжамуни Буддаг бид хүний санаа сэтгэлийг амирлуулагч хэмээдэг. Тэнгэрийн төрөлтнүүдэд жолоодогч багш байдаг эсэхийг бид нотолж чадахгүй. Зөвхөн шавь нар л мэднэ. Бидний сүнсэн бие дээшилж диваажинд очиход Багш маань тэнд ном айлдаж, тэнгэрийн төрөлтнүүдийг сургаж байхыг харна. Зөвхөн хүн төрөлтөнд ном айлдахгүй. Тэр үед бидний Багш бол тэнгэрийн болоод хүмүүн төрөлтний жолоодогч Багш мөн гэж багшийгаа магтан сайшаадаг. Жирийн хүмүүс үүнийг ойлгохгүй тул та яагаад Багшийгаа ингэж их магтана вэ? гэж бодно.

Учир нь тэрээр дотоодын ахуй ойлголттой ч түүнийгээ ярих аргагүй. Иймээс бид Шагжамуни Буддаг тэнгэрийн төрөлтний багш хэмээдэг. Учир нь түүний шавь нар диваажинд хүрч, Багшийгаа ном айлдаж байхыг харж, Багшийнхаа дэсийг мэджээ. Тиймээс Шагжамуни Будда бол тэнгэрийн төрөлтний багш хэмээн магтжээ. Үүнээс гадна Будда өөр олон нэртэй. Учир нь Төгс Гэгээрсэн Их Багшид тун олон чанар бий. Тэнгэрийн төрөлтний багш төдийгүй хүн биендээ туйлын төгс төгөлдөр, элбэрэл энэрэлтэй, цэцэн ухаантай, гоо үзэсгэлэнтэй, мэтгэлцэх чадвартай, нүүрийн

буянтай бөгөөд хаана ч явсан хүн бүхний хайрыг татна. Харин хаана ч явсан хүмүүсийн дургүйг хүргэдэг над шиг, Багш шиг нь биш. Үнэндээ надад дургүй нь цөөхөн хэд. Тэд дургүй биш. Тэд бол ном хамгаалагчид юм.

Арьяабалын бясалгалын аргаар бясалгах хэмжээнд хүрээгүй хүмүүсийн ирэх замыг хаах нь тэдний ажил гэж Багш нь дөнгөж сая ярьсан. Яг л Девадеттай адил. Шагжамуни Будда түүнийг их ном хамгаалагч гэсэн. Тодорхой сайн ойлгох хэрэгтэй. Энэ бол зөвхөн яриа төдий зүйл биш. Тэд бол үнэхээр Бурхан бодьсадвагийн зохицуулалтаар ирсэн ном хамгаалагчид юм. Ойлгов уу? Хэрвээ хожим хэн нэг хүн Багшийг нь гүтгэн буруутгавал түүнд тодорхой сайн тайлбарлаж өгөөд найзалж нөхөрлөн, цай кофегоор дайлж, хамт хооллоорой. Тэгээд түүнд: “Баяр хүргэе! Та бол Бурхан бодьсадвагийн зохицуулалтаар ирсэн их ном хамгаалагч байна” гээрэй.

Багшийнхаа өмнөөс түүнд талархал илэрхийлэх хэрэгтэй. Учир нь хамаг төрөлтөн дэндүү олон болохоор тэднийг бүгдийг гэтэлгэж барахгүй. Нэг хэсэг нь заавал энд үлдэж дараа ирж гэтэлгэхийг хүлээх хэрэгтэй. Эс бөгөөс биднийг дахин энд ирэхэд хүнгүй болно. Энд хэн ч байхгүй бол бид бас ирж чадахгүй. Бурхан бодьсатва заавал эмэгтэй хүний умайгаар дамжин бууж ирэх тул хүн байхгүй бол бид дахин яаж ирэх вэ? Хэрвээ бид ирэхгүй бол чулуу, модноос төрөл арилжин дөнгөж хүний төрлийг ологсодыг хэн гэтэлгэх вэ? Чийгийн улаан хорхой, жижиг шувуу, намгийн мэлхийнээс төрөл дээшилж хүн болон төрөгсөдийг хэн гэтэлгэх вэ? Өвс ногоо ч хожим нь хүн болон төрөх тул тэднийг гэтэлгэх хүн заавал ирэх хэрэгтэй. Ойлгов уу? Иймээс бусдыг гүтгэн муулдаг тэр “ном хамгаалагчид” заавал энд үлдэх учиртай. Тэд бас үлдэхгүй байхын аргагүй. Хэдийгээр тэд ном хамгаалагч ч боловч маш муу, муухай ажил хийсэн тул заавал үлдэж, угаан цэвэрлүүлнэ.

Бид ямар үйл хийнэ, тийм үрийг эдэлдэг. Тэд ном хамгаалсан ач буянтай тул үйлийн үр эдлэхгүй гэж болохгүй. Мэдээж тэд хожим бодьсатва болно. Гэхдээ үйлийн үрээ заавал төлж дуусгахаас нааш бодьсатва болохгүй. Эс бөгөөс үйлийн үрийн хууль оновчгүй болно. Девадет бол их бодьсатва, Шагжамуни Будда түүнийг бас магтан сайшаасан хэдий ч тэр заавал тамдунана. Учир нь тэр ямар нүгэл үйлдсэн түүнийхээ үрийг эдлэх ёстой. Тэр их бодьсатва учраас муу үйл хийсэн ч сайн үрийг эдэлвэл үйлийн үрийн хууль самуурна шүү дээ. Тийм байж болохгүй. Муу үйл хийвэл муу үр амсах нь тодорхой. Иймээс бодьсатва төрөлтөнд энэ дэлхийд бууж ирэх нь тун осолтой юм. Хянуур болгоомжгүй явбал нүгэл хилэнцтэй үйл хийж, сансрын хүрдэнд маш удаан эргэлдэнэ. Гэвч зарим хүн ийм ажил хийх дуртай байж магадгүй. Тиймээс бид тэднийг бас хорьж болохгүй. Энэтхэгийн уламжлалаар онцгой ёслол үйлдсэний дараа билгийн нүдэн дээр нь тусгай будаг түрхмэгц Будда болдог. Будда болсны дараа түүнийг Их Багш, Багш, Төгс Гэгээрсэн Их Багш, Будда хэмээн нийтээрээ хүлээн зөвшөөрнө. Энэтхэгт ийм уламжлалт аргаар шүншиглэн аравнайлдаг. Аравнайлсны дараа Будда болно. Будда болоогүй байсан бөгөөд энэ шүншиглэн аравнайлах ёслолоор сая Будда болж байгаа хэрэг биш. Харин энэ үед нийтээрээ Түүний байр суурийг хүлээн зөвшөөрч байгаа хэрэг. Түүнийг тойрон гороолж, Багштайгаа одоо адил болж, Түүнийг залгамжилж, Багшийгаа явсны дараа ажлыг нь үргэлжлүүлэн хийнэ. Эсвэл Багшийгаа хөгширч, тэтгэвэрт гарсны дараа Тэрээр олны өмнө гарч, ном айлдахад бүгд түүнийг хүндэлж, Багштай нь адилхан шүтэн биширнэ. Шүншиглэн аравнайж Будда болгоно гэдэг нь ийм учиртай. Ойлгов уу?

Авшиг хүртэхэд мөн шүншиглэн аравнайлна. Тиймээс та нар гэрэл хардаг. Энэ бол жинхэнэ шүншиглэн аравнайлах бөгөөд бидний бурхны мэлмийг нээсэн тул адилгүй

төвшнүүдийг харжээ. Бид дээд төвшнийг ерөөсөө харж байгаагүй. Учир нь бидний нүд нээгдээгүй байсан. Харин одоо бидний нүд нээгдэж харах боломжтой болжээ. Үүнийг л шүншиглэн аравнайлах гээд байгаа юм. Энэтхэгт өмнө нь бас ийм байсан бөгөөд аравнайлсны дараа гуравдагч мэлмийд нь зандан модны нунтаг түрхэнэ. Энэ нь тухайн хүн авшиг хүртэж гэгээрснийг илэрхийлдэг. Тиймээс энэтхэг эмэгтэйчүүд бурхны мэлмий, билгийн нүдэндээ улаан тэмдэг тавьдаг. Эрчүүд нь ч мөн адил. Гэвч одоо энэ нь улам цөөрсөөр байна. Тэдний ингэж түрхэх нь одоо бол утгагүй болсон. Өдөр бүхэн чулуун бурханд мөргөсөн хэвээр. Харин бид чулуу, модыг сийлээд дараа нь мөргөдөг болохоор арай “соёлтой” юм даа. Тэд бол чулууг бүхлээр нь гэртээ авчраад шууд мөргөнө. Энэ нь тэдний Бурхан, тэдний Эзэн Бурхан болно. Мөргөж дуусаад өөрөө билгийн мэлмийдээ улаан будаг түрхэнэ. Тэгээд өглөөний уншлагаа уншаад ажилдаа явна. Орой тарж ирээд нүүр гараа угааж, хувцсаа солиод өнөөх чулуундаа мөргөж, дараа нь дахин улаан будаг билгийн мэлмийдээ түрхээд өдөр бүр гэгээрч байгаагаа илэрхийлнэ.

Одоо бол эмэгтэйчүүд билгийн мэлмийдээ улаан будаг түрхэж, гэрлэсэнээ илэрхийлэхээс өөр утгагүй болсон байна. Эрчүүд улаан будаг түрхэх нь өглөө, оройн уншлагаа уншсан гэсэн санаа. Эсвэл тэд ямар нэгэн газар олон хүнтэй хамт очиж мөргөл үйлдвэл, мөргөсөн бүх хүнд хэн нэг нь будаг түрхэж, мөнгө тараана. Энэ бүх сийлсэн мод, чулуу ямар ч үүх түүхгүй. Бас дотоодын гэрчлэл гэх юмгүй. Зөвхөн өнгөн талын илэрхийлэл тул тэд яагаад ингэж үйлддэгийг бид бас таах аргагүй. Энэ нь шүншиглэн аравнайлах ёслолын үүсэл болсон байж магадгүй юм.

Модон бурхныг номын багш аравнайлаагүй бол түүнд мөргөөд ямар ч зөн мэдэл төрөхгүй гэж жирийн хүмүүс боддог. Би аравнайлахыг харж байгаагүй тул тэдний яаж

хийдгийг мэдэхгүй. Багшид нь тийм олон чадвар байхгүй. Би модыг бурхан болгож чадахгүй тул та бүхнээс уучлал гуйя. (Бүгд инээлдэв.) Ер нь би модыг бурхан болгодог аргыг сурах хэрэгтэй юм байна. Тэгвэл хүмүүс намайг гадаад номтон гэхгүй болно. Учир нь бүгдээрээ л ийм зүйл хийдэг, тийм биз?

Модыг сийлж дуусаад духан дээр нь дарж, нүдийг нь нээн бурхан болгоно. Та нар боддоо. Багш нь ингэж чадах уу? Чадна. Гэвч би ингэхгүй. Учир нь мод бол хүн биш. Мод, хүн хоёр асар их ялгаатай. Бидэнд ялгаварлах үзэл байгаа юм биш. Хүн бол хүн. Мод бол мод. Хэдийгээр төрөлтөн бүхэн бурхан чанартай ч, мод бол мод л юм. Мод маш урт хугацааны дараа хүний төрлийг олно. Тэр мэлхий, чийгийн улаан хорхой, шувуухай гэх мэт олон төрлийн жижиг амьтдын төрлийг дамжин авч, олон номын ёсыг сурах хэрэгтэй. Наян дөрвөн мянган номын аргыг сурч, түүнийг бясалгаагүй бол хүн болон төрөхгүй. Хүн болон төрсөн нь энэ 84000 номын ёсыг сурсан гэсэн үг.

Наян дөрвөн мянган номын ёс гэж юу вэ? Жишээ нь, бидний хорон муу сэтгэл их бол тийм ч сайнгүй байна аа гэсэн үг. Дахин ирж энэ хорт хилэнгээ арилгах хичээлд суралцах хэрэгтэй. Жишээ нь, бид могой, чичүүр хорхой байгаад хүн хазвал тэр дороо үхнэ. Хэтэрхий хорон санаатай бол тэр хорт эрчим биднийг хүн болгохгүй. Хүн болон төрсөн нь бид хэдийнээ тэдгээр 84000 номын ёсыг сурсан гэсэн үг. Харин одоо амжиж Будда болох номын ёсыг сурах хэрэгтэй. Эс бөгөөс байдал тун ярвигтай болно. Дахин төрөл авч, өөр нэгэн хичээл сурах болж ч магадгүй. Ингэх нь бидэнд ямар ч ач тусгүй.

Буддын сударт жинхэнэ хүний ёсоор амьдарч чадаагүй бол амьтны төрөл авч болзошгүй тухай тодорхой өгүүлдэг. Хүн байх нь сайхан гэж бодоод дахин энэ дэлхийд ирж жаргая гэвэл заавал бясалгах хэрэгтэй. Эс бөгөөс хүн

болж энэ ертөнцийн баяр баяслыг эдэлж, сайныг идэж, сайхныг өмсөж, сайн эхнэр, сайн нөхөртэй болж чадахгүй байж магадгүй. Арьяабалын аргаар бясалгадаг хүн энэ дэлхийд лавтай дахин ирэхгүй. Харин бид өөрөө хүсвэл ирж болно. Багш нь та нарыг баруун зүгийн Төгс баясгалант оронд, дорно зүгийн Биндэрьяа болор оронд амьдран суухыг албадахгүй.

Арьяабалын аргаар бясалгавал хүний энэ хорвоогоос үүрд ангижирна гэж сонсоод айх хэрэггүй. Зарим хүн энэ дэлхийд их хоргоддог. Тэгвэл илүү сайн бясалгах хэрэгтэй. Учир нь дараа төрөлдөө амьтан, чийгийн улаан хорхой, мэлхий, чичүүр хорхой болон төрж магадгүй. Иймээс сайн бясалгавал дараа төрөлдөө сайн хүн болж төрнө. Ёс суртахуунтай, байр суурьтай, бусдыг аврах хүч чадалтай хүн бодьсадва болон төрдөг. Шүншиглэн аравнайлах явдлын тухай энэ хүртэл яриад өндөрлөе.

Одоо та нар юу сонсмоор байна? (Үйлийн үр гэж нэг нь хариулав) Одоо болтол ойлгоогүй юу? Үйлийн үрийг ойлгоход амархан. Жүрж таривал жүрж л ургана. Сайн үйл хийвэл буян хураана. Тун ойлгомжтой. Жишээ нь, чи хэн нэгэн хүнд нөхөрсөг хандан хэцүү үед нь тусалвал тэр мэдээж талархана. Хожим нь чамд бас хүнд үе тохиолдвол тэр мөн тусална. Энэ бол их энгийн хэрэг. Арай гүн үйлийн үр нь адын үйлийн үрийн барилдлага олох, эсвэл Бурханы хутагийг бүтээх үрийг олох явдал юм. Жишээ нь, бид муу хэрэг хийж, буруу аргаар бясалгавал ад чөтгөр болно. Харин Бурханы номоор бясалгавал Будда болно.

Бурханы зам мөр гэж юу вэ? Арьяабалын аргаар бясалгавал Будда болно. “Баатар явагч их хөлгөн судар”-т зөвхөн Арьяабалын аргаар л бясалгавал Будда болж чадна. Бусад нь цөм дөхөм арга төдий гэж Шагжамуни Будда тун тодорхой айлдсан. Багш нь зөвхөн Арьяабалын аргыг заадаггүй. Хааяа Авид Бурханы аргыг заана. Бурханд

мөргөхийг заана. Учир нь Арьяабалын аргаар бясалгаж чадахгүй. тэр хүмүүс Багштай нь үнэ хэлэлцдэг. Жишээ нь: “Багшаа би Арьяабалын аргаар бясалгаж чадахгүй ээ. Мацаг хоол идээд хэдэн арван жил болж байна. Өглөөгүүр мацаг хоол иддэг. (өглөө мацагладагаа ингэж их гайхуулна. Би бол өглөө ер хооллодоггүй). Би Арьяабалын аргаар бясалгаж чадахгүй тул та өөр арга, өөр бясалгалын арга зааж өгнө үү? гэж гуйдаг. Эсвэл хийж буй ажил төрөл тохиромжгүй. Тэд загас, мах, архи, хорт бодис зарж борлуулах ажил хийдэг. Энэ нь гэгээнтэн хүний намба төрхөнд нийцэхгүй. Хэрвээ ийм нөхцөл байдалтай бол Багш нь тийм хүнийг хүлээн авч болохгүй.

Багш нь тэднийг буруутгаагүй, бас заавал ийм тийм болж өөрчлөгд гэж шаардаагүй. Арьяабалын аргаар бясалгах нь Будда болохын төлөө, бодьсадва болохын төлөө учраас наад зах нь ийм намба төрх, энэрэл нигүүлсэлтэй байх хэрэгтэй. Хамаг амьтан таны алдрыг сонсохын зуур л айн сүрддэг байж болохгүй. Бодьсадва болохыг хүссэн байтал хамаг төрөлтний махыг зараад зогсож байвал та ямар бодьсадва болох вэ? Бид сайхан сэтгэлтэй байсан ч тэд ойлгохгүй. Жишээ нь, нэгэн хүн би бясалгалаараа хоосны төвшинд хүрсэн тул миний хувьд мах зарах, жигнэмэг зарах хоёр яг адил гэнэ. Ингэж хэлэх хүн байж магадгүй. Гэвч хүмүүс үүнийг сонсоод айна. Ойлгов уу? Та өөрийгөө бодьсадва гэнэ. Энэ бол маш эрхэм дээд мөрийн хутаг. Бурхан болохын төлөө бодьсадвагийн номын ёсоор бясалгаж байгаа хүн ийм байж яаж болох вэ? Бид архи, тамхи, мансууруулах бодис зарж борлуулвал хамаг төрөлтөн бидэнд итгэхгүй. Ийм ажил хийдэг хүмүүс Арьяабалын аргаар бясалгаж болохгүй. Ажлаа заавал өөрчлөх хэрэгтэй.

Бурханы сударт найман зөв замыг тодорхой заасан. Бид зөв ажил, яг тохирох цэвэр ариун ажилтай байх ёстой. Ойлгов уу? Багш нь цоо шинэ зүйл яриагүй, Шагжамуни

Будда ч шинэ зүйл яриагүй. Есүс Христ, Лууз, Күнз ч бас шинэ онол яриагүй. Багш нь бол шинэ зүйл бүр ч яриагүй. Харин хэн ч ярилгүй удсан тул та нарт шинэ юм шиг санагдаж байна. Үнэндээ шинэ юм огт байхгүй. Багшийнх нь ярьсан зүйлс бүгд дотоодын ном.

Учир нь тэд заавал нэг бясалгалын аргатай болж, бясалгахыг хүсэх тул би тэдэнд унших ямар нэгэн маани, тарни, Авид Бурханы тарнийг зааж өгдөг. Будда болох аргаас өөр заах зүйл надад байхгүй тул тэдэнд Авид Бурханы тарнийг л заана. Учир нь, юу ч заасан бүгд ижилхэн юм. Зөвхөн Арьяабалын арга л хамгийн төгс дээд нь. Өөр бусад бясалгалын аргыг бид дөхөм арга гэдэг. Урмыг нь хугалахгүйн тулд тэдэнд Авид Бурханы тарнийг заана. Юу ч уншихгүйгээс дээр, ядаж л үүнийг уншвал сэтгэл нь жаахан төвлөрч, санаа бодол нь цэгцэрч, сэтгэл зүрх нь ариусаж, нисваанис нь аажимдаа багасах байх. Тэгээд яваандаа ургамал хоолтон болж, Арьяабалын аргаар бясалгаж бас магадгүй юм.

Зарим хүнд нь би хялбар дөхмийг бодож их нигүүлсэнгүй тарни, их бага мөргөлийн тарнийг заадаг. Иймээс “Баатар явагч их хөлгөн судар”-т Шагжамуни Будда: Бясалгалын бусад бүх арга бол дөхөм арга гэсэн нь ийм учиртай. Ойлгов уу? Багш нь зөвхөн ганц Арьяабалын бясалгалын аргыг заахгүй. Мөн өөр олон дөхөм арга заадаг. Гэсэн ч эдгээр дөхөм аргыг заах нь заагаагүйтэй бараг ижил гэдгийг мэднэ. Ойлгов уу? Багш нь түүнд дөхөм арга зааж бясалгуулахад өөрөө Багшид итгэлтэй бол жаахан барилдлага үүсч, нас барахдаа гурван муу заяанд унахгүй. Учир нь түүнд ном уламжилсан Багшийн буян хишиг байгаа хэрэг!

Багш нь түүнд олон янзын дөхөм арга заасан ч тэр бас бага сага буян хишигтэй болно. Учир нь тэр Багштай нь хэдийнээ багш шавийн холбоотой болжээ. Багш нь



бясалгалтай болохоор тэр жаахан буян зээлж болно. Хэрвээ тэд Багшид итгэлтэй бол энэ аргаараа бясалгавал бас буянтай. Харин түүнд өөр хүн заасан бол гурван муу заяанаас аврагдах эсэхийг би баталж чадахгүй. Ойлгов уу? Жишээ нь, өөр хүн түүнд Авид Бурханы тарнийг заасан бол би баталж чадахгүй. Авид Бурханы тарнийг өөр хүнээс сурч, хожим нь тамд унавал намайг бүү зэмлээрэй. Энэ нь миний хариуцлага биш. Ойлгов уу? Би заасан зүйлдээ л хариуцлага хүлээнэ. Хэрвээ би заагаагүй бол хариуцлага хүлээхгүй. Учир нь энэ нь адилгүй байдаг. Жишээ нь, та их баян бөгөөд ядуу хүн тусламж гуйхад тусалбал хүч чадалтайн илэрхийлэл. Тийм биз? Өөр нэгэн хүн хөрөнгө мөнгөгүй ядуу атлаа түүнтэй адил зөвшөөрч: “За, би чамд арван мянгыг өгье” гэвэл энэ хоёрын нөхцөл байдал тэс өөр. Тийм биш үү? Чи мөнгөтэй, түүнд туслахыг зөвшөөрсөн. Тэгвэл тэр даруйдаа, эсвэл маргааш, нөгөөдөр нь амалсан мөнгөө өгнө. Харин өөрөө мөнгөгүй байж, бусдад туслахыг амалсан өнөөх хүн мөнгөгүй тул хичнээн хоносон ч мөнгө өгч чадахгүй. Бүр сая удаа амалсан ч өгч чадахгүй хэвээрээ л байна.

Тиймээс заасан арга нь адил ч хүч нь адилгүй тул ямар ч тусгүй. Бид одоо Бурхан бодьсатва болохыг хүсч байна. Тэгвэл Бурхан болох, бодьсатва болох үйлийн үрийн барилдлага үүсгэх хэрэгтэй. Бид Бурхан бодьсатва, Эзэн Бурхан, богд хүн, гэгээнтэн хүний намба төрх, ёс суртахуунд эхлээд суралцах хэрэгтэй. Энэ бол гадна талын хичээлүүд. Дотооддоо тэдэнтэй ижил төвшинд хүрч адилхан ахуй ойлголттой болж чадвал бид Бурханы хутаг, бодьсатвагийн хутагт хүрнэ. Одоо бид эгэл хүн болох барилдлага үүсгэсэн тул эгэл хүний хутагийг олсон байна. Хэрвээ бид Будда болох барилдлага үүсгэвэл Бурханы хутагт хүрнэ. Тиймээс Арьяабалын аргаар бясалгавал лавтай Будда болно.

Багш өөрийгөө Будда гэсэн гэж зарим нь ярина. Өмнө

нь өөрийгөө Будда гэж би хэлээгүй ч тун олон хүн ингэж ярьсан тул одоо хэлсэн нь дээр. Хэрвээ Би Будда бол муу юм юу байх вэ? Мод ч Будда болж байхад яагаад би Будда болж чадахгүй байх вэ? Мод огт бясалгаагүй, тийм биз? Түүнийг уулнаас авчраад сийлбэрлэж, билигийг нь нээгээд л Бурхан болгосон. Үүнээс хойш өдөр бүр тэнд үй олон хүн ирж мөргөж байна. Харин би ядаж л нилээд хэдэн жил хичээнгүйлэн бясалгасан, бясалгалын төлөө, Төгс Гэгээрсэн Их Багшийг хайж олохын төлөө уул ус тахиж, маани тарни уншиж, бодьсатвагийн тарни унших зэргээр түмэн бэрхийг амссан байтал яагаад Будда болж чадахгүй байх вэ? Энэ чинь үнэхээр ёс журамгүй, шудрага бус явдал! Яагаад нэгэн модыг хүнээс ч илүү хүндэлнэ вэ? Тийм үү, үгүй юү?

Тиймээс Багш нь өөрийгөө Будда гэвэл нэг их хэтрүүлсэн зүйл болохгүй байх! Учир нь мод хүртэл Будда болж байхад тун олон номын багшийг шүтэн дагаж, олон удаа аравнайлуулж шүншиглүүлсэн би маш их зовж зүдрэн хичээнгүйлэн бясалгасан тул яагаад Будда болж чадахгүй байх вэ? Хэрвээ Будда болж чадахгүй бол сахилын багшийгаа дорд үзсэн хэрэг болно. Тийм биз? Тэр бас модыг ч Будда болгодог. Тэгвэл намайг яагаад Будда болгож чадахгүй байх билээ? Үнэн хэрэгтээ өөрчлөлт заавал байна. Арьяабалын аргаар бясалгаагүй ч хэдийнээ Будда болжээ. Учир нь миний шүтэн дагасан Багш модыг ч бурхан болгодог тул би бас Будда болох нь гарцаагүй! Будда болоод их удаж байна. Арьяабалын аргаар бясалгахын хэрэггүй, энэтхэгт очиж хатуу бясалгал хийж, даяанчлах шаардлагагүй, гаднаас эрж хайх хэрэггүй, өөрийгөө Будда гэх ч хэрэггүй. Учир нь угаасаа л Будда. Ойлгов уу?

Өчигдөр би өөрийгөө Будда гэсэн. Та нарын дунд эсэргүүцэх хүн байна уу, байгаа бол энд хэлээрэй. Араар шүүмжлэх хэрэггүй. Эсэргүүцэж байгаа хүн байна уу? Байхгүй юу. За тэгвэл би Будда боллоо шүү (за гэж бүгд

хариулав) Баярлалаа! Гэсэн ч бид бүгдээрээ Будда мөн. Миний хувьд та нар бүгд Будда. Будда биш хүн нэг ч байхгүй, харамсалтай нь үүнийгээ зарим нь мэднэ, зарим нь мэдэхгүй. Энд л та бидний ялгаа байдаг.

Учир нь би өөрийн Бурхан чанараа хэдийнээ таньж, би бол бурхан гэдгээ мэджээ. Бурхан чанар хаана байдгийг ч бас мэдсэн. Харин зарим хүн өөрийн бурхан чанараа хараахан таниагүй байна. Ийм л төдий. Бид бүгдээрээ бурхан чанартай. Гэвч зарим нь үүнийгээ таньж чадсан, зарим нь хараахан таниагүй байна. Зөвхөн ийм л ялгаа байна. Тэрнээс биш бурхан чанараа таньсаны дараа би бурхан чанартай болсон юм биш. Чи таниагүй болохоор бурхан чанаргүй гэсэн үг биш. Бид бүгдээрээ бурхан чанартай. Хэрвээ та бурхан чанараа мэдэхийг хүсвэл хамтдаа нийтийн бясалгал хийж болно. Ийм л юм. Бурхан болох эсэх нь миний хувийн явдал. Би өөрийгөө бурхан, эсвэл бурхан биш гэх нь бас л миний хувийн хэрэг бөгөөд та нартай хамаагүй. Ойлгов уу?

Хэрвээ би өөрийгөө Бурхан гэсэн бол энэ нь би өөрийгөө л хэлсэн хэрэг. Бидэнд үг хэлэх эрх чөлөө бий. Тийм биз? Тэгэхээр би өөрийгөө Будда гэхэд болохгүй юмгүй. Би хэнийг ч хорлоогүй, хулгай хийгээгүй, та нарыг итгэхийг албадаагүй. Би Будда мөн эсэх нь та нартай ямар ч хамаагүй. Хамгийн чухал нь та бүхэн өөрсдөө Бурхан чанараа эрж олох хэрэгтэй, өөрсдөө Будда болох хэрэгтэй.

Хэрвээ таны олсон хүн бурхан чанараа олоход чинь тусалж чадна гэвэл тун сайн байна. Танд баяр хүргэе! Та түүнээс суралцаж болно. Олсон хүн тань гадаадын хүн, дотоодын хүн байх нь огт хамаагүй. Хэн ч биднийг сургаж болно. Түүнээс суралцаж болно. Асуудалгүй. Заавал Багшаасаа суралцах албагүй. Хэрвээ олоогүй бас их яарч, нөхцөл байдал тулгамдуу байгаа бол надтай хамт бясалгаад үзээрэй. Ойлгов уу? Үнэ төлбөргүй! Ямар ч нөхцөл болзолгүй, юуг ч хүлээслэхгүй, намайг шүтэн

дагах шаардлагагүй, сахилын нэр авах хэрэггүй, надтай хамт амьдрах ч хэрэггүй, өргөл барьц авахгүй, сүм дуган барихгүй.

Надад ямар ч сүм хийд байхгүй. Би сүм барихгүй. Та нарт шулуухан хэлэхэд хаа нэгтээ удаан амьдрах зав надад үнэндээ байдаггүй. Нэг газарт удвал сэтгэл хоргодно. Энэ гэрээс тэр гэр лүүгээ явж байгаа шиг л юм болно. Сүм хийд ч гэсэн гэр орноос ялгаагүй бас л цементээр барьсан. Тийм биш үү? Шавь нар маань байр худалдан авч өгсөн ч би хаана ч амьдрахыг хүсээгүй. Хулсан байшинд ч бас амьдарч болно. Бид бас буцах бодолгүй байна. Одоо өмнөд нутагт очиж шинэ оноо угтана. Пиндунгийнхан Багшийг нь голын эрэгт шинэ жил тэмдэглэхийг урьсан бөгөөд би үүнийг нь зөвшөөрсөн. Ном тайлж дуусаад бид Пиндун луу явж, голын эрэгт шинэ оноо угтана. Хэрвээ та нар Багштайгаа хамт явж, майханд байхыг хүсвэл эртхэн явж, майхнаа авсан нь дээр. Шинэ жилийн үеэр олдохоо болино. Ойлгов уу? Гэвч Багш нь эхлээд та нарт сануулья. Тэнд суух газар байхгүй, зөвхөн мод чулуу л бий. Бут сондуул ихтэй тул явахад нилээн бэрхшээлтэй. Модны сүүдэрт сууна гэж бодохын ч хэрэггүй. Ядаж нэг дүүжин ор, уутан хөнжил аваарай. Шөнөдөө хүйтэн тул даарна.



## БОДСАДВАГИЙН ЗАМААР ЗАМНАХАД ЗААВАЛ ЗОВЛОН АМСАНА

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Формаса, Тайбэй хот, Шиньдиэн  
1987 оны 4 дүгээр сарын 9  
(Эх нь хятад хэлээр)*

Долоо хоногийн даяан удахгүй дуусна. Хоёрхон цаг л үлдсэн байна. Одоо та нар бясалгах уу, тоглож наадах уу? Тоглож наадахыг хүсэж байгаа нь гараа өргөөрэй. Та нар дуртай байгаа ч гараа өргөж зүрхлэхгүй байна. (бүгд инээв) Та нарыг хэтэрхий их ярьж, бусдыг үймүүлж байна гэж зарим хүн гомдол мэдүүлсэн. Багшид нь ч гэсэн төвөгтэй байхад авшигтнуудад яагаад төвөггүй байх билээ? Багш маань ариун гэгээнтэн, бодьсадва хүн тул биднийг юу ч хийсэн дургүйцэхгүй гэж бүү бод! Та нар бясалгахгүй бол Багш нь тун дургүй, бүр та нараас ч илүү дургүй. Та нар зөвхөн бага сага мөнгөний төлөө, хүүхэд багачуудаа шуугилдах, эхнэр, нөхөр орхиж явах, хүүхэд шалгалтандаа тэнцээгүй, наймаа арилжаа сайнгүй байх гэх мэтэд шаналдаг.

Миний санаа зовох юм та нарынхаас хавьгүй их. Шавь нар бясалгахгүй нь намайг хамгийн их зовоодог. Та нарын хэт их яриа, тодорхой бус яриа чинь намайг зовоодог. Та нарт тодорхой хэлье. Би бол бодьсадва биш. Хүмүүсийн бясалгал муу байвал миний сэтгэл их шанална. Тэр үед би

бодьсадва биш, харин шаналалт бодьсадва болно. Ашрамд ирээд бясалгахгүй, өдөржингөө зогсоо зайгүй яривал авшигтнууд дургүй. Тэдний хувьд цаг хугацаа тун үнэтэй. Энд ирээд ярьсаар байвал тун ёс зүйгүй хэрэг.

Надад хэцүү байсан ч зарим үед би тэвчих хэрэгтэй. Хэт их тэвчиж тэсвэрлэх нь заримдаа өвчин болдог. Учир нь та нар бүгдээрээ Багш хүн уурлах ёсгүй гэнэ. Дэргэд минь ирээд үймүүлж байхад яаж би та нарт уурлахгүй байх вэ? Өөрөө бясалгахгүй, намайг бясалгуулахгүй, бас Багшдаа төвөг удна. Ийм байхад яаж би уурлахгүй байх вэ? Уурлах нь зөв. Тэр ч байтугай та нарыг зодох нь зөв юм байна. Хожим би та нарыг зодох байх шүү. Хятад хүмүүс яагаад жаягийн мод хэрэглэдгийг одоо л би ойлголоо. (бүгд инээлдэв). Хэрэглэхээс өөр аргагүй тул хийд бүхэнд ийм мод байдаг аж. Би л ганцаараа тэнэг бололтой. Өчнөөн олон долоо хоногийн даяаныг ганц ч жаягийн мод хэрэглэлгүй тэсвэрлэн өнгөрөөжээ.

Зарим хүн угаасаа их хэлэмгий. Гэтэл яг хэрэгтэй үед юу ч дуугарахгүй. Уг нь тэр хүн загнахдаа тун сүрхий, гэтэл долоо хоногийн даяаны үеэр дүрэм журам зөрчсөн хүмүүсийг загнах хэрэгтэй болоход загнахгүй. Тэр нэрэлхэнэ, нэр нүүргүй болохоос айна. Хэрвээ хүнийг Багш шиг нь ингэж загнавал бүх хүн дургүйцнэ. Багшид дургүй байх нь хамаагүй, Багш нь бүгдийг тэвчиж, бүхнийг хийх хэрэгтэй. Багш нь та нарт адистай жигнэмэг тарааж, хаалгыг чинь онгойлгож, утасны дуудлага авч, хоол хийх хүнгүй бол очиж туслах гээд юм бүхнийг хийнэ. Та нарын ихэнх нь санаачилга тун муутай.

Гурав хоногийн даяан, долоо хоногийн даяаны үер бүх хүн жаргаж ганц л хүн зовж байв. Зовлон бүхнийг хүлцэн тэвчинэ. Хэн болохыг нь мэдэх үү? Зарим үед уурлаж болохгүй, заавал тэвчих хэрэгтэй. Та нарыг тэсэхгүй байх вий гэж айна. Миний биеийн тал нь энэ дэлхийд аж төрж

буй сэтгэл зүрх, бие махбодтой эгэл хүн. Хэрвээ би зөвхөн бодьсадвагийн сэтгэлтэй байвал яаж та нарын сэтгэлийг ойлгох билээ?

Та нар Багшийгаа бодьсадва гэдэг. Үүнийг би сайн мэдэхгүй. Хэрвээ би бодьсадва бол бодь сэтгэлтэй байх нь гарцаагүй. Гэсэн ч хүний сэтгэл бас байх хэрэгтэй. Хүний сэтгэлгүй бол хүмүүстэй ойлголцохгүй, та нарын сэтгэл зүрхийг мэдрэхгүй, санаа бодлыг ойлгохгүй, дэсийг чинь мэдэхгүй юм. Тиймээс хүний сэтгэл заавал байх хэрэгтэй. Гэхдээ энэ хүний сэтгэлээс болоод зовуурилах, зовох, бие махбод ядрах асуудал гарна. Учир нь энэ бол эгэл хүний бие махбод.

Багш маань бодьсадва болохоор юуг ч хүлээн зөвшөөрч, хүлцэн тэвчиж чадна гэж болохгүй. Хүлцэн тэвчинэ. Гэхдээ зовохгүй гэсэн үг биш. Зовж зүдэрсэн ч Тэр гомдоллохгүй. Хэрвээ чи Багшийгаа зодвол, Багш нь бас өвдөнө. Гэсэн ч тэр эгэл хүн шиг хариу цохихгүй. Хүнд зодуулвал хариу цохидог нь эгэл хүний араншин. Бодьсадва хүн өвдөглөө зодуулсан ч хариу барихгүй, оронд нь алим бэлэглэнэ. Ийм бол бодьсадва мөн.

Бодьсадва хүн бол онцгой нэгэн, Тэр сэрэл мэдрэмжгүй, шаналал зовлонгүй, хэнд ч баригдахгүй гэж бүү бод. Бодьсадва больё гэвэл энэ дэлхийд амьдрах хэрэгтэй. Баруун зүгийн Төгс баясгалант оронд амьдраад хэрэггүй. Тэнд өөр бодьсадва нар амьдардаг. Бодьсадва олон биетэй байдаг бөгөөд зарим нь баруун зүгийн Төгс баясгалант оронд, зарим нь зүүн зүгийн оронд, зарим нь энэ дэлхийд амьдарна. Энэ дэлхийд байгаа бие нь зовлон эдэлнэ. Учир нь түүний энэ бие нь хамаг амьтны зовлон зүдгүүрийг үүрэхийн тулд энэ дэлхийд ирдэг. Бие махбод байгаа учир зовлон байна. Их зовох уу, бага зовох уу гэдэг нь шавь нарын олон цөөн, хэр олон төрөлтний үйлийн үрийг үүрч байгаагаас хамаарна.

Энэ дэлхийд бодьсадвийн замаар замнах нь маш их зовлон бэрхшээлтэй. Жишээ нь, нэгэн шавийн бие нь өвдөөд эдгэсэн байна. Түүний өвчин хаачсан бэ? Багшийнх нь бие рүү шилжсэн. Энэхүү бие махбод шавь нарын үйлийн үрийг үүрэхийн төлөө байдаг. Та нар Арьяабал бодьсадваг үнэхээр агуу, хамгийн сайн гэж бодох хэрэггүй. Тэр одоо баруун зүгийн Төгс баясгалант оронд тун эрх тааваараа, онцгойлон хийсэн зүйлгүй, ариун бумбатай адисалсан рашаанаа сүрчин суугаа. (бүгд инээлдэв). Тэр махан биегүй болохоор зовохгүй.

Одоо энэ дэлхийд залран буй амьд бодьсадва л хамгийн ачтай тустай. Тэр бидний бүхий л үйлийн үрийг үүрнэ. Юуг ч хийж чадна. Дотоодоо ч хийнэ, гаднаа ч хийнэ. Тэрээр биднийг энэ дэлхийд сургах төдийгүй, нас барж ангижраад дээд төвшинд хүрэх үед ч сургана. Дотоодын бодьсадва бол тийм ч их хэрэгцээтэй биш. Тэр хүн загнахгүй, бусдын үйлийн үрийг үүрэхгүй, авшиг хүртээхгүй, биднийг шавиа болгохгүй. Учир нь ямар ч аргагүй.

Хэрвээ нэгэн Төгс Гэгээрсэн Их Багш таалал төгсвөл, Тэр ямар ч дэстэй, хүч чадалтай байсан дахин шинээр шавь элсүүлж, тэдэнд туслах аргагүй. Отгон шавь нарыг нь Түүний залгамжлагч харж хандана. Тэр зөвхөн авшиг хүртсэн шавь нараа л харж хандана. Тэр Багш хэдийнээ ангижирсан ч өөрийн авшиг хүртсэн шавь нартаа тусалсаар байдаг. Гэхдээ шинээр ирсэн хүнд авшиг хүртээхгүй. Авшиг хүртээгүй хүнд ч бас тусалж чадахгүй. Харин Тэрээр энэ дэлхийд амьд сэрүүн заларч байхдаа авшигтай, авшиггүй хэнд ч тусална. Хэнийг ч аварна. Зөвхөн авшиг хүртсэн хүнийг л аврах биш. Тэр хэнийг аврахыг хүснэ, түүнийгээ аварна. Таныг харахын зуурт дээш татна. Гэвч Шагжамуни Будда, Авид Бурхан, Арьяабал Бурхан хэн нь ч байсан энэ ертөнцөөс хэдийнэ ангижирсан бол бидэнд тийм ч их ач тустай байхгүй. Бидний үйлийн үрийг үүрэхгүй,



үхэж төрөхийн хүрднээс гэтэлгэхгүй, авшиг хүртээхгүй. Харин хувилгаан бие нь энэ дэлхийд дахин төрөл авсан бол тэр бие махбодоо ашиглаад биднийг шууд аварна. Тэр үед Арьяабал бодьсадва ч бас биднийг аварч чадна. Бие махбодтой байж байж л хүнийг аварна. Бие махбодгүй бол биднийг аврах аргагүй. Тийм биш бол Шагжамуни Будда энэ дэлхийд ирж юу хийх вэ? Майдар Бурхан ирж юу хийх вэ? Бусад богд гэгээнтэн, бодьсадва нар яагаад заавал ирдэг вэ? Бид эндээсээ залбирч даатгахад л болчих биш үү? Бие махбодтой байснаар бие махбодийг авардаг нь орчлонгийн хууль юм. Жишээ нь, Сиси бол хамгийн сайхан хүүхэн. Гэвч бид түүнийг санан дурсаж чадахгүй. Хүүхэдтэй больё гэвэл одоо амьд байгаа бүсгүйтэй гэрлэх хэрэгтэй. Өвчин тусвал одоо байгаа эмчээр эмчлүүлэх хэрэгтэй. Өнгөрсөн үеийн алдартай эмч Хуатөү, Биенчүе нарыг хайх хэрэггүй.

Та нар Багшийнхаа энд ирж, долоо хоногийн даяан хийх үедээ нилээд чимээ шуугиантай байсан ч гайгүй сайн ахуй ойлголттой байлаа. Зарим нь бясалгалаараа баруун зүгийн Төгс баясгалант орон, зүүн зүгийн Төгс баясгалант оронд хүрч, зарим нь Бурхан бодьсадватай холбогдож, тэдэнтэй ярилцаж, зарим нь Багшийнхаа хувилгаан биеийг, зарим нь өвгө багшийгаа харсан гээд тун олон зүйл харжээ. Энэ бас тийм ч амар хэрэг биш шүү. Бусад даяаны багш нарын зохион байгуулсан сүр жавхлантай, долоо хоногийн даяан нь бидний энэ долоо хоногийн даяаны зууны нэг хувьд ч хүрэхгүй.

Зарим авшигтан Арьяабалын аргаар бясалгахаасаа өмнө адад эзлэгдсэн байсан. Авшиг авмагцаа долоо хоногийн даяанд суугаад дотоодын дуугаа сонсож чадсан нь үнэхээр сайн хэрэг. Жаахан төвөгтэй байсан ч энэ хамаагүй, бүгд хувь хүний үйлийн үр юм. Хожим нь сансрын хүрднээс заавал гэтлэх бөгөөд энэ дэлхийд эргэж төрөхгүй болсон нь хамгийн сайн хэрэг. Сүүлийн тэмээний ачаа хүнд байдаг

болохоор жаахан зовлон эдлэхэд асуудалгүй.

Та нар өнгөрсөн төрлүүддээ тэдэнтэй холбоотой байж өглөгтэй болсон тул одоо жаахан хүлцэн тэвчих хэрэгтэй. Таван ариун нэрээ байнга уншвал байдал улам сайжирна. Гэхдээ тийм ч хурдан биш, хэрвээ хэтэрхий хурдан бол та нар үхчихнэ. Багш нь тэднийг чинь тэр дор нь аваад явбал та нар даруй ангижирна. Гэхдээ одоо ангижирч болохгүй. Дэс чинь өндөр биш бол ямар ч нэмэргүй. Багш нь тэр дотоодын ад чөтгөрүүдийг аваад явж болно. Гэхдээ энэ нь тусаар бага. Багш нь хүч хэрэглэж болохгүй. Аажим аажмаар хүлээцтэй хандаж, Багшаараа дотоодын чөтгөрөө сурган хүмүүжүүлэх хэрэгтэй. Хэсэг хугацааны дараа тэд аяндаа өөрсдөө явчихна.

Адад эзлэгдсэн тэр хоёр авшигтан тун даруухан, их тэвчээртэй. Хараад сэтгэл хөдөлмөөр. Энэ долоо хоногийн даяаны үеэр хамгийн их зовсон нь бид гурав. Тэр хоёрыг аврахын тулд Багш нь хэдэн арван адад хазуулсан. (Багш инээв.) Багш нь яриагүй л болохоос бид гурав тэсэхийн аргагүй их зовсон шүү.

Хүмүүст авшиг хүртээж аврахын төлөө Багш нь маш олон ад чөтгөрт байнга зодуулдгийг та нар харахгүй, гэхдээ зарим нь хардаг. Та нарын дотоодын ад чөтгөрийг бодвол тэд илүү аймшигтай. Та нар адад эзлэгдсэн ч ганц хоёроос хэтрэхгүй. Харин над руу Ганга мөрний элснээс ч олон сүнс дайрна, бас шүүмжилнэ. Эд бол бүгд та нарын төрөл төрлийн авлагийн эзэд юм. Одоо тэд та нар луу биш, над руу довтолж байна. Багш нь нэгэн бай болж хувирчээ. Яг л тавьсан өгөөшийг идэхээр ирэх олон загас шиг, торон дахь бяцхан амьтан луу дайрах арслан, бар мэт. Та нар биш, би л гомдол мэдүүлмээр байна. Та хоёрын асуудал бол сүртэй биш, өчүүхэн хэрэг. Багш нь жижиг торонд хашигдаад дүрсгүй төрөлтөнд дайруулж байхыг зарим нь хардаг. Бусдын өмнөөс төмөр гинж залгиж, мэст ууланд авирч

байхыг минь зарим нь үздэг. Хүнийг аврахын тулд Багш нь маш олон зүйлийг заавал хийх хэрэгтэй болдог. (Та энэ бүхнийг хийхэд тун их өвдөж зовдог байхдаа гэж нэг хүн асуув.) Өвдөж зовох биш. Харин үхэх шахдаг. (Багш инээв)

Долоо хоногийн даяаны үеэр та нар тийм ч дүрэм журамтай байгаагүй. Гэхдээ чамгүй сайн ахуй ойлголттой болжээ. Би өөр газар очиж, долоо хоногийн даяанд суухад тэдний ахуй ойлголт нь та нарын ахуй ойлголтын хаана нь ч хүрэхгүй байдаг. Бараг ахуй ойлголтгүй шахам. Багшийгаа улаан гэрэл дотор сууж байхыг харвал тэд их баярлаж: “Багшаа би таныг улаан гэрэл дотор бясалган суухыг харлаа” гэнэ. Улаан гэрэл юуг төлөөлдгийг та нар сайн мэднэ. Бидний хувьд угаасаа улаан гэрлийг харах ч шаардлагагүй. Формосад тун алдартай нэгэн даяаны багш бас улаан гэрэл дотор сууж байдаг гэнэ. Би хэн болохыг нь хэлэхгүй ээ.

Багш нь хэдийгээр их зүдэрдэг ч та нарыг долоо хоногийн даяан хийлгэмээр байдаг. Учир нь долоо хоногийн даяанаар та нарын дэвшил маш хурдан байдаг юм. Харин Багшийнх нь хувьд тун зовлонтой. Долоо хоногийн даяан хийх бүрт би дандаа л за энэ бол хамгийн сүүлийнх нь гэдэг. Нээрээ шүү. Бүр жинхэнээсээ сэтгэлээсээ тэгж хэлдэг. Гоморхоод ч тэгж байгаа юм биш. Заримдаа тэсэхийн аргагүй хэцүү байдаг болохоор хамгийн сүүлийнх болгоё. Би яагаад ингэж их зовох ёстой вэ? гэж боддог. Дэндүү их зовдог болохоор ном тайлж, авшиг хүртээж, бусдыг, бүр нэг ч сүнсийг авармааргүй санагдаж, тэтгэвэртээ гарч, амрахыг хүсдэг. Гэвч ингэж ярьж болохгүй. Зориг зүрхгүй байгаа хэрэг. Энэ үед шунал, хилэн, мунхаг, гомдол гэх мэт эгэл хүний сэтгэлийн нисваанисууд илрэн гарч ирнэ. Юунд шунана вэ? Баяр жаргалтай, амар хялбар байхад шунаж, хүн загнахгүй, бусдыг хамаарахгүй, тэдэнд муу үг хэлэхгүй байхыг хүсэж байна. Энэ нь нирваанд шунаж байна гэсэн

үг. Шагжамуни Буддад ч бас ийм сэтгэл үүсч байсан. Тэр Будда болсныхоо дөнгөж дараа хамаг амьтныг гэтэлгэх ямар бэрх болохыг хараад, толгой сэгсэрч: “Би нирваанд одлоо” гэж байсан. Миний бодоход бидэнд бүгдэд нь ийм сэтгэл байдаг. Ганцхан би л ийм юм болов уу? гэж бодоод бясалгагч хүмүүсийн намтрыг уншихад бүгдэд нь тийм үе байсан байна.

Тэр өдөр Багш нь Рама Кришна Их Багшийн тухай ярьсан. Тэр бас гомдоллож, Бурхан, бодьсадвад хандан: “Та энэ биеийг дэндүү их ашиглаж байна. Би тэсэхгүй боллоо. Одоо энэ бие махбод дийлэхээ больж, бүр муудлаа. Жаахан аажуу байвал сайнсан” гэжээ. Учир нь дэндүү олон хүн түүнийг шүтэн биширч, уулзаж, асууж лавлаж байсан тул тун их ядарч, тэсэхийн аргагүй болсон байна. Тэгээд Тэдэнд жаахан гомдол мэдүүлсэн хэрэг.

Багш нь ном айлдахдаа хэлсэн өгүүлбэр бүхэн маш их ач тустай. Санааны аяар ярьсан үг ч ач тустай. Багшийнх нь дуу хоолой байгаа л бол ач тустай. Тиймээс хэрвээ та нар мөнгөтэй бол дууны хуурцаг худалдаж аваад гэртээ сонсоорой. Багшийнх нь ном тайлж байгаатай ялгаагүй. Хэлбэлзлэлтэй, гэрэлтэй болохоор бидэнд тусалж угаан ариусгана. Та нар ердийн үед нийлээд бясалгаарай. Хамгийн багадаа долоо хоногт нэг удаа. Заримдаа ажиллаж байхдаа ч Багшийнхаа ном тайлсан дууны хуурцгийг үргэлжлүүлэн сонсвол та нарт адилхан тустай. Ажлаа хийнгээ сонсвол гэр орны уур амьсгалыг ариусгана. Мөн та нарын үйлийн үрийг ч угаана.

Авшиг хүртээх нь хамаг төрөлтнийг гэтэлгэж байгаа хэрэг. Аяндаа хамаг төрөлтнийг гэтэлгэж, хаана ч очсон тэр газраа ариусгана. Учир нь та нар Багшийн хүчийг түгээн тарааж, энэ дэлхийг ариусгадаг. Хэдийгээр ганц том цахилгаан станцтай ч түүнээс гарах тогийг хаа сайгүй түгээж, улс орныг бүхэлд нь цахилгаанаар хангавал, айл болгон

гэрэлтэй болж хоол хийх, хувцас угаах, гэрээ цэвэрлэх гэх мэт олон зүйлд ашиглана. Та нар бол тэр жижигхэн гэрлийн шилнүүд юм шүү.

Би өмнө нь нэг Их Багшийг таньдаг байлаа. Тэр Германд маш олон шавьтай. Би Германд очсон үед заримдаа хамт бясалгадаг. Тэд тун хичээнгүй, долоо хоногт хамгийн багадаа гурваас дөрвөн хоног хамт бясалгадаг. Орой болгон ажлаа тараад тэнд очиж, бясалгана. Би тэднээр маш их бахархдаг. Танай Формосачууд ч тийм их хичээнгүй биш. Долоо хоногт ганц удаа болдог нийтийн бясалгалдаа зарим нь бас ирэх дургүй.

Энэтхэгийн газар нутаг дэндүү том болохоор Багш дээрээ байнга очих боломжгүй. Тиймээс тэд бичлэг үзэж, Багшийнхаа дүрийг харж, ярихыг хагас цаг, эсвэл нэг цаг сонсоод хамтдаа бясалгадаг. Намайг Энэтхэгт байхад тэд надтай ойр байх, хамт байх тун дуртай байсан. Учир нь заримынх нь бясалгал нилээд сайн, хэн хүчтэйг андахгүй. Тэдний дотор олон жил бясалгасан нэгэн хатха йогийн багш байсан. Цагаан сахал, цагаан толгойтой яг л ариун гэгээн богд хүн шиг харагддаг. Өндөр настай ч тун сүр жавхаатай яг л эртний бясалгагч шиг.

Тэр надтай хамт бясалгах тун дуртай бөгөөд намайг яг л атомын бөмбөг шиг гэдэгсэн. (Багш болоод нийтээрээ зэрэг инээв). Намайг ороод очвол тэр: “Атомын бөмбөг ирлээ” гэнэ. Түүний бодлоор би тун их хүчтэй. Тэгээд атомын бөмбөг гэж нэрлэсэн аж. Тантай хамт суухад илүү амгалан тайван болдог гэж ярина. Тэр үнэхээр дуртай. Намайг очих болгонд л :“Би таны хажууд сууж болох уу? гэж асууна. Магадгүй хожим тэр өөрөө бас атомын бөмбөг болон хувирах байх аа. (Бүгд инээлдэв.)



## АРЬЯАБАЛЫН АРГААР БЯСАЛГАХААС ӨМНӨХ БЯСАЛГАЛЫН АРГА

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Формоса, Тайнан хот, Мадөү  
1988 оны 2 дугаар сарын 13  
(Эх нь хятад хэлээр)*

Багшид хараахан сайн итгээгүй тул Их Багшийг дагаж, Арьяабалын аргаар бясалгаагүй. Гэхдээ гурван муу заяанд унахаас айна. Тэгвэл ямар номоор бясалгасан нь дээр вэ? гэж нэг хүн асуулаа. Учир нь зарим хүн тэнд унаад маш их зовж байна. Тэр хүн болж төрсөн ч ямар аргаар бясалгавал дахин гурван муу заяанд унахгүй байх вэ? гэдгийг ойлгохгүй. Гурван муу заяа гэж юу вэ? Там, бирд, адгуусны төрөл авдаг үйлийн үр юм. Тамд унах, бирд болох нь Молом тойны (Модгальяана) эхийн байдалтай яг адил. Хоол байсан ч идэхийн заяагүй, тогоо шиг том гэдэстэй, хялгас шиг нарийн хоолойтой тул юу ч идэх аргагүй, ус ууя гэтэл аманд хүрэхийн цагт цус, эсвэл шатам халуун ус болон хувирна. Амаар орсон хоол бүхэн төмөр гинж болдог нь өлөн бирдийн эдлэх зовлон.

Бид гурван муу заяанд унахгүйн тулд бясалгадаг. Тийм биз? Тийм муу үр дагаврыг эдлэхийг хүсдэг хүн байна уу? Хэн ч хүсэхгүй! Сайн байна, зарим хүн гурван муу заяаны зовлонгоос ангижрахын тулд юуг бясалгах вэ?

гэж Багшаас нь асуусан. Багшид нь итгэхгүй хүмүүс байгаа учраас тэднийг хүчилж болохгүй. Хэрвээ Багшид итгэхгүй бол ямар арга байх вэ?

Энэ төрөлдөө Төгс Гэгээрсэн Их Багшийг хайж олох хэрэгтэй. Ойлгов уу? Их Багшийг хайх завгүй бол өөрийн дотоодын бурхан чанараа хайх хэрэгтэй! Энэ хүнд итгэхгүй бол өөр хүнд итгэж бас болно. Гэвч Төгс Гэгээрсэн Их Багшийг заавал хайж, Бурхан бодьсадвагаас чин сэтгэлээсээ тусламж гуйвал бид Төгс Гэгээрсэн Их Багшийг лавтай олно. Энэ насанд минь намайг жинхэнэ Төгс Гэгээрсэн Их Багштай учруулж өгөөрэй гэж даатгаарай. Төгс Гэгээрсэн Их Багшийн гадаад байдал нь сүр жавхаатай, эрдэм мэдлэгтэй, зөн билиг, ид шидтэй, хүч чадалтай өндөр төвшний Будда бол биднийг гурван муу заяаны зовлонд яасан ч унагахгүй. Гэвч энэ насандаа дахин уузахгүй байж магадгүй. Учир нь та өөрөө хэдийнээ Түүнээс татгалзчихжээ! Багшийг дагаж сураагүй хүмүүс бага ч гэсэн итгэлтэй байх хэрэгтэй. Багахан итгэл байвал гурван муу заяаны зовлонд унахгүй юм.

Арьяабалын аргаар бясалгаагүй бол ахин нэг төрөл аваад Их Багштай дахиад нэг уулзана. Гэвч тэр үед Багшийнх нь гадаад төрх өөрчлөгдөж, ийм урт сахалтай болсон байж магадгүй. Ойлгов уу? Эмэгтэй хүн биш, харин эрэгтэй хүн, эсвэл бүр эхээс төрөхдөө л шууд амьд бурхан болон мэндэлсэн жаахан хүүхэд ч байж магадгүй. Тун хачирхалтай шүү, би бага наснаасаа өнөөдрийг хүртэл өчнөөн олон жил бясалгасан тул өөрийгөө Будда гэхэд буруу нь юу байх вэ. Тийм үү? Төвөдөд тун олон амьд Будда хөлхөлдөж байхад хэн ч юу ч хэлдэггүй. Манай Формосад ч мөн маш олон хүн тэдгээр амьд Буддад мөргөж байдаг. Гурав, дөрөвхөн настай Төвөд лам нар бясалгасан юмгүй, айлдсан ганц шад номгүй атал хэдийнээ амьд Будда болдог. Та нар сонссон уу?

Ингэж төрсөн Буддаг хэн ч эсэргүүцэхгүй, хэн ч

түүнийг гадаад номтон гэхгүй. Гэтэл би тун их зовж зүдрэн бясалгаад, өөрийгөө Будда гэвэл хэтрүүлсэн явдал болохгүй байх. Тийм үү? (нийтгээрээ, тийм гэж хариулав) За, та нар Багшийгаа Будда болгон өргөмжиллөө. Би үнэхээр их талархаж байна. Арван гуравны өдөр Тайнаны Мадөүгийн нэгэн бага сургуулийн байранд Будда болж, номын хурал дээр хэдэн зуун хүн өргөмжлөв хэмээн өдрийн тэмдэглэлдээ бичнэ ээ.

Хэрвээ бидэнд Төгс Гэгээрсэн Их Багшийг хайж олох чин үнэн сэтгэл байх аваас яагаад ч тамд унахгүй. Үүнийг сайн тогтоож ав! Багшид итгээгүй ч, үнэнийг хайсан чин сэтгэл заавал байх хэрэгтэй. Ойлгов уу? Тийм бол тамд унахгүй. Гэхдээ боломжийнхоо хэрээр мацаг хоол ид. Хэрвээ байнгын мацаг хоолтон болж чадахгүй бол аль болох мацаг хоол идэхийг хичээ. Ногоо сайн ид, их идэх тусмаа бүр сайн. Амьтны амь насыг хороосноос үүсэх занал хорсол багасана. Ойлгов уу? Боломжтой бол долоо хоногт нэг удаа хоолоо сойж, Авид Бурхан, Арьяабал Бурхан, Манал Бурхан болон өөрийн шүтдэг бурхны тарнийг уншиж, арван зүгийн гурван цагийн Бурхадаас тусламж гуйгаарай. Өнгөрсөн цагийн Бурхад туслахгүй байж магадгүй ч харин одоо амьд байгаа Бурхан заавал тусална. Өөрийн итгэдэг Бурхандаа даатгавал одоогийн Бурхан бас тусална. Ойлгов уу? Чи түүнд итгэхгүй байж болно. Гэхдээ Түүнд даатгавал Тэр бас мэдрэнэ. Багшийнх нь ном тайлахыг сонссон хүн, надад итгэвэл тамд унахгүй.

Зарим хүн Багшаас нь: “Бурхан багш Будда болохоосоо өмнө юу сурсан вэ?, Ямар судар судалсан вэ?” гэж асуудаг. Өнөөдөр Багш нь бясалгахдаа энэ асуултыг саналаа. Энд та нарын дотор ийм асуулт асуух хүн байна уу? Бурхан Багш Будда болохоосоо өмнө Дөрвөн Ведийг судалжээ. Дөрвөн Вед нь Бярманы шашны хамгийн гол судар бөгөөд Бурхан Багш ном тайлахдаа энэ судраас нилээд



их иш татсан байдаг.

Олон хүн Багшийг нь Бярман шашных гэлцдэг. Нээрээ Бярман шашных ч байсан ч хамаагүй, миний багш Шагжамуни Будда ч мөн Бярман шашинтан. Ойлгов уу? Будда болохоос нь өмнө хэн түүнийг сургаж байсан бэ? Тэр бясалгаж эхлэхдээ Бярман шашны номын багшийг даган тэдний сургаалийг судалжээ. Будда болсныхоо дараа айлдсан номнуудын ихэнх нь Бярманы шашны сургаалаас үүдэлтэй байв. Яагаад вэ?

Бярманы шашны Дөрвөн Вэдийг судлах нь ер бусын онцгой явдал бөгөөд зөвхөн нийгмийн дээд давхаргын хүмүүс л судална. Дорд гаралтай хүмүүс судлах байтугай нэрийг нь ч сонсоогүй байдаг. Ном хэвлэх ажил өмнө нь одоогийнх шиг ийм амар хялбар, түргэн шуурхай байгаагүй. Ойлгов уу? Нэг судрыг барлахад маш их хугацаа орно. Зөвхөн баян чинээлэг дээдсийн хүрээнийхэн, эрхэм хүндтэй ахмад хүмүүс л энэ судрыг залдаг байжээ. Энэ байдал олон зуун жил үргэлжилсэн. Тиймээс Бурхан Багш Будда болсныхоо дараа тэдгээр ёс учрыг үргэлж ярьж, олон түмэнд түгээн дэлгэрүүлж, хөгшин залуу, эр эм ямар ч хүн сонсож болно, ядуу зүдүү, нийгмийн доод давхаргын хүмүүс ч мөн сонсож болно гэж байв. Учир нь Тэрээр хэнийг ч үл ялгаварлах сэтгэлтэй, түгээмэл хайртай, энэрэл нигүүлсэлтэй хүн байлаа. Шагжамуни Будда маш энэрэнгүй, маш шударга учраас үй олон хүний бишрэл хүндэтгэлийг олсон юм.

Тэр үед Бярманы шашны маш олон хувраг Түүнийг дагаж, Дөрвөн ведийн сургаалийг судалсан. Гэвч бас олон хүн Түүнийг гадаад номтон гэж байв. Түүний айлдсан номын тал хувь нь Дөрвөн ведийн номлол, тал хувь нь өөрийнх нь болоод шавь нарынх нь ахуй ойлголт байжээ. Нилээд сүүлээр Арьяабалын бясалгалын аргыг уламжлах болсон. Дөрвөн ведийн сургаалд дуу аялгууны тухай маш тодорхой дурдсан байдаг. Ямар ч төрлийн аялгууг маш тодорхой

тайлбарласан байдаг. Гэвч хүмүүс судрыг гүймэгхэн унших төдий өнгөрдөг болохоор яагаад ийм аялгуунууд байдгийг гүнзгийрүүлэн судалж мэддэггүй. Одоогийн Буддын шашны сүсэгтнүүд ч ялгаагүй.

Та бид, (Богдосын ном цагаан лянхуа судар)-ын номын багшийн эрдмийн зүйл бүлгийг уншихад хонхны дуу, цангийн дуу, эсэрваа тэнгэрийн хөгжим, чанагуухи ертөнцийн ялгуулсан дууны тухай өгүүлсэн байдаг. Бид өмнө нь огт сонсож байгаагүй тул нэгэн номын багш гарч ирээд ийм дотоодын дуу аялгууг хэрхэн танихыг бидэнд заан сургавал утгыг нь ойлгохгүй тул гадаад номтон гэж бусдад гүтгэгдэнэ. Энэ нь судар номонд хэт баригдсаныг харуулж байна. Учир нь тэд дотоодын ахуй ойлголтгүй. Тиймээс гадаад ном, харь гарагийн үлгэр түүх хэмээн боддог. Багшийнх нь зааж буй энэ арга Ау Лакын бясалгалын арга биш. Энэ бол Бурханы хутагийг олох номын арга. Эртнээс нааш уламжлагдсаар ирсэн бөгөөд зарим үед аль нэгэн газар дамжлага тасардаг ч хэзээ ч бүрмөсөн тасрахгүй. Үнэндээ бол төрөл тутамд хамаг төрөлтөнд ном уламжлах Бурхан бодьсадва нар заавал залардаг бөгөөд гэтэлж ангижрахыг эрмэлзсэн хүмүүсийг авран гэтэлгэдэг.

Бурхан бодьсадва нар туйлын энэрэнгүй. Үй түмэн галав өнгөрсний дараа сая нэг гарч ирж, хамаг амьтдыг гэтэлгэдэг биш. Хэрвээ тийм бол Бурхан бодьсадва байж нийцэхгүй. Тамын амьтдыг хүртэл гэтэлгэдэг бодьсадва байхад, цагаан цайлган сэтгэлтэй энэ ертөнцийн төрөлтнүүдийг гэтэлгэх бодьсадва байхгүй байх нь зүй ёсонд үнэхээр нийцэхгүй. Тийм биш үү? Тиймээс л Шагжамуни Будда, Будда болсныхоо дараа дөрвөн ведийн сургаалийг яг бярманы шашны номын багштай адил номлосон байна.

Гэвч Бярманы шашны номын багш Түүнийг яагаад гадаад номтон гэсэн бэ? Тэд дотоодын ахуй ойлголтгүй, судар номд бичигдсэн ахуй ойлголтгүй тул Шагжамуни

Буддагийн ярьсан зүйлсийг ойлгоогүй юм. Тиймээс Түүнийг гадаад номтон гэжээ. Харин Бурхан Багш тэднийг гадаад номтон гэсэнгүй. Хэрэв хоёулаа бие биенээ гадаад номтон гэсэн бол Шагжамуни Буддагийн зөв, тэдний буруу байх байлаа. Тэд харанхуй мунхаг учраас Бурхан Багшийг буруутган гүтгэсэн. Бурхан Багш үнэнийг таньсныхаа дараа энэ бүхнийг ярьсан бөгөөд Тэрээр үнэн ёсыг жинхэнээсээ ойлгосон байжээ.

Яагаад Түүнийг үнэн ёсыг ойлгосон гэж байна вэ? Учир нь Тэр ном сударт бичигдсэн дотоодын төвшнийг өөрийн биеэр жинхэнээр ойлгосон хэрэг. Эсэрваа тэнгэрийн оронд очдог тухайгаа бярманы шашны бусад номын багш нарт хэлэхдээ: Би эндээс Эсэрваа тэнгэрийн орон хүртэл чөлөөтэй ирж очдог. Тосгон хүрэх замыг та нар сайн мэддэгтэй яг адил гэжээ.

Бурханы сударт нэгэн хүн түүнээс Эсэрваа тэнгэрийн оронд яаж очих вэ? гэж асуусан байдаг. Эсэрваа тэнгэрийн орон бол бярман шашинтны хувьд хамгийн дээд төвшин. Ойлгож байна уу? Шагжамуни Будда түүнд Эсэрваа тэнгэрийн орон бол бас л тун доогуур түвшин гэж хэлээгүй. Мөн Эсэрваа тэнгэр бол бярманчуудын шүтдэг гадаад номын сахиус гэж ч хэлээгүй. Учир нь Тэр хамаг амьтны аясаар байдаг. Тиймээс Шагжамуни Будда тэр даруйдаа л түүнийг чи бол гадаад номтон, Эсэрвээ тэнгэрийг асууж яах нь вэ? гэсэнгүй. Энэ тосгонд төрж өссөн ч тосгоноосоо хэзээ ч гарч үзээгүй хүнээс нэгэн харь газрын хүн тосгон хүрэх зам асуувал, тэр мэдэх болов уу гэж Бурхан багш бярман шашны хуврагаас асуухад мэдээж мэдэлгүй яахав, тэр чинь энд төрж өссөн хүн шүү дээ гэв. Тэгэхэд нь Шагжамуни Будда: Үүнтэй яг адилхан санаа. Би Эсэрваа тэнгэрийн орноор байнга зочлон очдог. Тэр хүн тосгон хүрэх замыг сайн мэддэгтэй яг адил гэжээ. (Тэр хүн Түүнд итгэсэн байна)

Шагжамуни Будда Эсэрваа тэнгэрийн тухай яриад

гадаад номтон хэмээн шүүмжлүүлсэн нь Багш нь одоо католик шашны тухай ярихад учирч байгаа байдалтай яг адил. Бүгд л намайг гадаад номтон гэж байна. Яагаад би анхнаасаа байнга л Бурхан багшийг ярилгүй, зарим үед бас Есүс Христийн тухай ярьдаг байв аа? Учир нь хамаг амьтны аясыг дагасан хэрэг. Есүс Христэд муу тал ерөөсөө байхгүй. Тэр хамгийн их түгээмэл хайртай, хамгийн их энэрэнгүй сэтгэлтэн. Тэр ямар нэгэн буруу зүйл хийснийг би хараагүй. Та нар Түүнийг буруу муу зүйл хийсэн гэж сонссон уу? Библийн сударт Есүс Христ хэн нэгнийг ингэж хорлов гэж бичсэн байдаг уу? Байдаг уу? Тэр ядаж л хүний өвчнийг эдгээж, үхсэн хүнийг амилуулж, маш олон хүнд тусалж, бусдад ёс зүйтэй байх, дотоодын диваажинаа хайж олохыг заан сургаж байсан. Бүгд л сайн явдал шүү дээ! Бид Түүний ямар дэстэй, яаж бясалгаж байсныг ярихгүй ээ. Бусдын төлөө хийж байсан үйлсийг нь харахад л Тэр хэдийнээ тун аугаа байжээ. Тийм биш үү? Багш нь Түүнээр жишээ болгон ярихад ямар хамаа байх вэ. Шагжамуни Буддатай адил, Тэр бярмань сургаал номлолыг гадуурхалгүй, харин Эсэрваа тэнгэрийн орон хүрэх замыг би мэднэ гэж хэлсэн. Энэ нь юуг илэрхийлж байна вэ?

Шагжамуни Будда ч бас Бурханы тухай байнга яриад байсангүй. Бурхан гэдэг нь Төгс Гэгээрсэн Их Багш гэсэн төдий. Тэр өөрөө Төгс Гэгээрсэн Их Багш гэдгийг бүгдээрээ мэдэж байсан. Үргэлж бурхан, бурханы явдлыг ярих хэрэггүй байсан. Тиймээс тэр хүн хожим нь Шагжамуни Буддаг даган суралцаж, Түүнтэй хамт гэрээс гарч, Түүнийг шүтэн дагажээ. Бас нэг найзыгаа дагуулж ирсэн гэдэг. Тийм биз? Жишээ нь, католик шашинтай хүн энд ирээд, Багшаас нь диваажингийн талаар асуувал би түүнд, чи диваажинд очих хэрэггүй, тэр чинь католик шашны буруу номтны зүйл, би чамд ярьж өгч болохгүй, би бас ярихыг ч хүсэхгүй байна. Би бол Буддын шашинтан гэх мэтээр ярих нь зөв

үү, буруу юу? Гэрээс гарсан хувраг хүний намба төрхөнд нийцэх үү? Тэгвэл яагаад байнга над руу гадаад номтон гэж дайрна вэ? Ямар учиртай болохыг нь би ер ойлгохгүй байна. За за, энийг тоохоо больё. Тиймээс Багш нь Шагжамуни Буддагийн ярьсантай ижил зүйлийг ярьж, хүмүүсийг олон зүйлийн ёс журмаар сургаж, тэдэнд ойлгуулах хэрэгтэй.

Танай эндхийнхэн бүгд төв аялгуугаар ярьдаг. Харин би энд ирээд англи, франц, аулакаар яривал та нар ойлгох уу? Ойлгохгүй. Тиймээс би заавал төв аялгуугаар ярих хэрэгтэй. Яг үүн шиг. Хүмүүсийн шүтлэг бишрэл адилгүй учраас Багш нь өөр олон бясалгалын арга хэрэглэх хэрэгтэй болдог. Хамаг амьганд тустай байгаа нь л чухал. Тэрнээс ямар нэгэн нэр усанд баригдах хэрэггүй. Шагжамуни Будда ч ийм зүйлсэд баригдаагүй байтал би яаж баригдаж болох вэ? Би бол Түүний шавь. Тэгэхээр ийм зүйлст хүлэгдэж болох уу? Түүний үлгэр дууриаллаас яагаад би суралцахгүй байх билээ ?

Багш чинь хамгийн сайн бурхны шашинтан. Үүнийг би зоригтой хэлнэ. Би бас хамгийн сайн католик шашинтан. Мөн хамгийн сайн бумбын шашинтан, Күнзийн сургаалтан юм. Учир нь жинхэнэ үнэн ёс, жинхэнэ үнэн зам мөрийг бясалгаж байгаа хүн шашныг ялгаварлахгүй. Үнэн ёсыг олох нь л хамгийн чухал.

Шашин бүхэн ижил. Шашин нь хүмүүст гадна талд баримтлах ёс зүй, ёс суртахууныг зааж, дотоодын бурхан чанараа эрж олох, Төгс Гэгээрсэн Их Багшийг хайх хэрэгтэй хэмээн сургадаг. Бүхий л шашин ямар ч асуудалгүй гэдэгт бид итгэдэг. Бид өөрсдөө дотоодын ахуй ойлголттой болж, өөрийн шашны гол зорилгыг эрэх хэрэгтэй. Бүхий л шашин диваажингийн орон, тэнгэрийн орон, бурхны орон, бурхан чанараа хайж олохыг ятгадаг. Тийм биз? Хэрвээ бид судар ном уншаад бурхан чанараа олохгүй байгаа бол бусдаас, өөр хүмүүсээс та олсон уу гэж асуух хэрэгтэй. Ингэж асууж

явсаар байгаад нэг л өдөр олсоон гэх хүнтэй таарах болно. Тийм үү? Тэгээд түүнээс: Та намайг дагуулаад явж болох уу? гэж асуу. Болно оо гэвэл, яагаад түүнийг дагаж болохгүй гэж. Тийм биз дээ. Түүнээс мөн та католик шашинтан уу, эсвэл буддын шашинтан уу гэж асууж болно. Аа за, католик шашинтан бол хэрэггүй ээ, та хэдийгээр тэнгэрийн оронд очих байсан ч би таныг дагахгүй, учир нь та бол католик шашинтан байна. Ингэж хэлэх учир байна уу? Ингэж ярьж болох уу?

Хэрвээ католик шашинтай хүн Багш дээр нь ирж, Арьяабалын аргыг сурахыг хүсвэл, би түүнийг та их ёс суртахуунтай, бас ургамал хоол иддэг сайн хүн байна. Гэсэн ч та номлогчийг шүтэн дагасан католик шашинтан болохоор надад таалагдахгүй байна. Таныг шавиа болгож чадахгүй ээ. Ингэж хэлж болох уу? Болохгүй! Тиймээс ямар ч шашинд асуудал байхгүй, ганцхан ялгаварлах үзэлд л асуудал байна. Хэрвээ бид өөрийн дотоодын гэрлээ олвол тэр гэрэл нь диваажин, тэр гэрэл нь бурхан чанар мөн. Бясалгасны дараа аажмаар бид аливаа юмны учрыг мэдэж, судар бүхнийг ойлгож, шашин бүхнийг сэтгэлдээ багтаана. Бүх юмс маш тодорхой болно .

Хэрвээ бид энэ гэрлийг олоогүй бол билиг ухаан маань хэзээ ч нээгдэхгүй. Судар номыг хичнээн удаа уншсан ч тус нэмэргүй. Биднийг гэтлэхэд туслахгүй. Судар ном уншвал хүн ба тэнгэрийн төрөлтөн болж төрөх бага сага буян хураахаас хэтрэхгүй. Бид буян хишиг горилдоггүй болохоор үүнийг би бас баталж чадахгүй. Бидний сонссоноор зургадугаар үеийн их багш Хүй Нэн ганц ч үсэг мэдэхгүй, Тийм биз? Тэр ном судар огт уншаагүй ч хорин насандаа намжир бадар залгамжлаад явж оджээ. Шэньсиу бол түүний номын ах. Тэр гуч гаруй жил Багшийгаа дагаж, судар бүхнийг ойлгох болсон хэдий ч Хүй Нэн шиг агуу байсангүй. Тиймээс Бодьдармаа багш арвин их ном судар

уншиж судлах, сүм дуган барьж байгуулах, ном бичиг сурах нь өөртөө л саад болохоос хэтрэхгүй, ямар ч ач тусгүй гэж маш тодорхой хэлсэн.

Гэхдээ бас ач тусгүй ч биш ээ, ач тустай. Жишээ нь, гэгээрснийхээ дараа бид тэр ном судруудаар хамаг амьтдыг гэтэлгэж болно. Мэдээж тун сайн. Гэвч бид судрын агуулга, ахуй ойлголтуудыг гэгээрснийхээ дараа л жинхэнэ ёсоор ойлгоно.

Би багаасаа ном судар уншаад ойлгодоггүй байсан тул зүгээр л мөргөдөг байв. Арьяабалын аргаар бясалгаснаас хойш хүн заагаагүй ч аяндаа ойлгох болсон. Миний та нарт ярьж байгаа аливаа сургаал номлол нь миний багшийн заасан зүйл биш, харин бүгд миний өөрийн ойлголтууд болно. Заримдаа жишээ нь хотол зохилдогч зүйлийг анх удаа олны өмнө тайлахад би тэр гэгээрэлтэй холбоотой асуултуудыг өмнө нь хэзээ ч бодоогүй байсан, би бас судрыг дахин уншаагүй байв. Жишээ нь, ном тайлах үед шууд урсан гардаг нь ном тайлах тэр мөчид билиг нээгдсэнээс болдогийг өнөөдөр би олж мэдлээ. Намайг юу хэлж байгааг ойлгов уу?

Гэгээрсний дараа л өдөр бүр билиг нээгдэж чадна. Нэг л удаа билиг нээгдээд бясалгал болчихдог юм биш. Аяганы тагийг нэг л авсан бол байнга онгорхой байдаг шиг биш. Ойлгов уу? Өдөр бүр билигээ нээж байх хэрэгтэй. Тиймээс Шагжамуни Будда өдөр бүр бясалгадаг байсан. Зарим хүн Шагжамуни Буддаг Будда болсоныхоо дараа амарч, бясалгал хийхээ больсон гэж надад хэлэв. Би түүнд буруу бодож байгааг нь хэлсэн. Судар болгонд Шагжамуни Будда даяанд сууж, самади агуулсан суудлаасаа дөнгөж гарч ирээд ийм ийм газарт, тийм тийм ном тайлж, сургаал айлдав хэмээн бичсэн байдгийг ном судраас тодорхой уншиж болно. Энэ нь Шагжамуни Будда өдөр бүр бясалган суудаг байсныг харуулна. Тэр өөр онцгой газарт хүмүүсээс

тусгаарлаад тэндээ нам тогтуун бясалган суух бөгөөд дараа нь даяан хийж байснаа гарч ирдэг. Ингэж бичсэн байдаг, тийм үү? Энэ нь Шагжамуни Будда өдөр бүр бясалган сууж, өөр өөр төвшинд хүрч, өдөр бүр гэгээрлийн адилгүй төлөвт байж, өдөр бүр янз бүрийн ертөнцүүдэд очиж, адил бус ахуй ойлголтуудыг ярьдаг байсныг илэрхийлж байна. Будда болсон хүн ч нам тогтуун сууж бясалгаж байхад эгэл хүнийг хэлэхийн хэрэг юун!

Бясалгалд тун олон сонирхолтой явдал тохиолддог болохоор би яриад барахгүй. Би бас тэр бүх дотоодын ахуй ойлголтыг ярьж болохгүй. Учир нь зөвхөн бясалгадаг хүн л ойлгох болохоор үнэхээр харамсалтай. Бид энэ дэлхийн байдлыг ч таашаан эдлэхийн зэрэгцээ дээд дэсийн ертөнцийн сайхныг ч амсан жаргаж болно. Яаж бид өөрсдийгөө үгүйсгэж, гэтэлгэхгүй хорьж, энэ өчүүхэн жаахан уйтан давчуу ертөнцөд өөрийгөө хашаад яагаад ийм өчүүхэн зүйлст сэтгэл ханана вэ? Ихэнх хүн ийм байдалтай байдаг нь үнэхээр харамсалтай. Хэрвээ Төгс Гэгээрсэн Их Багшийг хайж, бясалгал хийх хүсэлгүй бол бас хамаагүй. Дэлхий ертөнц угаас амгалан. Хүн бүхэн өөрийн эрх тааваар байна. Гэвч жинхэнээсээ туулан ангижирч, жинхэнэ эрх чөлөөг олъё гэвэл Арьяабалын аргаар бясалгах хэрэгтэй.





## ӨӨРИЙН ТӨГС ЧАДВАРТ ХҮЧИЙГ ЧАДАМГАЙ АШИГЛА

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Формоса, Тайбэй хотын Сун Ят сений дурсгалын ордонд  
1991 оны 4 дүгээр сарын 19  
(Эх нь хятад хэлээр)*

“Бид бүгдээрээ бурхан чанартай, диваажин бидний дотоодод байдаг” гэдгийг бүгдээрээ сонссон. Гэвч бид яагаад бурхан чанараа олж чадахгүй байгаад байна вэ? Учир нь хаанаас хайж олохыг бид мэдэхгүй байна. Өмнө нь хэн ч бидэнд бүхнийг чадагч их хүчээ хайж олох нь тун амархан, маш энгийн гэж хэзээ ч хэлж байгаагүй. Уг нь бид энэ дэлхийд ингэж зүдэрч, эцэж туйлдатлаа ажиллаад олигтой үр дүнгүй байх ёсгүй. Уг нь бид юу ч хийсэн маш хурдтай байх ёстой юм. Бид юу хийнэ, түүнийхээ төгс төгөлдөр үр дүнг тэр даруйдаа хүртэх учиртай. Гэвч бид өөрийн дотоодын төгс чадварт их хүчийг ашиглаагүйгээс аливааг бүрэн төгс хийж чадахгүй байна, бусдыг төгс төгөлдөр хийхэд нь саад болох үйлдлийг бас байнга гаргаад байна. Энэ бурхан чанар, дотоодын диваажингийн тухай үнэндээ ярих аргагүй. Гэвч бясалгадаг бүх хүн Түүний оршин байдгийг, түүнийг яаж хэрэглэхээ мэднэ. Түүнийг олсон аргаа бусдад хэрхэн дамжуулахаа мөн мэдэж байдаг.

Энэ нь түүнийг хэрхэн олохыг хүмүүст зааж чадна гэсэн санаа юм.

Бясалгагч хүнийг харахад эгэл жирийн хүнээс ялгаагүй. Ижилхэн иднэ, ууна, унтана, амрана, ярина, хөөрнө, ажиллана, хөдөлмөрлөнө. Гэвч Түүний дотоод нь адилгүй. Бид түүнийг Төгс Гэгээрсэн Их Багш, Их билиг нээгдсэн хүн, Их Бодьсадва, Их Гэгээнтэн гэж нэрлэдэг. Тэр жирийн хүнээс юугаараа ялгаатай вэ? Жирийн хүн зөвхөн өмнөх ажлаа л хийдэг. Өөр онцгой чадах юмгүй. Тэд хаана амьдарна, тэндээ л байна. Өөр өөр газарт зэрэг ажиллах хувилгаан бие тэдэнд байхгүй. Тэд өмнөх ажлаа хийгээд үр дүнг нь хүртэнэ. Заримдаа хүртэж ч чадахгүй, чадсан ч тэр нь жирийн л нэг үр дүн төдий.

Эгэл жирийн хүн гэдэг нь дотоодын төгс чадварт их хүчээ олж чадаагүй хүн л гэсэн үг. Өдөр бүр найм, арав, арван хэдэн цаг завгүй ажиллана. Энэ нь ердөө л өөрийн болоод гэр бүл, улс орны ажил төрлийг зохицуулахын төлөө. Заримдаа олон улсын хэргийг шийдэх ажил хийнэ. Гэсэн ч байнга шийдэж дуусахгүй байдалтай. Харин бясалгадаг хүн, төгс чадварт их хүчтэйгээ аль хэдийн холбогдсон хүн бол адилгүй. Тэр магадгүй махан биеэ хооллохоор энд үлдээнэ. Харин хувилгаан бие нь нэгэн зэрэг арав, зуу, арван мянга, зуун сая... Ганга мөрний элсний ширхэг шиг тоолж барамгүй олон газарт өөр өөр ажил зэрэг хийнэ. Адилхан цагт, Тэрээр нэгэн газар сууж байсан ч хувилгаан бие нь хаа сайгүй оршино. Тэр унтаж байхдаа ч орчлонгийн орон зай бүхэнд тоолшгүй, сэтгэшгүй ажлыг хийж байдаг. Тиймээс эгэл хүмүүс Тэднийг “Түүнчлэн ирсэн” гэж нэрлэдэг юм.

“Түүнчлэн ирсэн”-ий утга нь ирэхгүй, очихгүй гэсэн санаа. Жинхэнэ хүн угаасаа ийм байх ёстой. Яагаад угаасаа ийм байдаг вэ? Учир нь бид эгэл хүн биш. Харин энэ ертөнцийн ажил төрлийг хийгээд тун завгүй байдгаас дотоодынхоо бүхнийг чадагч их хүчийг мартсан төдий.

Хэзээ нэгэн цагт энэ их хүчээ мэдэж, өөрийн уг дүрээ таниад жинхэнэ эзнээ олвол мөн адилхан хаа сайгүй оршиж, тэнгэр газрыг донсолгом тоо томшгүй их хэргийг нэгэн зэрэг хийх чадвартай болно. Гэхдээ бидний юу хийж байгааг хэн ч харахгүй, хэн ч мэдэхгүй. Энэ бүхнийг ойролцоох шавь нар, ерөөл барилдлагатай хүмүүс, эсвэл тухайн нөхцөл байдалд холбоотой хүмүүс л мэднэ.

Бүхнийг чадагч энэ их хүч хүн бүхэнд бий. Миний бүхнийг чадагч их хүч, таны бүхнийг чадагч их хүч, хүмүүсийн бүхнийг чадагч их хүч бүгд ав адилхан. Нэгэнд нь арай их, нөгөөд нь арай бага байна гэж байхгүй. Даанч хүн бүхэн Түүнийгээ хайж олох дургүй байдаг. Мөн өөрт нь тийм их сэтгэшгүй ач буян байдагт хүн болгон итгэдэггүй нь үнэхээр харамсаар. Хэрвээ энэ талаар хэн нэгэн хүн бидэнд яривал бид тийм ч амархан итгэхгүй. Тийм учраас маш олон дайралт, эргэлзээ, гүтгэлэг гардаг. Уг нь ийм байдал гаргах огт хэрэггүй. Ямар нэгэн шинэ сэргэг зүйл сонсвол түүний талаар эргэцүүлэн бодож, туршиж, сурч, оролдож үзэх хэрэгтэй. Тэгээд энэ нь яг үнэндээ юу болохыг мэдээд дараа нь түүний сайн, мууг шүүн дүгнэнэ. Гэтэл бид шинэ зүйл сонсмогцоо бодит нөхцөл байдлыг нь ойлголгүй, туршиж үзэлгүй, шууд шүүмжилдэг нь дэндүү түргэдсэн, хэтэрхий хариуцлагагүй, өөртөө тун шудрага бус хандаж байгаа хэрэг мөн.

Хүн төрөлхтөн эртнээс нааш оршин амьдрах чадвартай, дэвшил хөгжлийн төлөөх зориг санаатай байсан учраас гараг дэлхий маань ийм тавтай тухтай болсон билээ. Би ёс суртахууны талд гарсан өөрчлөлтийг бус, материаллаг талын өөрчлөлтийг хэлж байна. Материаллаг талаараа бид олон мянган жилийн өмнөхөөс хамаагүй сайжирч, тав тухтай болсон. Бидэнд юм бүхэн байна. Хаашаа ч явахад хурдан, хялбар болжээ. Дэлхий дахины шинэ мэдээ, мэдээллийг саадгүй сонсож байна. Хоол хүнс, амьдрах орон байр, эм

эмнэлгийн үйлчилгээ сайжирсаар байна. Энэ дэлхийд төрөл тутамд заларч байсан маш олон соёлт төрөлтнүүд өндөр хөгжилтөй дээд гарагуудаас ирж, билиг ухаанаа ашиглаж, өөрийн чадвараа хөгжүүлэхийг бидэнд байнга сануулж байсны ачаар манай дэлхий ийм соёлжингуй гараг болсон.

Манай ирээдүйн гараг дэлхий улам соёлжингуй болно. Учир нь тэр соёлт төрөлтнүүд манай дэлхийд тасралтгүй хүрэлцэн ирж, биднийг сурган хүмүүжүүлж байна. Соёлт төрөлтнүүд гэдэг нь сахиусан тэнгэрүүд, богд гэгээнтнүүд, шинжлэх ухааны эрдэмтэд юм. Тэд өөр гарагаас манай дэлхийд төрөл аван бууж ирдэг. Хамгийн дээд зэргийн эрдэмтэд нь Есүс Христ, Зөнч Мухаммед, Шагжамуни Будда нар болно. Тэд ойлгохгүй зүйл, чадахгүй явдалгүй. Гэвч тэдний хийх арга нь эгэл жирийн биднийхээс өөр. Тэд аливааг ямар ч ул мөргүй хийнэ. Учир нь Тэдний юу хийж буйг бид хараагүй болохоор тэд бол сэтгэшгүй, гарамгай, маш их соёлтой, үнэхээр агуу төрөлтнүүд гэж итгэхэд бэрх байдаг. Гэвч бид ч бас юу ч хийсэн яг ийм байх ёстой. Луузын хэлсэн “Аяндаа” гэсний утга нь энэ юм. Бясалгагч хүн ийм төвшинд хүрвэл энэ “Аяндаа” гэдгийн учрыг ойлгоно. Түүнчлэн ирнэ гэдгийн утгыг, Есүс Христийн дэсийг, Түүний яаж ажилладаг байсныг ойлгоно. Энгийн хүний хувьд энэ бүхнийг ойлгоход хэцүү. Ямар нэгэн шинжлэх ухаан, анагаах ухаан сурч буй хүн суралцах тусмаа дадлага туршлагатай болж, мэргэжлийн ажлаа хэрхэн яаж хийхийг улам сайн мэддэг болно. Харин бусад хүн хажууд нь байсан ч түүний хийж буй ажлыг ойлгохгүй байж магадгүй. Энэ дэлхийн эрдэм мэдлэгийг ойлгоход ийм хэцүү байхад материаллаг төвшнөөс хэтийдсэн мэдлэг, чанагуух ертөнцийн чадварыг ярихын аргагүй юм. Эгэл хүмүүс бид тэр цаглашгүй их билиг ухаанаас суралцаж, өөрөө ашиглахгүй бол яаж ойлгож чадах вэ? Тиймээс хэн нэгний дайрч довтлох нь, их бясалгагчдыг ойлгохгүй байдаг

нь зүй ёсны хэрэг. Гайхаж цочоод байх юмгүй. Учир нь сурсан зүйл нь адилгүй хоёр хүний үзэл бодол нь ч бас адилгүй.

Бага сургуулийн сурагч, их сургуулийн хичээлийг ойлгохгүйтэй яг адил. Бид сурч судалж байгаа зүйлээ заавал мэднэ, ямар нэгэн хэмжээгээр ойлгоно. Их сургуулийн сурлага муутай оюутан, хамгийн тааруухан оюутан ч бага сургуулийн хамгийн сайн сурагчаас дээр байх нь мэдээж. Тиймээс заримдаа бясалгагч хүмүүс бие биенээ аяндаа ойлгодог. Хэдийгээр бүгд адил тэгш боловч бүхнийг чадагч их хүчээ хөгжүүлэхгүй, билиг ухаанаа нээж ашиглахгүй бол адил тэгш биш болох бөгөөд адил тэгш байх ч аргагүй юм. Яг адилхан хоёр оюутан, нэг нь тун хичээнгүй, нөгөө нь залхуу бол нэг танхимд хамт хичээллэж, нэг багшаар заалгаж, сурах боломж нь ижил, ухаан санаа нь адилхан цэцэн сэргэлэн хэдий ч хичээл номдоо хандах хандлага нь өөр бол үр дүн нь ч өөр өөр байна.

Сургуульд сурч байхад өвдөх, гадагшаа явах, хичээлдээ явалгүй тогломоор санагдах гэх мэт ямар нэгэн шалтгаанаар чөлөө авах үе байдаг. Ганц хоёр хоногийн дараа ирэхэд нилээд хоцорч, багшийнхаа зааж байгааг ойлгохгүй болсон байх тул даруй нөхөж авдаг. Тийм биз? Дотоодын бурхан чанар, билиг ухаан ч ялгаагүй! Түүнийг хэрэглэхгүй, уудалж гаргахгүй, таньж мэдэхгүй бол байгаа нь байхгүйтэй адил болж ямар ч тус нэмэргүй. Тун их зовлон бэрхшээлтэй тулгарах, үхэж сэхэхийн даваан дээр байх үедээ бид дотооддоо чин сэтгэлээсээ даатган залбирах бөгөөд энэ үед бидний билиг ухаан түрхэн зуур тодрон гарч, бидэнд тусалдаг. Гэвч ийм байдал тун ховор тохиолддог, яагаад тэр вэ?

Бидний дотоодын билиг ухаан яг л усны цорго мэт. Дотроо устай ч дэргэд нь бид даатгах төдий байвал тэр урсан гарахгүй. Түүнийг яаж нээдгийг мэдэх хэрэгтэй. Би

усанд дуртай, надад ус хэрэгтэй байна гэж хэлж болно. Гэвч усны цоргыг нээсэн цагт л устай болно. Жирийн хүмүүсийн амьдрал үнэхээр өрөвдөлтэй. Хичнээн хичээж, зовж зүдэрч ажиллаад хичнээн их чин сүжгээр залбирч даатгасан ч сэтгэл нь хангалуун биш, амьдрал нь зовлонгоор дүүрэн байдаг. Хэрвээ бид өөрийн жинхэнэ эрдэнэсийн сангаа хаана байдгийг мэдэж, хамгийн зөв даатгах аргыг сурвал хүссэнээ хүртэхэд хөнгөн хялбар болно.

Шагжамуни Будда уг нь хүссэн юм бүхэн нь элбэг дэлбэг хааны хүү байсан. Гэсэн ч Тэр яагаад бясалгаж амьдрахыг илүүд үзсэн бэ? Тэр өдөр бүр бадар барьж, өчүүхэн бага зүйлээр өл залган хаа сайгүй явж, хамаг төрөлтнийг заан сургаж, удирдан чиглүүлж байв. Хааны хүү байх нь түүнд тавтай тухтай биш үү? Наад зах нь эд баялагаар элбэг дэлбэг тул энд тэнд бадар барьж явах хэрэггүй. Хоол унд, хувцас хунар, орон байранд санаа зовохгүй. Гэсэн ч энэ бүхнээс хавьгүй их, үй түм дахин үнэ цэнэтэй эрхэм нандин зүйл байдгийг бясалгагч хүн мэддэг. Тэр нь бидний амьдралыг тав тухтай, аз жаргалтай болгодог болохоор түүнийг ямар нэгэн материаллаг эд зүйлээр солих бодол огт үгүй.

Шагжамуни Будда бас мэдэж байсан нь гарцаагүй. Хэрвээ түүнд эд баялаг хэрэгтэй байсан бол олоход хялбар байсан. Гэвч нэгэнт хутагийг олсон гэгээнтэн хүн эд хөрөнгөнд үл шунаж, юу байна түүнийгээ л эдэлнэ. Эд зүйл эдэлж хэрэглэхэд баясахгүй. Маргааш идэх хоол, орох оронгүй болох вий гэж үргэлж айж эмээж явдаг эгэл бидний сэтгэлгээтэй адилгүй.

Есүс Христ ч мөн адилхан ёс учрыг ярьж: “Маргаашийн төлөө санаа бүү зов, тэр өөрөө өөрийгөө харж хандана” хэмээн сургаж байв. Тэрээр шавь нартаа хандан: “Бүү ай, маргааш юу өмсөх, юу идэх талаар бүү бод. Эзэн Бурхан бүгдийг зохицуулна” гэж байв. Мөн: “Эзэн Бурхан

нэгэн зэрлэг сараана цэцгийг ч тийм сайхан харж хандаж байхад хүмүүс биднийг бүр ч илүү сайн харж хандана” гэжээ. Тэдний бодол санаа, хийж бүтээх бүхэн нь бидэнтэй адилгүй. Зарим нэг ажил нь биднийхтэй ижил байж болох ч Түүний дотоодод бүх юм тун ойлгомжтой байдаг.

Шагжамуни Будда: “Будда, эсвэл маш өндөр дэстэй бодьсадвагаас бусад нь Буддаг ойлгож чадахгүй” гэж айлдсан. Хэрвээ тийм бол Тэр яагаад: “Хамаг амьтанд бурхны билиг ухааныг ойлгуулахын төлөө Би энэ ертөнцөд бууж ирсэн” гэж айлдсан бэ? Бурханыг ойлгож чадах хүнгүй юм бол Тэр яагаад бурхны билиг ухааныг бидэнд ойлгуулах үүрэгтэй бууж ирсэн бэ? Энэ бүхэн бидний залбирал даатгалаас болсон байна. Зарим хүний даатгал ийм их хүчтэй. Өөрийн билиг ухаан, бурхан чанараа хөгжүүлж, дотоодын их билиг ухаанаа хайж олох чин сэтгэлтэй хүмүүс байдаг. Тиймээс Шагжамуни Будда дөчин есөн жилийн турш хамаг төрөлтнийг сурган хүмүүжүүлэхийн төлөө зовлон бэрхийг хайхралгүй, газар сайгүй явж, бурхны билиг ухааныг хэрхэн ойлгох, бурхан чанараа яаж олох, олсны дараа аажим аажмаар таньж, улмаар бурхантай ямар ч ялгаагүй нэгэн ижил болж болохыг зааж байжээ.

Шагжамуни Будда: “Би Будда болов. Та нар бол ирээдүйд Будда болох хүмүүс” гэж айлдсан. Та нар хэзээ ч Будда болж чадахгүй гэж Тэр хэлсэнгүй. Есүс Христ: “Гүн нууцлаг зүйл, гүн нууцлаг үйлийг би хийж байгаа бол та нар ч бас ирээдүйд хийнэ. Магадгүй бүр ч илүү хийх болно” гэж байв. Энэ хоёр аугаа их Төгс Гэгээрсэн Их Багш бидэнд хэдийнээ ингэж айлдсан байхад бид яагаад өөртөө итгэхгүй, агуу их чадвараа нэн даруй эрж хайхыг хичээхгүй, зөвхөн эртний Их Багш нарыг шүтсээр сууна вэ?

Шагжамуни Будда, Есүс Христ болон бусад Төгс Гэгээрсэн агуу Их Багш нар энэ ертөнцөд биднээр шүтэн бишрүүлэхийн төлөө залраагүй юм. Харин бид Тэднээс

ялгаагүй, Төгс Гэгээрсэн Их Багш нартай ижил зам мөрөөр явбал бид өөрсдийн агуу их хүчийг олж, Тэдэнтэй ав адилхан болох боломжтой гэдгийг та бидэнд ойлгуулахын төлөө заларсан билээ. (бүгд алга ташив) Гэвч бид энэ гол агуулга, чухал зааврыг мартаж, өглөөнөөс үдэш болтол ажиллаад завгүй, Төгс Гэгээрсэн Их Багш нарт мөргөөд завгүй болсон тул Тэдэнтэй яг адилхан тийм агуу гэдгээ мартчихаад байна.

Би ч ялгаагүй урьд нь өөрийн агуу хүчийг мартсан байсан. Гэвч би тун азтай. Зовж буй хамаг төрөлтийг хараад тэднийг үнэн голоосоо энэрэн хайрлах сэтгэл надад байсан болохоор тэр даруйдаа сэрж чадсан. Тэр зовж буй хамаг төрөлтийг аврахын төлөө бүхнийг чадагч их хүчээ дахин таних, Будда болж чадах, тийм их хүч өөрт байдгийг мэдэх нэгэн арга олохыг би маш их хүссэн. Хэрвээ бид нэгэн зүйлийг үнэн сүсгээр үргэлж даатгавал бидний дотоодын бурхан бүхнийг зохицуулж, хаа нэгтээ хүргэнэ, хэн нэгэнтэй уулзуулна, эсвэл ямар нэгэн учрал тохиол бүрдүүлж, бурхан чанарыг маань таниулдаг юм. Энэ бүхнээ таньж мэдэхийг хүссэн чин үнэн сэтгэл байгаа л бол хүсэл чинь заавал биелнэ. Тэрнээс сүр жавхлантай баяр ёслол хийж, цэцэг жимсээр уул овоо тахиж, энэ сүм, тэр дуганд очиж мөргөх ямар ч шаардлагагүй. Чин үнэн сэтгэл байхад л бүрэн хангалттай.

Би өөрийн Бурхан чанарыг таних тэр агшинд сүм хийд, эсвэл мөргөлийн дуганд байгаагүй. Одоо ч гэсэн өдөр бүр өөрийн бурхан чанар, өөрийн диваажинг сүм хийдэд очвол таньдаг юм биш. Харин бидний бурхан чанар, бидний диваажин мөч хором бүрт бидэнтэй хамт байдгийг улам сайн таньсаар байна. Бид хаана ч хэзээ ч тэр Бурхан чанар мөн. Бидэнд Диваажингийн чанар угаасаа байдаг. Бид мунхаг харанхуй, маргалдах дуртай эгэл жирийн хүн огт биш, Ли хатагтай, Жан ноён, алдар цуутан, эсвэл юу ч үл ойлгох сул дорой нэгэн ч биш. Харин бид хэзээ ямагт



Бурхан мөн.

Хэрвээ хүн өөрийгөө Бурхан гэдгийг хэдийнээ танивал өөрийгөө маш мундаг хэмээн бодож, дүр төрх нь өөрчлөгдөөд их баяр баясалтай, омголон давилуун болдог гэж бодож магадгүй. Үнэн байдал тиймгүй. Үнэхээр тиймгүй. Бурхан чанараа таньсаны дараа, хүн чинь угаасаа ийм байх ёстой юм байна шүү дээ гэдгийг ойлгож, жинхэнэ жирийн хүн болдог. Өмнө нь бид үнэндээ жирийн биш байжээ. Өөрт байгаа асуудлаа ч ярьж чадахгүй, юу хэрэгтэйгээ ч хэлж зүрхлэхгүй, хүссэн зүйлээ авч байна ч гэж төсөөлөх зориггүй байжээ. Бид Бурхан чанараа таньсны дараа өөртөө улам итгэлтэй болж, бүхнийг зүй ёсны хэрэг хэмээн үзэх болно. Бидэнд хэрэгтэй байгаа юм бүхнийг заавал хүртэх юм.

Өмнө нь бид маш их цаг зав, хөрөнгө мөнгө зарцуулан энэ, тэр зүйлсийг худалдан авч Бурхан бодьсадвад тахил өргөдөг байсан. Бараг л Бурхан бодьсадваг хахуульдаж, Эзэн Бурханыг хахуульдаж, Бурхан бодьсадватай солилцоо хийх санаатай байжээ. Би үүнийг танд өргөө, та надад түүнийг өгөөрэй гэх жишээтэй. Гэсэн ч санаанд хүрэхгүй, байнга сэтгэлээр унана. Тиймээс заримдаа Эзэн Бурханд уурлаж, Бурхан бодьсадваг сэргэг соргог байсангүй хэмээн зэмлэнэ. Гэвч бид нухацтай сайн бодсон билүү? Эзэн Бурхан, Бурхан бодьсадва үнэхээр аугаа бөгөөд нэр алдартаа нийцдэг л бол яаж нэгэн наймаачин шиг байх билээ? Тиймээс ийм байдал үүсдэг нь бидний буруугаас, Бурхан бодьсадваг үл хүндэтгэснээс болсон хэрэг. Жинхэнэ Эзэн Бурхан, жинхэнэ Бурхан бодьсадва яаж биднээр ямар нэгэн өргөл өргүүлэх вэ? Тэд биднээс зөвхөн та бол өөрөө бурхан чанар мөн болохоо таних, бүхнийг чадагч их хүчтэй гэдгээ ойлгохыг л хүснэ. Бид юу ч хүсч гуйх хэрэггүй, Энэ их билиг ухаан аяндаа орчлонгийн хамтаар бүхнийг зохицуулж, биднийг ханамжтай болгож байдаг юм.

Миний шавь нар хичээнгүйлэн бясалгах тусмаа

аяндаа сэтгэл ханамжтай, улам их баяр жаргалтай болж байдаг. Үүнийг бас сайн дүрсэлж чадахгүй байна. Бид зөвхөн өөрөө л мэдэх төдий. Яг л бид ус ууж, сүү амсвал, жимс, жигнэмэг идвэл тэр амтыг өөрөө л мэдэхээс хажууд хараад зогсож байгаа хүн мэдэхгүйтэй адил. Тэр сайхан амтыг бидэнтэй адил эдлэн баясах аргагүй. (Бүгд алга ташив.)

Тиймээс өнөөдөр миний тайлсан номд алга ташаад бас тэгж их догдлоод баймаар зүйлгүй. Учир нь энэ бүхэн тун энгийн учир явдал. Заримдаа жаахан хурцхан сэдвээр яривал хүмүүс алга таших дуртай байх нь мэдээж. Өнөөдөр бол ном тайлсан анхны өдөр. Байнга бие биетэйгээ танилцах маягаар л өнгөрдөг. Өнөөдөр энд эргэлзэж тээнэгэлзсэн, сандарч тэвдсэн, сонжиж сонирхсон олон янзын ээдрээтэй сэтгэлтэй хүмүүс байна. Харин миний сэтгэл хэзээ ч хувирахгүй. Хүмүүсийн сэтгэл байнга хувирч байдаг. Эхний өдөр ер нь ойлголцоход жаахан хэцүү байдаг. Хоёрдох өдрөөс байдал арай дээрдэнэ. Тиймээс Бурхан бодьсадва бидэнд иймэрхүү бага сага хэрэг явдал өгөх, бидний эд зүйлийн хэрэгцээг хангах төдийгүй, бас биднийг бурхан чанараа таньж, хэн болохоо мэдэж, бүхнийг чадагч их хүчээ олоод өөрийгөө төдийгүй, өрөөл бусдыг аварч, гараг дэлхийгээ адислахыг хүсдэг билээ. Үнэндээ энэ бол бидний үүрэг хариуцлага юм. Хүн болж төрсний хамгийн гол зорилго нь Бурханы хутагт хүрч, төгс их хүчээ танин мэдэх явдал. Харин хүүхэд төрүүлж, идэж ууж, найм, арав, арван хэдэн цагаар өдөр бүр завгүй, зовж зүдэрч ажиллахын төлөө биш. Энэ бүхнийг бид жич амжуулна. Энэ нь үнэндээ тун өчүүхэн явдлууд. Хийсэн ч тийм их нөлөөгүй. Харин бид хүний амьдралын хамгийн гол зорилго болсон хэн гэдгээ таньж мэдэх ёстойг хэзээ ч мартаж болохгүй. Учир нь хэрвээ бид арш сахиус, ад чөтгөр, амьтан ургамал, чулуу шороо болоод төрсөн бол энэ агуу хүчээ таньж мэдэх ямар ч боломжгүй

байсан. Гагцхүү хүн болж төрсөн цагт л бясалгах завшаан олддог болохоор шашин бүхэн олдхойяа бэрх хүний төрөл хэмээн чухалчилдаг. Хэрвээ та бид өөрийн эрхэм нандин тэр зүйлтэй учирч чадалгүй энэ ховор нандин хүний биеийг шамшигдуулвал хичнээн хайран.

Маш цөөн хүн өөрийн энэ эрхэм нандин зүйлээ, агуу чадвараа таньж чаддаг. Тиймээс манай дэлхий одоо ч бас харанхуй мунхаг төрөлтнөөр дүүрэн хэвээр байна. Дайн дажин, гай гамшиг, зовлон зүдгүүр ч хангалттай их байна. Гэсэн ч хамаагүй, бүгдээрээ алгуур аажмаар хэдэн мянган жил, эсвэл хичнээн жил хүлээсэн ч яахав. Харин зарим хүн үнэхээр хүлээж чадахгүй болсон. Тэд энэ дэлхийд сатаарахаа больж, өөрийн агуу бурхан чанар, бүхнийг чадагч их хүчээ даруй олохыг хүсэж байна. Манай Арьяабалын бясалгагчид тийм хүмүүст туслах болно. Тиймээс бидэн лүү дайрч давшилан гүтгэн муулаад байх ямар ч хэрэггүй. Бид хэзээ ч хэнийг ч албадаж байгаагүй. Олж мэдсэн зүйлийнхээ сайн сайхныг өөрийн биеэр амсаж мэдрээд баталж нотолсон болохоор түүнийгээ бүх хүнтэй нээлттэй хуваалцдаг. Зөвхөн ийм хэрэг.

Яг л шинжлэх ухааны эрдэмтэд ямар нэгэн шинэ багаж төхөөрөмж зохион бүтээж, олж илрүүлэн хүн төрөлхтөнд тусалдаг бөгөөд тэдний соёл иргэншлийг урагшлуулж, аж амьдралыг нь тав тухтай болгодог шиг. Тэд ч мөн чадлынхаа хэрээр хүмүүст хэрэглүүлж, олны хүртгээл болгохыг чармайдаг. Бясалгагч хүмүүс ч ялгаагүй. Хүн бүр Эзэн Бурханаас хүртсэн өөр өөрийн ач ивээлээ бусдад зориулж, түүнээс амсаж эдлэх боломжийг бүгдэд нээлттэй олгодог. Гэвч хүртэх хүсэлгүй хүмүүс бас байж болно. Асуудалгүй! Хэрвээ бид өөрөө бясалгагч хүн байтлаа хүчирхийлэх бодол санаатай, бүдүүлгээр бусдыг дайрвал өөрөө бусдад дорд үзэгдэнэ. Хүмүүс ч бидний доогуур дэстэйг харна. Ярихгүй бол хүмүүс ойлгохгүй, яривал төвөг

удна. Бусдыг гүтгэн гүжирдэх, дайран довтлох нь өөрийгөө л хорлохоос өрөөлийг хорлохгүй. Учир нь хүн бүхэнд өөрийн гэсэн цэцэн мэргэн чанар, билиг ухаан, зөв бурууг магадлан дүгнэх чадвар байдаг.

Манай энэ бясалгалын нийгэмлэг ч сайн санааны үүднээс үүссэн! Бид хамаг амьтанд сайн сайхан зүйлийг түгээхийг хүссэн билээ. Хэзээ ч бид хүмүүсийг хүчилж байгаагүй. Бидэнтэй нэгдэж хамт бясалгахыг хүссэн ч бас тийм амар санаан зоргоор болохгүй! Тиймээс бүү ай! Албадаж байгаад бясалгуулах вий гэж бүү сандар! Шавь нарыг чинь урвуулахгүй, ер нь та нарыг яах ч үгүй! Бидний сорилт шалгалтыг хүлээн авч, тэсэж давах хүн тун ховор. Насан туршдаа ургамал хоол, ногоон хоол идэх хэрэгтэй болно. Олон хүнд үүнийг зөвшөөрөх нь тун хэцүү байдаг! Тэгээд бас сахил сахих хэрэгтэй, өдөрт доод тал нь хоёр, гурван цаг бясалгана. Нийтийн бясалгалд оролцоно. Үнэнийг хайх чин сэтгэлгүй хүн бол яаж энэ бүхнийг хийж чадах вэ? Тиймээс шашны урсгалууд, номын багш нар, бясалгалын бүлгэмүүд, бясалгагчид хэн нь ч сандарч тэвдэх хэрэггүй. Хүмүүс сандархаараа харалган болдог. Ойлгов уу? Хийх юмаа ч сайн хийхгүй. Хэт их сандарч, эгэл хүний ухаанаар учир явдлыг магадалвал нилээд оновчгүй болж мэднэ. Бид Бурхан бодьсадваг түших хэрэгтэй. Ямар ч үйл хэрэг хийсэн Оройн дээд их билиг ухааныг түших хэрэгтэй. Тэгвэл хожим харамсах явдал гарахгүй. Гэвч хэдийнээ ийм их чин сэтгэлээр бясалгасан бол орчлон ертөнц энх амгалан байж, бүх хүн гэгээрч, эртхэн гэтлэх болоосой гэж даатган хүсэх нь хамгийн сайн, хамгийн их ач буянтай юм. Харин хувийн өс хонзонгоо Бурхан бодьсадвад даатгаж, тэдэнд төвөг удах нь тийм ч сайхан зүйл биш шүү! Итгэж даатгах, түшиж тулах Бурхан бодьсадва, Эзэн Бурхантай бясалгагч хүн гэж та өөрийгөө боддог бол Тэдэнд найдаж, бидний өмнөөс юм бүхнийг шийдвэрлэж чадна гэдэгт

итгэх хэрэгтэй. Учир нь Эзэн Бурхан: “Өшөө авах эсэх нь Түүний таалал. Бидний чадах зүйл биш” гэжээ. (Don't judge others if you don't want to be judged) гэдэг нь: “Та шүүмжлэгдэхийг хүсэхгүй бол бусдыг бүү шүүмжил” гэсэн утгатай. Тэр бас: “Judgement belongs to me” гэж хэлсэн. Энэ нь: “Шүүх эрх нь Түүнийх, Эзэн Бурханд хамаарна” гэсэн санаа. Хэрвээ бид Эзэн Бурханд, Бурхан багшид итгэдэг бол Тэднээр бүхнийг шийдүүлэх хэрэгтэй. Тэгвэл бид үйлийн үрд унахгүй. Тиймээс би энэ нууцыг та нарт чин сэтгэлээсээ хэлж байна. Өнөөдрөөс эхлээд үүнийг сайтар тогтоож ав! Бас бодитойгоор хэрэгжүүл! Эс бөгөөс тун олон төвөгтэй явдал үүсч, бясалгал чинь амжилтгүй болно!

Шагжамуни Будда энэ дэлхийд заларч байхдаа ямар зүйлс хийсэн вэ? Тэрээр: “Бурхан барилдлагагүй хүнийг гэтэлгэхгүй” гэж айлдсан. Тэр бүхий л боломжоороо ном айлдаж байжээ. Тэр өөрийн дотоод сэтгэлийн ухаарал, олж хүртсэн номын ёс, ач тус, билиг ухаанаа хүмүүст ойлгуулахийн төлөө өргөл болгосон юм. Хэрвээ чи түүнийг нь хүртэхийг хүсвэл сонгож болно. Хүсэхгүй ч байж болно, хамаагүй. Тэр орчлонгийн үйлийн үрд хэзээ ч хөндлөнгөөс оролцохгүй, харин хамаг төрөлтний хүсэл эгээрлийн дагуу л хийж байдаг. Ойлгов уу? Есүс Христ ч мөн адил. Тэрээр шавь нартаа хандан маш болгоомжтойгоор: “Сувдыг тооройд өгч идүүлж болохгүй!” хэмээн хэлжээ. Тэр хэзээ ч, та нар хурдхан гарч яваад бүх гахайг цуглуулж, бидэнд байгаа хамаг сувдыг тэдэнд өгч идүүл гэж хэлээгүй юм.

Их бясалгагчид хэрвээ шавь сонгох болбол тун их зовж, хатуу чанга хандаж сонгодог. Хэний цаг нь болсон, хэн нь бясалгаж чадах, хэн нь чадахгүйг Тэд угаасаа мэдэж байдаг. Тэдний хэн нь ч олон шавьтай болохыг хүсдэггүй. Үгүй! Үгүй! Ийм маягийн шунал байж болохгүй. Байсан ч санаан зоргоор болохгүйг бүгд мэднэ! Аливаа бүхнийг Эзэн Бурхан, Бурхан бодьсадва зохицуулдаг. Хэрвээ бид

хэн нэгний хийсэн ярьсныг буруутгаж байгаа бол Бурхан бодьсатва нарын хамгийг болгоогч мэлмийг үл ойшоосон хэрэг болно. Тэд өөрт хамаатай бүхнийг зохицуулж байдаг.

Би цөөнгүй хүмүүсийг шавиа болгохоос татгалзсанаа та нарт шулуухан хэлье! Хамаг шавийг минь хамж аваад явчих вий гэж сандарч байгаа хүн гадуур тун олон байгааг сонсоод гайхаж байна. Үнэндээ ийм явдал байхгүй! Хүмүүсийн төсөөлөн бодох чадвар тун баялаг юм. Гэрээс гарсан хувраг, гэрээс гараагүй эгэл хүмүүсийн аль аль нь манай бүлгэмд элсэн ороход тийм ч амархан биш. Өмнө нь олон хүнийг зөвшөөрөөгүй. Боломж байвал хойшид ч зөвшөөрөхгүй байж магадгүй. Гэвч олны өмнө ном тайлах үеэр хүмүүсийн хүсэлтийг нээлттэй хүлээн авах болдог. Тэгээд ургамал хоол идэж, сахил сахиж, бясалгаж чадна хэмээн зөвшөөрсөн ямар ч хүнийг авшигт бүртгэдэг. Би нэг нэгээр нь гаргаж ирээд тэр нь болно, энэ нь болохгүй гэхийн аргагүй. Ойлгов уу? Учир нь хүн бүхэн бясалгаж болно гэж хэдийнээ зөвшөөрсөн шүү дээ. Харин зарим нэг хүн өөрөө над дээр аз туршин ирдэг. Тэр үед нь сайтар шинжээд чадах эсэхийг нь хэлж өгнө.

Үнэнийг хэлэхэд манай нийгэмлэг шавьтай болохын төлөө явдаггүй. Харин хүмүүс Багштай болохын төлөө ирдэг газар. Миний хувьд тэнгэрийн дор угаас амгалан. Надад алдар хүнд, олон мянган шавь, хэн нэгэн төрөлтөнд шунах хэрэг огт байхгүй. Бүгд дотооддоо билиг ухаантайг би мэднэ. Хэзээ түүнийгээ гаргаж хэрэглэх нь тэдний асуудал. Үүнд миний оролцоо хэрэггүй. Харин хамаг төрөлтөнд хүсэл хэрэгцээ байгаа болохоор л гарч ном айлддаг. Тэрнээс энэ бүх учир явдал, нэр төр надад хэрэгтэй учраас биш. Энэ ертөнц угаасаа худал хуурмаг, нэр төр хий хоосон болохоор энэ бүхэн миний хувьд ямар ч утгагүй. Тэгээд ч газар сайгүй явахад амрах завгүй тул тун их ядардаг. Бие махбод зүдэрч, сэтгэл санаа зовно. Үргэлж ийш тийш аялж явах нь

бүсгүй хүний амьдралын хэв маяг огтхон ч биш. Ойлгов уу? Зарим үед нилээд хатуу ширүүн аргаар шавь нараа сургах хэрэгтэй болдог. Энэ нь эмэгтэй хүнд байдаг эелдэг зөөлөн ааш зан биш тул заримдаа би өөрийгөө өрөвддөг. Учир нь жирийн эмэгтэй бол нүүрээ будаж, үсээ гоёод ганган сайхан хувцаслаж, дуулж бүжиглэн далайн эргээр зугаалж, хээрийн хоол амталж, амьдралын жаргал, ертөнцийн баярыг ханатал эдэлж байгаа.

Би яагаад ингэж их зүдрэнэ вэ? Заримдаа яг л онгоц шиг, өнөөдөр энд, маргааш тэнд нисэж явдаг. Өдөрт хоёр, гурван удаа онгоцонд суувал тун их ядарч, үхэх шахдаг. Бурхан минь! Нэгэн эрүүл чийрэг эрэгтэй хүн ч ингэж явахад хэцүү. Энэ бол миний хийж буй ажил. Ийм уйтгартай ажилд би дурлаагүй, харин энэ ертөнцөд хэрэгцээ шаардлагатай төрөлтнүүд байсаар байна. Бас залбиран даатгах хүмүүс байсаар байна. Тиймээс хийхээс өөр аргагүй. Үнэндээ бас татгалзаж зүрхлэхгүй. Учир нь бясалгагч хүн бие, хэл, сэтгэлээ хамаг төрөлтний төлөө зориулах ёстой. Тиймээс та нар тэгж их буруугаар ойлгох хэрэггүй. Надад талархахын оронд харин зэмлэн буруушааж байна. Энэ чинь ичмээр бус уу?

Би өөрөө мөнгөө олдог. Чамлахааргүй их. Гэхдээ би мөнгө олохын төлөө ажиллахгүй, алдар нэрэнд ч дурлахгүй. Алдар цуутай болсон хүмүүс түүнийг хадгалах ямар хэцүүг ухаардаг. Од болсон хүмүүсээс сайхан байна уу гэж асуугаарай? Тэдний зарим нь олны анхаарлын төвд байх дуртайдаа биш, харин татгалзаж үл болох нөхцөл байдлаас болсон тохиолдолууд ч бас бий. Ерөнхийлөгч, эсвэл эзэн хаан уг албаа удаан жил хашвал уйддаг. Яг л амттай сайхан зүйлийг их идвэл бялуурдаг шиг. Алдрын оргилд хүрсэн хүн дэндүү ихийг хүртэхээрээ залхаж эхэлдэг. Ойлгов уу? Үүрд мөнх хэн нэгэн байхыг хүсдэг хүн үнэндээ байхгүй.

Алдар нэрэнд дургүй ч хамаг амьтанд үйлчлэхийн

тулд үргэлжлүүлэн ажиллах хэрэгтэй. Бясалгагч хүн бүхэн ийм санаа зоригтой байх ёстой. Тийм ч учраас Шагжамуни Будда хамаг төрөлтөнд үйлчлэхийн тулд тун их зовж, газар сайгүй явж байсан. Есүс Христ Бурханы хутагийг олж, эрх чөлөөт нэгэн болсон ч харанхуй мунхаг хамаг төрөлтөнд туслахын төлөө өөрийн бие махбод, оюун ухааныг золиосолсон юм. Учир нь Тэдэнд бусдын төлөө өөрийгөө золиослох агуу чанар бий. Үүний ачаар өнөөдөр даян дэлхий улам хөгжингүй, ухаалаг болж, эд баялаг арвижин ийм соёлжингүй болжээ.

Хүн бүхэн дотооддоо билгүүн ухаантай хэдий ч хэн нэгэн хүн үүнийг сануулж, хэрхэн яаж хэрэглэхийг заахгүй бол мартдаг. Жишээ нь, хүн болгон төрж, өсөж торнин сургуульд сурч эмч, багш, инженер болдог. Гэвч бага наснаас нь эрдэм ном зааж, сурч боловсрохын чухлыг ойлгуулаагүй бол хожим нь эмч, инженер болохгүй. Бид бурхан чанартай атлаа түүнийгээ ашиглахгүй байдаг нь дэндүү харамсалтай.

Манай нийгэмлэгийнхэн, Багш нь ч бас тэдэнтэй хамт урьд өмнө нь зарим хүн үнэн сүсгээр гуйн хүссэн учраас бурхан чанараа хэрхэн таних, бүхнийг чадагч хүчээ яаж ашиглах, өөрийн хичнээн аугааг таньж ойлгодог нууц аргыг бүх хүнд өргөл болгосон билээ. Бид илүү ч үгүй, дутуу ч үгүй ийм нэгэн зорилготой. Үнэн сэтгэлээсээ бясалгахыг хүсвэл бидэнтэй холбогдож, энэ нийгэмлэгт таарч тохирох, өөрийн жинхэнэ мөн чанарыг олох чин үнэн хүсэл эрмэлзлэлтэй эсэхээ мэдэж аваарай. Манай зорилго ердөө л энэ. Ийм хялбар. Сурахыг хүсэхгүй бол бас хамаагүй. Аажуу тайвуу хүлээж хэдэн мянган жилийн дараа дахин уулзаж болно шүү. (нийтгээрээ инээлдэж, алга ташив)





## ИХ ГУТАЛТ БЯСАЛГАЛЫН АРГА

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Формоса, Тайнан хот, Мадөү  
1988 оны 2 дугаар сарын 14  
(Эх нь хятад хэлээр)*

Өнөөдөр бүгдээрээ эхлээд саяхан таалал төгссөн ноён ерөнхийлөгч Жиан Жиенгүо-ийн дурсгалыг хүндэтгэн залбирал үйлдэж, дараа нь Буддын магтаал уншина. Өмнө нь тайзан дээр гарах бүрдээ эхлээд шууд Буддын магтаал уншдаг байсан, хоолой сайн гарахгүй, тийм сайхан аялгуулж чадахгүй тул та нарын сонорыг чилээх төдий.

Бид ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн Ерөнхийлөгчийг гашуудан дурсахын хамт нас барсан бусад хүмүүсийг бас сэтгэлээсээ дурсъя. Бидний сэтгэлтэлийгаач Ерөнхийлөгчийн төлөө эмгэнэн гашуудна. Тиймээс энэ мөчид бүгдээрээ найз нөхөд, садан төрлөө алдсан бусад хүн ч хичнээн их шаналан зовдогийг саная. Хожим та бидний аав ээж, ах дүүсэд ч ийм явдал тохионо. Энэ ерөөл барилдлагын төлөө ач буянаа хуваалцан сайтар чармайн бясалгаж, Ерөнхийлөгч болон нас барсан бусад бүх хүн баяр жаргалтай оронд төрөх болтугай хэмээн залбирч, хамаг төрөлтнүүдэд туслахыг Бурхан бодьсадвад чин сүжгээр даатгая.

Одоо та бүхэн бидэнтэй хамт энэ дэлхийн хамаг

төрөлтнүүдийн төлөө өөрийн итгэж биширдэг шашны сургаалын эзэн болон Эзэн Бурхан, Бурхан бодьсадвад чин сэтгэлээр даатгаж, нигүүлсэнгүй сэтгэлээр тэднийг нөгөө эрэгт хүргэж өгөхийг залбиран гуйя. Дараа нь бүгдээрээ Буддын магтаал уншина. Өнөөдөр Улиасны мөчрийн ариун усыг дуулна. Хүний сүнснийг адислан гэтэлгэдэг нэгэн зүйлийн рашааныг Улиасны мөчрийн ариун ус гэдэг. Арьяабал бодьсадва, Есүс Христ, Амиитаба Будда, Шагжамуни Будда, арван зүгийн гурван цагийн бүх бурхан, гэгээнтэн, их бодьсадва нар бүгд ийм рашаан устай байдаг. Тэднээс энэ рашааныг нигүүлсэн адислаж, төрөлтөн бүхэн тусыг хүртэх болтугай хэмээн залбиран гуйя.

Энэ дэлхий бол Маяагийн (Хий хуурмагийн хаан) харьяат газар. Энд биднийг Бурхны ажил хийхэд Маяа уурладаг. Тэр бидний ажлыг саатуулахын тулд маш олон арга сэднэ. Тийм болохоор энэ бүхэн шинэ содон биш, хэвийн зүйл. Шагжамуни Будда энэ дэлхийд заларч байхдаа Маяагийн хорлолд олон удаа өртөж, Есүс Христ, Лууз, Күнз ч зовлон зүдгүүр, хүнд бэрхийг амсаж байжээ. Зөвхөн тэд ч биш, шавь нар нь ч бас адил. Тиймээс энд ирээд хоёр цаг хагас ном сонсоно гэдэг маш их буян заяа. Үүнийг та нар ойлгох хэрэгтэй. Та бид олон хүний нөр их хичээл зүтгэлийн үр дүнд саад тотгоргүй хүрэлцэн ирээд ном сонсож байна. Тиймээс дүрстэй болоод дүрс үгүй бодьсадва нарт талархаарай.

Үнэндээ талархахгүй байсан ч тэд бас яах ч үгүй. Энэ бүхнээ хийх ёстой зүйл хэмээн боддог. Хийсэн зүйлдээ баярлаад барахгүй байхад ач тусыг минь та нар ингэж тэгж хариулах болов уу гэж яаж бодох вэ? Тэд ерөөсөө ингэж бодохгүй. Тэд, бүхнийг Багшийн төлөө, номын төлөө, хамаг төрөлтний төлөө, ард түмний төлөө, номын ахан дүүсийн төлөө хийдэг. Тийм ч учраас өөрт тохиолдох бэрхшээл зовлонгийн талаар огт бодохгүй. Харин Багш нь энэ

бүхний нь мэдэж байдаг. Ажлаа тааруухан хийвэл Багшдаа загнуулна. Багш хүн шавиа омог бардам болохоос эмээж, хэзээ ч магтдаггүй. Энэ удаа ч гэсэн магтаагүй, харин бодит байдлыг ярилаа. Тун удалгүй хариад тэднийг бас загнаж магадгүй. Эс бөгөөс тэд өөрийгөө тун аугаа гэж бодно. Ингэвэл аюултай. Бясалгал нь дэвшихээ больдог. Ном сонсох завшаан олдсон чинь тун ховор боломж шүү гэдгийг та нарт хэлэхийн тулд л энэ бүхнийг ярилаа.

Нэгэн жинхэнэ Төгс Гэгээрсэн Их Багш ирж ном тайлахад ад чөтгөрийн саад тун их гардаг. Энгийн нэг ном тайлах, Амиитаба Бурханы номын хурал хийвэл ямар ч асуудал гарахгүй байж магадгүй, тэр ч байтугай олон хүн ирж тусална, өргөл өргөж, цэвэрлэгээ хийнэ. Жинхэнэ номыг айлдвал асуудал үүсч, багш шавь, номын ахан дүүс бүгд саад бэрхшээлтэй тулгарна. Тэр ч байтугай өчүүхэн төдий тусалсан хүнд ч асуудал үүснэ. Туслахыг хүссэн ч хараахан амжаагүй байхад хэдийнээ асуудалд орно. Хүнд дарамт мэдрэгдэж, олон хүн ирж төвөг удна. Жишээ нь, өмнө нь хэвийн ажиллаж байсан машин тэрэг, тоног төхөөрөмж яг хэрэгтэй үед гэнэт эвдэрч ажиллахгүй, хөдлөхгүй болно. Ийм жижиг сажиг зүйлсийг яриад байвал дуусахгүй. Тиймээс та бүхэн энд хүрэлцэн ирж, ном сонсож чадсан өөрийн буян хишигтээ талархаарай! Өөр хүнд талархаад хэрэггүй, талархаад баймаар юмгүй, бүгд та бидний өөрийн буян хишиг байдаг.

Бид өөрийн ач буянаа мэдвэл Багшийн хэлсэн санааг ойлгох төдийгүй, Багш нь яагаад энд ирж ном айлдах болсны учрыг бас ойлгоно. Учир нь та бүхэн асар их буянтай. Надад өөрт буян гээд байх юмгүй. Та нар дэндүү их буянтай учраас бид боломж завшааныг зүдрэн байж бий болгоод буяныг тань эдлүүлж байна. Хэрвээ дайллага хийж, зочноо тавхан минут баярлуулвал ач тусаар тун бага. Харин үнэн ёсыг яривал хэзээд хамаг төрөлтөнд мөнхийн ач буянтай

төдийгүй, хэдэн төрөлд нь ач тустай. Авшиг аваагүй ч энэ гурван өдөр дараалан ирж, ном сонссон хүн тэр даруйдаа өндөр төвшний гэгээнтэн болж, дэс нь дээшилдэг.

Бурхны номд: “Урсгалд орогч заавал дахин долоон удаа төрөл авна. Ном сонсож буй та бүхэн бүгд урсгалд орогч мөн. Та нар шравака мөн” гэжээ. Шагжамуни Буддаг заларч байхад шравака, баридагабудда байсан. Та нар хамгийн наад зах нь шравака мөн. Ойлгов уу? Шравака бол нилээд дээгүүр дэс. Тэд тамд унахгүй, адгуус болж төрөхгүй. Та нар хэдийнээ ийм гэгээнтний дэсэд хүрчээ.

Хэрвээ та нар Багшийг орхиж, Багшдаа үл итгэж, Багшийг гүтгэн буруушаавал Багш нь бас ямар ч аргагүй. Бурхан бодьсатва хамаг амьтны бодол санаа, сонголт хийх эрх чөлөөнд хөндлөнгөөс оролцохгүй. Тэд: ”Хөөе! Хөөе! Нааш ир! Би энд байна. Тийшээ явбал тун аюултай шүү” гэж хэлж болохгүй. Хэлсэн ч та нар сонсохгүй. Багшдаа ядаж тавин хувийн итгэлтэй бол бас болж байна. Багштайгаа адилхан хүсэл мөрөөдөлтэй бол бүр хамгийн сайн. Багшдаа ингэж итгэх нь авшиг хүртсэнд тооцогддог.

Багшид итгэдэггүй ч Багш нь бас тусалж болно. Хэдийгээр тэр явах тусмаа номоос улам хөндийрдөг боловч үнэндээ бас тийм ч хол явахгүй. Учир нь Багш нь нэг уртаас урт уяатай. Хүүхдүүд цаасан шувуу наадуулахыг та нар харсан уу? Салхи цаасан шувууг хэдий хэр өндөрт, ямар ч хол нисгэсэн тэр уяагаар татаад тогтоон барьдаг. Төд удалгүй татаад авчирчихна. Тэр жаахан тоглож зугаацаж байгаад цаг нь болохоор буцаад ирнэ. Тиймээс ном айлдахыг нэг л сонссон бол хожим их холдохгүй. Багшийг гүтгэн муулсан хүн нилээд их зовлон амсдаг ч бас их холдохгүй. Учир нь үйлийн үрээ төлж дуусгах хэрэгтэй. Сайн үйл үйлдвэл сайн үр хураана. Муу үйл үйлдвэл муу үр хураана.

Нэгэн жинхэнэ бясалгагчийг, гэм зэмгүй, ёс суртахуунтай хүнийг хорловол муу үйлийн үр хураана.

Жишээ нь, бидэнд ямар ч муу зүйл хийгээгүй, бидэнтэй огт хамаагүй нэгэн бясалгагчийг байнга гүтгэн муулвал тусгүй. Жирийн хүнийг гүтгэн муулахад бидэнд ямарч ашиггүй, бас маш их муу үйлийн үр хураана. Тэгвэл нэгэн их бясалгагчийг гүтгэн муулаад хураах нүгэлийг хэлэхийн аргагүй! Магадгүй Тэр хүн хэдийнээ гэгээрч Бурханыг төлөөлөх болсон ч юм билүү. Өчигдөр та бүхэн Багшийгаа “Будда” хэмээн өргөмжилсөн. Би та нарт итгэж байна. Тиймээс Бурханыг буруутгах хэрэггүй. Та нарыг мэдэхгүйгээсээ болж нүгэл хураах вий гэж би айдаг. Үнэндээ Бурханд бол энэ бүхэн ямар ч асуудалгүй. Тэр урьдын адил иднэ, ууна, унтана, амарна.

Өнөөдөр жинхэнэ миний билиг нээгдэж, Формосагийн хүмүүстэй яагаад барилдлагатай болсноо ойлгов. Яагаад гэдгийг та нар мэдэх үү? (мэдэхгүй гэж хариулав). Формосагийн хүмүүс юугаараа алдартай, юугаараа онцгойг та нар мэдэх үү? Идэх дуртай. “Дайзы”(Багш тайвань аялгуугаар ярив). Идэх тун дуртай, Тийм биз?(бүгд инээлдэв) Хариулж зүрхлэхгүй байна уу? (бүгд: Тийм гэв). Нэг жилийн дотор хоёр хурдны зам идчихдэг гэж сонссон (бүгд инээлдэв). Энэ чинь муухай зүйл биш. Ичих хэрэггүй. Би ч бас идэх дуртай. Тийм болохоор бид барилдлагатай байна. (бүгд инээлдэв) Миний шавь нар Багшдаа хайртай байдаг нь дан ганц Арьяабалын аргаас ч болоогүй. Багш нь сайхан хоол хийж, хоолыг амттай болгох олон арга сэддэгээс бас болсон байх. Итгэхгүй байвал та нар туршаад үз. Өнөөдөр ямар сайхан хоол идэв гэж тэднээс асуу. Магадгүй дэлхий даяараа идэж үзээгүй, сонсож байгаагүй нэр дуулах вий. Би шинэ хоол зохиохдоо тун гарамгай. Яагаад юм бол?

Та нар битгий уйдаарай. Удахгүй Бурханы ном айлдана. Зөвхөн хоол унд ярихгүй. Гэвч Бурханы номыг ертөнцийн номоос салгахын аргагүй. Хоол унднаас эхлээд гэтэлж ангирах хүртэл ярина. Гэдэс дундуур бол бясалгаж

чадахгүй. Тийм байдаг уу? (бүгд тийм гэж хариулав). Би яагаад тийм сайхан амттай хоолны жор зохиодог гээч? Учир нь би багаасаа маханд дургүй тул дандаа л өлсдөг байсан. Ургамал хоол олдохгүй болохоор өөрөө арга бодож хоол олж иднэ. Том болсныхоо дараа ч өнөөх хамгийн сайн зоогийн газруудад очих дуртай байв. Тэнд очвол сэтгэлээ цадтал хооллоно. Харин жирийн хоолны газарт орвол хооллох ямар ч хүсэлгүй болдог. Өөр нэгэн шалтгаан нь Германд очсоны дараа ургамал хоол идэхэд тун амаргүй байсан явдал юм. (гэрээс гараагүй байхдаа би ургамал хоолтон байсан) Германд ургамал хоолтон байх үнэхээр хэцүү.

Формоса бол яг л диваажин гэсэн үг. Хүссэн бүхнээ идэж болно. Хаана ч очсон ялгаагүй, үүнийг та нар төсөөлөхийн аргагүй. Германд бол глутин, дүүфүү авахын тулд хэдэн арван миль газар явж, хятад худалдааны төвд, эсвэл ази барааны захад хүрвэл сая олж авч чадна. Өмнө нь би өөрөө глутин гаргаж, дүүфүү хийдэг байв. Учир нь байнга явж авах нь төвөгтэй. Зарим үед мөнгө байсан ч санаан зоргоор олдохгүй. Учир нь цөөхөн бас байнга байгаад байхгүй. Формосад бол үйлдвэр нээгээд глутин хийдэг. Ийм зүйлийг авах хүн Германд цөөн тул бага байдаг. Тиймээс арга сэдэж, өөрөө сайхан хоол хийнэ. Өглөөнөөс орой болтол хоол идмээр байсан ч завгүй, гэсэн ч зав гаргаж хоол хийх хэрэгтэй. Энэ нь та бидний ярьдаг “цаг үе баатрыг төрүүлдэг” гэсэнтэй утга нэг.

Одоо бас яагаад сайхан хоол хийж идэхийг хүснэ вэ? Учир нь идэх сонирхолгүй болсноос юм. Өмнө нь өдөр болгон л өлсдөг байв. Харин одоо өлсөхөө больсон. Тиймээс та нар: ”Багш яагаад ийм туранхай байна вэ? Багш тун бага идэх юм. Багш хоол идэхээ больчихвол яана? Багш ер нь яагаад ингээд байна вэ?” гэх мэтээр боддог. Тэд намайг өлсөж үхэхээс айж тул одоо би өөртөө илүү сайхан хоол хийхийн тулд их хичээж, ямар нэг аргаар их идэх хэрэгтэй

болсон. Тэгвэл мах мариа нэмэгдэнэ. Эс бөгөөс улам жижигрээд идэхгүй бол бүр турж эцээд эцэстээ намайг олж харах хүнгүй болох байх. (бүгд инээлдэв)

Тиймээс би заримдаа сайхан амттай хоол хийж, идэх дуршлаа нэмдэг. Тэр үед өлсөөгүй байсан ч амтархан иднэ. Арай ахиу хийвэл гэрээс гарагсад, номын ахан дүүстэй хамт хооллоно. Өнөөдрийн хоол та нарт таалагдав уу? (Таалагдсан гэж хариулав). Тийм ээ! Багш нь хоол хийх бүртээ, эсвэл идмээр санагдсан үедээ хийсэн хоол тун амттай болдог. Тийм биз? Тийм шүү дээ. Гэрээс гарагсад сайн мэдэж байгаа. Харин гэрээс гараагүй хүмүүс байнга Багшийнх нь хийсэн хоолыг иддэггүй болохоор бараг мэдэхгүй. Эндээс бид өөртөө туслах нь бас бусдад туслагдгийг харж болно. Тэдний сэтгэлийг зовоохгүйн төлөө арай ахиухан идэх арга хайсан хэрэг.

Энэ явдлаас үзвэл бид бүгд түгээмэл хайртай байх ёстой. Бусдыг хайрлах нь өөрийгөө хайрлаж байгаа хэрэг. Би зөвхөн хүнийг ч биш, бас нохдыг их хайрладаг. Нохойг яаж хайрлахыг та нар мэдэх үү? Нохойны ном бясалгадаг, нохойны хэл ойлгодог хүн байна уу? Зарим хүн ойлгодог. Олон жил нохой тэжээсэн хүн түүнд юу хэрэгтэйг тун сайн ойлгоно. Би нохой тэжээдэггүй болохоор тэднийг сайн ойлгохгүй юм. Та нар Багшийн билиг ухаан аугаа их гэж бүү бод. Би нохойны сэтгэл санааг ойлгохгүй, мөн тэдэнд бурхан чанар байдаг эсэхийг мэдэхгүй. Байдаг уу, үгүй юү? (Тайзны дор сууж буй даяан бясалгадаг нэгэн хүнээс Багш асуув. Тэрээр: зургаан заяаны амьтад бүгд бурхан чанартай гэж хариулав). Багш: Зургаан заяаны амьтан бүхэн бурхан чанартай. Харин надад байхгүй. (бүгд инээлдэв) (Тайзны дор сууж буй хүмүүсийн нэг нь: Багш бурхан чанаргүй гэдэг нь нэн өндөр дэстэй болсныг илтгэнэ). Нохой бас бурхан чанартай болохыг би өнөөдөр л мэдлээ.

Багш нь Чень овогт увшийн гэрт амьдардаг байв.

Тэдний нохой тун хөөрхөн. Жижигхэн биетэй, цагаан зүстэй болохоор нь жижигхэн цагаанаа гэж дууддаг (хүмүүс инээлдэв). Тэр нохой тун онцгой. Намайг авшиг хүртээж эхэлсэн цагаас тэр тахилын идээнээс огт идэхээ больж, ургамал хоолтон болсон. Авшигтай хүн ирвэл ерөөсөө хуцахгүй. Авшиггүй хүнийг бол өөрийн эзэн, байнгын зочин, хааяа нэг ирдэг хүн аль нь ч байсан ялгаагүй тасралтгүй хуцна. Харин авшигтай хүн ганцхан удаа ирсэн ч ер хуцахгүй. Өдөр, шөнө хэзээ ч адил огт дураараа хуцахгүй. Их хачин нохой байсан. Тун номхон дөлгөөн тул хүн бүхэн түүнийг хайрлана. Биднийг сэрээхгүй, бясалгаж байвал гадаа хаалга манана. Багш нь авшиг хүртээх үеэр тэр шахцалдан орж ирдэг. Гар гэвэл гарахгүй. Багшийг нь байхгүй үед хаачсан нь мэдэгдэхгүй алга болно.

Өнөөдөр бүтэн сайн тул бүгд нийтийн бясалгал хийж байна. Энэ үед би тэдний билгийг нээнэ. Энэ бол миний хувьд тун энгийн явдал. Билиг нээнэ гэдгийг ойлгож байна уу? Модыг бурхан болгохгүй, харин хүнийг бурхан болгоно. Хичээнгүй биш байвал би та нарын билгийг нээгээд Бурхан болгоно шүү. Айж байна уу? (бүгд үгүй гэж хариулав). Би билиг нээчихээд гараа угаана, эсвэл Цагаанааг харахаар явна. Тэр байнга Багшийг нь харж байдаг. Намайг мэндэлвэл ярьж эхэлнэ. Уг нь тэр огт ярьдаггүй. Намайг харахаараа сүүлээ л хөдөлгөнө. Харин өнөөдөр надтай хамгийн анх удаа ярьж байгаа нь тэр. Би нохойны ном бясалгаагүй болохоор түүний яриаг ойлгосонгүй.

Түүний яаж ярьсныг та нар мэдэх үү? Тэр: Хэн! Хэн! (Багш нохойг дуурайн хэлэхэд бүгд инээлдэв) гэж дуугарна. Би түүнд хандан: Юу? Уучлаарай! гэхэд, дахиад л хэн! хэн! (бүгд инээлдэв). Би ер ойлгосонгүй. Би: Яадаг билээ! Будда болсон мөртлөө нохойны санааг ойлгохгүй гэж үү?(бүгд инээлдэв). Будда болсон хүн ямар ч амьтны сэтгэлийг үггүй ойлгоно гэдэг биш билүү? Гэтэл би ойлгохгүй байх ч гэж



дээ гэж бодоод харамсан сэтгэл зовж зогсов. Тэр дахиад л: Хэн! Хэн! Хэн! гэнэ. Ойлгохгүй байгааг минь өршөөгөөрэй. Толгойгоо илүүлэх гэсэн юм уу гэж асуугаад толгойг нь илэхэд дахиад л: хэн! хэн! гэв. Өлсөө юу гэхэд (бүгд инээлдэв) Ээ! Ээ! гэсэн. Нээрээ шүү! Би түүнд хоол авчирч өгсөн.

Бүх хүн бясалгаж байхад би нохой хооллож явлаа. Тэд Багшийгаа тун сүр жавхаатай бясалгаж байгаа даа хэмээн бодож байхад харин би энд, тэндээс хоол хайж нохой гэжээв. Эхлээд түүнд адисалсан жигнэмэг өгөв. Юунд дуртайг нь мэдэхгүй тул өөр зүйл хайсан ч олоогүй. Авшигтнуудын хоол хүнснээс үлдсэн зүйл хайсан ч юу ч үгүй болсон байв.

Дараа нь нэг талх олоод идэх үү? гэж асуухад ээ, ээ гэхээр нь талхнаас хугалж өгвөл хормын дотор идэж дуусгасан. Талханд дуртай юм уу гэхэд ээ, ээ ээ гэдэг нь иднэ гэсэн үг гэж ойлгоод дахиад талх авчирав. Тэгээд хэрвээ би өөрөө идэх байсан бол энэ талхыг веган масло, веган бяслагтай идэх байсан даа гэж бодоод бяслаг болон масло хайсан боловч зөвхөн масло олсон. Тэд бяслагаа хөлдөөгчинд хадгалдаг юм.

Миний шавь нар Багшийгаа тун сайн халамжилдаг. Намайг бяслагт дуртайг мэднэ. (веган бяслаг, зарим нь веган биш. Өөрсдөө хийсэн нь цэвэр веган байдаг). Хүмүүс авч явахаас айгаад хөлдөөгчинд хадгална. Уг нь бяслагыг хөлдөөгчинд хадгалах ёсгүй. Үнэн шүү! Барууныхан тэгдэггүй, харин Формосагийн хүмүүс л ингэж хадгалдаг. Намайг авахад тэр бяслаг яг л чулуу шиг, нохой ч идэхийн аргагүй байв. Би түүнээс уучлал хүсээд: Масло байхад болно доо! гэв.

Ургамал хоолны шим тэжээл муу гэж ярихыг сонссон болохоор (бүгд инээлдэв) нохойнд шим тэжээл дутагдаад байгаа юм шиг санагдаад өөр хоол хайж, давсалсан глютин олоод өгвөл голов. Уг нь нохой хүнтэй л адилхан идэштэй

гэж бодсон чинь үгүй байлаа. Тэр зөвхөн талханд л дуртай.

Иймээс өнөөдөр би хүн бүрт өөр өөрийн бясалгах арга байдгийг олж мэдлээ. Хэнийг ч юунд ч хүчээр итгүүлэх аргагүй. Бид олон зүйл ярих хэрэггүй. Манай шашны бүх зүйл сайн гэх мэтээр. Зарим нэг нь дэндүү туйлширч, өөрийнхөөсөө бусад нь бүгд муу гэж үзээд бусдыг байнга татна, хүчлэнэ. Янз бүрийн аргаар бусад шашны урсгалыг тараан бутаргаж, хүмүүсийг нь элсүүлэхийг оролдож, тун таагүй уур амьсгал үүсгэнэ. Элсэж байгаа, элсүүлж байгаа хоёр аль аль нь тайван бус таагүй, сэтгэлийн дарамттай болдог.

Энэ тал дээр Арьяабалын аргаар бясалгадаг хүмүүс бусдаас өөр. Бид хэзээ ч бусдыг ятган сэнхрүүлж, хүчээр итгүүлэхийг оролдохгүй. Багшийг нь муулдаг, мөн намайг орхиж явсан шавь нарын араас хэн ч утсаар ярьж, хаалгыг нь тогшиж, захиа бичихгүй, мөн “Чи яагаад ирэхгүй байна вэ? Ирэхгүй бол тамд унана шүү, бла бла...” гэж зэмлэхгүй. Явья гэсэн нь явж болно. Хэнийг ч албадахгүй, ийм явдал огт гарахгүй.

Анх намайг Формосад ирэхэд авшиг авсан хүн цөөн, уншиж судлах зүйл бага, би жуулчны визтэй байсан болохоор заавал буцах хэрэгтэй. Тиймээс тэднийг халамжлах цаг зав хомс байсан. Мөн тэдэнд зориулсан унших ном товхимол бараг байгаагүй. Тэгэхээр намайг муулж, намайг орхисон нь тэдний буруу биш, миний алдаа. Учир нь би уншиж судлах, лавлаж мэдэх ном, сэтгүүл хангалттай бэлдэж өгч чадаагүй.

Тэр үед би Формосад дөнгөж ирээд байсан, мөн тэдний итгэл үнэмшил сулхан, авшигтан цөөн байснаас хамгаалж түших хүчээр дутжээ. Хүмүүс олноороо шохоорхон авч байгаа зүйлийг бид дуурайж авдаг, дараа нь тийм ч сайн эд биш болохыг мэдсэн ч ажиг сэжиг төрөхгүй. Тийм биз? (бүгд тийм гэж хариулав)

Хэрвээ тааруухан зоогийн газар хүн олноор ирж

хооллон суувал сандалгүй байсан ч хүмүүс чихэлдэн орно. Гэтэл сайхан хоолтой зоогийн газар хүн цөөхөн байвал эднийх ч лав хоол муутай даа гэж таамаглаад цонхоор нь харж хүнгүй бол тэр даруй холдон явдаг, тийм биз?

Тиймээс та нар миний одоогийн болоод өмнөх шавь нар Багшийг нь муулж байвал битгий тоо, битгий уурлаж хорс! Номоо хамгаалахын тулд зарим үед хариу үйлдэл хийх нь буруугүй ч хамгийн гол нь уурлаж болохгүй. Ном хамгаалахад аливааг энэрэл нигүүлсэл, билиг ухаанаар шийдэх хэрэгтэй. Ингэж чадвал учрах саад бэрхшээл бага. Хамаг амьтан тун мунхаг, бусдыг үл тоож, байнга алдаа эндэл гаргах тул тэднийг уучлах хэрэгтэй. Тийм биз?(бүгд тийм гэж хариулав)

Өчигдөр “Билиг ухаан”-ы талаар ярьсан. Будда болсон хүн л билиг ухаантай. Өчигдөр багш нь явал Будда болж чадах вэ? гэж ярьсан. Тийм үү? Будда болоход ямар байдалтай байдаг вэ? Яаж түүнийг мэдэх вэ? Будда болсон төрөлтөн бол нэгэн төгс төгөлдөр багш. Түүнд хүлцэн тэвчих, уучлан өршөөх, түгээмэл хайрлах, энэрэн нигүүлсэх, билиг ухаан гээд бүхий л чанар бий. Билиг ухаан хамгийн чухал. Хэрвээ билиг ухаангүй бол юуг ч төгс төгөлдөр шийдэхгүй. Ертөнцийг билиг ухаанаар ажиж, билиг ухаанаар бүхнийг шийдвэл хамгийн сайн, хамгийн төгс. Энэ ертөнцөөс энэ ертөнцийн билиг ухааныг л олно. Харин дээд ертөнцөөс дээд билиг ухааныг олно. Жишээлбэл, бага сургуульд бага боловрол эзэмшинэ. Арай илүү мэдлэг боловсролтой болохыг хүсвэл ахлах сургууль, дээд сургуульд суралцах хэрэгтэй. Тийм биз? (бүгд тийм гэж хариулав). Бага сургуульд их сургуулийн мэдлэг эзэмших боломжгүй. Тиймээс манай бурхны шашинд “Ямагт бурханыг даган суралцах” гэж ярьдаг. “Ямагт бурханыг даган суралцъя” гэвэл бурхны оронд очиж өндөр төвшний бурхны их сургуульд суралцвал бурхны билиг ухаантай

болно. Эгэл хүний хэл яриагаар илэрхийлэгдэж байгаа бүхэн Бурхны билиг ухаан биш. Тиймээс бидний ярьсан нь бас бурхны билиг ухаан биш юм, үгээр илэрхийлэх аргагүй тул Бурхны билиг ухааныг би зөвхөн танилцуулж байгаа төдий. Сонирхож байвал Багшдаа бүртгүүлж болно. Тэгээд бурхны их сургуульд суралцаарай. Иймээс Шагжамуни Будда: “Би бол гараараа сарыг зааж буй хүн болохоос сар биш. Миний гарыг дагуулан харвал сарыг та олж харна” гэж хэлсэн нь ийм утгатай юм.

Билиг ухаантай хүн аливааг санаж шийдэхдээ тун хурдан. Тэдний санаж сэтгэх нь биднээс хэдэн зуу мянга дахин хурдан бөгөөд бүхнийг тун нарийн нягт, бүрэн төгс тунгаан боддог. Өнөөдөр манай авшигтнуудын зарим нь Тайбэйгээс, зарим нь Шинжүгээс Багштайгаа уулзахаар ирсэн. Тэд Багшийгаа хамт шинэлье хэмээн урьсан ч хэдийнээ Тайнан, Пиндунгийн авшигтнуудад зөвшөөрсөн тул энэ удаа Тайбэйд очиж чадахгүй. Харин шинийн арван таванд очиж магадгүй. Учир нь тэд миний ирэхийг дэндүү их хүсэж, уйлсан байна.

Багш бидэнд өмнөх өдөр модон бурханыг шүншиглэх талаар ярьж өгсөн. Үнэхээр хачин шүү, бидний хэн нь ч энэ тухай өмнө нь яагаад бодож байсангүй вэ? гэж тэд хоорондоо ярилцжээ. Энэ тухайгаа надад хэлсэн юм. Яагаад нэгэн эгэл хүн модыг ч Бурхан болгож чаддагийг бодож үзсэн хүн байна уу? Ингэж болно гэж хүн бүр итгэдэг. Олон жил бясалгасан хүн өөрийгөө Будда гэж хэлээгүй ч, хүнийг Тэр Будда болгож чадна. Гэвч түүнд нь хэн ч итгэхгүй. Энэ хүн юу ярина вэ? Бодит байдал дээр ийм явдал байж болохгүй. Ямар ч боломжгүй гэж бодно. Номын тэдгээр багш модыг шүншиглээд Бурхан болгон хувиргадаг. Гэсэн ч тэдний хэн нь ч өөрийгөө би Будда гэж хэлж зүрхлэхгүй, би Будда болсон, гэгээрсэн гэж хэлж зориглохгүй. Бид хэдийнэ гэгээрсэн гэж хэлж зориглох хүн байна уу? Байвал тэдэнд баяр хүргэе,

байхгүй бол бас байх л явдал. Яагаад гэвэл тэд гэгээрээгүй учраас хэлж зүрхлэхгүй байна. Гэсэн ч гэгээрээгүй эгэл хүн Будда төрүүлж байна шүү дээ. Модыг бурхан болгож байна. Үүнийг хачин жигтэй хэрэг гэж хэн ч хэлэхгүй, учир зүйд нийцэхгүй ч гэж ярихгүй. Харин хүнийг бурхан болгодог арга надад байхад олон хүн үүнийг: “Хачин жигтэй хэрэг. Энэ тухай урьд өмнө нь хэзээ ч сонсож байгаагүй. Зөвхөн Шагжамуни Будда л үүнийг чадна. Бид чинь бүгд эгэл хүмүүс шүү дээ” гэцгээнэ. Билиг ухаантай нэгнийг даган суралцвал бидний дэвшил хөгжил хурдан байна. Эс бөгөөс хоёр мянган жил өнгөрсөн ч эдгээр учир зүйг ухааж ойлгож чадахгүй байсаар л байна.

Энэ үнэндээ тун хялбархан явдал. Багш нь та нарт ухаарч ойлгохгүй, учрыг нь олох аргагүй өндөр төвшний юм ер яриагүй. Харин жирийн явдал, нүдний өмнөх бодит байдлыг ярьж байна. Би “Олонхи бурхны судар”-ын дэс ямар байх вэ? Бусад ертөнцүүд нь ямар вэ? гэж яриагүй. Тэднийг та нар баталж чадахгүй, магадгүй тэр төвшинд та нар хараахан хүрээгүй байх. Манай авшигтнуудаас гадна өөр хүмүүс хэдийнээ тэр төвшинд хүрээд “Богдосын ном цагаан лянхуа”-н төвшин ямар байдгийг мэддэг болсон. Гэвч ойлгохгүй хүн бас олон байгаа болохоор би тэр дэсийн талаар ярихгүй. Зөвхөн учир шалтгаанд нийцэх зүйлсийг л ярьсан төдий. Та нар ойлгохгүй байж яаж өндөр төвшний бясалгагчдыг шүүмжилж, тэдний хүрсэн төвшин, хүрсэн дэсийг ярьж болох вэ? Та нар яаж ойлгох вэ?

Судар бол хоёр мянга таван зуун жилийн өмнөх бясалгалын ахуй ойлголтууд юм. Тэднийг бид гэртээ залаад мөргөж тахиад ямар ач буян хүртэх вэ? Гэсэн ч мөргөж тахивал ач буянтай гэж бүгд итгэдэг. Жишээ нь, Хотол зохилдогчид, Шагжамуни Буддагийн шавь нарын бясалгалын ахуй ойлголтыг тэмдэглэн бичжээ. Үүнийг би яаж мэдсэн бэ? Учир нь би тэнд тэмдэглэсэн ахуй

ойлголтын төвшнийг хэдийнээ давсан. Арьяабал Бурхантай уулзах, мөн далайн түрлэгийн чимээ, эсэрваагийн дуун, гүн нууц ялгуулсан ертөнцийн аялгууг сонсож байгаа нь ердөө л анхан шатны төвшний ахуй ойлголт. Тиймээс уг судрын энэ хэсгийг уншаад энэ бол бясалгалчийн ахуй ойлголт, авшиг хүртэх үеийнхээ ахуй ойлголтыг бичиж тэмдэглэсэн болохыг мэдсэн.

Яг манай авшигтнууд шиг, тэд авшиг хүртмэгцээ үзсэн сонссон ахуй ойлголтуудаа, жишээ нь, далайн түрлэгийн чимээ, эсэрваагийн дуун, чанад ертөнцийн ялгуулсан дуун, өөр бусад өндөр төвшний ертөнцийн дуу аялгуу, мөн ямар ямар гэрэл олж харсанаа бичиж тэмдэглэдэг. Тийм биш бол яаж логикт нийцэх вэ? Хотол зохилдогчид Арьяабал бодьсадвагийн дэсийг ярьж байснаа гэнэт эсэрваагийн эгшиг, далайн түрлэгийн чимээ, чанагуухи ертөнцийн ялгуулсан дууны тухай бичээд дээд, доод утга нь авцалдахгүй, ойлгоход бэрх болдог. Яагаад ийм болсныг мэдэхгүй. Бясалгалын ахуй ойлголт хоёр янз байдаг. Нэг нь үзэж харсан төвшний гэрэл, нөгөө нь сонссон дуу аялгуу. Тиймээс хотол зохилдогчийн эхний хэсэгт гэрлийн төвшин, сүүлийн хэсэгт аялгууны ахуй ойлголтыг бичсэн байна. Ийм учиртай.

Бидний бясалгадаг арга ч хоёр хэсгээс бүрдэнэ. Нэг нь Их нууц номын нүд буюу зарим хүн “Гэрэл ажих” гэж нэрлэнэ. Бодьдармаа багшийн “Судал дамжилгын онол судар”-т: “Нарнаас ч хурц гэрэл олж харсан тэр агшинд гэгээрдэг” гэжээ. Тиймээс бид заавал бясалгах хэрэгтэй. Тэгж байж судар номыг ойлгоно. Жишээ нь, Багшаас нь авшиг хүртсэн хүн Хотол зохилдогчид бичсэнтэй ижилхэн ахуй ойлголттой бол түүний хувьд Хотол зохилдогчийг унших хэрэггүй. Тэр хэдийнээ ойлгож, ижил түвшинд хүрсэн байна. Түүнд дахин судар ном унших хэрэгцээ байна уу? (бүгд байхгүй хэмээн хариулав)

Тийм учраас Бодьдармаа:“Тэр гэрлийг олж авсан, Бурхан чанараа харсан, тэр төвшинд хүрсэн бол бурханд мөргөх хэрэггүй, судар унших шаардлагагүй” гэсэн нь ийм утгатай! Тэр судар номыг ч буруутгаагүй, Гурван эрдэнийг ч буруутгаагүй. Гурван эрдэнэ гэж юу вэ? Эхнийх нь Бурхан эрдэнэ, дараах нь ном эрдэнэ, удаах нь хувраг эрдэнэ юм. Бурхан эрдэнэ гэж хэн вэ? Энэ цаг үед дэлхийд заларч буй Төгс Гэгээрсэн Их Багш бол Бурхан эрдэнэ мөн. Та бүхэн маш тодорхой ойлголттой байх хэрэгтэй. Будда гэж сонсмогц ихэд эмзэглэж огт боломжгүй хэмээн боддог. Яагаад боломжгүй гэж? Төгс Гэгээрсэн Их Багш төрөл тутамд залардаг. Төгс Гэгээрсэн Их Багшийг яаж эрж хайхаа бясалгадаг хүн бүхэн мэднэ. “Миний багш бол Төгс Гэгээрсэн Их Багш мөн, хамгийн мундаг нь! Би Төгс Гэгээрсэн Их Багшийг олж чадсан” гэж шавь нар нь магтана. Тэр үед хэн ч юу ч хэлэхгүй байж магад. Харин Төгс Гэгээрсэн Их Багш гэлгүй, самгарьд хэлний үгийг ашиглан: Би Буддхаг олсон гэж хэлвэл бид орчуулаад бурхан гэнэ. Адилхан л Төгс Гэгээрсэн Их Багш гэсэн үг боловч хүмүүс лавтай: “Болохгүй! Болохгүй! Түүнийг бурхан гэж хэлж болохгүй гэнэ. Энэ нь нэр, нэршилд дэндүү баригдсанаас болж байна.

Хэрэв бид тодорхой орчуулвал Шагжамуни Бурханыг (буддха) Будда гэж шууд орчуулж болохгүй. Харин Төгс Гэгээрсэн Их Багш Шагжамуни гэж орчуулсан бол одоогийнх шиг ийм их төвөг саад, буруу ойлголт, олон өрсөлдөөн, шашны урсгал хоорондын эмзэг асуудлууд үүсэхгүй байсан. Ийм өчүүхэн, маш амархан, энгийн явдлыг олон хүн ойлгохгүй байгаа нь тун харамсалтай. Бид бясалгах тусам яримааргүй болж, харвал толгой сэгсэрч, өөрчлөх хүсэлгүй болдог. Өөрчлөх аргагүй бол юу ч ярихав дээ? Учир нь бясалгах тусам ярих хүсэлгүй болдог.

Авшигтан, эсвэл өөр нэг хүн Багшийг нь урьж, ном

айлдуулах болгонд би яаж ярьж чадаад байгаагаа маш их гайхдаг. Учир нь би ярьж чадна гэдэгт огт итгэхгүй байсан. Жишээ нь, бид хөдөө тосгонд тариачин айлд төрж өссөн бол аав ээжийн маань амьдрал тун энгийн, сүрлэн сууцанд амьдарч, өдөр бүр тариа ногоо тарьж, зэрлэг өвс зулгаана. Биднийг өсөж томроход их сургуульд сургаж, шинжлэх ухаан, өөр өөр өндөр төвшний мэдлэг боловсрол эзэмшүүлнэ. Сургуулиа төгсөж, гэртээ хариад ээж, аавдаа сурсан аль нэг онол мэдлэгээ яривал тэд юу ч ойлгохгүй тул бид их юм ярихгүй. Тийм биз?

Анагаахын сургуульд сурч эмч болоод гэртээ ирэхэд аав, ээж нь ариун цэвэр ч биш байвал бохир заваан байх нь аюултай, өвчин тусаж болзошгүй гэдгийг сануулж хэлэхээс өөр аргагүй. Энэ нь ээж, ааваа үл хүндэлж, тэднийг буруутгасан хэрэг огт биш. Халдварт өвчин тусахаас одоо бүгд айдаг. Гэвч бид яаж ч сануулсан тэд ойлгохгүй, олон дахин хэлбэл уурлаж, дөнгөж сая их сургууль төгссөн байглаа биеэ тоолоо хэмээн бодно. Үнэндээ тийм биш, биеэ тоосон хэрэг огт байхгүй. Харин арай өндөр төвшний мэдлэг сурч эзэмшсэнээс өөр болсон мэт санагджээ.

Дахин дахин яриад хүлээн авахгүй бол ямар ч нэмэр тусгүй санагдаж, толгой сэгсрэн амаа хамхиад тэднийг дураар нь орхино. Энэ үед бид ч өөрсдөө чөлөөтэй болно. Сэтгэл ханамжгүй байлгадаг жижиг сажиг асуудлуудыг анзаарахгүй. Одоо та бид олон янзын амьдралын хэв маяг, өөр өөр үзэл бодлыг хүлээн зөвшөөрч, хөгшин, залуу хоёр үеийн аль алиных нь нөхцөл байдалд дасан зохицож сурсан. Жишээ нь, бясалгаад тун удаагүй, эсвэл жаахан үр дүнд хүрсэн хүн сэтгэл нь хөдөлж дэлхийг өөрчилмөөр санагддаг. Ахиухан бясалгавал дэлхий угаас амгалан болохыг ухаарна. Энэ нь энэрэл нигүүлслийн сэтгэлгүй болсон хэрэг огт биш, харин арай илүү өндөр төвшний ухаарал ойлголттой болж, төрөлтөн бүхэн сайн, өөрчлөх зүйл байхгүйг ойлгосон хэрэг.



Тиймээс өчигдөр нэгэн хүн: “Ямар ч нөхцөл байдлыг өөрчлөх хүсэлгүй болсон нь хамгийн дээд төвшин мөн” гэсэн. Магадгүй тухайн үед тэд Багшаасаа ч илүү дээшилсэн байх. Учир нь тэд юунд ч хүлэгдэхгүй болжээ. Харин Багш нь ургамал хоолонд хүлэгдсээр байна. Би та нарт тахианы мах идэж үзүүлэх үү? Болно шүү! Даанч би үнэхээр дургүй. Ойлгов уу? Идэж болно, тэгээд яах гэж? Ургамал хоол байсаар байтал тахиа идээд яах вэ? Та нартай адил бурхныг дурсах хүсэлгүй гэвч нэг дурсвал гурав хоног амаа угаана. Би бас дурсаж чадна. Шавь нарт маань тийм сонирхол байвал би зөвшөөрнө. Хамаагүй. Багш нь энд ч бас бурхныг дурсаж байна. Та нар Багшийгаа Амиитаба Бурханы тарни уншиж байхыг харсан уу? Асуудалгүй.

Хамаг амьтад бүгд өөр өөр аргаар бясалгадгийг бид мэдэх хэрэгтэй. Би та нарыг Арьяабалын аргаар хүчээр бясалгуулах гэж энд ирээгүй. Хүн бүхэн нийгмийнхээ сайн сайхны төлөө өөрийн хувь нэмрийг чадахын хэрээр оруулах үүрэгтэй. Эмч өвчтөнийг эмнэнэ, ажилчин хүн зам гүүр барина, барилгачин байшин барилга барих зэргээр хүн бүхэн чадах чинээгээрээ хувь нэмэр оруулдаг. Багш нь бясалгагч хүн болохоор бясалгал ном л мэднэ. Иймээс би ном эрдэнийг олон хүнд зориулж, гарын авлага болгон өгөх нь зүй ёсны хэрэг. Энэ нь бас аяндаа л болж буй хэрэг. Та нар сонсохгүй, итгэхгүй байж болно, тэр ч байтугай юу ч хийхгүй байж болно. Харин итгэл байвал хамт бясалгаарай. Итгэхгүй бол бас хамаагүй.

Буруутгадаг хүмүүсийн тухайд санаа зорилгыг нь сайн мэдэхгүй ч тэд бол ирэх учиргүй хүмүүсийн замыг хаадаг бодьсатва (ном хамгаалагч) гэж өмнө нь би тодорхой ярьсан. Сүм дуган дотор хоёр ном хамгаалагч байхыг харсан уу? Тэдний дүр төрх тун сүрдмээр! Тэд зарим нэгэн ирэх учиргүй хүмүүсийг айлгаж, ирэх зориггүй болгохын тулд байдаг. Тэд бол дүрстэй ном хамгаалагч бодьсатва

нар. Дүрс үгүй ном хамгаалагч бодьсадваг харвал үнэхээр сүрдэж унамаар, үйлдэл нь ч аймшигтай. Гэвч бид бурхан чанараараа бурхныг харж, бурхан чанараараа хүнийг харах хэрэгтэй, учир нь тэд бүгдээрээ бурхад юм.

Та нарт шулуухан хэлэхэд Багшийнх нь хувьд хүн бүхэн бодьсадва. Жишээ нь, мэлхийн дотоодод бурхан бодьсадвагийн хүч үгүй бол хөдөлж чадахгүй. Тиймээс үхэх үедээ бие нь мэлхийтэй адил ч хэдийнээ хөдөлж чадахгүй болсон байдаг. Учир нь бурхан чанар нь байхгүй болчихож. Бид бүгд бурхан чанартай ч заавал яагаад бясалгах хэрэгтэй вэ? Бурхан чанараа бие цогцост хорьсон тул хорионоос суллаж, эрх чөлөөтэй, орчлонгийн бурхан чанартай нэгдмэл нэг болгох хэрэгтэй.

Аяганд далайн ус хийгээд таглаж тавибал тэр ус далайтай ямар ч хамааралгүй болно. Учир нь далайн их устай холбогдох боломжгүй болсон тул тун их өнчирнө. Удалгүй ус өмхийрч, доторх загас жараахай, дун хавч нь үхнэ. Багшийнхаа санааг ойлгов уу? Бид одоо доторх усыг асгая гэсэн ч яаж онгойлгохоо мэдэхгүй. Сандрахдаа энэ хавьд нь цоолно. (Багш халуун савны гадрыг заав) Гадна талыг цоолсон ч бас дотортой болохоор ус нь гоожихгүй.

Бид энэ дэлхийгээс буцахад бие цогцосоо үлдээсэн ч эрх чөлөөтэй болж чадахгүй байж магадгүй. Учир нь бидний олон давхар бие, бурхан чанарыг маань багласан байдаг. Тиймээс эрх чөлөөгүй. Эрх чөлөөт больё гэвэл аргаа мэдэх хэрэгтэй. Аягаа эвдэхгүйгээр тагийг нь онгойлгоход болно. Ингэвэл аяга ч бүтэн, ус ч чөлөөтэй урсана. Аль алинд нь ээлтэй сайн арга. Хатуу бясалгал хийж, өөрийгөө зовоож шийтгээд турж эцэн, өвчин хуучтай болсон ч бурхан чанараа олоогүй байдаг. Учир нь хатуу бясалгал бидний бурхан чанартай ямар ч холбоогүй юм.

Зарим хүн яаж бясалгах аргаа мэдсэн тул бурхан чанараа ямар ч илүү дутуу зүйлгүйгээр тун хялбархан олно.

Нисваанисыг яаж бодь сэтгэлд урвуулах вэ? гэж Багшаас нь олон хүн асуусан. Энэ тун амархан. Нисваанис бол нисваанис. Бодь сэтгэл бол бодь сэтгэл. Үүнийг анхаарах хэрэггүй, хольж хутгах ч шаардлагагүй. Бид бол бодь мөрийг эрэгсэд. Нисваанисыг бүү тоо. Нисваанис бол нисваанис. Хамаагүй хэрэг. Жишээ нь, бүсгүйчүүд очир алмаасанд их дуртай. Тэр очир алмаас нь шороонд булаастай тул гүн малтах хэрэгтэй болно. Алмааз нь өчүүхэн бага ч, шороо нь тун их. Гэвч ухсан шороог анхаарах хэрэг бидэнд байна уу? Шороо бол шороо. Ямар ч хамаагүй. Хажуу тийш нь хаяхад л болно. Харин хайсан очир алмаасаа олох нь л бидэнд хамгийн чухал.

Дахиад өөр нэг жишээ авья. Урт холын аян зам өргөст бут, хад чулуугаар дүүрсэн байв. Хэрвээ бид гэртээ харья гэвэл эхлээд замын чулууг зөөж, бут сондуулыг цэвэрлэх хэрэгтэй болно. Энэ бол тун яршиг төвөгтэй ажил. Тийм биз? Тэгвэл нисваанис яг үүн шиг. Бид яах хэрэгтэй вэ? Бид ердөө л урт түрийтэй зузаан гутал өмсөх хэрэгтэй. Тэгвэл хад чулуу, бут сондуул ихтэй замаар явсан ч тун хялбархан ямар ч саадгүй яваад гэртээ харина. Харин явах замдаа хад чулуу, бут сондуулыг нэгд нэгэнгүй цэвэрлэн урагшилвал ийм байдлаар хэзээ гэртээ харих вэ?

Үүнтэй ижилхэн зарчим, хэрвээ бид сайн номын аргатай, жишээ нь, Арьяабалын бясалгалын аргатай бол бидэнд нисваанис байсан ч (энэ дэлхийд нисваанисгүй байна гэж хэзээ ч байхгүй. Нисваанисгүй бол энэ дэлхий ч огт оршихгүй) нисваанисыг бид тоохгүй, авч хэлэлцэхгүй. Арьяабалын аргаар бясалгавал бид яг нисваанисгүй мэт болж өөрчлөгдөнө. Байсан ч тун бага өчүүхэн төдий. Бид иймэрхүү зүйлсийг огт тоохгүй болдог.

Та нарт ойлгуулахад амрыг бодож арай бодитой жишээ авья. Залуус (ахимаг настай ч байж болно) дурласан үедээ хаана ч амьдарсан аз жаргалтай байдаг. Харанхуй газарт

хамгийн дуртай. Саад болох хүнгүй сэтгэл баяр жаргалтай л байвал болно. Харин бид харанхуй гэрэл муутай газар очих дургүй. Тэд бол харин тун дуртай, харанхуйг хайхрахгүй, өөрсдийгөө л хайхрана.

Мөрийтөй тоглоомчид хичнээн хоног угааж, цэвэрлээгүй аяга таваг овоорсон, тамхины иш хөглөрсөн бохир заваан газар тамхи татан орчин тойрноо ч анзаарах сөгөөгүй тоглоомондоо улайраад мөрийцөх хүн, тоглох хөзөртэй л байвал баярлаж суудаг. Тийм биз?

Жирийн хүмүүс ч бүгд иймэрхүү байдалтай. Гэтэл бясаллагч бид нисваанисыг юуг нь тэгж их анхаарах вэ? Ийм жижиг сажиг нисваанисуудыг мартаж хэмжээнд хүртэл анхаарлыг маань татах сайн ажил үйлийг олж хийгээгүйгээс нисваанис тэлж томроод биднийг баяр жаргалгүй болгож байгаа хэрэг.

Одоо би та нарт лавлагаа болгож, өөрийн ахуй ойлголтыг ярьж өгье. Яагаадыг мэдэхгүй бие маань байнга өвддөг. Эмч бас эдгээж чадахгүй. Үүнийг бид үйлийн үрийн өвчин гэдэг. Үйлийн үрийг мэдэх үү? Заримдаа тэсэхийн аргагүй. Шавь минь санаа нь зовж, багшаа би танд өвчин намдаах наалт авчраад наагаад өгье гэнэ. Жирийн наалт бол ямар ч нэмэргүй. Нэг өдөр тэр дахиад л Багшаа халуун чинжүүтэй наалт тун сайн байдаг гэнэ гэв. Халуун чинжүү? гэж би асуусан. Тийм л нэртэй юм байна даа гэж бодсон тул за за, наагаад үзье. Чи л баярлаж байвал боллоо гэв. Энэ бол шавийн минь сайхан сэтгэл. Тэд арга бодож, Багшдаа туслахыг, Багшийгаа хамгаалж, халамжлахыг хүссэн. Гэвч халамжлах тусам нь би улам дордож, завгүй болгоно. Гэрийг маань янзалж цэгцлэх бүртээ юмсын байрыг солино. Би өөртөө таалагдсанаар чухал зүйлсээ нүдэнд ил, гарын дор байлгадаг юм. Гэр маань үнэхээр цэвэрхэн сайхан болсон ч үнэндээ ямар ч тус болсонгүй. Юмаа хайгаад олохоо болив. Тиймээс Багшдаа туслах тусам намайг улам завгүй

болгосон.

Өнөөх чинжүүний талаар дахиад ярья. Түүнийг наасны дараа түлэх мэт болж өмнөхөөс улам дордов. Өвдөнө, дээрээс нь түлнэ. Түлэхээс нь болоод би угийн өвчнөө ч мартаж орхив. Өвдөнө, түлнэ, тэсэхэд бэрх ийм байдалтай байснаа удалгүй өвдөхөө ч мэдрэхгүй болсон. Өвдөхөө больсон хэрэг биш. Харин энэ наалт дэндүү түлснээс болоод одоо зөвхөн тэсэхийн аргагүй халуу шатахыг л мэдэрч угийн өвчнөө мартжээ.

Үүнтэй нэгэн адил байдал. Ямар нэгэн хэрэг явдал бидний анхаарлыг маш хүчтэй татвал бусад нисваанисыг аяндаа мартана. Танай нэг хичээнгүй ажилчин шиг, зарим ажилчид завгүй, өлсөж байгаагаа ч анзаарахгүй. Хоолны цаг болсон ч идэхээ мартаад удалгүй бүр өлсөх ч үгүй болно. Эрдэмтэд мөн ажилдаа тун шаргуу, зарим нэг хүн хоёр, гурван хоног юу ч идэхгүй, ажлаа дуусаад л юу ч идээгүй яваагаа мэднэ. Та нар бас заримдаа ингэдэг. Ажил ихтэй бол идэхээ мартана, идсэн ч дуршилгүй. Тийм биз? Тиймээс хэрвээ сайн бясалгалын аргатай бол бид аз жаргалтай, уужуу тайван болно. Өдөр бүр жаахан ахуй ойлголт үзэж, тэр жаахан ахуй ойлголт маань хэдийнээ бидэнд хангалттай хүрэлцээтэй. Учир нь шуналгүй болсон тул баруун зүгийн Төгс баясгалант орныг тэр аяар нь харуулсан ч, арван зүгийн гурван цагийн бүх бурхан бодьсадва нар ирж, хаалга тогшсон ч бид илүү ихийг хүсэхгүй болсон байдаг. Тийм үү, үгүй юү? Тиймээс бид нэгэн Төгс Гэгээрсэн Их Багштай бол тэр биднийг жаахан ахуй ойлголттой болгож, сэтгэл ханамжтай болгоно. Учир нь ингэвэл сая бид энэ зовлонт ертөнцийг тэсвэрлэж чадах юм.

Саяхан нэгэн авшигтан, өдөр бүр өөр өөр дэвшил гарч байгааг мэдэрч, дээшилж буйгаа харсан нь өөртөө урам зориг өгөх хүч болж өчүүхэн нисваанисуудыг мартаж чадсан гэсэн. Бид бясалгах тусмаа нисваанисгүй болсоноо

мэдэрнэ. Нисваанис мэдээж байсаар байгаа, гэхдээ түүнийг бид хэдийнээ мартжээ. Яг л өнөөх ажил ихтэйгээсээ болж, хоолоо идэхээ мартдаг шиг. Том гутал өмсвөл хөл дээр замын чулуу унасан ч мэдрэхгүй болдог шиг. Тийм биш үү?

Бас нэг зүйлийг та нарт хэлье. Арьяабалын аргаар бясалгадаггүй хүн гурван муу заяанд унахаас хэрхэн зайлсхийх вэ? Энэ талаар Багш нь өчигдөр ярьсан. Аль болох цагаан, ногоон хоол ид! Багшдаа итгэх нь мэдээж маш сайн. Багшийг дагаж бясалгахгүй ч итгэхэд л болчихно. Итгэх итгэхгүйд ямар ч үнэ төлөхгүй шүү дээ. Заавал надад мэдэгдэх ч албагүй. Багшид итгэсэн бол дотооддоо чимээгүй итгэ! Багшид итгэсэн бол үнэн ёсыг хайсан, гэгээрлийн хайсан сэтгэл заавал байдаг. Тэгэхээр Төгс Гэгээрсэн Их Багшаас гуйх хэрэгтэй. Энэ маш чухал гэдгийг сайн санаарай. Учир нь та нарын цаг болоогүй, Арьяабалын аргаар бясалгах хүсэлгүй, гэртээ харихыг хараахан хүсээгүй, энэ дэлхийгээс уйдаагүй байж болно. Зүгээр ээ! Харин гурван муу заяаны зовлон—тамд унах, бирд болох, адгуусны төрөл авахаас зайлсхийх хэрэгтэй. Учир нь тэдний зовлон маш их. Тэр газар үнэхээр хэцүү байдгийг би та нарт баталъя. Тиймээс та нар номч сэтгэлтэй, үнэн ёсыг хайх итгэлтэй бол өдөр бүр өөрийн дотоодын хамгийн дээд хүчинд даатгаж, түүгээр хамгаалуулж, дэндүү доогуур төвшин лүү унагахгүй байхыг Түүнээс гуйгаарай. Үнэн ёсыг заавал олох хэрэгтэй. Хэрвээ би энэ насандаа үнэнийг хайхгүй, Төгс Гэгээрсэн Их Багшид итгэхгүй бол энэ болоод дараа дараагийн төрөлдөө заавал Төгс Гэгээрсэн Их Багшийг хайж олоход минь туслаарай хэмээн даатгавал үнэн ёсыг хайсан хүсэл зориг чинь нэгэн хамгаалах хүчийг үүсгэж, чамайг гурван муу заяаны зовлонд унагахгүй юм.

Мөн сорилт шалгалтыг заавал таних хэрэгтэй. Бид өдөр бүхэн соригдож байдаг. Жишээ нь, хэн нэг нь чам дээр ирээд: Энэ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай бол гадаад

номтон шүү! Гэвэл энэ бас сорилт юм. Ойлгов уу? Бусдын дэл сул ярианд амархан итгэж болох уу? Гэтэл бид Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайг огт танихгүй мөртлөө түүнийг муулсан ганц үгэнд даруйдаа итгэдэг нь дүгнэж цэгнэх чадваргүй, хангалттай даруу биш, үнэн ёсыг хайсан сэтгэл нь тун сул дорой болохоо харуулна. Үнэн ёсыг чин үнэнээр, жинхэнээсээ хайсан хүн бол эхлээд тэр номын Багшид бараалхаж, түүний номын айлдварыг сонсож, айлдсан номуудынх нь агуулгыг заавал сонирхоно. Үүний дараа сайн, мууг нь дүгнэж чадна. Ингэх нь үнэхээр шударга явдал мөн! Эхлээд заавал оролдоод үзэх хэрэгтэй. Алдах юмгүй! Айх зүйлгүй!

Хүмүүсийн шүүмжлэхийг сонсоод итгэдэг, аливааг билиг ухаанаар шүүн тунгаадаггүй бол харалган мунхаг хүн. Энэ бүхэн биднийг шалгасан Бурхан бодьсадвагийн шалгалт байдаг. Үнэндээ ямар ч муу хүн байхгүй. Юмсыг магадлан дүгнэх чадваргүй бид л өөрсдөө муу байгаа хэрэг. Бурхан бодьсадвагийн өгсөн билиг ухааныг ашиглаж, өөрөө сорилт шалгалтанд орж байгаа тэр агшнаа харж чаддаг, таньж мэддэг байх хэрэгтэй. Шавь хүнд ирэх сорилт шалгалт үнэхээр их. Үүнийг бясалгадаггүй байсан өмнөх үетэй жишвэл тодорхой байдаг. Бусдыг буруутгаж байгаа хүнийг сонсохгүй байх нь хамгийн сайн. Түүнд: “Та надад иймэрхүү зүйл битгий ярь! Надад ямар ч хэрэггүй” гэх хэрэгтэй. Тиймэрхүү дэл сул яриа бидэнд тустай юу? Тусгүйгээр барахгүй бидний оюун бодлыг самууруулж, сэтгэл санааг бохирдуулахаас цаашгүй. Өөрөө л хичээнгүйлэн бясалгавал хангалттай, бусдын ярих дэмий үгийг бүү сонс! Төгс Гэгээрсэн Их Багшийг хайсан номч сэтгэл, ангижирч чадах бясалгалын аргатай байх нь хамгийн чухал юм.



## ӨӨРТӨӨ НАЙДАХ НЬ ХАМГИЙН ДЭЭД ЭЗЭН БУРХАНД НАЙДАЖ БУЙ ХЭРЭГ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Формоса, Таоюань бясалгалын төв  
1990 оны 7 дугаар сарын 13  
(Эх нь хятад хэлээр)*

Нэгэн шавьтай хүн байжээ. Тэр шавь нь анх Багшийгаа маш их билиг ухаантай, бясалгалтай хүн гэж сонссоод түүнээс суралцахыг хүсчээ. Багш нь түүнийг шавиа болгохоосоо өмнө тун сүрхий шалгасан бөгөөд шалгалтын дараа: “За, би чамайг шавиа болгон авлаа” гэв. Яаж бясалгахыг өдөр бүр түүнд заана.

Нэг өдөр Багш нь түүнийг өөр нэгэн газар битүүмжлэн бясалгаж байгаа хүнд хоол хүргүүлэхээр явуулав. Даяан хийж буй хүнд харж хамгаалах, өдөр бүр хоол хүнс дөхүүлэх хүн заавал хэрэгтэй. Шавь нь Багшдаа: Даяанчилж буй хүн голын нөгөө эрэгт суудаг аж. Би сэлж чадахгүй, тэнд завь байхгүй, яаж тэнд хүрэх вэ? Би бас тань шиг их ид шидгүй гэв. Багш нь их шидтэй, Хуатөү эмч шиг хүн эмчлэхдээ тун гарамгай.

Багш нь түүнд: “Зүгээр зүгээр, сүрдэх юмгүй. Чи голын эрэгт очоод: “Хоёр тийш ярагдан зам гаргаж, намайг гаргахтүн! Багш минь намайг томилон явуулав. Миний багш бол хэзээ ч бүсгүй хүнтэй ойртоогүй хүн ” гэж усанд



ХЭЛ ГЭЖЭЭ.

Тэр толгой сэгсрэн суусан ч Багшдаа харагдаж зүрхэлсэнгүй. Учир нь Түүний багшийн шавьдаа тавьдаг цорын ганц шаардлага бол чин сэтгэл, гүн итгэлтэй байх явдал. Эргэлзэж тээнэгэлзсэн сэтгэлтэй бол хөөгдөнө. Гэвч тэр дотроо: “Сонин юм даа! Багш эхнэртэй, бас гурван хүүхэдтэй. Тийм байтлаа яагаад надад ингэж хэлнэ вэ? Худлаа ярьж болохгүй гэж сахилд тодорхой байдаг даа” гэж бодов.

Уг нь асуумаар санагдсан ч, ийм зүйл бүү асууж бай гэснийг санаж, итгэлгүйгээ харуулсан хэрэг болно гэж бодоод асуусангүй. Тэгээд ч Багшийн хэлсэн нь заавал нэг учиртай гэж бодоод хоолыг авч, голын эрэг рүү хурдхан явжээ. Эрэг дээр очоод голын усанд: “Миний багш нэг ч эмэгтэй хүнтэй ойртож байгаагүй. Тэр намайг энд хүргэлээ. Усаа ярж, намайг гаргахтун!” гэхэд, ус үнэхээр хоёр тийш ярагдаж, түүнийг гаргажээ. Ингээд даяанчийн хоолыг хүргэв. Миний Багш үнэхээр аугаа юм даа гэж бодсон ч сэтгэлд үлдсэн өнөөх зангилаас тайлагдсангүй.

Битүүмжлэн бясалгаж байгаа өнөөх хүн хооллож дууссахад юм хумаа хумьж буцахыг завдав. Гэнэт яаж харих билээ гэж бодов. Багш маань намайг сая хүргэж ирсэн, харин яаж буцахыг зааж өгөөгүй, одоо яадаг билээ? (бүгд инээлдэв) Ус эргээд нийлчихсэн байгаа даа гэж бухимдан бодоод ямар ч арга олсонгүй. Тун их уруу царайтай байхыг харсан даяанч: “Чи яав?” гэхэд, тэр: “Би одоо яаж гол гаталж, гэртээ харих вэ гэв. Даяанч бол Багшийнх нь сайн найз. Тэрээр “Энэ тун амархан. Эрэг дээр очоод “Даруйхан усаа ярж намайг гаргана уу? Хэзээ ч хоол идээгүй нэгэн хүн намайг энд хүргэж ирлээ” гэж хэлээрэй гэв. Түүний энэ үгийг сонсоод бас л толгой сэгсэрч (сэжиг төрөв). Үнэхээр сонин юм! Дөнгөж сая миний авчирсан хоолыг нүдний минь өмнө юу ч үлдээлгүй идчихээд хэзээ ч хоол идээгүй нэгэн

хүн хүргэж ирлээ гэж хэл гэх юм. Гэвч ч ингэж хэлүүлэх нь лав нэг учиртай биз. Багшийнхаа хэлсний дагуу хийж, гол гаталсан болохоор одоо ч бас адил буйзаа гэж бодов. Өөртөө байх бүхий л зүрх зоригоо хөвчлөн голын захад хүрч очлоо. “Хэзээ ч хоол идээгүй нэгэн хүн намайг энд хүргэж ирлээ. Усаа хурдхан ярж, намайг гаргана уу” гэхэд нээрээ л ус ярагдаж, түүнийг гаргажээ.

Харьсныхаа дараа ч тун ер бусын санагдсаар байсан тул тэсэлгүй Багшаа би итгэхгүй байгаа биш, харин дэндүү нууцлаг, ер бусын санагдсан тул асуумаар байна, болох уу гэсэнд Багш нь зөвшөөрөв. Голын эрэг дээр очоод би таны заасан үгийг хэлсэн. Таны үгэнд бүрэн итгэлтэй байсан болохоор би гол гаталж чадсан. Гэтэл та эхнэр, гурван хүүхэдтэй байтал эмэгтэй хүнтэй хэзээ ч ойртож байгаагүй хүн гэж хэлээрэй гэсэн. Мөн өнөөх даяанч бас хэзээ ч хоол идээгүй хүн гэж хэлүүлсэн. Яагаад ингэж хэлүүлсний учрыг би олохгүй байна гэв.

Багш нь түүнд: Чи зөвхөн гадна талыг нь хараад сэтгэлийг нь харахгүй байна. Гаднаа эхнэр хүүхэдтэй мэт байвч сэтгэл минь энд байхгүй, хүн нь ч энд байхгүй. Би эхнэртэй. Учир нь би анхнаасаа эхнэртэй байсан. Би эхнэртэйгээ хамт байна, тэр хүүхдэд хайртай. Надад бол хүүхэдтэй байх эсэх нь тийм чухал биш. Би юунд ч үл дурлана. Гэсэн ч гадна талд байгаа бүхнээ сэтгэл ханамжтай байлгаж, үүрэг хариуцлагаа биелүүлэх ёстой. Энэ бүхэн миний үүрэг.

Чамд хэлэхдээ би худал зүйл яриагүй. Үнэнийг л хэлсэн, Тиймээс миний үг хүчтэй. Чи яг Багшийнхаа заавраар хийсэн учраас уг хүч дамжихдаа ч ижил байжээ. Миний даяанч найзын хэлсэн хэзээ ч хоол идээгүй гэдэг нь ч үнэн. Тэр амьд байвал олон хүнд тустай учраас хүмүүсийн төлөө өөрийн биеийг хадгалах хэрэгтэй. Тэрнээс биш хоолонд дурлаад хоолонд шунаад идээгүй. Хоолны амттай,

амтгүй түүнд ялгаагүй. Хооллох дуршил байх эсэхийг ч тоохгүй. Хоол идэх, эм уух хоёр түүний хувьд яг ижил.

Дэлхийн хүмүүсийн ихэнх нь хоол хүнсгүй бол дайн дажин хийж, өш өвөрлөн энийг ч голж, тэрийг ч шилнэ. Энэ бүхэн бүгд идэхийн төлөө. Сэтгэлдээ сэвгүй хооллох үе гэж бараг үгүй. Багшийнхаа санааг ойлгов уу?

Тэр бясалгагчдын юу хийж байгааг хэн ч мэдэхгүй. Хүүхэдтэй ч эмэгтэй хүнтэй огт ойртоогүй гэнэ. Цадталаа хооллосон ч идээгүй гэнэ. Шагжамуни Будда бас ингэж ярьсан. Тэр дөчин есөн жил би юу ч яриагүй гэсэн. Тэр тун арвин их зүйл ярьж, хүмүүс бүгд сонссон (бүгд инээлдэв), бас зарим нь тэмдэглэж авсан. Гэтэл тэр ганц ч өгүүлбэр яриагүй гэжээ. Учир нь Түүний сэтгэл юунд ч үл хүлэгдэнэ. Тэрээр өөрөө ярих дуртайдаа биш, харин сонсох хүсэлтэй хүмүүс байснаас ном айлдаж байжээ. Тэр, ертөнцийн сайн, муу явдлыг хамаарч, хүмүүсийг сурган хүмүүжүүлэх дуртай тул хийж байсангүй. Харин Түүн дээр ирж, асуух хүн тун олон тул ярихаас өөр аргагүй байсан. Асуухгүй бол Тэр ярихгүй. Тиймээс, Бурхан айлтгаагүй бол айлдахгүй. Бурхан барилдлагагүй хүнийг гэтэлгэхгүй гэдэг. Тэд хамаг амьтныг аварч туслах, гэтэлгэж ангижруулах ажлыг ер яаруу сандруу хийхгүй. Тэдний сэтгэл тун сэрүүн тунгалаг, уйлахдаа уйлж, инээхдээ инээж, заримдаа уурлаж, заримдаа баярлаж байвч тэдний дотоод сэтгэл нь үүрд мөнхийн дао – “үнэн ёс”, үүрд тэр янзаараа хөдөлшгүй байдаг. Ямар ч нөхцөлд Тэдний үйлдэх нь эгэл хүн шиг л байна. Гэхдээ Тэр өөрийн биедээ хажуугаас харах хөндлөнгийн хүн шиг оршино. Та нарын уйлах, инээхийг харах нь надад ямар ч хамаагүй шиг, ойлгов уу?

Гэрээс гараагүй та нар шиг хүмүүс гэр бүлтэй байж болно. Гэхдээ сэтгэл хүлэгдэхгүй, гэр бүлийн уур амьсгал, хайр сэтгэлд төөрөлдөхгүй байвал гэрээс гарсанаас өөрцгүй. Тиймээс Багш нь гэрээс гарсан, гэрээс

гараагүй хэн ч бясалгаж болно, бүгд адил мөрийн хутагтай гэж байнга хэлдэг нь ийм учиртай. Харин ч зарим гэрээс гарагсад энэ ертөнцийг огоорч чадахгүй байх нь бий. Хэрэв хуврагийн хувцастай ч энэ ертөнцөд сэтгэл татагдсаар байвал ямар хэрэг байх вэ? Гэрээс гараагүй ч сэтгэл юунд ч хүлэгдэхгүй, үүргээ сайн биелүүлж, ажлаа хариуцлагатай хийж, эхнэр хүүхэдтэй бол зайлшгүй асарч халамжилна. Тэднийгээ хэнд найдаж орхих вэ? Энэ бүхэн өөрийн үүрэг хариуцлага гэдгийг сайтар ойлгох хэрэгтэй. Энэ бүхнийг хийж гүйцэтгэхийн зэрэгцээ чармайн сурч, чин сэтгэлээсээ үнэн ёсыг хайвал ижилхэн ахуй ойлголттой байна. Та нар гэртээ бясалгаж, зарим нь ахуй ойлголт сайтай, ахуй ойлголт ихтэй байдаг, тийм биз? Энэ нь Багшийнх нь ярьсан бүхэн зөв, хуурмаггүйг баталж байна. Бидний сэтгэл ямар байна, тийм мөрийн хутагийг олж, тийм үр дүнд хүрнэ. Хэрвээ хэн нэгэн хүн цаг ямагт үнэн ёсыг хайсан даруу бөгөөд чин үнэн сэтгэлтэй, үнэхээр бясалгах хүсэлтэй бол ямар ч нөхцөлд үүний төлөө тэмцэж, юунд ч нөлөөлөгдөхгүй байж чадна. Хэрвээ үнэнийг хайсан сэтгэлийн хүч нь сул дорой бол сорилт шалгалт ирэхэд амархан ганхана. Бид бясалгал бохирдож сэвтэхээс их эмээдэг. Гэхдээ сэтгэл бат бөх бол хаана ч алзахгүй.

Мэдээж гэртээ бясалгадаг хүмүүсийн зарим нь сайн бясалгаж чадахгүй байгаа нь хүч нь хүрэлцэхгүй, юу ч тохиолдсон автаад бууж өгөөд дараа нь уйлж дуулан таван нэрээ ч уншихаа мартаж, харин зургаан нэр, найман нэр уншаад (бүгд инээлдэв), ертөнцийн зарим явдлыг дурсан самуурч, сэтгэлээ татахгүй, анхаарлаа билгийн мэлмийдээ төвлөрүүлэхээ мартдаг. Та бидний дотор оройн дээд Эзэн Бурхан, Оройн дээд Будда заларч байдаг бөгөөд бид өдөр бүр түүндээ найдах хэрэгтэй. Бусдад биш, өөртөө найд гэдэг нь өөрийн дотоодын бурхан чанар, сүнс, уг мөн чанартаа найдаж ямар ч нөхцөлд Түүнийг илрэн гарч ирэхийг хүсч,

ямар ч хүнд бэрх үед Түүнээс тусламж хүсвэл Тэр заавал тусална. Хамгийн гол нь та гуйлт хүсэлтээ дотоодынхоо хамгийн гүний гүнд чин сэтгэлээсээ хүргэж чадвал Тэр хүлээн авч, заавал танд тусална.

Бид түүнийг Дотоодын багш хэмээн нэрлэдэг. Энэ бол бидний өөрийн их билиг ухаан. Гэвч бид өөрийн тэр их билиг ухаантай холбогдож чадахгүй учраас дотоодын багш байдаг. Тэр эхлээд хажуугаас тусалж, гэртээ хараахан хүрч чадаагүй замын дунд явахад чинь харж хамгаалан сэтгэлийг тайвшруулна. Тиймээс “Багшийн хувилгаан биеийг харах нь замын хагаст хүрсэн төдий гэсэн үг. Өөрийгөө харж, өөрийн хэн болохыг мэдвэл тэр сая хамгийн төгс дээд гэж Багш нь хэлдэг.

Багшийгаа харж байгаа нь Багш болон би ангид байна гэсэн үг, Өөрөө өөртөө туслахгүй, өөр нэгнээр туслуулж байна гэсэн үг. Мэдээгээ хүрэх ёстой газарт нь хүргэж чадаагүй байна. Тийм төвшинд хүрээгүй байна гэсэн үг. Яагаад бид хүргэж чадахгүй байна вэ? Ихэнх хүний чин сэтгэл хангалтгүй тул аргагүй чадахгүй байна. Бид чин сэтгэлтэй байхыг хүсээгүйдээ биш, харин чин сэтгэл гэж юу болохыг мэдэхгүй байна. Бид яагаад анхнаасаа ийм чин сэтгэлтэй байж чадаагүй вэ? Яагаад гэвэл бид өөрийн чадвараар тэмцэж дадсан байдаг. Жишээ нь, хэн нэг хүн биднийг хорловол бид түүнийг хорлох, эсэргүүцэх арга саам хайдаг. Бид хэзээ ч өөрийн дотоодын билиг ухаанаас тусламж гуйж, өөрт тохиолдсон хүнд хэцүү асуудлыг түүгээр шийдвэрлүүлж сураагүй. Аливааг бид бодмогцоо шууд шийддэг. Энэ бол зөвхөн оюун ухаанаа л ашиглаж байгаа явдал. Оюун ухаан бол гадна давхарга, Бурхны мөн чанарт нэвтэрч амжаагүй байдаг. Оюун ухаан бол автомат хариу үйлдэл үзүүлэгч. Яг л нэгэн ажилчин өдөр бүр автомат машин дээр өдөржингөө энэ ч товчлуурийг дарж, тэр ч товчлуурийг дарж суудаг шиг. Ямар товчлуурыг

дарвал юу гарч ирэхийг зохицуулж байдагтай ижил. Хэрвээ бүтээгдэхүүний гарц муу байвал хурдасгах товчлуурыг дарна, хэт удаан бол өөр нэг товчлуурыг дарна.

Тэр өдөр бүр тоног төхөөрөмжтэй харилцаад эзэнтэйгээ холбогдохгүй, тийм цаг завгүй яваад байдаг. Эзэнтэйгээ уулзаж цалингаа нэмүүлье гэвэл заавал түүний албан өрөөнд очих хэрэгтэй. Машинаасаа холдохгүй, эсвэл доогуур албан тушаалын хүмүүстэй уулзаад ямар ч тусгүй, эзэндээ л хэлэх нь хамгийн зөв. Учир нь одоо чамд их цалин, албан тушаал хэрэгтэй байна. Цалин хүрэлцэхгүй, дэндүү бага байгаагаа хэнд хэлэх вэ? Мэдээж өөрийн эзэнд санаа бодлоо хэлнэ. Түүнд өөрт нь хэлэхгүй, гадуур яриад ямар ч тус нэмэр байхгүй. Цаг заваа гарздаж, бусдад буруугаар ойлгогдохоос цаашгүй. Аливаа яриа хүмүүсийн ам дамжаад хувирч өөрчлөгддөг. Эзэнтэйгээ уулзаж ч амжаагүй байтал хэдийнээ түүнд буруугаар ойлгогдож, үгүй, үгүй яахаараа чи ийм их цалин шаарддаг билээ? Энэ тухай дахиж ярих хэрэггүй, явж ажлаа хий гэж хэлж магадгүй.

Ад ч мөн үүнтэй адил. Өөрийн дотоодын бурхан чанарт үнэн сүсгээр даатгаж, жинхэнэ өөрийн эзнийг илрэн гарч ирээсэй гэж хүсэхгүй, гадна талын элдэв сахиусанд залбирч, даатгавал зөвхөн ад чөтгөрт л сонсгосон явдал болно. Тэгэхээр ад чөтгөр л ирж тусална биз дээ. Тус нь ч тэгээд олигтой биш. Ад чөтгөр өчүүхэн тус хүргээд үлэмж ихийг шаардана. Тийм учраас хүмүүс дахин дахин төрөл авч сансарын хүрдэнд эргэлдээд байдаг. Учир нь жинхэнэ эзнээ олж уулзахгүй, дандаа л гаднын нөхдүүдэд яриад байжээ. Хүмүүсийн ихэнх нь сүмд очиж мөргөдөг. Ямар ч сүмд очиж мөргөсөн ялгаагүй, тэдний чин сэтгэл нь хүрэхгүй, хэнд хандахаа мэдэхгүй тул эгэл хүний хүсэл сэтгэлээр юу хүссэнээ даатгаж явдаг. Эгэл хүний эгээрэл хүсэл, шийдэх арга зам нь ханьцашгүй үнэхээр илтэд туулсан бодь хутаг, Оройн Дээд Эзэн Бурханаас ялгаатай нь тодорхой. Жишээ

нь, Бидний оюун ухаан, нэг саяыг өгвөл баярлана, эсвэл ийм тийм аргаар хийвэл илүү сайн хийнэ гэж бодоод сахиусанд хандан: “Миний бодлоор ингэж хийвэл илүү сайн, та надад заавал тусал” гэж даатгана. Үнэндээ ад чөтгөр л ирж туслана. Заримдаа тусална, заримдаа чадахгүй. Учир нь бид өөрийн хүсэл эгээрлийн дагуу, өөрийн зохицуулсан арга барилаараа л хийхээс Оройн Дээд Эзэн Бурханы тааллыг сонсдоггүй. Бид хангалттай чин сэтгэлгүй, өглөөнөөс орой болтол бүхнийг өөрөө л шийдэхийг оролдоод л байдаг. Багшийг нь даган маш олон хүн суралцаж байна. Зарим үед тэд өөрсдөө шийдэж зохицуулаад дараа нь над дээр ирж, би ингэж, тэгж хиймээр байна гэдэг. Хэрвээ би түүнд: Ингэж болохгүй ээ, тэгж хийсэн нь дээр гэвэл тэр сонсохгүй.

Багшийн зааврыг дагаагүй тул амжилтгүй, эсвэл ямар нэгэн асуудал үүсдэг. Мэдээж ийм байдал үүсэх нь тодорхой. Учир нь дотоодын багшаараа шийдүүлэлгүй, өөрийн ялихгүй өчүүхэн цэцэн сэргэлэн оюун ухаанаар шийдсэн тул үр дүн нь өөр байх нь тодорхой. Тэгээд дараа нь дахиад өөрөөсөө: Яагаад би амжилтанд хүрсэнгүй вэ? Багш яагаад надад тусалсангүй вэ? гэж асуудаг. Багш нь чамд туслаагүй биш, харин чи Багшийнхаа тусалж буй аргыг дагаагүй хэрэг. Ойлгов уу?

Ихэнх хүний бясалгал амжилтгүй, дэвшилгүй байдгийн гол шалтгаан нь ердөө л оюун ухааныг хэтэрхий их ашигласантай холбоотой. Бид өөрөө л тэмцэх гээд байдаг дадалтай, өчүүхэн жижиг, явцуу уйтган, доройтож муудсан энэ нэг оюун ухааныг ашиглаад байдаг. Бас түүнийгээ тун сүрхий гэж цаг ямагт бодно. Чин сэтгэл нь хаана ч хүрэхгүй, чин сэтгэл гэж юу болохыг ч мэдэхгүй. Тиймээс дотоод ерөнхий командлагчийнхаа сэтгэлийг хөдөлгөж чадахгүй байна. Тийм учраас хамгийн сайныг хүртэж үл чадна, өөрийн эзэнтэй уулзаж үл чадна. Өдөр бүр тэндээ гомдоллон ажиллана. Хамт ажилладаг хүндээ гомдоллоно. Эрх мэдэл

багатай жижиг даргадаа ч гомдоллож: “Миний ажил дэндүү залхмаар, цалин бага, хэзээ нэг өдөр би заавал их цалин өгөхийг шаардана” гэх мэтээр өдөржингөө үглэвэл сонссон хүн залхахаас өөр юмгүй. Магадгүй хэн нэг нь өдөржингөө гомдоллох чамайг эзэндээ ховлож, энэ их муу хүн гэвэл чамд бөөн төвөг үүснэ. Санаа бодлыг чинь ойлгоогүй эзэн чинь чамайг хөөгөөд явуулж ч мэднэ.

Яг үүн шиг, бидний бясалгал ч бас адил. Хэрвээ үнэнхүү чин сэтгэлээр дотоод руугаа хандаж, амь насыг аврах их чадвараа хайвал бидний бясалгал тун хурдан дэвшинэ. Өөрийн жинхэнэ биеэ чин сэтгэлээсээ хайрлаж, хамгаалж, чин зүрхнээсээ хүсэн гуйж, жинхэнээсээ дурсан санавал амжилтанд хүрнэ. Харин бид өөрсдийн дадсан аргаараа бүхнийг шийдээд байвал дотоодын жинхэнэ эзэнтэйгээ хэзээ ч уулзахгүй. Бүхнийг өөрийн оюун ухаанаар, гадны элдэв хүчээр шийдвэл сахиус, ад, чөтгөр мэт дүрс үгүй төрөлтнүүд ирж, харш саад болохоос цаашгүй.

Заримдаа та нар, авшиг авах үед тун сайхан ахуй ойлголттой байснаа гэртээ хариад багасчихлаа гэгцгээдэг. Гэхдээ хүн бүхэн биш л дээ. Авшиг хүртэх үед Багш нь жаахан тусалж, та нарыг ямар ч завсрын зүйлийн оролцоогүйгээр шууд угтан авдаг болохоор ахуй ойлголт чинь адилгүй байжээ. Харин гэртээ хариад оюун ухаанаа хэт их ашигласанаас болж, явах тутам саад тотгор ихэссэн байна.

Бидний бодсон санасан бүхэн илрэн гардаг. Жишээ нь, сэтгэлд эргэлзээ тээнэгэлзээ байвал бас нэг саад тотгор үүснэ гэсэн үг. Учир нь бүх зүйл сэтгэлээс үүдэлтэй байдаг. Бидний сэтгэл хангалттай цэвэр ариун бус бол өөртөө маш их саад тотгор дуудна. Ямар ч нөхцөлд үргэлж бусдыг хардан сэжиглэнэ. Ялангуяа Багшдаа эргэлзэх тэр агшин бол чиний хувьд найдаад байх юмгүй болж, зүрх сэтгэл хангалттай ариусаагүй, сайхан сэтгэлээр тун дулимаг гэдгээ мэдэх үе



юм. Хүмүүсийн олонхи нь ямар ч шалтаг шалтгаангүйгээр бусдыг хардан сэжиглэдэг, энэ нь өөрсдөө тэд хангалттай сайн биш, бясалгал нь их дутуу гэсэн үг. Хичнээн жил завилан сууж, хэдий удаан битүүмжилэн бясалгаж, өдөрт ганц удаа хооллоод тэр ч бүү хэл идэхгүй, уухгүй байгаад ч нэмэргүй. Чин сэтгэлээрээ Түүнийгээ хамгаалж, жинхэнээр Түүнийгээ хайж олоод хэн болохоо мэдэж, жинхэнэ ёсоор үүрд мөнх үхэхгүй, төрөхгүй болох хэрэгтэй.

Төрөхгүй, үхэхгүй гэдэг нь юу вэ? Багш яагаад худлаа ярина вэ? гэж та нар бодож магадгүй. Манай авшигтнуудаас олон хүн нас барсан, гэтэл Багш үхэхгүй, төрөхгүй гэж ярих юм. (Багш болоод бүгд инээлдэв) Бясалгагч хүн хувцас болсон биеэ орхидгоос үхдэггүй. Иймээс Багш нь нирваанд буцсан ч та нар Багштайгаа уулзсаар байх болно. Энэ нь яг л дахин амилахтай ижил. Есүс Христ шиг, түүний бие махбод бол махан бие биш. Гэвч Тэр махан биетэй болон хувирч чадна.

Есүс Христийн дахин амилсантай ижил өөр нэгэн түүх байдаг. Төгс Гэгээрсэн Их Багшаас суралцахыг үнэхээр их хүсдэг нэг хүн байжээ. Их Багш нэгэн өдөр тэдний гэрийн хажуугаар явж өнгөрөх үед Их Багшид хандан намайг шавиа болгон авна уу хэмээн гуйжээ. Их Багш түүнд зөвшөөрч, дараагийн долоо хоногт манайд ирээрэй. Би чамд ном заана гэв. Дараагийн долоо хоногт өнөөх шавь болох хүн Их Багшийнд очиж гэнэ. Гэтэл Их Багш дөнгөж нирваанд буцсан байсан бөгөөд Түүнийг чандарлаж эхэлсэн байв. Хүн бүхэн гашуудаж, уйлж, шавь нар нь мөргөж байлаа. Өнөөх шинээр ирсэн шавь их л итгэл алдарч: ”Энэ хүн ер нь жинхэнэ Төгс Гэгээрсэн Их Багш биш байх. Өөрийнхөө өөд болохыг ч мэдэхгүй, бас намайг мэхлэн энд авчрав. Тийм холоос зорин ирэхэд өөрөө харин нас барчихсан байх юм. Надад хэлэхгүй дээ. Би ч бараг буруу хүн дээрээ ирж дээ” гэж бодов.

Харихаар шийдэж гарахыг завдтал нэгэн морьтой хүн хурдаараа давхин ирээд: “Хөөе, та намайг дагаад яв. Маш чухал хэрэг гарлаа. Сайн найз чинь чамайг хүлээж байна” гэсэнд өнөөх хүн бүр гайхширч, итгэж ядан түүнийг даган явжээ. Уг газар хүрч ирээд морьтой хүн малгайгаа авч, хувцсаа тайлтал нөгөө Их Багш байлаа. Тэгээд шавьдаа ном заажээ. Энэ үед л Түүний нас бараагүйг ойлгож, Төгс Гэгээрсэн тэр Их Багш үхье гэвэл үхэж, төрье гэвэл төрдөг болохыг мэдэж гэнэ.

Хүн нас барвал түүний хорвоо ингээд л дууслаа даа гэх бидний бодол бүгд хуурмаг. Харин Арьяабалын аргаар бясалгадаг хүмүүст нэгэн төрлийн үхэлгүйн систем байдаг. Үүнийг би бас та бүхэнд тайлбарлах аргагүй. Яавал үхэхгүй байхыг мэддэг гэсэн үг. Тайлбарлахад хэцүү юм, гэхдээ би нэг арга олно оо. (бүгд инээлдэв)

Мөхөөлдөс яаж хийдгийг бүгдээрээ мэднэ. Хийхэд тун амархан. Усанд үнэр, амт оруулагч, үнээний сүү, элсэн чихэр нэмээд л болно. Сүү бол сүү. Ус бол ус. Амтлагч бол амтлагч. Тэдний аль нь ч мөхөөлдөс биш. Гэхдээ бид хийх аргыг нь мэдвэл хооронд нь холиод өөр өөр амттай мөхөөлдөс хийж болно. Уг нь зөөлөн, урсамтгай байдаг ч тусгай аргаар түүнийг хүйтэн хөлдүү болгоно. Энэ нь идэхэд таатай, зуны цагт бүр ч тохиромжтой. Өөр зүйлд бас ашиглаж болно. Хөргөгчинд хийгээд удаан хадгалж болно. Заримдаа хүүхэд халуурвал духан дээр нь жин болгон тавибал халуу нь бууна, бидний биеийн хаа нэг газар халуу оргивол тэнд мөсөн жин болгон тавибал тун таатай. Мөсөн жинг олон янзаар хэрэглэдэг. Заримдаа хүн бэртээд нэг гараа тайруулвал та түүнийг бушуухан хөргөгчинд хийж, дараа нь даруйхан эмнэлэгт хүргэвэл эмч тэр тасарсан гарыг дахин залгаж оёно. Хэрвээ мөсөн жин байхгүй бол энэ тасарсан гар эмнэлэг хүрэх замдаа муудаад залгаж оёх аргагүй болно.

Харин усыг ингэж ашиглаж болохгүй. Гэвч мөсийг

усаар хийдэг. Бид яаж хийдгийг нь мэдвэл усыг мөс, мөсийг ус болгон хувиргана. Энэ бүхэн тун амархан. Харин мэдэхгүй хүнд бол тун нууцлаг санагдана. Мэддэг хүнд бол тийм сүрхий зүйл биш. Африкийн нэгэн алс бөглүү газарт амьдардаг овгийн хүмүүс ийм арга байдгийг огт үзэж сонсоогүй бол үүнийг хараад бараг л биднийг бурхан хэмээн санаж, ямар сүрхий вэ? гэж бодно. Үнэндээ энэ бол тун энгийн явдал.

Яг үүн шиг Арьяабалын арга бол оршин амьдрах чадвар мөн. Тиймээс хүмүүс Арьяабалын номын ёсоор бясалгаж эхлээд л мөнхөрдөг. Эрт дээр үед олон янзын нарийн бүтэцтэй зүйлсийг холиод зууханд хайлуулж хувилгаан үрэл хийдэг байжээ. Мөнхрөх аргаа мэддэггүй учраас ингэж хийдэг байсан хэрэг. Үнэндээ бол бидний хувилгаан үрэл энд (билгийн мэлмий) байдаг. Өдөр бүр өөрийнхөө галаар буюу гэрлээр түүнийг хайлуулж, өөр өөр аялгуугаар хөөргөдөн хөөрөгдсөөр эцэст нь үхэлгүй мөнхрөх хувилгаан үрэл болгон хувиргана.

Эртний хүмүүс юу ч ярьсан зүйрлэлийг ашигладаг. Есүс Христ ч мөн ингэж ярьдаг байв. Тэр байнга Эзэн Бурхан, бясалгал гэгээрэл, Арьяабалын арга, аялгуу ажих, гэрэл ажих тухай яриад байсан бол хүмүүст уйтгартай санагдана. Багш нь ч мөн адил. Гурав, дөрвөн жилийн турш би зөвхөн Арьяабалын арга, бясалгал гэгээрлийг ярьж байна. Миний ярьсан үлгэр түүхүүд маш олон дууны хуурцаг, видео бичлэг болсон бөгөөд тус бүр өөр өөр утга агуулгатай. Гэсэн ч нэг л зүйлийг яриад нэг л эмийг сурталчилаад байсан төдий. Шөл нь өөрчлөгдсөнөөс эм нь өөрчлөгдөөгүй.

Тиймээс эрт дээр үед Төгс Гэгээрсэн Их Багш нар арвин их судар ном айлдсан ч үнэндээ энэ нэг зүйлийн эмийг л сурталчилж байжээ. Бид ухаж ойлгож чадахгүй тул тэднийг тун их зүйл ярьсан гэж боддог. Өнөөдөр “Богдосын ном цагаан лянхуа судар”, маргааш “Баатар явагч их хөлгөн

судар”, нөгөөдөр “Билгийн чанад хязгаар хүрсэн Очир огтлогч судар”, нөгөөдрийн маргааш “Амитаба Бурханы судар”, уржигдарын цаад өдөр “Оточ Манал Бурханы судар”, “Олонх Бурханы судар”-ыг тайлах гэх мэт. Үнэндээ судар ном гэмээр юм байхгүй.

Адил нэгэн аргаар адил бусын зүйрлэлийг хэрэглэж хүмүүст ойлгуулдаг. Яг л Есүс Христ өөрийн гол санааг ойлгуулахын тулд Библийн сударт маш олон үлгэр түүх ярьсан шиг. Багш нь өчигдөр та бүхэнд Библийн сударт байдаг олон богино түүхийг ярьсан. Та нар сонсохыг хүсвэл хуурцаг худалдаж аваарай. Богинохон хэдий ч маш сайхан агуулгатай, тун ойлгомжтой.

Би дахиад богино зүйрлэлээр тайлбарлая. Жишээ нь, нэгэн тариачин байжээ. Түүний ажил нь эрдэнэ шишийн үр цацах бөгөөд үрнүүд зарим нь чулуун дээр, зарим нь замын хажууд унаж шувууны хоол болно. Зарим нь өвсөн дунд цацагдаад ургаж чадалгүй дарагдаж үхнэ. Харин үржил шимтэй хөрсөнд унасан үр нь өндөр сайхан ургана.

Есүс Христийг ном айлдсаны дараа мөн ялгаагүй, зарим нь сонсоод ойлгоно. Зарим нь буруушааж гүтгэнэ. Зарим нь сонсоод мартана. Харин зарим нь сонсмогц Түүнийг даган суралцаж, ач тусыг нь хүртэнэ. Тэрээр маш олон түүх ярьсан бөгөөд бүгд нэг л санааг илэрхийлдэг. Өөрийн санааг бусдад ойлгуулж, ямар жигнэмэг сурталчилж байгаагаа мэдүүлэхийн тулд юм.

Тэрээр буй бүхий л өвчнийг эдгээдэг нэгэн номын ёсыг танилцуулж, буй бүхий л өвчнийг эмнэдэг тийм нэгэн эмийг тайлбарлаж байв.

Яагаад үхэхгүй гэдэг вэ? Учир нь бид угаасаа үхэх ёсгүй. Харин мэдэхгүй учраас үхэж, төрөхийн тухай хий хуурмаг бодлоо эвдэж чадахгүй байна. Эвдэж чадвал үхэхгүй, төрөхгүйг ойлгоно. Тиймээс л үхэхгүй, төрөхгүй, хиртэхгүй бохиртохгүй, нэмэгдэхгүй хорогдохгүй гэж

ярьдаг. Энэ бүхэн ердөө л бидний өөр өөр үзэл бодлоос болсон төдий. Ойлгов уу?

Буддын шашны өөр нэгэн түүх байдаг. Эрхийн тэнэг нэгэн гүнж байжээ. Түүний ордонд сувд эрдэнэс, мана, үнэт чулуу бүх юм бий. Хаан эцэг, хатан ээж нь түүнийг цорын ганц гүнж хэмээн маш их эрхлүүлэх тул түүнд юм бүхэн бий. Нэгэн өдөр борооны ус нуурын мандалд хүрмэгц хөөс болохыг олж харжээ. Хөөс үүсэх тэр агшинд нарны туяа тусаж таарав. Зарим үед нартай бороо ордог доо. Нарны туяа нуурын мандалд тусаж, маш сайхан солонгорсон гэрэл цацрахыг харсан гүнж, би тэр хөөснүүдийг цуглуулаад зүүлт хийж зүүнэ гэж хаан аавдаа хэлэв. Хаан аав нь болохгүй ээ, сувд хэрэгтэй бол аав нь илүү томыг чамд өгье, тэгэх үү? гэв. Гүнж хэрэггүй, хэрэггүй гэхэд аав нь очир алмаас хэрэгтэй бол аав нь бас том томоор нь авчруулья гэв. Гэсэн ч гүнж огт зөвшөөрсөнгүй.

Эрхийн тэнэг болсон хүүхэд ямар байдгийг та нар сайн мэднэ. Юу ч хий гэсэн зөвшөөрөхгүй. Бүх түшмэлээ дуудаж туслуулах гэсэн боловч ямар ч тус болсонгүй. Явал гүнжийн санаа амрахыг хэн ч мэдэхгүй байв. Учир нь түүнд одоо хөөснөөс өөр юу ч хэрэггүй болсон байлаа. Гүнж уйлж, хоолноос гарч турж эцэн бие нь өвдөв. Хаан ямар ч аргагүй болж, гүнжийн өвчнийг эдгээсэн хүнд хаан төрийн хагасаа өгнө хэмээн түмэн олонд зар тараажээ. Тэр улсын хамгийн алдартай сайн эмч ч эдгээж чадсангүй. Бүгд аргагүй байдалд орж гэнэ.

Нэг өдөр настай өвгөн надад арга бий гэсээр ирэв. Хаан өвгөнийг дагуулан охин дээрээ очиход аав нь энэ хүнд чиний хүслийг биелүүлж, хөөсөөр сондор хэлхэх арга байгаа гэнэ гэхэд гүнж баярласандаа үсэрч харайн, дахин бие нь өвдсөнгүй гэнэ. Өвгөн дараа нь гэвч би хэдийнээ өндөр настай болсон болохоор хөөсний гоё муухайг ялгаж чадахгүй, тэгэхээр гүнж та эхлээд хамгийн гоё нэг хөөсийг

надад авчирч өгвөл сондор хэлхээ, тэгэх үү? гэжээ.

Тэр хоёр нуурын захад очив. Усны хөөс барих гэж гүнж хичнээн оролдовч чадсангүй. Хажууд байсан ордны гоо бүсгүйчүүд жиг жуг инээлдэв (бүгд инээлдэв). Гүнж нилээд санаа нь зовсон янзтай, надад хөөс хэрэггүй ээ, харин сувд алмаас эрдэнэ байвал болно. Би энэ хөөсийг түүж чадахгүй юм байна гэж аавдаа хэлэв. Аав нь охиноо их л өхөөрдөж, энэ чинь зүгээр л нэг хөөс төдий гэж би чамд хэлсэн дээ гэв. Тэгээд ордон руугаа буцаж, гүнж ч дахин өвдөж зовоосонгүй.

Яг үүн шиг. Бид үхдэг, төрдөг гэж боддог нь үхэж, төрөх гэж юу болохыг ойлгоогүйгээс болдог. Бүгд хуурмаг төсөөлөл төдий. Говийн зэрэглээн дунд ус үнэндээ байдаггүй шиг. Замаар давхиж явахад өмнө талд ус харагддаг. Гэвч энэ нь ус биш, гэрэл ойсноос болсон үзэгдэл. Говийн зэрэглээнд олон хүн, адуу мал, орд харш үзэгдэх бөгөөд далайн дунд гандирсын хот, дуу аялгуу, гоо охин загас, загасан гоо охин (багш зориуд үгийн байрлалыг сольж хэлэхэд бүгд инээлдэв) харагдахад бүгд үнэмшдэг. Үнэндээ бүгд хий хоосон зүйл. Үзэгдэх талбай нь хэт том тул хүмүүсийн нүд эрээлжилжээ.

Заримдаа зам дээр нарны туяа туссанаас утаа уугих шиг, эсвэл ус шиг харагдах нь бий. Би багадаа ийм зүйлд хууртаж л байсан. Сургуульдаа явган явдаг байсан бөгөөд ус харагдвал гүйж очно. Гэвч юу ч үгүй, дахиад л өмнө маань ус харагдана. Гүйгээд очвол бас юу ч байхгүй. Сүүлдээ энэ бүхэн хий хоосон, хүнийг хуурдаг болохыг ойлгосон.

Үүнтэй нэгэн адил бид энэ ертөнцөд төрөл авсаар байдаг нь бид нойрноос сэрээгүй, энэнээс ч зуурч, тэрнээс ч зүүгдэж, энэнд ч хүлэгдэж, тэрэнд ч татагдаад бүх юм хий хоосон, худал хуурмаг болохыг танин мэдээгүйгээс болдог. Гэвч бид нэг л өдөр мэдэх болно. Ийм байдалтай нүүр тулвал бид сэрээд сүнсэндээ нэгэн сэтгэлээр дасгал хийх ганц өдрийг зориулахад л Тэр даруйдаа сэрнэ.

Учир нь одоо сайн төвлөрөхгүй байна. Гэсэн ч дадуулсаар байх хэрэгтэй. Нэг л өдөр машин барьж сурдаг шиг, эхлээд сурамгай биш байснаа удалгүй хурдан давхидаг болно. Мөн анх дугуй унаж сурахдаа унаж тусдаг байсан бол мөдхөн хурдан жийдэг болно. Морь унах, өөр юуг ч унасан яг адил, байнга дадуулвал сурамгай болно.

Ингэж их дадуулсан байтал яагаад би чадахгүй байна вэ? гэж заримдаа зориг мохдог. Гэвч бүрэн сурах өдөр заавал ирнэ. Бага байхад бичиж сурна гэдэг үнэхээр хүнд ажил байв. Хичээж хичээж бичсэн зүйлээ багшдаа үзүүлэхэд муухай болж гэнэ. Одоо бол та нар бичих дасгал хийх шаардлагагүй. Нүдээ аниад бичсэн ч хурдан бичнэ. Яг хэзээ бичиж сурснаа би ер санадаггүй. Яг үүнтэй ижил. Бид бясалгалдаа тууштай тэвчээртэй хандвал нэг л өдөр заавал амжилтанд хүрнэ. Тэгээд ч урам зориг өгч тусалж дэмжин, алдаа мэдгийг чинь засаж залруулах Багш хажууд чинь байгаа болохоор лавтай амжилтанд хүрэх юм.

Шагжамуни Будда Бурханы хутагт хүрч чадсан байтал бид яагаад чадахгүй байх вэ? Тэр зургаан жилийн дотор Будда болсон. Бид ядаж арван зургаан жилийн дотор Будда болно биз дээ. Эсвэл жаран жилд ч юм уу. Жаран жил ч оройтохгүй. Миний бодлоор Шагжамуни Будда тийм ч сүрхий биш. Тэр идэж ууж, наргиж цэнгэн ертөнцийн жаргал цэнгэлийг хорин есөн жил эдэлсний дараа бясалгахаар шийдсэн. Та нар бол Түүнээс мундаг санагдаж байна. Тэр бясалгахаасаа өмнө ордны гаднах амьдрал ямар их зовлон зүдгүүртэй байдгийг төсөөлдөг ч үгүй байсан болохоор ууж идэж, наргиж цэнгэж байжээ.

Нэг өдөр ордноос гарч яваад билиг нь нээгдсэн. Энэ нь мөнх бусын ертөнц болохыг, мөн бидний амь нас үүрдийн залуугаараа байдаггүйг ухаараад тэр тун хурдан сэхээрч, даруй Төгс Гэгээрсэн Их Багшийг хайн олж бясалгахаар шийдсэн. Тэр нилээд чин сэтгэлтэй, бас яарч байлаа.

Хүмүүсийн байдлыг хараад маш их цочирдсон, ийм хэцүү байдгийг хэзээ ч мэдээгүй байжээ. Хүн бүхний амьдрал яг л хааны ордных шиг тав тухтай, амар амгалан, өдөр бүр дуулж бүжиглэн өвөл нь өвлийн ордондоо тухалж, зун нь сэрүүн ордонд заларч байдаг хэмээн боддог байжээ. Хавар, намарт мөн л өөр өөр маягаар амьдарна. Ийм нөхцөлд тэрээр хорин есөн жилийг өнгөрөөсөн. Гадна талд иймэрхүү байдалтай байдгийг анх удаа хараад түүний цочиж балмагдсаныг та нар төсөөлөөд үз. Тийм учраас л Тэр маш хурдан бүхнийг огоорсон байх аа.

Бид жирийн үед өдөр бүр хүмүүстэй уулзаж, заримдаа баярлана, заримдаа зовно. Тиймээс бид нэг их цочиж гайхдаггүй. Авшигтнууд нас барах юмуу, танил нөхдийн нэг өчигдөрхөн амьд байснаа өнөөдөр гэнэт нас барах, найзтайгаа муудалцах, худалдаа наймааны түнш урваж мэхлэх, хайр сэтгэл, нэр төр, эд мөнгөний хохирол амсах гээд аль нь ч тохиолдсон тун их шаналж, тэр үедээ гэнэт маш их чин сэтгэлтэй болдог. Тиймээс төрөх, өглөх, өвдөх, үхэхийн зовлон нь бидэнд бясалгах хэрэгтэйг сануулж байдаг. Энэ дэлхийд амьдарч байгаа маань үнэндээ бүгд л хий хуурмаг. Хий хуурмаг ч гэсэн бидэнд ямар нэг зүйлийг сануулж байдаг. Сэтгэл санаанд үл нийцэх нөхцөл байдал, зовлон бэрхшээл тулгарвал тэнгэр хангайд гомдох хэрэггүй. Харин ч баярлах хэрэгтэй. Энэ бүхэн бидэнд ямар нэгэн сураг чимээ дамжуулж байгаа түүний хайр юм. Дахин бүү унтаа бай, цаг хугацаагаа дэмий бүү үр хэмээн сануулж буй хэрэг. Нэг насандаа хэдэн жил амьдарч, хэдий хэр хоол хүнстэй байх нь тогтсон байдаг, үүнийгээ чухам хаана, юунд хэрэглэж байгаагийг чинь ч харж байдаг. Жишээ нь, таны машин Тайбэйгээс Каошун хүртэл хоёр зуун долларын бензин хэрэглэнэ. Хэрвээ чи шууд Каошун явалгүй замдаа эргэж буцаж, нааш цааш сэлгүүцсэн бол зорьсон газартаа хүрэлгүй хоёр зуун долларын бензин чинь дуусна.



Хэрвээ бид энэ олдсон цаг хугацаагаа амжиж зөв ашиглан бясалгахгүй бол энэ насаа талаар үрсэн явдал болно. Гэсэн ч хүмүүс хэзээ нэгэн цагт заавал сэрэх юм.

Тиймээс та бүхэн бас зовж зүдэрч буй хүнийг хараад сандарч тэвдэх хэрэггүй. Тэдэнд өөрийн гэсэн цаг хугацаа бий. Бид ч гэсэн ийм л замыг туулсан. Оройн дээд Бурхан тэднийг харж халамжилж байдаг. Хэн нэгэнд ойлгуулж чадвал түүнийгээ хийх нь мэдээж. Хэрвээ тэд сонсохгүй бол зовж шаналан сандарч тэвдээд хэрэггүй. Хүчлэх ч шаардлагагүй. Өөрсдийнх нь дотоодын Эзэн Бурхан тэднийг харж хандана. Одоохондоо тэдэнд ийм зүйл тийм ч их шаардлагагүй санагдана.

Та нар эзэн хүн, нохой хоёрын байдлыг анзаардаг уу? Нохой энд тэндгүй дураараа явах дуртай. Гэвч эзэн нь түүний хүзүүнд урт уяа углаад эхний үед хэсэг дураар нь явуулна. Тэр бусад ноходтой зодолдоно, бусдын найзыг булаана, хаа сайгүй шээнэ, баана, хүн руу хуцна, дайрна. Хүссэнээ хийгээд их л эрх чөлөөтэй мэт санагдах боловч үнэндээ урт уяатай, эзэн нь алсаас харж байдаг. Тэгээд цаг нь болоход түүнийг буцаагаад авчирна. Тэгээд ч буцахгүй байж болохгүй.

Бид бүгд дотооддоо өөрийн гэсэн эзэнтэй. Хэзээ түүний хэрэг гарна, тэр цагт үнэн сэтгэлээсээ тусламж гуйвал тэр бидэнд тусалж, харж хандана. Өнөөх нохойтой тун адил. Нохой хэдийгээр ийш тийш гүйсэн ч зүгээр, шархадвал, нохойнд уруулвал эзэн нь даруй түүнд тусалж хамгаална.

Яг үүнтэй адил, бүгдэд маань үүрд бидэнд туслах дотоодын багш байгаа болохоор айх зүйлгүй. Тэр цаг ямагт биднийг харж, хамгаалж байдаг. Бид л харин зарим үед дадлаараа бодож сэтгэн Түүнээс хөндийрдөг. Ойлгов уу? Эзэн нь дуудахад нохой шууд хүрээд ирэхгүй ийш тийш гүйж харайн урт уяа нь модонд, эсвэл цахилгааны утастай

орооцолдоно. Эсвэл хүний хөлийг орооно. Үнэхээр төвөгтэй. Цаад хүн нь тэсэлгүй өшиглөнө. Уг нь эзнээ дуудах үед шууд ирсэн бол асуудал үүсэхгүй байсан. Хэрвээ үргэлжлүүлэн энд тэндгүй гүйж, өөрийн дураар явбал удах нь мэдээж. Эзнээ ирж зохицуулах хүртэл нааш цааш нилээд олон удаа явсан тул өөртөө нилээд их саад бэрхшээл үүсгэжээ.

Заримдаа та нар ч гэсэн ийм байдалд ордог. Дөрвөн талаасаа маш баг бөх хамгаалагдсан байшинд нэгэн амьтан хоригджээ. Бид түүнд ямар ч муу юм хийхгүй, харин тавьж явуулах санаатай барихаар хөөцөлдөхөд тэр бидэнтэй тэмцэнэ. Тэр галзуурсан мэт эсэргүүцэж, далавчаа хугалж, хөлөө гэмтээв. Энэ нь бидний буруу биш. Чамайг аврах гэсэн юм. Юунд ингэтлээ эсэргүүцэнэ вэ? гэж түүнд хэлэх хэрэгтэй болно. (бүгд инээлдэв) Тэр бидний үгэнд орохгүй нь мэдээж. Заримдаа сонсоно, заримдаа үгүй. Бид түүнтэй дайтаж юмыг нь булаах гэж байгаа мэт амь тэмцэн эсэргүүцэнэ.

Үүнтэй нэгэн адил, заримдаа Төгс Гэгээрсэн Их Багшийн хувьд ч хүмүүсийг аврахад тун хэцүү, аврагдаж байгаа хүн өөрөө харш саад ихтэй байдаг. Хүн түүнийг аврахаар ирэхэд ямар нэгэн зүйлийг минь авч, ашиглах нь гэж бодно. Түүний одоогийн энэ байдлаас нь авмаар, ашигламаар юм юу байх вэ дээ. Гурван ертөнцийн доторх юм бүхэн бохир, мунхаг харанхуй, туслах хэн ч байхгүй. Бидний юм хэнд хэрэгтэй гэж? Хэдийнээ эрх чөлөөтэй болчихсон хүнд юм бүхэн байх тул өөр юуны ч хэрэггүй.

Амьтанд амьтны санаа бодол, хүнд хүний санаа бодол, бодьсадвад бодьсадвагийн санаа бодол бий. Хүн, амьтнаас өөр, хүн бодьсадва хоёр ч бас адилгүй. Бид уг нь тэр амьтныг аварья гэж бодсон ч тэр бидний санааг ойлгохгүй. Харин ч эсэргүүцэж, ийш тийш сандран нисээд аврах боломж олгохгүй. Хойно хойноосоо хөөцөлдөөд улмаар далавчаа хугална. Ингээд бүр ч хөөрхийлөлтэй

болох бөгөөд би чамд хэдийнээ хэлсэн шүү дээ. Би чамайг аврах гэсэн юм. Бүү эсэргүүц. Сонсохгүй байснаас болоод нэг далавчаа хугалчихлаа. Одоо яаж нисэх вэ? Аварсан ч бас зовсоор байх нь. Тэгэхээр түүнийг хамгаалах хэрэгтэй.

Бид Төгс Гэгээрсэн Их Багшид эргэлзэж, бусад хүнд бас эргэлзэж, эд намайг ашиглах нь гэж бодох нь дэндүү мунхаг хэрэг. Номч сэтгэлгүй, бид угаас хоосон гэдгийг сайн ойлгоогүй байна. Бусдад ашиглуулчихмаар юм бидэнд юу байгаа юм бэ? Гэвч энэ ертөнцөд буг ч бий, бурхан ч бий. Хүмүүсийг аварч, аз жаргалтай, баяр баясгалантай, амар амгалан байхад нь туслах нь Бурхны хийдэг тусгай ажил. Харин Маяа яг үүний эсрэг ажлыг хийдэг. Сарнай цэцгийг Бурхан бүтээхэд Маяад хийх ажил олдохгүй уйтгартай байсан тул түүнд өргөс нэмжээ. Бурхан нарыг бүтээж, хүмүүст тав тух, баяр баясгаланг бэлэглэхэд Маяа шөнийг, харанхуйг бүтээв. Харанхуйд хэн ч юу ч олж харахгүй.

Маяа бас ямар нэгэн зүйл бүтээхийг оролдсон ч дэндүү болхи, олигтой сайн болоогүй. Жишээ нь, Бурхан хайрын сэтгэлийг бүтээж бие биенээ хараад хайрлаж дурладаг болгоход Маяа дээрээс нь тачаал гээчийг нэмэв. Тачаалаас болж хардаж сэрдэх, үзэн ядах, бачимдан бухимдах, шунан дурлах сэтгэл үүсдэг. Хүсэл тачаал хэтэрвэл тамир тэнхээ доройтож, олон хүүхэд төрүүлэн эцэст нь бие биентэйгээ зууралдан хүлэгдэнэ. Хэрвээ хүн төрөлхтөн зөвхөн сэтгэлээсээ хайрлан дурлалцвал ийм явдал үүсэхгүй юм.

Эрт дээр үеэс өнөөг хүртэл хичнээн хүн хүсэл тачаалаас болж бие биенээ хөнөөснийг, хайр дурлалынхаа төлөө хичнээн олон хаад ноёд хаан суудлаа алдаж, хичнээн олон улс гүрэн мөхөж доройтон хичнээн олон сайн сайхан зан заншил устаж баларсан, хичнээн олон авьяас чадвартан харилцан алалцаж, хичнээн олон бичгийн хүн, яруу найрагч бэх цаасаа гарзсаныг бид мэднэ.

Бид муу муухай болохоороо л бясалгал хийж байгаа

юм биш, мөн өөрийгөө ч байнга буруутгах хэрэггүй. Энэ нөхцөл байдлаа хамгаалж, хор хөнөөл учруулахгүй байхын төлөө таван нэрээ сайтар уншиж, дотоодын багш, Эзэн Бурхан, Бурхан бодьсадваг дурсан санах хэрэгтэй. Зөвхөн үйлийн үрээ арилгахын төлөө ч биш. Тийм их үйлийн үр бидэнд байхгүй байж ч мэднэ. Чи үнэтэй машин унадаг бас барихдаа ч сайн, өөртөө бүрэн итгэлтэй, архи уудаггүй байсан ч чиний араас өөр нэг машин ирж мөргөвөл зайлах аргагүй гэж Багш нь ярьсныг санаж байна уу?

Хэдийгээр би жолоо барьдаггүй ч миний суусан машин өөр машинд мөргүүлж байсан. Мөргөсөн машины жолооч архи уусан, эсвэл муу жолооддог зэргээс болсон. Тиймээс машин тэрэгний осол аваар гарах нь чи хууль зөрчсөнөөс биш, харин ямар нэг өөр шалтгаанаас болж болно. Энэ дэлхий ч бас адил. Бид өөрсдөө муу хүмүүс биш хэдий ч бас бясалгах хэрэгтэй. Эс бөгөөс бид энэ дэлхийн дарамт шахалт, бохир бургтгийг тэсвэрлэж чадахгүй. Бидний сэтгэл санаа зарим үед тун хөнгөн сэлүүн, зарим үед бохирдож сэвтдэг. Энэ нь бүгд чиний буруу биш тул өөрийгөө дэндүү буруутгаж, хоолоо сойн мацаг барьж, өдөржингөө завилан суугаад сүүлдээ гэрээс гарах дургүй болбол өөр бусад хүн ирж, таныг хүчээр гадагш гаргана.

Бясалгал энгийн байх тусмаа сайн. Энэ ертөнцөд бидний сэтгэл санаа үе үе сайхан, муухай янз бүр болохоос зайлсхийх аргагүй. Гэвч үнэнийг чин сэтгэлээсээ хайж, аврагдахыг жинхэнээсээ хүсвэл алзахгүй. Та нарт тарааж өгсөн бясалгалын өдрийн тэмдэглэл нь алдаа дутагдлаа илрүүлж, хэр их бохирдсоноо хянахад тустай. Түүнээс биш, өөрийгөө зэмлэн буруутгахад зориулагдаагүй шүү. Бясалгалын өдрийн тэмдэглэл нь осолтой газраар явах, хурдтай машин тааралдах, улаан гэрэл асах болон аюултай үед гишгэж зогсоох тоормостой ижил. Энэ тэмдэглэл нь бидний бясалгалын тоормос гэсэн үг. Гэхдээ тоормосоо

өдөржингөө гишгэх хэрэггүй. Араас гэнэт машин мөргөвөл тоормосоо гишгэж ч амжихгүй шүү дээ. Тиймээс өөрийгөө буруутгах хэрэггүй. Ийм байдал зөндөө гардаг.

Тиймээс бид өөрийн сайн, муугаас үл хамааран бясалгал хийх нь хамгийн чухал. Хамаг сайн, муугаа өөрийн дотоодын багшаараа шийдүүлнэ, сүнсээрээ шийдүүлнэ. Өөрийн эзэндээ даатгавал Тэр бидэнд туслана. Өөрийн эзэндээ: Миний нөхцөл байдал ийм байна аа. Өөртөө тусалж чадахгүй байгаа тул Та надад тусална уу? Би байдаг чадлаараа хичээсэн. Сайн, муу бүхнийг минь болгоон зохицуулна уу? гэж даатгавал Тэр бидэнд туслана.

Өдөр бүр ийнхүү тасралтгүй даатгасаар, үнэнхүү ханасан чин сэтгэлийн нэгэн удаагийн даатгал дотоодын гүний гүнд нэвтэрч чадсан тэр өдөр маш их гэрэлтэй, маш өндөр дээд төвшинд хүрч, туйлын баяр жаргалтай газарт хөвөн дүүлэн очиж тун магад. За одоо дуусгая, тун их зүйлийг ярьжээ. Үнэндээ бол бүгд ижил. Арьяабалын бясалгалын аргыг л яриад байгаа хэрэг. (бүгд алга ташив)



## ОРЧЛОН ЕРТӨНЦӨД БИД Ч БАС БАГТАНА

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Формоса, Миаоли аймаг, Шиху ашрамд  
1988 оны 10 сарын 17 (Эх нь хятад хэлээр)*

Бусдыг ялгаварлах сэтгэл маш их байгаа учраас бид Будда болж чадахгүй байна. “Энэ бол минийх биш, чинийх” гэсэн бодол сэтгэлд байнга байна. Тийм учраас Будда болж чадахгүй байгаа юм. Бясалгал хийдэг маш олон хүн байдаг ч, олсон үрийн хутаг нь тун өчүүхэн, дэвшил нь маш удаан байна. Энэ нь цөмөөрөө Багшаасаа зөвхөн гэр бүлийнхэн болон аав, ээждээ тусламж гуйн залбираад төд удалгүй дахиад л Багшаас миний ээж тун хэцүү байна, авга маань өвчтэй, ач хүү маань... гэх мэтээр бүх хүнд толгой дараалан тусламж гуйдгаас болж байна. (бүгд инээлдэв) Санаанд орсон бүх хүний нэрийг дурдана.

Хаа холын Тайбэйгээс Багш дээр ирээд миний нөхөр саяхан нас барсан. Ойрын үед гэрээрээ эргэхдээ тун зовлонтой харагдлаа. Багш минь та түүнд туслаач гэж гуйна. Чи өөрөө түүнд –“Амьд байх үед нь туслаагүй байж, одоо надаар ямар тус хүргүүлэх гээ вэ?” гэж би түүнд хэлсэн. Амьд байхад нь Багш түүнийг нилээд хэдэн удаа авшиг хүртээхээр дуудахад тэр ирсэн ч жаахан хүлээчихвэл муухай ааш нь хөдлөөд буцаад явчихдаг. Эхнэр нь түүнд дэндүү

“сайн” тул битгий яв гэж ятгаж чадахгүй харин: За за, авшиг хүртэх дургүй бол гэртээ харь даа. Хамаагүй! хамаагүй! гэдэг байсан юм. Ингэж хэлвэл тэр мэдээж загнахгүй ч сэтгэлийн авшиг хүртэж чадахгүй шүү дээ.

Ийм байдал хэдэн удаа давтагдсан. Удалгүй түүний нөхөр гэнэтийн тохиолдлоор нас барав. Нөхрийгөө нас барсны дараа Багш дээр ирээд: “Миний нөхөр тун зовлонтой байна” хэмээн дахин дахин ярьж, төвөг удна. “Дэлхий даяараа зовлонтой байна. Гэтэл чи ганцхан хүний төлөө л зовоод байх юм. Амьд байхад нь сайтар ятгаагүй байж, одоо үхсэн хойно нь туслаад ямар ч нэмэргүй” гэж би түүнд хэлсэн.

Ах дүү, хамаатан саднаа амьд байхад нь нэг их тоохгүй, бясалгалын ач тусын талаар хэлж сануулахгүй, оюун санааг нь халамжлахгүй. Хүмүүсийн дийлэнх нь ийм байдаг. Олон хүүхэдтэй бол тэдэнд ургамал хоол идэхийг ятгах хэрэгтэй. Гэтэл хүүхэд ургамал хоол идвэл шим тэжээлийн дуталдалд орно гэсэн шалтгаар ургамал хоол хийж өгөх дургүй. Харин төрөл төрөгсдийн нэг нь нас барах, зовлон бэрхшээл тохиолдвол даруй Багш руу гүйж, тусламж хүснэ.

Хүнийг аваръя гэвэл сүнснийг нь аврах хэрэгтэй. Махан биеийг нэг их анхаарах хэрэггүй. Олон авшигтны хүүхдүүд эхийнхээ гэдсэнд байхаас ургамал хоолтон болдог бөгөөд төрсний дараа тун эрүүл чийрэг өсөж бойждог талаар манай сэтгүүлд тодорхой бичсэнийг хүмүүс мэдэхгүй гэж үү? Ургамал хоол шим тэжээл муутай гэдэг шалтгаанаар эхнэр, нөхөр, үр хүүхдээ бясалгуулах дургүй авшигтан одоо ч байсаар байна.

Өөрөө ургамал хоол иднэ, бас бясалгана. Харин гэрийхнийгээ Багшийн шавь болж бясалгая гэвэл хорьж суудаг. Тэд бясалгахгүй гээгүй. Тэд харин өөрсдөө бясалгахыг нь эсэргүүцсэн, ийм шалтгаанаар бясалгаагүй бол хамаагүй.

Харин гэрийнхэнтэйгээ хамтдаа бясалгах хүсэлтэй хүнийг манай авшигтан хорьж саатуулж байна гэж бодоод үз. Тэр нээрээ тун “сайн” хүн байна шүү. Өөрөө сайн сайхан зүйлийг мэдсэн ч түүнийг бусадтай хуваалцахгүй, тэднийг ирж хүртэхэд нь саад болно. Ингэх нь маш хүнд үйлийн үртэй байдаг. Тийм хүн бясалгаж ч чадахгүй. Бясалгаад ч хэрэггүй. Гэртээ харьж хамаатан садантайгаа ижил болсон нь дээр.

Ийм хүмүүс хэдийгээр бясалгалтай ч буян нь бусдаар бясалгалын замаа хаалгасан чин сэтгэлтэй тэр хүмүүсийн буянаас хол дутуу байдаг. Бясалгах хүсэлтэй ч авшиг хүртээгүй чин сэтгэлтэй хүмүүсийг Багш нь харж хандаж байдаг. Харин авшиг хүртэж бясалгал хийдэг ч гэр орныхныгоо хорьж бясалгуулдаггүй хүмүүсийг Багш нь хамаарахад хэцүү.

Энгийн үед гэр бүлээ сайтар анхаарч халамжлахгүй хэрнээ зовлон бэрхшээл тохиолдмогц дэлхий даяарын зовлонг үл тоон Багшдаа ирж төвөг удна. Таны сэтгэл хэдий чинээ уужим байна, төдий чинээ хүчтэй байдаг. Ганц хоёрхон хүний төлөө бид бясалгадаггүй гэж Багш нь олон удаа ярьсан. Бид гэр бүлийнхнийгээ гэтэлгэх хэрэгтэй. Тэдэнд ургамал хоол идэж, сайн үйл хийж, бясалгаж, ёс суртахуунтай амьдрахыг ойлгуулна. Ингэвэл тэднийг аварна. Харин нас барсных нь дараа Багш дээрээ ирж, миний буянгаас хулгайлах биш. Ойлгов уу?

Бид гэр бүлийнхнийгээ мэдээж гэтэлгэнэ, гэхдээ хорвоо дэлхийг үл тооно гэсэн үг биш. Энэ хорвоогийн хүмүүст бүгдэд нь тусалж, нэг нэгээр нь гэтэлгээд дуусахгүй. Тиймээс та бид дэлхийн дахин энх амгалан байж, хүн бүхэн гурван ертөнцөөс гэтлээсэй гэж даатгах хэрэгтэй. Гэхдээ бид садан төрлийнхөө хүмүүсийг гэтэлгэнэ. Бид тэднийг шууд гэтэлгэж болно. Тэднийг хамт бясалгахыг уриална. Та нарын нас барсан төрөл төрөгсдийг Багш нь яриангүй харж



хандана. Харин та нарын хориглосноос болоод бясалгаж чадаагүй төрөл садан чинь нас барвал Багш нь харж хандаж чадахгүй байж магадгүй. Учир нь тэдний замыг та нар хаасан учраас. Багшийнхаа санааг ойлгов уу?

Та нар харин залбиран даатгавал Багш нь сая тэдэнд тусалж чадна. Та нар залбирч даатгахгүй байснаас цаг нь бас өнгөрчихвөл тэдэнд туслая гэсэн ч амаргүй болсон байдаг. Энэ дэлхийд үйл байвал үр байна. Тэд ирэх замаа бусдаар маш удаан хаалгасан тул хэдэн зуу, хэдэн мянган жил хүлээсний эцэст дахин туслуулна. Тухайн “үйл”-ийг хэдийнээ хийсэн болохоор “үр”-ийг нь амсахаас өөр аргагүй. Одоо цэцэг ургаж, үр нь гарсан бөгөөд бүрэн боловсорч үр нь унасны дараа тэндээс бас дахин өөр нэгэн цэцэг ургаж, өөр нэгэн үр боловсорно.

Бясаллагчид бид дэлхийн энх тайвны төлөө, хүн амьтан, мод чулуу, ус ургамал, эрдэс бодис гээд бүхий л төрөлтний төлөө санаа тавих ёстой. Ийм хүн л бясалгагч хүнд тооцогдоно. Олон хүн Будда болж чаддаггүйн учир нь тэдний залбирал даатгал зөвхөн эд зүйлийн төлөө байдаг. Зарим хүн Багшид нь захиа бичиж, эхнэр маань өвдөөд байна, та түүнийг заавал авраарай гэнэ. Багш нь хариу захиа хэдийнээ бичсэн байтал тэр дахин надтай уулзаад түүнийгээ байн байн ярина.

Ийм жижиг зүйлсийг дотоодынхоо багшаас гуй, Надад ирж ярих хэрэггүй. Бид мэдээж ах дүү, хамаатан саднаа харж хандана. Гэхдээ үүнийг өөрийн дотоодын багшаар хийлгэвэл хамгийн сайн. “Багш аа, би өөрийн бүхий л хамаатан садан, найз нөхдөө танд даатгая. Тэдэнд яаж тусалж, яаж хандах нь бүгд таны таалал” гэж дотооддоо хэлээрэй.

Жирийн үед бид зөвхөн садан төрлөө л анхааран халамжилдаг. Бид тэднийг харж хандах хэрэггүй гэсэн үг биш. Харин зөвхөн тэдэндээ л санаа зовох нь буруу. Бид бүх

дэлхийн зовлон шаналалыг мартаж өсгүй. Сэтгэл зүрхээ илүү уужим болгон тэлж, төрөлтөн бүхнийг сэтгэлдээ багтаавал жинхэнэ ёс зүйтэй, жинхэнэ бясалгалтай хүн мөн.

Хэрвээ бид зөвхөн өөрийн төрөл садан, найз нөхдөө халамжилвал эгэл хүн ч чадна. Амьтан ч чадна. Эгэл хүмүүс зөвхөн гэр бүлээ л харж ханддаг, заримдаа тэднийхээ төлөө бусадтай зодолдоно. Арай өргөжвөл улс орныхоо төлөө бусад оронтой дайтна. Илүү өргөн хүрээнд бол гарагууд хоорондоо дайтна. Иймээс л дэлхий дахин амгалан тайван биш, орчлон хорвоо ч энх амгалангүй байна .

Хүмүүс Бурхан болж чаддаггүйн гол шалтгаан нь ердөө л сэтгэл нь дэндүү давчуу, өглөөнөөс үдэш болтол хамаатан садан, найз нөхдөө л ярьж, Багштайгаа уулзаад аав маань нас бараад арван жил болж байна гэнэ. Дахин уулзахдаа ээж маань нас бараад хоёр жил болж байна гэнэ. Гурав дахь удаагаа уулзвал тэр хүнийг сайн танихгүй ч манай нилээн холын хамаатан юм байна. Түүний таван настай хүү саяхан нас барчихлаа гэнэ. Дөрөвдэх удаагаа уулзахдаа бас өөр нэг хүний тухай ярьж байдаг. Тухай бүртээ Багшаасаа хамаатан саднаа онцгойлон анхаарч халамжлахыг хүснэ.

Бид энэрэнгүй нигүүлсэнгүй байх нь яриангүй. Гэхдээ бусдын бясалгалын хүчийг ашиглах ёсгүй. Эсвэл ингэж зовоон шаналгах аргаар нэгэн бясалгагчийг хүчилж болохгүй. Бусдын бясалгалын хүчинд хүндэтгэлгүй хандах нь бусдын эд хөрөнгөнд халдаж байгаатай ижилхэн. Тухайн хүний сайхан сэтгэлтэйг мэдээд байнга ирж, ямар нэгэн юм хүсэж шаардана. Эхлээд би өөрөө ингэж бусдаас хүсэж шаардах юу хийсэн билээ гэдгээ бодож үзэх хэрэгтэй.

Тэр бидэнд хэдийнээ маш ихийг өгсөн. Сар бүр амьдралын хэрэгцээнд зориулж мөнгө өгнө, биднийг анхаарч халамжлахын төлөө маш их зовж зүдэрнэ. Сайхан сэтгэлийг нь далимдуулан Түүнээс дэндүү ихийг хүсэж шаардах нь үнэхээр дур гутмаар.

Та нарт тодорхой хэлье. Ийм гутмаар байж болохгүй. Аливаад сэтгэл ханадаг, “ханах” гэж юу болохыг мэддэг байх хэрэгтэй. Дотоодын багш маань биднийг анхааран халамжилна. Тэр бидний дотоодын хүсэл эгээрлийг мэднэ. Бидний дотооддоо ярьсан юм бүхнийг Тэр ойлгоно. Түүний махан биеийг хэтэрхий их зовоож болохгүй. Хүн бүхний ярих хэрэгтэй, хэрэггүй зүйлсийг сонсоод байвал хамаг цагаа гарздана. Ойлгов уу? Жишээ нь, манай ерөнхийлөгч улс орноо ерөнхийд нь хамаардаг. Тэрээр эхлээд олон ажлыг хуваарилна. Цэргүүд юу хийх ёстойг, цагдаа болон яамд ямар ажил хариуцахыг тус тус зохицуулж өгнө. Надад хаанахын тусламж хэрэгтэй болно, би тийшээ очих хэрэгтэй. Цагдаагийн тусламж хэрэгтэй бол цагдаа руу явна. Өчүүхэн бага хэргийн төлөө ерөнхийлөгчтэй уулзах шаардлагагүй. Тийм биз? Засгийн газар ядуу хүмүүст туслах нийгмийн халамжийн газруудыг байгуулдаг. Эд зүйлээ хулгайд алдах, бусдын хүчирхийлэлд өртсөн бол цагдаагийн газар очих ёстой. Өчүүхэн жаахан хэргийн төлөө өдөржингөө ерөнхийлөгчид төвөг удах хэрэггүй.

Яг үүнтэй адил, та нар Багшийнхаа махан биеийг дэндүү их ашиглаж, Түүнийг хэт ядраадаг. Иймээс заримдаа Багш нь өөр бусад ажлаа хийх аргагүй болно. Махан бие хэт ядарснаас болоод та нарын оюун санааг ч сайтар харгалзаж чадахгүйд хүрвэл Багшид нь тун харамсалтай. Ердөө л хэдхэн хүний төлөө өдөржингөө надаас ямар нэгэн тусламж шаардана. Та нар бас мэдэхгүй байна. Зарим хүн өөрийн ажил хэргээ ч сайн зохицуулж чадаагүй байж бусдын явдалд оролцон түүнийг Багшдаа ирж ярьдаг. Сэтгэл нь ихэд хөөрч догдлоод яг л “Орчлонгийн хүйс” болсон мэт явна.

Багшийнхаа ярьсан “Цөвүүн цагийн шавь нарын төрөл” гэдэг лекцийг та нар хараахан сонсоогүй байх. Шавь нарыг олон ангилдаг бөгөөд тэдний нэг нь “Орчлонгийн хүйс” гэдэг нэртэй. Түүнгүй бол орчлон ертөнц эвдэрч

сүйрэн дэлхий ертөнц эмх замбараагүй болно. Ийм шавийг “Орчлонгийн хүйс” гэдэг. Өөрийгөө дэндүү чухалд тооцож, өдөржингөө орчлонгийн хэрэг явдлыг хамаараад Эзэн Бурхан яаж хийхээ мэдэхгүй болж, Бурхан бодьсатва нар бүгд унтаж, ганцхан тэр л сэрүүн байгаа тул хүн бүхэн түүнтэй ирж уулзан өглөөнөөс үдэш болтол тун ч завгүй. Энэ нь өөртөө л төвөг удахаас өөр ямар ч тус нэмэр байхгүй. Сэтгэл нь догдолж, өөрийгөө тун чухалд тооцох ч эцсийн дүндээ юунд ч тусалж чадахгүй, дахин ирж Багшийгаа л үймүүлнэ. Хөөр хөгжөөнтэй, сандарч гэвдсэн хүн хүрч ирээд нэг их үүх түүх ярьж, Багшийгаа улам завгүй болгодог. Тийм сайхан сэтгэлтэй хүнд Багш нь бас юм хэлж зүрхлэхгүй, загнаж чадахгүй. Иймэрхүү сайхан сэтгэл эсрэгээрээ бусдыг тун их хорлодог.

Бясалгагч хүн сэтгэлээ маш цэвэр тунгалаг байлгаж, “Дэлхий дахин угаас амгалан” гэдгийг мэдвэл зохино. Өөр өөрийн хийвэл зохих ажлаа чадлын хэрээр сайн хийхэд л болно. Ойлгов уу? Хэн нэгэнд бидний тусламж хэрэгтэй бол тэр даруй тусал! Энэ нь үнэндээ маш өчүүхэн зүйл. Дараа нь хурдан мартаж хэрэгтэй. Түүнийг нэг их чухалд бодож, сүржигнэх хэрэггүй. Та бид орчлон даяарын төлөө бясалгадаг болохоос өдөржингөө энүүгээр өвчин зовлон, үхэж үрэгдсэн хүн ярьж Багшдаа төвөг удаж явдаг ганц нэг хүний төлөө бясалгаагүй. Тэр бүхнийг нь өдөржингөө сонсох хэрэгтэй болдог тул би бас маш их ядарч, хайран цагаа гарздана. Тэр цаг хугацааг Багш нь амралт, бясалгал, бусад хүний дотоод хүсэл шаардлагыг зохицуулахад зориулсан бол тун хэрэгтэй. Бусдыг халамжлах гэж Багш нь дотоодоороо халамжлахыг хэлж байна. Бие махбод байхгүй бол дотоодын багш ч байхгүй, ойлгов уу? (Бүгд ойлголоо гэж хариулав)

Хэрвээ та Багшийнхаа бие махбодыг дэндүү гамгүй ашиглаад туйлдуулбал махан цогцос үгүй болж, дотоодын

багш ч байхгүй болно. Махан бие цогцос байгаа цагт шинээр авшиг авсан хүмүүсийг харж хандах хувилгаан бие байдаг юм. Махан бие үгүй болбол авшиг хүртээх аргагүй болж, бусад хүмүүсийг харж хандахад ч амаргүй болно. Та нар шиг явцуу сэтгэлтнүүд ч бас анхаарч халамжлуулах аргагүй болно.

Тиймээс эрт дээр үеэс өнөөг хүртэл их бясалгагчид бүгд нуугдан бясалгадаг байжээ. Тэд хүнээс маш их айдаг. Юунаас айдаг вэ? Бусдыг зовоон тамладаг хүмүүсээс айна. Учир нь тэд үнэн ёсны төлөө ирдэггүй, оройн дээд зам мөрийг хайхын төлөө биш, эгэл ертөнцийн хэрэг явдлын төлөө ирдэг. Жишээ нь, хүүгийнхээ сурлага амжилттай байгаасай, эхнэр нь хүү төрүүлээсэй, эцэг эх, эхнэр нөхрийнх нь өвчин зовлон хурдан эдгээсэй гэх мэт. Тэр ч байтугай өөрийн хамаатан садан биш хаа холын хэн нэгний жаргал зовлонг Багшдаа ирж тоочно. Энэ нь үнэмлэхүй дээд үнэн ёс гэж юу болохыг, бясалгалын жинхэнэ зөв зорилго ямар байхыг огт ойлгоогүйн шинж бөгөөд бусдын бясалгалын буян хишгийг завшиж яваа хэрэг мөн.

Та бид сансрын хүрднээс гэтэлж, Бурханы хутагийг олоод хамаг төрөлтнийг зовлонгоос ангижруулж, орчлон ертөнцийг адислахын төлөө бясалгах ёстой. Ойлгов уу? Хэдий чинээ олон хүн бясалгана төдий чинээ орчлонгийн гэрэл гэгээ, баяр жаргал нэмэгдэнэ. Бясалгал бол цөөн хэдэн бүлэг хүний төлөө байдаггүй. Тийм ч учраас хүмүүс эрт дээр үеэс өнөөг хүртэл гэрээс гарагсадыг маш их хүндэлсээр ирсэн. Учир нь гэрээс гарсан хүн өөрийн жижиг бүлэг хүрээллийг огоордог. Бурханы хутагт хүрснийхээ дараа хамаг төрөлтнийг гэтэлгэх, орчлон даяарыг гэтэлгэх нь гэрээс гарагсдын хүсэл болно. Тэд ямар ч хүнийг өөрийн аав ээж, ах дүү, садан төрөл, найз нөхөд шиг үзнэ. Гэрээс гарсан хүний хүсэл мөрөөдөл нь ийм байдаг.

Гэрээс гарсан зорилго нь хүмүүст хүндлэгдэж, тэдний

өгсөн өргөл барьцыг хэрэглэж, хөнгөн хялбар амьдрахын төлөө бол тэр хүн гэрээс гарагч гэж тооцогдохгүй, бусдад хүндлэгдэх ч эрхгүй. Ойлгов уу? Ихэнх хүн бясалгалынхаа зорилгыг тодорхой сайн ойлгоогүйгээс сэтгэл зүрх нь тун уйтан давчуу байдаг.

Ах дүү, хамаатан саднаа тоохгүй байна гэсэн хэрэг мэдээж биш. Өвчин зовлонтой үед нь бид дотоодын багшдаа хандан: “Багш минь ээ, миний төрөл садангийн хүн өвджээ. Хэрвээ түүнд хэрэгтэй бол та тусална уу? Түүнд юу хамгийн сайн байж болохыг та л мэднэ. Та бол хамгаас дээд билиг ухаантай тул яавал зохихыг хамгийн сайн мэднэ. Би түүнийг Танд бүрэн даатгая. Яах нь таны таалал” гэж залбир.

Энэ бол жинхэнэ даатгал мөн. Тэрнээс энд ирээд Багшдаа тулгаж, та заавал аврах ёстой, хурдлаарай, эс бөгөөс би номоосоо буцаж, даруй мах идээд дахиж хоёр цаг хагасын бясалгалаа хийхгүй хэмээн айлгах хэрэг биш. (бүгд инээлдэв) Ингэж аашлах нь үнэндээ ямар ч тус нэмэргүй (энэ бол айлган сүрдүүлж байгаа хэрэг гэж нэг хүн хэлэв). Тийм! Юуных нь залбирал даатгал байх вэ?, харин ч хутга тулгаад хурдан авар гэж дарамтлахтай ижил. Яг л дээрэмчин бусдын мөнгийг авахын тулд айлган сүрдүүлж, мөнгөө гарга, үгүй бол амийг чинь авна гэсэнтэй агаар нэг .

Манай авшигтнууд яг үүн шиг, хутга гаргаж ирээд Багш руугаа хандан, буянаа гаргаж, надад өг! Бясалгалын хүчээ хурдан гаргаад ир! гэх шиг л болдог. (Багш болоод хүмүүс бүгд инээлдэв) Ийм хүнийг бясалгагч гэх үү? Хулгай хийдэг хүнээс өөрцгүй байна. Хүний эд хөрөнгийг хүчээр гаргуулж, өөртөө ашиглаж байгаа нь залбирч гуйж байгаа биш, харин хүчирхийлж байгаа хэрэг юм. Тэдний хэлж ярьж байгааг сонсоход үнэхээр дур гутмаар байдаг. Хэн нэгэн ийм маягаар даатгавал би загнах болно. Магадгүй тэд намайг хатуу сэтгэлтэй л гэх байх! Гэвч түүний дотоод сэтгэл нь хичнээн дургүй хүрмээр байдгийг та нар ойлгохгүй.

Нэгэн Бурхан бодьсадвад залбиран даатгахдаа яаж ингэж хүчилж болох вэ? Аман дээрээ ярихаас цаашгүй, өчүүхэн ч чин сэтгэлгүй. Яг л худалдаа наймаа хийж байгаа мэт. Эд бараагаа авахыг тулган тасралтгүй ярих шиг. Та нар ийм байдлыг мэдэх үү?

Заримдаа гадуур гарч, зах дэлгүүрээр явахад эд бараагаа зарахын төлөө улайрах худалдагчийн ярианд толгой өвддөг. Авах эрх нь, мөнгө нь чинийх боловч авахыг албадсан өнгө аясыг далд утгаар тасралтгүй илэрхийлэх нь эцэстээ чамайг бухимдуулж, аргагүй байдалд оруулна. Хариад өнөөх зүйлээ хараад бүр ч бухимдаж, сонин юм аа! Яагаад тэр хүний үгэнд ороод ямар ч хэрэгцээгүй зүйл авчихав аа гэж өөртөө уурлана. Тийм биз? Ахимаг насны бүсгүйчүүдэд бүгд нь ийм зүйл тохиолдож байсан байх. (бүгд инээлдэв) Тиймээс нөхрүүд чинь гэрээр дүүрэн юунд хэрэглэх нь тодорхойгүй, хүнээсээ олон эд юмсыг харж суудаг. Бараг л сууж хэвтэх газаргүй болгодог. Энэ нь ердөө л хүмүүсийн ятгалгаар, хүчээр хийсэн худалдан авалтууд.

Зарим худалдагч ярихдаа чадамгай. Авмааргүй байсан ч орхиж явахаас санаа зовж, үл үзэгдэгч олсоор баглуулсан мэт хөдөлж чадахгүй болж, тэр хүн хэдийнээ халаасанд гараа хийж, мөнгийг чинь гаргаад ирэх шиг, эсвэл гараас барьж, халааснаас маань мөнгө авах шиг болдог. (бүгд инээлдэв)

Үүнтэй ижил. Манай авшигтнуудын зарим нь яг үүн шиг. Хэрвээ чи тэдний нэг болохоо олж харвал үүнийгээ хурдан засаарай. Эс бөгөөс Багштайгаа удаан амьдрах аргагүй шүү. Наад зах нь бид хоёрын хэн нэг нь удаан амьдарч чадахгүй. (Багш болоод хүмүүс инээлдэв) Магадгүй хамгийн сүүлд Багш нь чамтай холбоогоо тасална, эсвэл таслахаас нь санаа зовж, хэтэрхий их ядарч, дэндүү их зүдэрснээс болоод түргэхэн шиг ангижрах хэрэгтэй болно. Эртнээс нааш их бясалгагчид, хүмүүсээс тун их айдаг гэж

Багш нь сая хэлсэн. Тэд хүмүүст ном уламжилсан нь маш цөөн. Тийм болохоор өнөөдөр Арьяабалын бясалгалын аргыг мэдэх хүн бараг байхгүй байгаад гайхах юмгүй. Энэ бол жамаараа болсон хэрэг. Иймээс Багшийг нь буруутгах хүмүүс, Багшид нь итгэхгүй хүмүүсийг хараад та нар тэднийг хорсон занаж болохгүй. Зөвхөн тэд ч биш, мунхаг хүмүүс дэлхийгээр дүүрэн. Зарим нь бүр зориудаар чимээ шуугиан дэгдээнэ, нэг нь далдуур сэм буруутгана. Та нар бараг мэдэхгүй. Та нар бодож үз, дэлхий даяараа харанхуй мунхаг, Арьяабалын аргаар бясалгаж байгаа хүн хичнээн байгаа билээ? Хичнээн хүн энэ “Арьяабалын арга” гэсэн нэрийг мэддэг билээ? Үүрийн гэгээнээс үдшийн бүрий болтол ердөө л нэг тэнгэр сахиус, мод чулууны дүрсэнд мөргөөд завгүй. Битгий мөргө гэсэн ч сонсохгүй.

Зарим нь нэг алхамд нэг, гурван алхамд гурав сөгдөж мөргөх нь ямар нэг буян хишиг горилж, сайн бясалгаж байгаагаа улс орон, дэлхий нийтэд мэдүүлэхийн төлөө. Нэг алхамд нэг мөргөл хийхийг нь зурагтаар хүртэл мэдээлж байдаг. Ийм хүмүүс үнэхээр өрөвдөлтэй.

Санаж байна уу? Багш нь нэг удаа Тайдунд ном айлдаад буцаж явахад зам дээр мөргөл хийж байсан ганц хоёр хүнтэй таарсан. Би эхлээд тэднийг хараад тун их цочсон, юунд мөргөөд байгааг нь ойлгоогүй. Хажуугаар нь гарахдаа арын толиндоо харвал тэд Багш руу хялам ч хийхгүй, замын хажууд нөгөө тийш харан мөргөж байсан. Ай даа! Жинхэнэ мөргөх зүйлээ олж мөргөсөнгүй дээ гэж би хэлсэн. (Багш болоод бүгд инээлдэв) Тэдний мухар сохроор ингэж тасралтгүй мөргөхийг төсөөлж чадах уу? Нээрээ мөргөх ёстой хүндээ мөргөсөнгүй ээ. (бүгд инээлдэв) Манай машин явдлаа сааруулж, шавь минь надад, Багшаа та буугаад тэдэнд ном айлдах уу гэсэнд би, ярьсан ч нэмэргүй дээ, хурдхан явсан нь дээр гэж билээ.

Тэдний энэ үйл буян хишиггүй биш, буян хишигтэй.



Гэхдээ ач буянгүй. Ач буян гэдэг нь өөрөө бясалгаж, ангижирсаны дараа хураах буяныг хэлдэг. Харин буян хишиг гэдэг нь тэнгэрийн, эсвэл хүний төрлийг авах буяныг л хэлдэг. Маш их буян хураавал тэнгэрийн хүн болон төрөөд мөнх бус ертөнцийн жаргалыг хэдэн зуу, хэдэн мянган жилээр эдэлнэ. Буянаа эдэлж дуусаад дахин унаж, хорхой шавж, буг чөтгөр, эсвэл хүн болж төрнө. Учир нь бид дэндүү их буян хураавал түүнийгээ эдлэхийн тулд заавал буцаж ирэх хэрэгтэй болно. Тиймээс сансрын хүрднээс гэтэлж чадахгүй.

Буян хишиг, үйл түйтгэрийн аль аль нь буцаж ирэх шалтгаан болдог. Тиймээс миний хувьд буян хишиг, үйл түйтгэр хоёр нь онцын ялгаагүй, аль аль нь биднийг гэтэлгэхгүй энд хүлж байдаг. Бяцхан шувуухайг торонд хийжээ. Нэг нь алт, нөгөө нь төмөр тор байв. Хоёулаа ялгаагүй л тор. Та нар бол тэр алтан торонд суухыг дурлана, тийм үү? Торонд суухаас л хойш арай сайханд нь суусан дээр гэж үү? Үнэндээ энэ хоёрт нэг их ялгаа байхгүй. Гэвч өнөөх бяцхан шувуухайнууд алтан торонд ч суух дургүй, моддын дунд чөлөөтэй дүүлэн нисэхийг хүснэ.

Жуанзын нэгэн зохиолд ийм үлгэр байдаг. Ерөнхий санаа нь нэг ийм. Нэгэн хаан хоёр их түшмэлээ явуулж Жуанзыг ноён болохыг урьсанд тэр очихгүй ээ гэж татгалзжээ. Их түшмэл түүнээс яагаад тэр вэ? Чи тансаг сайхан орд харш, элбэг баян амьдралд дургүй юм уу гэж асуусанд Жуанз түүнд ийм нэгэн үлгэр ярьжээ. “Хааны ордонд байх сүрлэг сайхан яст мэлхий хэдийнээ амьгүй болж, алуулаад хааны ордны үзмэр болсон нь дээр үү, эсвэл их далайдаа дураар сэлж, хэдэн зуун жил амьдарсан дээр үү? гэж их түшмэлээс асуухад тэр: Мэдээж, их далайдаа эрх дураараа хэдэн зуун жил амьдарсан нь дээр байлгүй яахав, юунд хааны ордны тансаг үзмэр болж хананд өлгүүлэхийн төлөө халуун амиа золиослох вэ? гэж хариулав”.

Хааны ордон хэдийгээр элбэг дэлбэг, баян тансаг ч

тэнд байхын тулд амь насаа алдах нь ямар тустай вэ? Хүмүүс өдөр бүр өнөөх яст мэлхийг хараад: Хөөх энэ чинь яасан сайхан үхсэн яст мэлхий вэ? Хааны ордны хананд үзмэр болсон нь тун их буян хишиг шүү. Ийм хувь тавилантай нь хэд билээ? Үнэндээ зарим хүнд ч хааны ордонд орох хувь дутдаг байтал энэ мэлхий харин маш их буянтай юм гэгцгээнэ. (бүгд инээлдэв) Их түшмэл: “Мэдээж яст мэлхий тийм хурдан үхэхийг хүсэхгүй” гэхэд Жуанз: “Би ч гэсэн адилхан. Би ч гэсэн ноён болж, хүний захиргаанд байж, бусдын боол болохыг хүсэхгүй. Хээр талдаа эрх дураараа, ая тааваараа байж, хүссэнээ хийж амьдарсан нь дээр гэж бодно ” гэж хэлээд явжээ.

Арц хүж уугиулж, нэг алхамд нэг мөргөж, уул овоо тахиж, мөнгө хөрөнгөөрөө сүм хийд бариулж, өргөл барьц өргөж, өглөг үйлдэх нь бүгд буян хишигтэй. Гэвч бид энэ бүх буянаа эдлэхийн тулд заавал эргэж төрөх хэрэгтэй болно. Тиймээс бид бясалгах гэж байгаа бол тун хянамгай хандаж, аль бүлгэм нь хүмүүст юу хийхийг зааж сургадгийг сайтар судлан зааж байгаа нь энэ дэлхийн ном уу, эсвэл чанагуух ертөнцийн ном уу гэдгийг нь ухаж ойлгосны дараа суралцах хэрэгтэй. Буян хураахад сургаж байвал энэ ертөнцийн номыг зааж байна гэсэн үг. Харин хүмүүст энэ ертөнцөөс хэтийдэх гэтлэхүйн номыг зааж байвал чанагуух ертөнцийн ном мөн.

Чанагуух ертөнцийн номыг бясалгаж байгаа хүмүүс ч бас өглөг өргөдөг. Огт өргөхгүй биш. Харин өглөг өгөхийг нэг их чухалд тооцохгүй. Бидний хувьд өглөг өгөх нь дэндүү амархан, энгийн явдал санагддаг. Яг л бид хоол идэж, унтаж амарч, өөрийгөө анхаарч халамжилж байгаатай ижил. Сайрхаад бахархаад баймаар юмгүй. Хүмүүст мэдэгдэхийн тулд сүр бараатай ёслол хийх ч хэрэггүй гэж үздэг. Ойлгов уу? Чанагуух ертөнцийн номыг бясалгаж байгаа манай хүмүүс энэ ертөнцийн номыг ч бас бясалгана. Зөвхөн энэ ертөнцийн номыг бясалгаад чанагуух ертөнцийн номыг

бясалгахгүй бол дэндүү дутуу дулимаг хэрэг болно.

Чанагуух ертөнцийн номын бясалгал олон зүйлийг багтаадаг. Сайн эхнэр, сайн нөхөр, сайн хүү, сайн охин байх энэ бүхнийг Багш нь бүгдийг заасан. Харин бусад нийгэмлэг, шашны урсгал нь зөвхөн энэ бүхнийг л заадаг. Тэдний ихэнх нь нийгэм дээрх гадна талын зүйлсийг л анхаарахаас ертөнцөөс гэтэлж ангижрах аргыг эрж хайдаггүй.

Багшийнх нь бясалгалын арга олон талыг багтаана. Багш нь биеэ засахаас эхлээд гэрээ төвхнүүлэх, улс гэрээ засаглах, дэлхий дахиныг түвшитгэн амар амгалан болгох гээд бүхнийг сургана. Манай авшигтнуудын дунд дарга, их хурлын гишүүн бий. Авшиг хүртсэнийхээ дараа хариуцлагаа үргэлжлүүлэн гүйцэтгэж, бүр сайн хийдэг. Би тэдэнд ажлаа орхиж, энд ирээд үсээ хусуулж хувраг болохыг санал болгохгүй. Тухайн хүний ерөөл барилдлагаас бүх зүйл шалтгаална. Хувраг болох уу, дарга хийх үү, тариачин байх уу гэдэг нь тухайн хүний ерөөл барилдлагаас болно. Та юу хиймээр байна, түүнийгээ л хий. Чөлөөтэй.

Гэхдээ юу ч хийсэн мөнх бус гэдгийг санах хэрэгтэй. Хувраг болох нь ч бас мөнх бус. Хувраг хүний хүсэл мөрөөдөл жирийн хүнийхээс өөр. Тэд энэ дэлхийд туслахыг хүсдэг. Дарга хүн улс орондоо туслахыг хүснэ. Энэ нь бас сайн хэрэг. Магадгүй түүний үүрэг даалгавар байх. Дарга болох нь муу хэрэг гэж яриагүй.

Үнэндээ хүн бүхэн гэрээс гарч чадахгүй. Хүн бүхэнд тийм хүсэл зориг байхгүй. Гэрээс гараад олигтой сайн бясалгахгүй бол гэртээ байсан нь дээр. Гэртээ суугаад өөрийн үүрэг хариуцлагаа сайн биелүүлвэл гэрээс муу гарснаас хавьгүй дээр. (Багш болоод бүгд инээлдэв) Та нар ойлгож байна уу? (Ойлголоо гэж бүгд хариулав) Гэртээ байгаа хүмүүс өөрийн үүрэг хариуцлагаа сайн биелүүлэхийн зэрэгцээ энэ дэлхийн төлөө чармайн бясалгах хэрэгтэй. Бясалгах хүн нэгээр нэмэгдсэн ч энэ дэлхийд тун их тустайг

МЭДВЭЛ ЗОХИНО.

Тиймээс бид энэ дэлхий энх амгалан байж, бүх хүн сансрын хүрднээс гэтэлж, гурван ертөнцөөс ангижрах болтугай хэмээн залбиран даатгадаг. Зөвхөн ганц хоёрхон хүний төлөө Бурхан бодьсадвад даатгах хэрэггүй. Мэдээж ах дүү, хамаатан садныхаа өмнөөс даатгах хэдий ч бусдыг бас хэзээ ч мартаж болохгүй. Хэрвээ та нар Багшаасаа бүх дэлхийд туслахыг гуйвал Тэр танай ах дүүг мартах уу? (Мартахгүй гэж нэг хүн хариулав) Мэдээж мартахгүй. Учир нь таны ах дүү бол дэлхийн хүмүүсийн нэг хэсэг. Тийм болохоор ах дүүг чинь адилхан харж хандана. Бид ах дүүгээ мартадаггүй шиг дотоодын багш маань бидний ах дүүг яаж мартах билээ?

Зарим хүн Багшаас нь ийм нэг ёж асуулт асуудаг. Жишээ нь, та миний нас барсан хамаатанд тусалж чадах уу? Эсвэл би өөр номын Багшийг хайж, түүний хойтохыг даатгах уу? (бүгд инээлдэв) Ийм асуултыг сонсмогц Багшийнх нь зүрх “дэлбэрэх” шиг болдог. Хагарч дэлбэрэхийн дэлбэрэх шүү. Зүрх шимшрэн өвдөж, хагарах шахдаг. Зүрх сэтгэл уужран тэлэх биш, харин чинэрээд дэлбэрч байгаа хэрэг. Миний шавь нар олон янз. Иймэрхүү ном доройтуулагч шавь тун олон байдаг. Ном хамгаалагч биш шүү. Олон хүн шавь шиг биш, харин шавар шиг байдаг. (бүгд инээв) Тийм тэнэг мунхаг, тийм хахир хатуу, Багшийгаа огт ойлгоогүй, ийм хүмүүсийн итгэл нь өчүүхэн амьсгаа төдий, зүрх сэтгэл нь туйлын явцуу давчуу.

Та нар бясалгадаг хүн бүхэн адилхан гэж бүү бод!. Адилгүй шүү, зарим нь нэр төрд шунан дурлах сэтгэлтэй, зарим нь бясалгахдаа сэтгэл зүрх тун давчуухан, заримынх нь бясалгалын итгэл зориг тууштай биш. Гэсэн ч энэ бүх нөхцөл байдлыг уучилж, тэдэнтэй хамтдаа бясалган аажуухан урагшилна. Зарим нэг хэтэрхий хүнд нөхдүүд засал авахгүй тул орхихоос өөр аргагүй. Үнэндээ орхиж

байгаа ч биш. Түүнд өөр нэгэн номын ёсыг заах хэрэгтэй болдог. Тийм хүнд зөөлөн аядуу бясалгалын арга зохихгүй тул нилээд хатуу бясалгалын арга хэрэглэхээс аргагүй.

Энэ нь та нар хүүхдээ хүмүүжүүлдэгтэй яг ижил. Номхон дөлгөөн нэгнийг нь хайраар зөөлөн хүмүүжүүлнэ. Нилээд дүрсгүй заримыг нь хайртай хэдий ч арай өөр аргаар хүмүүжүүлэх хэрэгтэй. Заримд нь зориуд царай өгөхгүй, нилээд хөндий байж, хатуу чанга харилцана. Ингэвэл тэр жаахан үг сонсдог, номхон болох жишээний. Энэ бүхнийг түүнийг сайн хүн болгон хүмүүжүүлэхийн төлөө, бас та өөрийнхөө төлөө хийдэг. Эс бөгөөс та түүнийг хүмүүжүүлж дийлэхгүй, хожим нь бүр их шаналах болно. Тиймээс түүнийг хатуу чанга бясалгалын аргаар сургах хэрэгтэй болдог. Энэ нь орхиж хаясан хэрэг огт биш. Миний санааг ойлгов уу?



## ҮЙ ТҮМЭН ХУВИЛГААН БИЕ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Формоса, Миаоли, Шиху аирам  
1988 оны 10 дугаар сарын 15  
(Эх нь хятад хэлээр)*

Одоо Багш нь та нарт Түүнчлэн ирсний үй түмэн хувилгаан биеийн тухай дахин ярьж өгье. (Нийтээрээ нижгэнэтэл алга ташив)

Бурханы хутагт хүрсэн хүн яаж үй түмэн хувилгаан биетэй болдог вэ? Тэр яаж хувилдаг вэ гэдгийг та бүхэн мэдэх үү? (бүгд мэдэхгүй гэж хариулав) Өөрийн биеэ хэсэг хэсэг хэрчээд (бүгд инээлдэв) гаргаж явуулдаг уу? Яг л Сүн Ү күн шиг үсээ сугалж, нэг үлээгээд л үй олон хувилгаан биетэй болдог шиг. Бурхан бас ингэж хувилдаг уу? Үгүй ээ, Сүн Ү күний үснээс хувилсан тэр олон бие төд удалгүй алга болж, үс л үлддэг. Үүнийг та нар мэднэ. Тэр дахиад хувилъя гэвэл эрдэм чадлаа гарган үсээ үгтээж хувилгана. Хэрвээ үй түмэн хувилгаан биетэй больё гэвэл харин биеийн бүх үсээ үгтээгээд нүцгэн үлдэх хэрэгтэй болно.

Харин Бурханы хувилгаан бие нь ямар ч хүч чадал гаргахгүйгээр аяндаа үүсдэг. Та бүхэнд тусалж, сэтгэлийн авшиг хүртээж байгаа нь бас аяндаа болж буй явдал. Сэтгэлийн авшиг хүртсэнээс чинь хойш Багшийн хувилгаан бие хорин дөрвөн цагийн турш байнга хамт байна. Тэр

бидний дэргэд ямагт байж, хэрэгцээ гарвал даруй бидэнд тусална. Түүнийг тэнгэрээс ямар нэгэн юм буулгаж өгөхийг хүлээх хэрэггүй.

Та нар “Эзэн Бурхан ч бас галзуу” гэдэг кино үзсэн үү? Африкчууд хэзээ ч онгоц үзээгүй, энэ тухай юу ч мэдэхгүй. Тэнгэрээс хоосон шил унаж ирвэл Эзэн Бурханы өгсөн бэлэг гэнэ. Кока коланы хоосон сав унаж ирсэн ч Эзэн Бурханы бэлэг гэнэ. (бүгд инээлдэв) Тэгээд өнөөх саваа бариад хаа сайгүй явж, Эзэн Бурханы илгээсэн бэлэг гэж зарлана. (Багш болон нийтээрээ инээлдэв)

Дэлхий дээр энэ Африкчуудтай адилхан хүмүүс маш олон байна. (бүгд инээлдэв) Жишээ нь, гаднаас их хөлгөн тарни, ямар нэгэн тарни сурч ирээд түүнийгээ замбараагүй уншин бусад хүнийг гэтэлгэж сууна. Энэ нь африкчуудтай харьцуулвал тун төстэй. Зарим хүн ямар нэг номын хурлын багаж хэрэгсэл олвол Арьяабал бодьсадва түүнд соёрхсон гэж бодоод гарч ном дэлгэрүүлнэ. Ийм номын багш гэгдэгч хүмүүс Тайваньд тун их байдаг, шавар (тэнэг) шавь олонтой. Энэ нь үнэндээ ярихад ч хэцүү тун төвөгтэй хэрэг бөгөөд үнэн худлыг ялгахад бас бэрх. Олон хүн бясалгаад жаахан ахуй ойлголттой болмогц өөрийгөө тун сүрхий болсон гэж үзээд хурдхан гарч, ном дэлгэрүүлэхийг санаархана.

Арьяабалын аргаар бясалгах нь хамгийн дээд төвшний шинжлэх ухаантай адил. Адилгүй тал байхгүй. Жишээ нь, Амиитаба Бурханы сударт баруун зүгийн Төгс баясгалант орны хүмүүс үг хэл хэрэглэхгүй. Хоёр хүн ярилцвал нэг нь сэтгэлдээ бодоход л хангалттай. Нөгөө нь шууд ойлгоно. Энэ нь хүний бодол уншихаас огт өөр. Тэдний хэлбэлзэл нь ижил болж, би ярьж байна, чи ярьж байна гэсэн ялгаа зааггүй нэгдмэл нэг болсон байна. Багшийнхаа санааг ойлгов уу?

Дээд төвшинд бүгд ийм байдалтай байдаг. Зөвхөн баруун зүгийн Төгс баясгалант оронд ч биш. Тун олон төвшин ийм байдалтай байдаг юм. Иймээс тэдэнд үг

ярианы хэрэгцээ байхгүй. Манай энэ дэлхийд л үг хэл хэрэглэх бөгөөд заримдаа төвөг удахаас цаашгүй. Ярьж дуусаагүй байтал буруугаар ойлгоно. (бүгд инээлдэв) Энэ дэлхийн хэлийг ойлгоход бэрх төдийгүй маш олон янз байдаг болохоор хоорондоо байнга үл ойлголцоно. Өндөр дээд дэсийн ертөнцөд бүгд нэгдмэл нэг байх тул үг ярианы хэрэгцээ байхгүй. Ийм байдал нь бидний гэртээ хэрэглэдэг радиотой төстэй. Төв станц, эсвэл авиалах станцаас цацсан мэдээг радио заавал хүлээн авна. Учир нь тэдний хэлбэлзэл, давтамж ижилхэн. Дээд төвшний ертөнцүүдэд байдал яг ийм байдаг. Гэвч бид радио биш хүн. Тиймээс бид бясалгал хийж, өөрийн хэн болохыг мэднэ. Бид болоод та нар гэж ялгаварлахгүй нь мэдээж. Гэхдээ бид хэн болохоо мэдэж чадна. Радио бол тэгж чадахгүй, сэрж мэдрэхгүй. Харин хүн бол сэрж мэдэрнэ. Бид радианоос үүгээрээ ялгаатай.

Тиймээс бид бясалгаад нэгдмэл нэг болдог ч бас нэгдмэл нэг бус. Нэгдмэл бус ч нэгдмэл нэг. Манай дэлхийн хэл тун хязгаарлагдмал ядмаг болохоор өндөр төвшний байдлыг илэрхийлж чадахгүй. Зөвхөн тоймлон ярихаас хэтрэхгүй.

Бид дээшилсний дараа бүхнийг ойлгоно. Одоо хараахан тэнд хүрээгүй байгаа ч баруун зүгийн Төгс баясгалант оронд хүрч чадна. Жишээ нь, заримдаа бидний гэртээ бодож байсан зүйлийг Багш тэр дор нь мэдээд тусалдаг. Хичнээн ч хүн зэрэг даатгасан ч ялгаагүй, Багшийнх нь энэ толгой самуурна гэж байхгүй. Ийм олон хүсэлт гуйлт, яаж туслах билээ гэхгүй. (Багш болоод хүмүүс бүгд инээлдэв) Тиймээс бид Арьяабал Бурхан мянган мэлмий, мянган мутартай гэж ярьдаг нь тэр мянган мутар, мянган мэлмийг гаргаж явуулдаг гэсэн үг биш. Үнэндээ мянган мутар мянган мэлмийтэй гэдэг нь ч түүнийг бүрэн дүүрэн дүрсэлж чадахгүй. Үй түмэн хувилгаан биетэй гэж хэлээд ч бас дүрсэлж чадахгүй. Ер нь бол тоо томшгүй хувилгаан



биетэй гэсэн санаа. Иймээс Амитаба Бурханыг “Гэрлийн дундаас Бурхан хувирах нь тоо томшгүй” гэж хэлдэг. Энэхүү гэрлийн дундаас гэдэг нь юу гэсэн үг вэ? Гэрлийн дундаас гэдэг нь түүний өөрийн хэлбэлзэл, түүний өөрийн давтамж юм.

Хамаг амьтны хүслийн дагуу түүний хэлбэлзлэлийн давтамж тэр даруйдаа хувирч, тухайн хүнийхтэй ижил болж, сэтгэлийг нь ойлгоно. Энэ хувирал маш хурдан нүд ирмэхийн зуур, бүр түүнээс ч хурдан болох аяндаа явагддаг систем юм. Багш нь чиний тайвань хэлээр ярьсныг хүлээн аваад төв аялга руу буулгана, (бүгд инээлдэв) эсвэл төв аялгуу ойлгохгүй бол англи хэл рүү хөрвүүлж, нааш цааш болгосоор байтал чи аль хэдийнэ үхчихнэ. (Багш болоод бүгд инээлдэв) Ялангуяа машины ослын үед чиний санааг орчуулж ойлгодог бол аварч амжихгүй. Ойлгов уу? Ийм бодол дамжих хурд нь аливаа чанагуух ертөнцийн гэрэл аялгуунаас ч хурдан байдаг. Тиймээс Будда хамаг амьтнаас өөрцгүй гэдэг. Учир нь Тэр хамаг амьтантай нэгдмэл нэг байдаг .

Хэрвээ Будда хамаг төрөлтнөөс өөр бол яаж хамаг төрөлтний даатгал залбирлыг тэр даруйдаа мэдэх вэ? Өөрийн гарыг гэмтээж байсан бол өвдөхийн зовлонг сайн мэднэ. Хэрвээ бусдын гар гэмтвэл бид харсан ч гэсэн түүний зовуурийг мэдрэхгүй. Эсвэл огт хараагүй бол тэдний яриаг сонсож байж л итгэнэ. Өөрөө өвдсөн бол нүдээ аниад унтсан ч мэдэрнэ. (бүгд инээлдэв) Хэн нэгэн хүн бидний гарыг хутгаар зүсвэл хараагүй ч лавтай тэр даруй мэдэрнэ. Сонсох шаардлагагүй ойлгоно. Учир нь бүгд нэгдмэл нэг юм. Ойлгов уу?

Гар харахад нүднээс өөр ч бидний л нэг эрхтэн. Биеийн аль ч хэсэг байсан ялгаагүй бидний биеийн хэсэг. Харахад өөр өөр ч бүгд нэгдмэл нэг. Будда хийгээд хамаг төрөлтөн харахад ялгаатай ч үнэндээ нэгдмэл нэг. Учир нь

Тэр хамаг төрөлтнийг өөрийн нэг хэсэг болгон өөрчилж чадна. Тиймээс хамаг төрөлтний бодсон бүхнийг даруй мэддэг болохоор түүнийг бид үй түмэн хувилгаан биетэй гэдэг.

Тэр үй түмэн хувилгаан биетэй. Тэрээр үй түмэн хувилгаан биетэй байдаг хэдий ч тэр үй түмэн хувилгаан бие нь Тэр биш. Яагаад гэдгийг мэдэх үү? Тэр өөрөө огт хөдлөхгүй ч хэлбэлзлэлээ хамаг төрөлтний хэлбэлзэлтэй ижил болгон өөрчилнө. Тиймээс түүнийг Түүнчлэн ирсэн гэдэг. Учир нь тэр ирэхгүй, очихгүй нэг л газраа байдаг. Гэхдээ чи Түүнийг хаа сайгүй харж болно. Иймээс Түүнчлэн ирсэн үй түмэн хувилгаан биетэй гэдэг. Харин ганц, хоёрхноор хувилах биш.

Авшиг хүртэхэд Тэр хэдийнээ бидэнд нөлөөлж, Түүнтэй бид холбогдож нэгдмэл нэг болчихсон. Яг л наалдсан мэт. Тэр үед чи юу даатгана, Тэр даруй мэднэ. Яг л радио, зурагт шиг, тогонд залгаад асаах товчийг дарвал радиогийн мэдээ сонсож, зурагтын нэвтрүүлэг үздэг шиг. Дуу, дүрсийг нь сонсох боловч уг хүнийг нь барих боломжгүй. Тэр дуу, дүрс бол уг хүн нь биш болохоор бидэнд туслахгүй. Нэвтрүүлэгт оролцож буй хүнээс, та хэдэн настай вэ? гэж асуувал тэр хариулахгүй. Түүнийг бид цайгаар дайлвал тэр уухгүй. Өндөр дээд дэсийн ертөнц болоод үй түмэн хувилгаан биеийн байдал яг үүн шиг. Бурхан заларч буй газраасаа өөрийн хэлбэлзлэл, давтамжийг хувирган биднийхтэй ижил болгох тул бидэнд тусгаарлагдсан мэдрэмж төрөхгүй, тэр даруйдаа Түүнийг олж харна. Хожим нь радио, зурагт хөгжөөд өндөр дээд дэсийн ертөнцийнхтэй ижил болбол бидэнд ямар ч багаж төхөөрөмжийн хэрэгцээгүй болж, хүссэн зүйлээ бодохын зуурт л үздэг болно. Тэр жүжигчид, урлагийн одод манай гэрийн зочны өрөөнд шууд ирээд тоглоно. Өндөр дээд дэсийн ертөнцүүдэд бүх юм ийм байдаг. Энэ бол үй түмэн хувилгаан биеийн түүх юм.

Бурхан энд тэндгүй гүйхгүй, харин өөрийн хэлбэлзэл давтамжаа биднийхтэй ижил болгодог тул бид хаана ч байсан түүнтэй хамт байна. Түүний хэлбэлзлэлийн давтамж цаг хугацаа, орон зайн заагийг үгүй болгодог. Тиймээс зарим хүн баруун зүгийн Төгс баясгалант орон бидний дотоодод байдаг гэнэ. Та нарыг бясалгаж байхад хэлбэлзлэлийг чинь Багш нь Бурхан бодьсатва нарын хэлбэлзэлтэй ижил болгон өөрчилдөг, тэр үед та нар Бурхад бодьсатваг хардаг юм. Тэрнээс бид биенээсээ гарч яваад Бурхан бодьсатвагийн газарт хүрч байгаа хэрэг биш. Зарим үед биеээсээ гарч байгаа мэт санагддаг ч энэ нь хий хуурмаг бодол төдий.

Үнэндээ бид хаашаа ч явдаггүй, харин хэлбэлзлэлээ л хувиргадаг. Бүхий л зүйлс хэлбэлзлэл давтамж бөгөөд өөр юмгүй. Өмнө нь хүн төрөлхтөн видео камер зохион бүтээгээгүй байхад хэлбэлзлэл давтамжийн тухай мэддэггүй байсан. Хожим нь энэ тухай ойлголттой болсноор АНУ-д болж буй тоглолтыг Формосад үзэх боломжтой болсон. Дараа нь улам боловсронгуй болж, ямар ч тоног төхөөрөмжийн оролцоогүйгээр үздэг болно. Зөвхөн давтамжаар, бодлоо ашиглахад л хангалттай. Тиймээс бясалгал хийнэ гэдэг чинь хамгийн шинжлэх ухаанч хэрэг болоод байна.

Бие далдлах эрдмийн талаар Багш нь та нарт өмнө нь ярьж байсан. Энэ нь бас л давтамжийн өөрчлөлт. Жишээ нь, чиний ойролцоо байгаа олон хүн өөр өөрийн хэлбэлзлэлийн давтамжтай, өөр өөр соронзон талбайтай. Чи өөрийн давтамжаа шууд үгүй хийж, энэ хэсгээ энэнтэй адил, тэр хэсгээ тэрэнтэй адил, аль ч хэсгээ тухайн зүйлтэй адил болгоод нийт соронзон талбайгаа үгүй хийж, хэн ч чамайг харахгүй болгож болно. Үүнийг л бие далдлах эрдэм гээд байгаа юм. Ойлгов уу?

Гэхдээ энэ нь бас нэг төрлийн ид шид. Орчлон ертөнц дээр бидэнд суралцаж болох асар их зүйл байна. Бас бид маш их зүйлийг хийх боломжтой. Тиймээс бид

өчүүхэн буян хишиг, өчүүхэн ач буян хийгээд сүр бадруулах хэрэггүй. Хорвоо дэлхий уудам хийх ажил их байна. Бид одоогоор тун багаханыг л хийж байна. Тиймээс Багш нь та нарыг бүү бардамна, жаахан авьяас чадвар, жаахан онцгой чанар байгаа бол омог бардам зан бүү гарга, орчлонгийн энгээр харвал үнэндээ бид юу ч биш, туйлын өчүүхэн шүү гэж хэлдэг.

Орчлон ертөнц хязгааргүй уудам, эд зүйлсээр туйлын баялаг. Бид өчүүхэн жаахан хэсгийг нь мэдсэн ч ийм бардам, ийм замбараагүй байвал бясалгалын дэвшил маш муутайн шинж. Бид тийм доогуур дэсийн зүйлд хүлэгдээд өөрийгөө тун сүрхий сайн гэж бардамнавал тэндээ гацаж, үргэлжлүүлэн суралцах боломжгүй болно. Тийм биз? Нэг жаахан хүүхэд бага сургуулиа төгсөөд өөрийгөө тун мундаг, орчлон дээр би л хамгийн эрхэм дээд гэж бодвол (нийтээрээ инээлдэв) дунд ангид элсэн орж чадахгүй. Хэн ч түүнийг яаж ч ятгасан үл сонсож, хаана ч явсан бага сургуулийн гэрчилгээгээ тэврээд үүнийгээ хэдийнээ хангалттай гэж бодсоор байна. Энэ дэлхийн хүмүүсийн ихэнх нь яг л ийм байдалтай байдаг. Тиймээс та нар хар даа ихэнх хүн хэн нэгэн хүнийг Багшаа болгон шүтэх чин сэтгэлгүй байгааг. Зөвхөн би л хамгийн эрхэм дээд нь хэмээн бодож, бүгд хаан болохыг санаархана. Нэг жаахан ид шидтэй болвол тэр даруй олонд зарлаж, бас ч үгүй бусдаас, чамд ийм ид шид байна уу? хэмээн тавлан асууна. (бүгд инээлдэв) Ид шидийг хөөргөдөж болохгүй гэдгийг бид бүгд мэднэ. Байгаа ид шидээ нууж хаагаад дийлэхгүй байхад юуных нь бас хамаг хүнд гайхуулах вэ?

Багшийгаа дагаж бясалгах явцдаа өвчин зовлон чинь эдгэрч илааршсан бол энэ талаар бүү ярь гэж Би захидаг. Сонссон зарим нь гэгээрлийн төлөө биш, өвчин зовлонгоос салахын төлөө наашаа гүйлдэхээс Багш нь эмээнэ. Өвчин нь эдгэж өмнөхөөсөө илүү эрүүлжин, амьдрал байдал нь

дээшилж, элбэг хангалуун болсон бол битгий яриарай гэж хэлдэг. Харин өөр талаар жаахан ололтой болмогцоо л хөөргөдөж, бусдыг аварна, өвчин эмнэнэ хэмээн сонин, сэтгүүлээр зарлаж, бусдад мэдээлнэ. Үүнийг хараад л та нар аль нь зөв зам, аль нь буруу зам болохыг өөрсдөө ойлгоно. Дао-үнэн ёсны төлөө, ханьцашгүй дээд гэгээрлийн төлөө, үхэж төрөхийн хүрднээс гэтэлж ангижирахын төлөө бясалгавал энэ чинь жинхэнэ бясалгал мөн. Харин өвчнөө эдгээхийн төлөө ирвэл сайнгүй, эсвэл жаахан эрдэм чадвар, өчүүхэн ид шидтэй болмогц түүнийгээ тэр даруй магтаж яваа бол тэр хүн мөрийг бүтээгээгүй - төгс гэгээрэлд хүрээгүйг харуулна. Учир нь орчлон ертөнц энгүй уудам, хязгааргүй их юмтай байхад үүнээс өчүүхэн жаахныг сурч мэдээд түүнийгээ магтан яривал тэндээ гацаж, өөрийн өчүүхэн дэсээс мултарч чадахгүй болдог. Яг л жижиг шувуухай алтан торонд орчихоод түүндээ сэтгэл хоргодон гарч чадахгүй байгаатай адил. Алтан торонд суух нь ховор боломж болохоор орхиод нисэж түвдэхгүй. Алтан тор олж авах нь нь тун хэцүү гэж бодох тул түүнээсээ зуураад огоорч чадахгүй болжээ.

Олон хүн замаа алдаж, буруу замаар ордог нь бүгд ийм жижиг сажиг зүйлсийг огоорч чадаагүйгээс болдог, үнэн, худлыг дэнсэлж чадахгүй, аль нь зөв зам, аль нь буруу зам болохыг ялгахгүйгээс болдог. Зөв, бурууг магадлахад тун амархан. Хүмүүсийг гэтэлгэж чадахгүй бол бүгд буруу зам. Хүн тэнгэрийн буян хишгийг үйлдүүлж, салхи дуудан бороо оруулж, өвчин зовлонг эмнэн засдаг мэт нь бүгд буруу зам. Энэ дэлхийн хүн ийм олон гэтэл Арьяабалын аргаар бясалгадаг тун цөөн байна. Олонх нь бүгд өчүүхэн ид шидэнд төөрөлджээ.

Одоо та бүхэн үй түмэн хувилгаан биеийн тухай сайн ойлгож мэдлээ. Өдөр бүр дадуулаад бай! Сайн дадсаныхаа дараа Түүнчлэн ирсэн болж хувирна. Ийм амархан, Ойлгов

уу? Өдөр бүр бясалга, өөрийн хэлбэлзлэлээ хувиргаж сур, хэлбэлзлэлээ хувиргаж чадаж байгаа учраас та нар гэрэл хардаг. Тэрнээс өмнө нь харж чаддаггүй байсан шүү дээ. Үүнээс гадна өмнө нь бид цэвэр тунгалаг биеийг харж чаддаггүй байсан. Одоо бол чадна. Мөн бие махбодгүй болох төлөвийг харж чаддаггүй байсан бол одоо хардаг болсон. Энэ бүхэн бол бид Түүнчлэн ирсний байдал ямархуу байдгийг хэдийнээ бага багаар мэдрэх болсныг харуулж байна. Гэхдээ энэ нь өчүүхэн төдий л дөө. Удалгүй бас алга болно. (бүгд инээлдэв) Маргааш заавал дахин хичээнгүйлэн чармайн бясалгавал байж байна.

Энэ байдлыг Шагжамуни Будда “Богдосын ном цагаан лянхуа судар”-т өгүүлэхдээ: “Худаг ухах үед жаахан чийгтэй шороо гарвал удахгүй ус гарахын тэмдэг. Тэгээд санаа амар үргэлжлүүлэн ухна”. Үүнтэй адил. Та нар үргэлжлүүлэн ухах уу? (Ухна аа гэж шавь нар хариулав) Ус гарах хэдийнээ ийм ойртсон байхад ухалгүй яахав, ухахгүй бол дэндүү хайран даа.

Та нар өглөөний нарнаас үдшийн бүрий хүртэл хүмүүст мэхлэгдээд өөрөө ч мэдэхгүй. Ид шидтэй хүн, тун сүрхий хүн, өдөрт ганц хооллодог хүн гэж сонсвол гүйж очно. “Энэ хүн манай Багшаас мундаг болов уу? Хэрвээ боломжийг алдвал дэндүү хайран” гэж бодно (Бүгд инээлдэв) Сэтгэл нь тогтоогүй, эндээс тэндээс дандаа юм эрж хайж явдаг. Хайгаад олохгүй бол Багшаасаа: “Тэр хүн мундаг Багш байх тийм үү” гэж сэмхэн асууна. Мундаг биш ээ гэж хэлэх надад бас хэцүү. Ойлгов уу?

Та нар дэндүү мухар сохор байна. Дүгнэж чадахгүй. Заримдаа би та нарын төлөө үнэнийг хэлэхээс аргагүй болдог. Хэдийнээ бясалгаад тийм сайн болсон та нарыг уруу татагдаад явчих вий гэж айна, дэндүү хайран. Маяагийн урхи занга ийм байдаг. Бид бясалгаад жаахан дэвшвэл тэр үй түмэн арга сүвэгчилж, унагахыг оролдоно. Заримдаа

биднийг тун зөөлөн аядуу аргаар урхидаж, буруу замаар оруулан Багшаас чинь хөндийрүүлж, Арьяабалын аргаар бясалгуулахгүй болгоно. Энэ бүхэн цөм буруу зам мөр.

Маяагийн саад яг ийм байдаг. Тэрнээс биш үхэр толгойт чөтгөрийн хаан ирээд үзэшгүй муухай хөлчин чөтгөрийн царай харуулахыг хүлээх хэрэггүй. Иймэрхүү чөтгөрүүд бол харин ч учрыг нь олоход амархан. Ойлгов уу? Царай зүсийг нь хараад л чөтгөр гэж мэдэх тул түүнийг бид мэдээж хүлээж авахгүй. Тэр юу ч ярьсан бид сонсохгүй.

Харин ёс суртахуунтай царай гаргах, эсвэл ид шидээр мэхэлвэл танихад хэцүү. Энэ үед бид тун амархан хууртагддаг. Хэдийнээ бясалгаад замын хагастаа хүрч чадсан байтал уруу татагдаад явбал үнэхээр хайран. Тиймээс Багш нь та нарын бясалгалын дэвшлийн төлөө үнэнийг хэлэхээс өөр аргагүй болдог. Гэхдээ хэн нэг нь асуусан тохиолдолд л хэлнэ. Би өөрөө зориуд ярихгүй. Би бусдын хэрэгт хөндлөнгөөс оролцох дургүй. Гэвч та нар төөрөлдөөд ойлгохгүй. Хэдийнээ бясалгаад тийм сайн төвшинд хүрсэн мөртлөө тун амархан уруу татагддаг. Тиймээс энэ дэлхий дээр маш цөөн хүн Бурханы хутагт хүрдэг юм.

Хэдийгээр Арьяабалын аргаар бясалгаж байгаа ч гэсэн Маяад уруу татагдаж байгаа нь бидний бясалгалын тогтсон хүч сул, буруу, зөвийг ялгах чадвар муу, өөрийн билиг ухаанаа бүрэн төгс ашиглаагүйтэй холбоотой. Тиймээс л Төгс Гэгээрсэн Их Багш байх хэрэгтэй байдаг. Учир нь бид хангалттай сайн гэгээрээгүй байна. Бид заримдаа гэгээрсэн, заримдаа харанхуй мунхаг, заримдаа хагас гэгээрсэн, хагас мунхаг төлөвт байдаг. Тиймээс бидэнд гэгээнтэн хэрэгтэй. Хэрвээ бид бясалгаж эхлэхдээ л бүхнийг ухаарч ойлгодог бол Түүний хэрэг байхгүй юм. Бүрэн төгс сайн ухаараагүй байх тул бясалгалын замд тань сануулж сэхээрүүлэх хэрэгтэй байдаг. Тиймээс авшигтан нөхөд ч тун чухал, Багш ч мөн маш чухал.

Багшийнх нь ном айлдсан бичлэг тун олон байдаг ч та нар бүгдийг сонсож чадаагүй байна. Бүгдийг нь сонсож дууссан хүн байхгүй дээ. Заримыг нь та нар сонсоогүй. Хэрвээ сонссон бол саад бэрхшээлтэй тулгарвал яаж давахаа мэднэ. Тиймээс өнөөдрийн энэ асуудал ч үүсэхгүй байсан. Та нар хааяа нэг энд ирж Багшийгаа харах, эсвэл долоо хоногт ганц удаа ирж лекц сонссоноо хангалттай, Багш бүгдийг хэлчихлээ гэж боддог. Гэтэл үнэндээ өөр газар нийтийн бясалгал хийвэл тэнд бас өөр нэгэн сэдвээр ном тайлдаг гэдгийг та нар мэдэхгүй. Гэртээ чимээгүйхэн бясалгаж, завтай үедээ энд ирж Багшийгаа харчихаад явж байвал хангалттай гэж боддог.

Зарим нэг нь долоо хоногт, эсвэл сард ганц удаа ирж, долоо, найм хоногийн даяан хийсэн болоод (нийтээрээ инээлдэв) өөрийгөө бүхнийг ойлгочихлоо гэж боддог ч сорилт шалгалт ирэхэд юу ч ойлгож мэдээгүйгээ ухаардаг. Ойлгож ухаараагүйгээр барахгүй, гадны хүнд уруу татагдаад алга болно. Тиймээс л тэгж их эргэлзэж тээнэгэлзэн яахаа мэдэхээ больж, сэтгэлд нь ажиг сэжиг үүсэж номоосоо буцах хандлага бий болдог. Өөрөө тийм сайн ахуй ойлголттой, авшигтнуудаа ч сайн ахуй ойлголттой байдгийг мэддэг мөртлөө номоосоо буцаж байгаа юм чинь ямар ч ахуй ойлголтгүй тэр хүмүүсийн талаар юу хэлэх вэ дээ? Тэд ахуй ойлголтгүй, бас Багшийнхаа сургаал номлолыг ч ойлгоогүй болохоор намайг буруутгах нь мэдээж хэрэг.

Энэ дэлхий дээр бясалгахад үнэхээр хэцүү, үнэхээр хэцүү. Та нарын бясалгал ийм хэцүү байхыг хараад миний нүдний нулимс гардаг. Арай гэж сэтгэлээ барьтал дахиад л гарна. Хүмүүсийг гэтэлгэдэг миний энэ бизнес үнэхээр хийхэд амаргүй ажил. (хүмүүс инээлдэж алга ташив) Энэ бол тогтворгүй наймаа. Өөр хүн бол нэгийг аваад нөгөөг нь зарахдаа мөнгө олно, Багшийнх нь наймаанд мөнгө олох баталгаа байхгүй. Дөнгөж ганцыг зартал төд удалгүй буцаана.



Хэзээ алдагдалд орохоо мэдэхгүй байна. (Багш болоод бүх хүн инээлдэв) Гэхдээ зүгээр ээ, хамаагүй. Үнэндээ Багш нь жинхэнээсээ наймаа арилжаа хийгээгүй, харин та бүхэнд ямар ч үнэ төлбөргүй бэлэглэж байна. Тийм болохоор алдах зүйлгүй. Ерөөл барилдлагатай хүн гэтэлгэгдвэл сайн хэрэг, гэтэлгэгдэхгүй бол бас асуудалгүй.



## ДЭЭД ДЭСИЙН САМАДИ- ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШИЙГ ХАЙЖ ОЛОХЫН ЧУХАЛ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Бразил улс.  
1989 оны 6 дугаар сарын 16  
(Эх нь англи хэлээр)*

Найз нар минь, та бүхнийхээ хайрын сэтгэлд талархлаа. Дахин энд ирсэндээ би тун их баяртай байна. Ажил ихтэй, завгүй байгааг нь мэднэ. Өдөржингөө ажиллаад ядарсан ч орой нь ном сонсохоор яаран яаран ирсэн чин сэтгэлийг тань бодохоор сэтгэл минь үнэхээр догдолж байна. Өнөөдөр нэгэн сайхан түүхийг та нартайгаа хуваалцахаар шийдлээ. Үүний агуулга нь Төгс Гэгээрсэн Их Багшид итгэж, Түүнийг дагах хичнээн амаргүй тухай юм.

Төгс Гэгээрсэн Их Багш болох тун хэцүү. Төгс Гэгээрсэн Их Багшийг олж уулзах бүр хэцүү. Түүнд итгэж, Түүнийг дагах нь бүр ч хамгийн хэцүү. Үнэхээрийн Төгс Төгөлдөр нэгэн Их Багш байжээ. Гэсэн ч тэр бидний сэтгэлдээ бодож төсөөлдөг мөрөөдлийн Багштай маань адилгүй байлаа. Тэрээр хааяа шавь нараа загнана, ганц нэгийг нь зодно, яг л Миларайбын (төвөдийн йогч, их бясалгагч) багш шиг. Хэрвээ та нар Миларайбын түүхийг сонсоогүй бол дараа би ярьж өгье. Бидний бодлоор бол ямар

ч Төгс Гэгээрсэн Их Багшийн хийх ёсгүй бүх үйлдлийг энэ багш хийсэн байна. Их Багш хүн хэзээ ч уурлах ёсгүй гэж бодож байтал уурладаг. Бидний боддогийн яг эсрэг. Тэр Багш яг л “солиотой хүн” шиг. Үнэндээ бид яг нэг “солиотой хүн” шиг болж байж л Төгс Гэгээрсэн Их Багш болно. Хэрвээ чи эрүүл саруул хэвийн хүн шиг бол Төгс Гэгээрсэн Их Багш болж чадахгүй. Учир нь энэ дэлхий дээр бүх зүйл эсрэгээрээ эргэж, хөл толгой нь солигдсон байдаг. Бид сайн үйлийг муу гэж харна. Муу үйлийг сайн гэж үзнэ. Зөвхөн Төгс Гэгээрсний дараа л чи энэ дэлхийн инээд хүрмээр байдлуудыг тодорхой харна. Үүнийхээ дараа чи солиорч нэгэн төгс “солиот”, хамгийн баяр баясгалантай “солиот”, жинхэнэ эрүүл саруул “солиот” болох болно.

Энэ этгээд сонин Багш нэг өдөр шавьдаа: “Чи яваад хоёр төмс олоод ир. Тэгээд тэр хоёр төмсийг идээрэй” гэв. Заавал хоёулангий нь идэх хэрэгтэй шүү гэж шавьдаа дахин дахин сануулав. “Тэр хоёр төмсийг заавал иднэ шүү” гэж дахиад захив. Өнөөх шавь нь голын эрэг дээр очиж суугаад төмсөө идэж эхэлжээ. Хоёр төмс идэхэд ядах юу байхав дээ. Энэ ч харин амархан шалгалт байна, хэн ч төмс идэж чадна гэж та нар бодож байгаа байх. Тэр төмсөө идэж байхдаа: Багшаа та яасан бэ? Юу л болоод байна даа гэж бодов. Гэсэн ч тэр Багшийгаа тун олон жил дагаж байгаа тул Багшийнх нь хэлсэн бүхэн заавал нэг учиртай байдаг, түүний үгийг дагах ёстой гэдгийг сайн мэднэ. Эхлээд нэг төмсөө идээд дараагийн төмсөө идэхээр завдтал нэгэн өлсөхийн туйл болсон гуйлгачин хүрч ирээд: ”Надад үлдсэн ганц төмсөө өгч хайрла! Та хэдийнэ нэгийг идчихлээ. Харин би олон хоног хэлэн дээрээ юу ч тавиагүй явна. Хэрвээ та наадхаа өгөхгүй бол би тун удалгүй өлбөрч үхэх нь байна” гэв.

Хэрэг явдал ингэж өөрчлөгдвөл чи яах вэ? Багшийнхаа захисны дагуу хийх үү, эсвэл өөрийн энэрэн нигүүлсэх сэтгэлээ дагах уу? Багш нь түүнд хоёр төмсөө хоёулангий

нь заавал өөрөө идээрэй гэж хатуу захижээ. Дүрэм журмаар бол өчүүхэн жаахан зүйл дээр ч Багшийн үгийг зөрчих ёсгүй. Гэтэл бид бас энэрэн нигүүлсэх сэтгэлтэй байх ёстой! Өлсөж цангаж, зовж зүдэрсэн хүнд туслах ёстойг хүн бүхэн мэднэ. Өлсөж зовсон хүнд хоол хүнсээ өгөхгүй байх нь тун харгис явдал. Иймээс тэрээр Багшийнхаа үгийг дагах уу, энэрэн хайрлах сэтгэлээ дагах уу хэмээн шийдэж ядан суув.

Өнөөх гуйлгачин уйлж, газарт унаад үхэх шахсан болохоор тэрээр үлдсэн ганц төмсөө түүнд даруй өгөөд гэрийн зүг явав. Өнөөх гуйлгачин ч харагдахгүй болов. Буцаж очоод болсон явдлыг ярихад Багш нь түүнийг их дуугаар хашгиран загнажээ. Үгэнд орсонгүй гэж биш, харин шавийнхаа өмнөөс харамссандаа Багш нь ингэж их уурласан байна. Тэр хоёрдох төмс нь маш их гэгээрэх адислалын хүчтэй байсан бөгөөд хамгийн дээд төгс гэгээрэлд хүргэх байжээ. Харин нэгдэх төмс нь энэ дэлхийн эд баялаг, алдар нэр, амжилт бүтээлийн адислалтай байв. Чи үнэхээр тэнэг юм даа гэж Багш нь санаа алдаад магадгүй энэ нь чиний хувь тавилан байх. Түүнийг хүртэж чадаагүй нь ямар харамсалтай вэ! гээд санаа алдав.

Хожим тэр шавь нь нийгэм дээр үргэлж амжилттай байж, их мөнгөтэй, алдар нэртэй хүн болсон ч Төгс Гэгээрсэн Их Багш болж чадаагүй. Эцсийн гол зорилго болсон орчлонгийн хамгийн эрхэм дээд байр сууринд хүрч чадсангүй. Энэ бол бидний ихэнхэд нь тохиолддог асуудал. Бид өөрсдийгөө ямар ч асуудлыг шийдэж чадна, юм бүхнийг мэднэ, би гэх үзэл байхгүй, нэгэн Төгс Гэгээрсэн Их Багшийг бүрэн дагах нь тун хялбар гэж боддог. Үгүй, үгүй, үгүй, өчүүхэн ч хялбаргүй. Хоёрхон төмс идэхэд л ийм асуудалтай байхад өөр олон хүнд хэцүү сорилт шалгалтыг давж гарна гэж мөрөөдөх ч юм биш. Яагаад гэвэл бидэнд эхэлж тогтсон үзэл ойлголт маш их, тогтсон үзэл хэтэрхий олон, нийгмийн элдэв уламжлал, зан заншил, улс орны сурган хүмүүжүүлэх

арга барил зэрэг нь хэдэн мянган жилийн турш хүмүүсийн сэтгэл зүрх, оюун ухаанд нэвт шингэсэн байдаг. Энэ бүх үзэл бодол, ойлголт хэдийнээ бидний уураг тархинд шингэн үлдсэн болохоор богинохон хугацаанд энэ бүхнээс сална гэдэг үнэхээр амаргүй.

Бид ерөөсөө өөрсдийгөө сайн, муу бүх зүйлийг мэддэг гэж боддог. Энэ бүх тогтсон үзэл бодол бидний гэгээрэлд ямар нөлөөтэй вэ? Энэ бүхэн бидний бясалгалын замд харш саад болдог. Багш биднээр ямар нэгэн зүйлийг хийлгэхийг хүссэн тэр үед бид заавал өөр зүйл хийдэг. Дотроо үгүй, үгүй, би мэдэж байна, ээж маань тэгж хэлдэг байсан, сургуулийн багш тэгж сануулж байсан, сүмийн номлогч ингэж захисан гэх мэтээр бодно. Тиймээс л бидний хийсэн бүхэн байнга Их Багшийн хүссэний эсрэг болоод байдаг. Багш маань бидний тогтсон үзэл бодолтой өдөржингөө тулалдах хэрэгтэй болдог. Энэ дэлхийн хүмүүсийн ихэнх нь хэлгүй, дүлий, бас сохор. Зөвхөн Төгс Гэгээрсэн Их Багш л бүхнийг тодорхой хардаг. Бусад хүн бүдэг бадаг, хагас хугас, эсвэл бүр юу ч харахгүй. Бид харж байна гэж боддог ч үнэндээ хараагүй байдаг. Ойлгож байна гэж боддог ч ойлгоогүй байдаг.

Энэ дэлхийн хий хоосон хүсэл мөрөөдөл үнэхээр сэтгэшгүй! Маяа болоод хий хоосон хүслийн шилдэг бүтээлүүд нь биднийг итгэхийн аргагүй зүйлд ч мухар сохроор итгүүлнэ, тэднийг баяр хөөртэй, үнэнчээр дагаад улмаар хамтдаа уруудаж доройтно. Хэн нэгэн сэрж сэхээрч, гэгээрсэн хүн ирж, хоосон зүүднээс маань дугтран сэрээх хүртэл энэ байдал үргэлжилсээр байдаг. Гэтэл бас тийм ч хурдан сэрэхгүй. Сэрүүлгийн дуунаар сэрсэн ч даруй зогсоогоод үргэлжлүүлэн унтдагтай яг ижил. Яагаад ийм олон шашны урсгал, тийм их туулан гэтэлгэдэг гэгдэгч номын ёс байсаар байтал бодит байдал дээр бидэнд юу харагддаг билээ? Манай дэлхийн хүн ам өдрөөс өдөрт улам л ихсэж байна. Энэ нь туулан ангижирч байгаа хүн бараг

байхгүй, байсан ч тун цөөн гэдгийг харуулна. Уг нь бол улам л цөөрөх ёстой баймаар. Гэтэл яагаад эсрэгээрээ байна вэ? Хэрвээ хүмүүс бүгдээрээ гэтэлсэн бол диваажингийн гэртээ заларч, тэнгэрийн элч, Эзэн Бурханы туслагч, Түүний хүү, охин болоод диваажингийн цэцэрлэгтээ үүрд мөнх амьдрах учиртай. Тэгвэл энэ дэлхийн хүн ам мэдээж цөөрнө.

Тиймээс жинхэнэ Төгс Гэгээрсэн Их Багштай учраагүй л бол тийм ч амархан туулан ангижирдаггүй байх нь. Тэр Их Багш, Есүс Христ, Шагжамуни Будда, Лууз, Жуанз, Кришна, Сократ зэрэг урьд үеийн Их Багш нартай адилхан агуу бөгөөд диваажин руу буцах замыг мэддэг. Бид өөрсдөө өдий төдий учир явдлыг яаж ч хийсэн туулан ангижирч чадахгүй. Бид хэдийгээр адилгүй замаар тун сайн явсан ч тэр маань үнэндээ буруу зам байжээ. Заримдаа бид өөрсдийгөө урагшаа яваад байгаа л гэж боддог, гэтэл гараан дээрээ эргээд ирдэг. Тиймээс өөртөө найдаж, зөв замыг олно гэдэг амаргүй. Эзэн Бурханы адис ивээлд түшиглэж, нэгэн жинхэнэ Төгс Гэгээрсэн Их Багшийг олно. Есүс Христ багш амьд байхдаа: “Би бол зам мөр. Би бол энэ дэлхийн гэрэл” гэж байв. Мөн Тэрээр: “Зөвхөн би энэ дэлхийд саатаж байх үед” гэж онцлон хэлсэн билээ. Шагжамуни Будда: “Хэрвээ чи Буддад итгэхгүй бол гадаад номтон. Туулан ангижирч чадахгүй” гэжээ. Тэд энэ дэлхийд заларч байдаа бүгд ингэж айлдаж байсан. Тэд чин үнэнийг ярьдаг бөгөөд энэ дэлхийд заларч байгаа ямар ч Төгс Гэгээрсэн Их Багшийн хувьд бодит байдал үнэхээр ийм байдаг.

Яаж бид өөрсдөө Төгс Гэгээрсэн Их Багш болох вэ? гэдгийг одоо би та нарт хэлж өгье. Учир нь Төгс Гэгээрсэн Их Багшийг хайхад тун бэрх. Тиймээс хамгийн сайн нь бид өөрсдөө Төгс Гэгээрсэн Их Багш болох нь нилээд аюулгүй. Бид бүхэн нэгэн Төгс Гэгээрсэн Их Багштай уулзвал намайг Төгс Гэгээрсэн Их Багш болгож өгөөрэй л гэж гуй, өөр зүйл бүү гуй! Бурхан багш энэ дэлхийд заларч байхдаа: “Би

энэ тоост хорвоод бууж ирсэн нь хүмүүст Төгс Гэгээрсэн Их Багшийн билиг ухааныг ойлгуулахын төлөө юм” гэж айлдсан. Өөрөөр хэлбэл хүмүүсийг Төгс Гэгээрсэн Их Багш болгон сургадаг. Есүс Христ ч мөн: “Надад итгэсэн хэн ч бай хожим харанхуйд төөрөхгүй”, мөн “Өнөөдрийн миний хийж буй ер бусын гайхамшигтай зүйлсийг хожим та нар надаас ч илүү хийх болно” гэж хэлж байв. Бурхан Багш: “Би Бурханы хутагийг бүтээлээ. Та нар ч бас ирээдүйд Бурханы хутагийг бүтээнэ” гэж айлджээ.

”Будда” гэж билиг нь нээгдсэн Их Багшийг хэлдэг. Самгарьд хэлний Будда гэдэг үг нь билиг нээгдсэн, сэрсэн хүн гэсэн утгатай бөгөөд “Бодийн хутаг”-ийг олсон хүн буюу Будда, Төгс Гэгээрсэн Их Багш гэсэн утгыг илэрхийлнэ. Яагаад билиг нь нээгдсэн гэж байна вэ? Билиг нээгдэхэд дотоод, гадаад чинь бүгд гэрэлтэж, чиний гэрэл орчлон даяар түгнэ. Чиний хүчирхэг гэрэл дөрвөн зүгт цацарч, эргэн тойрон чинь гэрэлтэхийг хүмүүс хардаг. Иймээс Есүс Христ, Бурхан Багш ,бусад агуу их гэгээнтний эргэн тойрон гэрлийн цагариг байхыг бид хардаг. Энэ бол бидний ярьдаг “Билиг нээгдэх” юм. Тиймээс та нар Төгс Гэгээрсэн Их Багш болохыг хүсэж байгаа бол эхлээд гэрэлтэй болох хэрэгтэй, билиг нээгдэж гэгээрэх хэрэгтэй. Энэ бол нэн түрүүнд тавигдах шаардлага. Дараа нь хоёр зүйлийн самадийг заавал эзэмших ёстой. Самади гэдэг нь гүн бясалгалд орж, дотоодын хязгааргүй баяр жаргал, номын баясалд умбана гэсэн утгатай. Жинхэнэ самади нь билгүүн ухаан, төгс баясгаланг авчирна. Та самадид ороход жинхэнэ самади танд билгүүн ухаан, төгс баясгаланг олгоно. Та самадид оросноор энэ билгүүн ухаан, төгс баясгаланг газар дэлхийд түгээн цацрааж, таны хэрэгцээ байгаа, тантай холбоотой ямар ч хүнтэй хуваалцана.

Зарим багш нар гүн самадид оршоод дэлхийн хүмүүсийг заан сургахаар гарч ирдэггүй. Зарим Их Багш

нарын дэргэдийн гарамгай шавь нар нь Багшийнхаа хажууд байх, эсвэл хамт бясалган суувал гүн самадид ордог. Маш гүн дээд дэсийн самади агуулах үедээ та нар бие махбодоо оршин байхыг ч мэдрэхгүй. Мөн энэ дэлхийд яаж ажиллахаа ч мэдэхгүй болно. Жишээ нь, будаа чанаж байснаа дуусгаж амжилгүй самадид орсон бол тогоо шатахыг ч та мэдэхгүй. Тэр ч байтугай хүн цохиод авахыг ч мэдрэхгүй, хүн таныг харааж загнавал тэвэрч аваад үнсэж мэднэ. Учир нь энэ дэлхийн ялгаварлах занг мартаж, сайн, муу, сайхан, муухай ялгал үгүй болдог. Тэр ч байтугай хэдэн өдөр, хичнээн сараар хоол унд идэж уухгүй байсан ч тоохгүй, өчүүхэн ч хүсэл шуналгүй, хэрэгтэй зүйл нэгээхэн ч байхгүй юм шиг санагдана. Бусдад туслах ёстой гэж бодохоо ч болиод хүн бүхнийг өөртэйгөө адил баяр жаргалтай, сэтгэл хангалуун байгаа гэж санана. Учир нь та өөрөө номын баясалд умбаж байгаа болохоор дэлхий даяараа мөн адил төгс баясгалан дунд байгаа гэж бодно.

Багшийнх нь цөөнгүй шавь нар ийм самадийн ахуй ойлголттой. Тэдэнтэй хамтарч ажиллахад жаахан хэцүү. Би тэднийг дуудвал за, Багшаа... гэнэ. Удалгүй ажил даалгавал, за... гэх хэдий ч тэндээ суусаар л байдаг. Өчүүхэн ч хөдлөхгүй. Энэ үед яах вэ? Тэднийг самадигаас нь гаргахын тулд загнах юмуу, зодох хэрэгтэй. Эс бөгөөс тэндээ зууралдаад салахгүй, гэр орноо умартаж, эхнэр хүүхэд нь өлсөж, тусламж хэрэгтэй олон хүн хүлээж байгааг мартана. Үнэндээ бид баяр баясгалантай төвшинд байгаа ч зовж зүдэрсэн хүмүүс бас байсаар байна. Ийм маягийн самади сонсоход сайхан ч, харьцуулахын аргагүй өөр нэгэн самади бас байна аа. Самади олон янз. Багш нь зөвхөн хоёр төрлийн жирийн байдлыг танилцуулна. Та нар Төгс Гэгээрсэн Их Багш болох юмуу, ийм дэсэд тун ойртсон үедээ энэ бүхнийг мэддэг байх хэрэгтэй. Багш нь жинхэнэ их хүчтэй, Эзэн Бурхантай нэгдмэл нэг, тийм л Төгс



Гэгээрсэн Их Багшийг хэлээд байна. Тэрнээс биш, өнөөдөр хаа сайгүй байгаа нэр алдартай Багш хэмээгчдийг яриагүй. Миний ярьж байгаа Төгс Гэгээрсэн Их Багш нар нь Есүс Христ, Шагжамуни Буддатай яг адил бөгөөд Шагжамуни Будда ном дэлгэрүүлэхээр гарч ирэхээсээ өмнө бодь модны дор бясалгаж, анхны тэр самадиг дөчин ес хоног өчүүхэн ч хөдлөлгүй агуулжээ. Есүс Христ номоо дэлгэрүүлэхээс өмнө цөлд бас яг ийм төрлийн самадид орж, өчүүхэн ч хөдлөлгүй, идэж уулгүй дөчин ес хоног суужээ. Зөнч Мухаммед ч гарч, ертөнцийн хүмүүсийг сургахаасаа өмнө агуйд сууж бясалгаж байхдаа ийм самадийн ахуй ойлголттой байсан. Гэвч ч Тэд бүгдээрээ тийм самадигаасаа заавал гарах хэрэгтэй байв. Учир нь тэд энэ төвшний жаргалыг эдэлж эхлэх үед нь Эзэн Бурхан тэдэн рүү хүмүүс илгээж: Болохгүй, болохгүй, заавал гарч, энэ дэлхийг аврах хэрэгтэй гэж хэлүүлсэн хэрэг.

Тэр үеэс эхлэн Тэд өдөр болгон бясалгадаг боловч өөр нэг зүйлийн нилээд жирийн самадид байсан. Та хорин дөрвөн цагийн турш самадид байна. Бас хорин дөрвөн цагийн турш самадид байхгүй. Та төгс баясгаланд ч байна, энэ дэлхийд ч бас байна. Ийм биш бол дэлхийд тусалж чадахгүй. Энэ бол нилээд өндөр төвшний самади юм. Ийм төвшнийг олоход маш хэцүү. Тэр ч байтугай нэгдэх төрлийн самади агуулах нь хэдийнээ тун хэцүү байтал хоёрдох төрлийн самади агуулахын хэцүү бэрхийг хэлэхийн аргагүй. Нэгдүгээр самадид орвол та тун их баяр жаргалд умбаад энэ дэлхий дээр ажиллах аргагүй болно. Бусад хүнийг сургаж чадахгүй, бусдын хэргийг хамаарахгүй, зөвхөн өөрийн аз жаргалтай төвшнийг л эдлэн сууна. Бусдыг сургая гэсэн ч өөрөө ажиллахын аргагүй санагдана. Энэ дэлхийн ажил амьдрал, хүсэл мөрөөдөлтэй зохицохын аргагүй болчихно. Төгс Гэгээрсэн Их Багш болж, хамаг амьтныг гэтэлгэж аварья, тэднийг ангижрахад нь тусалъя гэвэл та самадийн ийм төвшнээс оюун ухаантай зохицон ажиллах хэрэгтэй.

Самади танд дотоодын их хүчийг өгнө. Иймээс таны ерөөсөн, танаас тусламж хүссэн хүн бүхэн адислагдана. Хэрвээ та самади агуулаагүй бол хэнийг ч адислахгүй. Хэнийг ч аврахгүй. Хэнд ч туслахгүй. “Та хаа сайгүй оршиж чадахгүй”, өөрөөр хэлбэл та нэгэн зэрэг олон газар илрэх боломжгүй гэсэн үг. Үүнээс гадна уураг тархины үйл ажиллагаа хэвийн биш бол зовж зүдэрч буй эгэл жирийн төрөлтнүүдтэй холбогдож, тэдний нөхцөл байдлыг ойлгож чадахгүй. Тиймээс танд энэ хоёр хүч заавал нэгэн зэрэг байх хэрэгтэй. Ийм байх нь үнэндээ тун хэцүү. Тиймээс эртнээс нааш энэ дэлхийд Төгс Гэгээрсэн Их Багш маш цөөн байжээ. Шалтгаан нь энэ амаргүй чадварт байгаа хэрэг. Хүний энэ хорвоод оршино бас оршихгүй. Самади агуулна бас самади агуулахгүй. Ийм байдал нь биднийг Төгс Гэгээрсэн Их Багшийг эрж олоход тун төвөгтэй болгодог. Учир нь Тэр самади агуулснаа мэдүүлдэг эхний төрлийн багшаас өөр. Эхний төрлийн Багш нар бол байнга самади агуулан баясаж, хүмүүсээр хүрээлүүлэн цэцгэнд хучигдаж, шүтэгдэн суух бөгөөд нүдээ нэг нээвэл: “Өө, та нарт сайн сайхныг ерөөе!” гэнэ.

Энэ Төгс Гэгээрсэн Багш нар бол богд хүмүүс, ариун гэгээн сүнснүүд. Тэднийг бид үнэхээр хайрлан шүтүүштэй. Ийм нэгэн ариун сүнс болох нь тун амаргүй. Учир нь бид бясалгаж байхдаа энэ ертөнцийг санаж бодсоор байдаг учраас самади агуулж чаддаггүй. Уулын шугуйд очсон ч сэтгэл ертөнцийг дурссан хэвээр, толгойд элдэв бодол эргэлдэж, сэтгэл санаа тогтохгүй зовсоор байдаг. Зарим хүнийг харахад гүн самадид байнга оршиж, царайнаас нь гэрэл цацраад инээд баяслаар бялхан биднийг ерөөж суудаг. Бидний бодлоор ийм хүмүүс бол хэдийнээ эглээс хэтийдсэн ариун гэгээнтнүүд юм. Ийм гүн самадид ганц минут, эсвэл таван минут орших ч их хэцүү. Хэдийнээ ийм самадид хүрч хөдөлшгүй болсон хүн бол аугаа их богд гэгээнтэн мөн. Тэд

өөрийн сэтгэлийг эрхшээн жолоодох асар их хүчийг олсон байдаг.

Үүнээс бүр илүү амаргүй нь тэр нэгэн зэрэг самади ч оршино, энэ дэлхийд ч оршино. Тэд дотооддоо аниргүй гүн амгалан байхын зэрэгцээ гадна талын ажлуудыг зохицуулж, хий хуурмаг хүслийн ертөнцийн манангаас аварч гаргахын тулд ямар ч төрлийн хүнийг сургаж чадна.

Энэ бол яг л Есүс Христ болон Бурхан Багш шиг бүрэн Төгс Гэгээрсэн Их Багшийн байдал мөн. Иймээс нэгэн Төгс Гэгээрсэн Их Багш болох нь үнэхээр амаргүй. Учир нь энэ дэлхийд заларч буй Төгс Гэгээрсэн Их Багш янз бүрийн төрөлтний олон янзын дадал зуршил, сэтгэл санааны олон төрлийн саад тотгорыг зохицуулж, тус бүрд нь тохируулан эмчилдэг болохоор Түүнийг магадлан танихад тун хэцүү.

Харахад эгэл жирийн хүн шиг байдаг. Шавиа загнана, зэмлэнэ, хэрэгтэй бол аашилна, хайр халамж хэрэгтэй бол хайрлана. Түүний загнах нь ч хайр, гэврэх нь ч хайр. Илрэх хэлбэр нь л өөр болохоос аль алинаас нь Багшийн их хайрыг мэдэрнэ. Бидний билиг хараахан их нээгдээгүй тул ийм төрлийн Багшийг, Түүнд байх онцлог чанаруудыг тодорхой харахгүй. Багш хичнээн цагаар бясалгадгийг мөн гүн самади тэгш агуулсан байдлыг нь бид харж чадахгүй. Одоо байгаа Их Багш маань бидний төсөөлдөг үргэлж нүүр дүүрэн инээмсэглэж, бал бурам шиг сайхан үг хэлж байдаг багшаас өөр. Биднийг харахад Багш маань жирийн хүн шиг байна. Энгийн үйлдэл, жирийн байдал нь Түүнийг тун эгэл болгон харагдуулдаг. Гэтэл нэгэн жинхэнэ Төгс Гэгээрсэн Их Багшийн үйл ажиллагаа нь эгэл хүн шиг байх боломжгүй. Үнэхээр жирийн биш!

Хоёр төмсний үлгэрийг бүү мартаарай. Бид ихээр гэгээрээгүй, эсвэл анх удаа Багшийг харж байгаа, эсвэл Түүний шавь болоод удаагүй байхад Их Багш чамд хоёр төмс өгөөд идэхийг захиж, бас үүнийгээ гурав дөрвөн удаа

сануулсан бол чамд юу бодогдох бол? Та их гайхах байсан, тийм үү? Манайд төмснөөс их юм алга. Би уг нь энд илүү их адислал, сүнслэг тусламж хүсэж ирсэн, гэтэл Багш надад хоёр төмс өгөх юм. Хөөх, төмс! Би төмсөнд ёстой дургүй. Энэ хүн яаж Төгс Гэгээрсэн Их Багш болсон юм бол? Миний төмсөнд дуртай, дургуйг ч мэдэхгүй, дотроо юу бодож байгааг маань ч ойлгохгүй, яасан инээдтэй хэрэг вэ? Хоёр төмс шүү! Бас намайг заавал ид гэж хэд хэдэн удаа хэлсэн. Төмс яаж иддэгийг би мэдэхгүй гэж үү? Бид үнэндээ иймэрхүү л юм бодож суухаас биш, хоёр төмсний цаад утга учир нь юу вэ? гэдгийг огт мэдэхгүй.

Багш маань бидэнд хайрын хүч шингээсэн адислал дүүрэн зүйл өгвөл түүнд нь юм бүхэн бий. Хэдийнээ энгийн төмс биш, харин их буян хишиг, хязгааргүй оюун санааны хүч болон хувирсан байдаг. Формосад Багшийнх нь шавь нар миний өгсөн адистай зүйлсийг булаацалдан авдаг. Зөвхөн Формосад ч биш, адистай зүйлийн цаад учрыг мэддэг шавь нар би тэдэнд юу ч өгсөн тун их баярлана. Хамт гадагш явбал ямар нэгэн зүйл өгөхийг хүсэн хүлээнэ. Ганц ширхэг газрын самар, чихэр ч байсан хамаагүй. Юу л байна, түүнийгээ хуваахад тэд тун их баярладаг. Заримдаа бид гадаа олуулаа цугларч, юм хум хувааж байвал харсан энгийн хүмүүс хүрч ирээд авдаг. Тэд хүсвэл би бас өгөх дуртай. Миний хувьд авшигтай, авшиггүй ялгаагүй. Тэд бүгд л Эзэн Бурханы хүүхдүүд. Гэвч тэдний нүүрний хувирлаас бүгд л ижилхэн байдгийг мэдэж болно. Үнэхээр хөгжилтэй! Тэд ганц самар, ганц чихэр авбал нүүр дүүрэн гайхширсан царай гаргаж: Хөөх! Ганцхан ширхэг самар? Манайд самар шиг их юм байхгүй гэнэ. Тэгээд үүнийх нь үр дүн өнөөх төмсний үлгэртэй адил болно.

Иймээс Багш нь олон нийтийн дунд адистай зүйл тараахыг хүсдэггүй. Заримдаа шавь нараас ийм хүсэлт ирдэг ч би хорьдог. Учир нь зарим хүний буруу ойлголт,

шүүмжлэлээс эмээнэ. Багшид нь хамаагүй ч харин тэдэнд бол муу. Хожим нь саад тотгор ихтэй болно. Бид үүнийг үйлийн үр гэдэг. Самгарьдаар карма гэнэ. Үйлийн үр гэдэг нь хийсэн сайн, муу үйлийн үрээр хожим нь үүсэх барцад саадыг хэлж байна. Төгс Гэгээрсэн Их Багш болоход ийм хэцүү юм чинь бид яасан нь дээр вэ? Багшийнх нь сурталчилгааны самбар, зарлал дээр “Агшин зуур гэгээрч - нэгэн төрөлдөө туулан ангижирна” гэж байхаас биш, “Нэгэн төрөлдөө Төгс Гэгээрсэн Их Багш болно” гэж байхгүй. Бид Төгс Гэгээрсэн Их Багш болохыг хүсвэл ямар ч эргэлзээгүй, мэдээж болно. Гэхдээ тийм ч амаргүй. Хамгийн наад зах нь билиг ухаан нээгдэж, туулан ангижирсан байх хэрэгтэй. Төгс Гэгээрсэн Их Багшийн дэсэд ойртож, ариун гэгээнтэн, бодьсатва нарын төвшинд хүрч чадвал тун сайн! Тийм биш гэж үү? Эс бөгөөс бидэнд найдлага байхгүй.

Нэгэн Төгс Гэгээрсэн Их Багш тун их азтай бол амьдралынх нь туршид ганцхан л залгамжлах шавь гарна гэж Энэтхэг хүмүүс байнга ярьдаг. Йогчийн намтар хэмээх номд энэтхэгээс ирсэн нэгэн Төгс Гэгээрсэн Их Багшийг Йогананда гэх бөгөөд тэр америкт ихэд алдаршсан, одоо ч хэвээрээ. Гэсэн ч түүнийг залгамжлах шавь гараагүй юм. Өөрөөр хэлвэл хэн ч түүний тэр өндөр дээд дэсэд хүрэхүйц болж чадаагүй гэсэн үг. Гэгээрч туулан ангижрах нь тийм хэцүү биш, харин өөрөө Бурханы хутагт хүрч, Төгс Гэгээрсэн Их Багш, Есүс Христ болох нь хэцүү. Гэсэн ч бид бүгдэд ийм боломж бий. Багш нь та нарт хэцүү гэж хэлж байгаа ч энэ нь огт боломжгүй гэсэн үг биш. Хүнд бэрх байлгах эсэх нь ерөөсөө л бидний гарт байдаг. Бид нэгэн Төгс Гэгээрсэн Их Багшид итгэж, энэхүү төгс төгөлдөр Их Багшийн ном сургаалыг бүрэн дүүрэн хүндэтгэн дагаж чадвал ирээдүйд бид Төгс Гэгээрсэн Их Багш болж чадна. Гэхдээ л Их Багшийг бүрэн дүүрэн дуулгавартай дагана гэдэг л хамгийн хэцүү нь. Яагаад гэвэл бид би гэх үзэлтэй.

Би гэх үзэл - эго нь: “Би” үүнийг хийж чадна. “Би” эдгээрийг ойлгоно гэдэг. Энэ “Би” хэмээгч нь билиг ухааныг нээн хөгжүүлж, Төгс Гэгээрсэн Их Багш болоход хамгийн аймшигтай дайсан болдог.

“Би гэх үзлийг таслахад үнэхээр амаргүй. Бусдыг захирч болно. Харин өөрийгөө захирах хамгийн хэцүү. Иймээс л эртний хүмүүс: “Өөрийн сэтгэлийг эрхшээж чадсан хүн хамгийн аугаа ялагч мөн” гэж хэлжээ. Бид бясалгалаар, Арьяабалын аргаар энэ бүхнийг хийж болно. Багш нь та нарт яаж хийдгийг удахгүй зааж өгнө. Аажим аажмаар Арьяабалын бясалгалын дотоод хэлбэлзлэлийн хүч буюу Эзэн Бурханы хамгийн их хүч бидний саад тотгорыг арилгаж, тогтсон үзэл бодлыг цэвэрлэж, та биднийг туулан ангижруулж, эрх чөлөөт нэгэн болгоно. Үүний дараа л бид, би гэх үзэлгүй, нэр алдар, эд хөрөнгө, эрх мэдэлд шунан дурлахгүй болно. Энэ дэлхийн баяр жаргал, зовлон гуниг байсан ч нөлөөлөгдөхгүй болно. Юм бүхэнтэй мөртлөө юу ч үгүй хоосон. Яг л Эзэн Бурханы адис хайраар дүүрсэн хоосон сав шиг болно. Юу ч үгүй хоосон болсон тэр цагт чинь Эзэн Бурхан чамайг билгүүн ухаан, энэрэл хайраар дүүргэнэ. Харин Би гэх үзэл байсаар, бас бус зарим зүйлтэй зууралдсаар хоосорч чадаагүй бол Эзэн Бурханы соёрхсон хүчийг бид бүрэн дүүрэн хүлээн авч чадахгүй. Ойлгов уу?

Энэ бол Төгс Гэгээрсэн Их Багш болох нөхцөл болзол юм. Бид эхлээд заавал би-үгүй болж өөрчлөгдөх хэрэгтэй. Ямар ч үнэ цэнэгүй эгэл доорд хүн болон хувирах хэрэгтэй.

Есүс Христийн хэлсэнчлэн: “Хүүхэд шиг цайлган цагаан сэтгэлтэй болоогүй л бол диваажин руу буцахгүй”. Лууз мөн адил: “Бид эргээд хүүхэд болох хэрэгтэй” гэжээ. Тэд бүгд нэг ижил зүйлийг л хэлсэн байна.



## ЭНХ ТАЙВНЫГ ӨӨРӨӨСӨӨ ЭХЛҮҮЛЬЕ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Малайз улс. 1989 оны 10 дугаар сарын 1  
(Эх нь англи хэлээр)*

Эрхэм ноёд хатагтай, найз нараа! Аль ч газар ном тайлахын өмнө явал төгс сайхан ярьж, сонсогч олонд хамгийн их ач тусыг хүргэх вэ? гэж би сэтгэлдээ гүн гүнзгий тунгаан боддог. Эзэн Бурхан, Бурхан Багшид үргэлж даатган бүхнийг чадагч Эзэн Бурханд хандан надад энэрэл нигүүлслээр туслахыг гуйж, бүхий л найз нөхөд, тэнгэрийн төрөлтөн, ад чөтгөр, мөн энд хуран цугласан бүхий л хүнд миний энэ хоёр цагийн номын айлдвараар дамжуулан хамгийн их ач тусыг хүртээж хайрлана уу хэмээн залбирдаг.

Өнөөдөр хэдийгээр гаднах сүм дуганд очиж залбирч даатгаагүй ч өөрийн сэтгэлийн сүмдээ чин сэтгэлээсээ залбирлаа. Өөрийн энэ эрдэнэ болсон биеийг би Эзэн Бурхан, Бурхан Багшид даатган залбирах сүм болгосон юм. Энэ удаагийн номын айлдвар та бүхэнд хамгийн их ач тусыг хүртээж, нэгэн мартагдашгүй сайхан дурсамжийг үлдээх болтугай хэмээн даатгав. Ингэж даатгах бүртээ би ач тус, адис ивээлийг хүртэж байдаг. Энэ бол хүн бүхэн яагаад өдөр бүр залбирч даатгадгийн шалтгаан билээ.

Учир нь бид ач тусыг нь хүртэж байгаагаа илэрхий мэдэрдэг, тиймээс Христийн сүмд очиж, Эзэн Бурханд

залбирч, Исламын шашны сүмд очин Аллах бурханд мөргөж, Буддын сүмд очиж Бурхан Багшид даатгадаг. Эзэн Бурхан, Бурхан Багш, Аллах бурхан болон бусад шүтэж биширдэг бурхныхаа адис ивээлийг хүртэж буйгаа бүгд мэдэрдэг. Хүмүүсийн амьдралын суурь нөхцөл адилгүй, соёлын төвшин өөр байдгаас шалтгаалан орчлонгийн түмэн бодисыг бүтээгч тэр хамгийн их хүчийг өөр өөр нэрээр нэрлэдэг. Биднийг хайрлагч тэр их хүчийг зарим нь Дао, зарим нь Эзэн Бурхан, зарим нь Бурхан чанар, Аллах гэнэ. Иймээс маргалдах хэрэг байхгүй. Ямар шашин шүтдэг байх нь ерөөсөө хамаагүй. Христ, Ислам, Буддын, Сикийн, Бумбын шашин гээд аль ч шашныг шүтдэг байж болно. Хүн бүхэнд өөрийнх нь шашин шүтлэг хамгийн их ач тустай санагддаг. Надад ч мөн адил. Хамгийн сайн сайхан санагддаг бүхэн бидэнд ач тусаа өгч байдаг.

Бид заримдаа шүтдэг шашныхаа сургаалын эзэнтэй уулзахыг хүснэ. Жишээ нь, Буддын шашинтан бол Бурхан Багштай Арьяабал бодьсадватай уулзахыг хүснэ. Хэрвээ та Христийн шашинтан бол Эзэн Бурхан, Есүс Христ, Гэгээн Мари эх болон өдөр бүр даатган залбирдаг гэгээнтнээ харахыг хүснэ. Та нар Эзэн Бурхан болоод Бурхан Багштай уулзахыг над шиг их тэгж их хүсдэг эсэхийг би мэдэхгүй.

Би урьд нь Бурхад бодьсадва, Эзэн Бурхантай уулзахыг маш их хүсч байлаа. Эзэн Бурханд, Бурхан Буддад сэтгэл зүрхний гүн дэх зовинол, хүсэл мөрөөдөл, эргэлзээ тээнэгэлзээ, өөрийн болоод бусдын туулсан бэрхшээл зовлонг тоочиж нүүр тулан ярилцахыг тун их хүссэн. Гэгээрэхээсээ өмнө өдөр бүр сүмд очиж залбирдаг байв. Сүм харагдвал ороод Эзэн Бурхан, Бурхан Багшид даатган залбирч: “Та үнэхээр оршин байдаг бол надад өөрийгөө харуулж болохсон болов уу? Хэзээ нэгэн өдөр ямар ч аргаар хамаагүй надад та өөрийгөө илчилнэ үү. Би зөвхөн Таныг л харахыг хүснэ, өөр зүйл хүсэхгүй” гэдэг байлаа.



Нэгэн удаа сүмд Бурхан Багшид даатган: “Хайрт Бурхан багш минь ээ, та үнэхээр оршин байдаг бол үүнийгээ баталж, надад болоод бусад хүнд илрэн харагдана уу? Хамгийн зохимжтой аргаар бидэнд өөрийн сүр жавхланта дүр төрхөө харуулбал таны хайр энэрэл, хүч чадалд улам итгэлтэй болж, сэтгэл санаа минь ч айдасгүй болно” гэв.

Ийм маягаар би олон удаа даатгасан ч Эзэн Бурхан, Бурхан Багшийг хараагүй л байлаа. Нэг өдөр би өглөө, оройн уншлагаа дуусаад дараа нь тун их залхаж уйлав. Буддын шашинтан хүн өглөө, оройн уншлага яаж хийдгийг та нар сайн мэднэ. Модоор хийсэн тогшуур, бас нэг хонхтой. Тогшуур тогшин (Багш тогшуур тогшиж, хонх цохин ном унших байдал үзүүлэв) тарни уншина. Их нигүүлсэнгүй тарни, Арьяабалын тарни, Амитаба Бурханы тарнийг олон дахин уншина. Тэр өдөр би өглөөний уншлагаа ингэж хийгээд дуусгасан ч Бурхныг бас л олж харж чадаагүй. Хичнээн олон удаа залбирч даатгаснаа бодохоор тэсэлгүй ихэд шаналан уйлав. Яг л хүссэн юмаа авч чадаагүй хүүхэд хөлөө дэвсэн яагаад надад өгсөнгүй вэ? гэж гоморхон уйлдаг шиг.

Бурхан минь! Би танд итгэхгүй байгаа юм биш, харин таныг олж хараагүйдээ сэтгэл минь өнчирч байна. Таныг олж харахгүй юм чинь хүмүүс яаж танд итгэх вэ? Би тун их шаналан тасралтгүй уйлсаар байв. Хөрш маань орж ирээд: Юу болов? Чи ямар нэгэн тэнэг хэрэг хийгээгүй биз гэхэд би: Үгүй ээ! Би яагаад тэнэг хэрэг хийх гэж гэхэд тэр: Чи өглөөжингөө уйллаа! гэв. Намайг ямар нэгэн буруу хэрэг хийж гэж тэр боджээ. Гэтэл би үнэндээ Бурханд хандан чанга дуугаар шаналан уйлсан нь хөршийн хүмүүсийг сэрээсэн байжээ. Тун санаа зовмоор хэрэг болсон.

Тэр өдрөөс эхлэн өдөр бүр залбирч мөргөөд өглөө, оройн уншлага үйлдээд бурханд мөргөөд судар уншаад ч сэтгэл ханахгүй байгаагаа ухаарсан. Учир нь Бурханы барааг

ганц ч удаа хараагүй тул явахаар шийдэв. Энэ арга нэг л болохгүй байна, өөр арга зам хайх хэрэгтэй. Энд өчүүхэн ч дэвшилгүй, ингээд гацаад сууж болохгүй гэж бодогдов. Би бурханы дүрийг харахыг үнэхээр их хүссэн. Тиймээс би таарсан сүм болгонд орж мөргөл үйлдэн бурханыг илрэн харагдахыг хүсч байлаа. Энэ дэлхий дээр ямар л сүм хийд, лам хувраг, гэлэн гэлэнмаа, христийн сүм байна би тэр бүхэнд очиж хүндлэл үзүүлэн залбирал даатгал хийдэг байв. Бага ч атугай билиг нь нээгдсэн, нэр алдартай хэн нэгний тухай сонсвол би даруй түүн дээр очиж жаахан ч гэсэн гэгээрлийн ахуй ойлголт өгөхийг гуйн мөргөдөг байсан. Ийм маягаар олон жил өнгөрсөн ч би тийм ч их зүйлийг олж чадаагүй. Заримдаа жаахан хариу мэдрэмж ирнэ. Хариу мэдрэмж гэдэг нь та Эзэн Бурхан болон Бурхан Багшид даатгах үед хүртдэг хариулт юм.

Би даатгах үедээ заримдаа жаахан хариу мэдрэмж олж, заримдаа шууд зөн совингоор мэдэрдэг болов. Жишээ нь, нэгэн удаа би Амитаба Бурханыг хараад л байсан бөгөөд Түүнээс: “Та яагаад намайг баруун зүгийн Төгс баясгалант оронд аваачсангүй вэ? гэж асуув. Дараа нь бас: “Надад жаахан зөн мэдрэмж өгөхсөн болов уу” гэсэнд тэр үнэхээр өгсөн. Би маш их чин сэтгэлтэй, маш их шаналсан байв. Түүнд би зөн мэдрэмж өгч болохуйц санагдсан байх, намайг Тэр дээш татаж маш өндөрт гаргав. Гэнэт би хөндий хоосон орон зайд сууж байгаагаа мэдээд айсан, тэгээд би: “Үгүй, үгүй, үгүй! Намайг буулгачих” гэв.

Яг л нисэж байгаа мэт санагдсан. Ийм мэдрэмжийг та нар мэдэх үү? Хэрэв чин сэтгэлээсээ даатгавал гэнэт тогонд цохиулсан юм шиг тийм нэгэн мэдрэмж танд төрж, бага сага зөн мэдрэмж төрнө, Бурханы илгээлтийг мэдрэх хариу мэдрэмж жаахан бий болно. Заримдаа та самадийн төвшинд хүрнэ. Энэ бол бидний ярьдаг “Бурханыг дурсах самади” юм. Энэ нь та Бурхны алдрыг дурсах үедээ өөрийгөө бүрмөсөн

мартсан мэт болно гэсэн утгатай. Энэ нь хамаг анхаарал нь татагдан гүн бясалгалд, эсвэл самадид орсон гэсэн үг. Та тэнд суугаад онцын гайхамшигтай номын баясал бялхсан амар амгалангийн орны аз жаргалыг эдлэн сууж, эгэл ертөнцийн бүхий л нисваанисыг мартана. Энэ байдлыг самгарьд хэлээр самади гэнэ. Хятадаар (санми) гэнэ. Европчүүд ч самади гэдэг. Бидний сэтгэл нэг зүйлийн цаглашгүй баясалтай онцын нам гүм төвшинд хүрч, ямар ч нисваанисгүй, айдасгүй болдог. Энэ бол самади юм. Самадийн төвшинд бид төгс төгөлдөр болсон мэт санагдана. Энэ дэлхий дээр биднийг сэтгэлийг зовоомоор зүйлгүй, үнэндээ ямар ч учир явдал байхгүй, бүхий л зүйлс төгс төгөлдөр санагдана. Бид ийм байдалд орвол ертөнцийн түмэн бодист өөр өөрийн эмх цэгц байдгийг ухаарна. Тиймээс Лууз самадид ороод: “Дэлхий дахин угаас амгалан” хэмээн дуу алджээ.

Үүний утга нь орчлон дээр угаасаа ямар ч асуудал байхгүй. Бүхий л зүйл жам ёсоо даган өрнөж байдаг гэсэн санаа юм. Үүнийг би Эзэн Бурхан, Бурхан Багшид чин сэтгэлээсээ даатгах үед олсон жаахан ахуй ойлголтоороо мэдэх болов. Гэвч ийм зүйлийг мэдээд өөр зүйлийг олсонгүй. Энэ нь надад хангалтгүй санагдсан тул цаашдаа бурхнаас арай ахиухан хариу мэдрэмж өгөхийг хүсэн хүлээдэг болсон. Ийм мэдрэмж ямар байдгийг та нар мэдэх үү? Жишээ нь, бид нэг сайхан хоол идэх гэтэл амсуулах төдий үлдээгээд бусдыг нь өөр хүн аваад явчихвал сэтгэл дундуур, гомдолтой үлдэж дахин идэхийг хүснэ. Тийм үү? Яг үүн шиг надад ахиухан ахуй ойлголт хэрэгтэй байлаа. Би энд, тэндхийн сүм хийдээр очиж, жинхэнэ хариултыг олохыг хичээв. Билиг өчүүхэн багаар биш, харин ихээр нээгдсэний дараа л би бүгдийг ойлгож, тийм хол явж, үүгээр түүгээр хайх хэрэггүй, харин бүх зүйл бидний дотоодод байдгийг ойлгож мэдсэн. Өөрийн бие сэтгэлээ тайвшруулж, нам жим байвал Бурхны илгээсэн мессежийг хүлээн авах буюу мэдэж

чадна. Үнэндээ хүлээн авах биш, харин илрүүлнэ. Бидний ихэнх нь залбирч даатгаад олсон хариу мэдрэмжээ Бурхнаас соёрхсон гэж боддог. Үнэндээ тийм биш. Бидний дотоодод угаас бүхнийг чадагч их хүч байдаг. Зөвхөн бид өөрсдөө л мэддэггүй.

Чин сэтгэлээсээ хичээнгүйлэн залбирах үед бидний би гэх үзэл, бодол санаа бүрмөсөн алга болно. Дараа нь бид тэр хамгийн дээд их хүчтэй нэгдэж, нэгэн цогц болох бөгөөд тэр их хүчийг Эзэн Бурхан, Бүтээгч, Зам мөр, Бурхан чанар гэж нэрлэнэ. Учир нь тэр үед бид тэр хамгийн дээд их хүчтэй нэгдэж чадаад гэнэт их билиг ухаантай болон хувирч, учир явдлыг бүр ч тодорхой харж, их хүчийг хэдийнээ олчихсоноо ойлгоно. Энэ бол дээд тэнгэрээс бидэнд соёрхсон биш, харин бидний ач буяны сан хөмрөгт угаасаа хадгалаастай байж байжээ.

Та нарт сануулахын тулд л энэ бүхнийг би яриад байна. Хэрвээ бидний амьдралд таагүй зүйл тохиолдож, хүсэл мөрөөдөл маань биелэхгүй байгаа бол бид жинхэнэ хэрэгцээтэй зүйлээ эрж хайхаа мартсанаас болсон хэрэг. Жишээлбэл, Бурхан Багш оршин байдаг, Есүс Христ ч бас оршин байдаг, Эзэн Бурхан, Аллах ч бас оршин байна. Түүнийг юу ч гэж нэрлэсэн хамаагүй, Тэр угаасаа оршин байдаг. Гэвч бид олж хардаггүй. Учир нь бид Түүнийг эрж хайхаа мартсан. Юу ч гэмээр юм дээ? Таны шүтэж байгаа Бурхан, Эзэн Бурхан, Есүс Христ, бусад богд дээдэс бүгд оршин байхаар барахгүй бидний хүссэн бүхэн дотоодын маань сан хөмрөгт хадгалагдаж байдаг. Тиймгүй бол бид юу ч хүсэхгүй байх байсан. Жишээ нь, африкт алс бөглүү нутагт амьдрах отог овгийн хүмүүс хэдэн зуун жил болсон ч зурагт радио огт үзээгүй тул түүний тухай ямар ч ойлголтгүй. Учир нь тэдний оюун санаанд ийм төрлийн дурсамж байхгүй. Амьдралаас бидний олж хүртэхийг боддог бүхий л зүйл, нэр төр, алдар гавьяа, аз жаргал, уулзахыг хүссэн Эзэн Бурхан,

Бурхан багш зэрэг нь бүгд бидний дотоод санд байж байдаг. Өмнөх олон төрөлдөө бид энэ бүхнийг ой санамжиндаа хадгалсан болохоор одоо энэ бүхнийгээ хүсэж байгаа юм. Тэрнээс биш, бид яаж энэ бүхнийг хүсэж шаардах билээ? Энэ бүхнийг бид яаж мэддэг болсон байх вэ? Өмнө нь бидэнд байсан учраас л одоо авахыг хүсээд байгаа юм.

Ихэд гэгээрч, их билгүүн ухаантай болсон үедээ бүх зүйл бидний дотоодод байдгийг олж мэднэ. Эзэн Бурхан, Бурхан Багш бидэнд одоо л соёрхож байгаа бус, угаасаа соёрхчихсон байжээ. Харин бид ашиглахаа мартсан хэрэг ажээ. Эзэн Бурханы хайрыг, Бурхан Багшийн энэрэл нигүүлсэлийг таньж мэдье гэвэл зүрх сэтгэлээ намжаан тайтгаруулж, аниргүй нам гүмийн дунд Тэднээс ирэх мэдээг сонсох хэрэгтэй.

Өдөр бүрийн дасгал хоёр хэсгээс бүрдэнэ. Эхнийх нь хүссэн зүйлээ даатгах даатгал. Удаах нь түүнийг хаанаас олж авч болохыг айлдсан Эзэн Бурхан, Бурхан бодьсатвагийн илгээлтийг сонсох. Хэрвээ бид зөвхөн гуйгаад л сонсохыг хүсэхгүй, бурхны илгээлтийг хүлээж авахгүй бол ямар ч хариултгүй суух нь мэдээж. Бид завсар зайгүй гуйхаас биш, Эзэн Бурхан ямар хариу өгсөнийг мэддэггүй. Жишээ нь, нэгэн багш дээр очиж, англи хэлний талаарх асуулт асуусан бол түүний хариултыг чимээгүй сууж сонсоно. Үүнтэй нэгэн адил, бид Эзэн Бурханаас, Бурхан Багшаас ямар нэгэн зүйл хүсвэл өглөө, оройгүй, өдөр, шөнөгүй гуйна. Бид яриад л байхаас биш, Эзэн Бурхан ямар хариулт өгснийг, Бурхан Багш яаж хийхийг заасныг мэдэж чаддаггүй. Энэ бол бидний амьдрал дээшилж дэвжихгүй байдгийн гол шалтгаан.

Эзэн Бурхан их нигүүлслээр үргэлж бидэнд туслахыг хүсдэг, арван зүг, гурван цагийн бурхад ч бүгд биднийг харж хандахаар олон олон заавар зөвлөгөө өгч, амьдарлаа хэрхэн зөв авч явах, өдөр тутам тохиолддог хэрэг явдлуудыг яаж шийдэх, хамгийн дээд их билиг ухааныг хэрхэн яаж хүртэх,

энэ дэлхийд амьдрахын зэрэгцээ орчлонгийн олон янзын өөр өөр дэстэй ертөнцүүдийг хэрхэн яаж туулан гарахыг заасан олон төрлийн заавар зөвлөгөө өгдөг. Тиймээс бид өөрийгөө нам гүм, намжуун тогтуун байлгах хэрэгтэй. Энэ бол бидний ярьдаг нам суун бясалгах юм. Гэвч бясалган суусан ч оюун ухаан өөр зүйлийг бодож байвал энэ нь жинхэнэ нам сэлүүн бясалгал биш, дотор өрнөсөн яриа болох төдий. Тиймээс бид хэрхэн зөв бясалгахыг, хэрхэн яаж нам гүм суудгийг заавал мэдэх хэрэгтэй. Үүнийг л би та нарт санал болгоод байна.

Хэрхэн зохимжтой, зөв оновчтой бясалган суувал Эзэн Бурхан, Бурхан Багш, Аллах болон өөрийн итгэж биширдэг багш нараас ирэх илгээлтийг хүлээн авч чадах вэ? гэдгийг заадаг нэгэн арга бий. Заримдаа бид сэтгэлээ заавал тайван тогтуун болгох хэрэгтэй. Тэгвэл эдгээр сураг чимээг хүлээн авахад хялбар болно. Эзэн Бурхан, Амитаба Бурхан бидний хүсэл гуйлтыг сонсохгүй биш, харин Тэднийг бид өөрсдөө сонсохгүй байна. Одоо ойлгов уу? Эзэн Бурхан, Бурханы алдрыг байнга дурсах нь тийм ч их тустай биш гэж миний номд бичсэнийг та нар уншсан. Тэд бидний хүсэлт гуйлтыг сонсохгүй биш, харин бид өөрсдөө хэт их үймээн шуугиантай, хэт их ярьдгаас Тэднээс ирсэн зааврыг сонсож чадахгүй байна. Үүнийг шийдэх арга нь бид бурхнаас өдөржингөө гуйж хүссэн бол одоо харин тодорхой цаг зав гаргаад нам гүм бясалган сууж, Эзэн Бурханаас илгээсэн илгээлт, Бурхан Багшаас ирсэн заавар зөвлөгөөг сонсох хэрэгтэй. Ингэх нь үнэхээр учир зүйтэй биз дээ?

Одоо хоёрдох хэсэгтээ орёе. Яаж бясалгах вэ? Жирийн үед бясалгахдаа бид жинхэнэ нам тайван байдалд орж чаддаггүй. Заримдаа бясалгахаар суумагц нөхцөл байдал улам дорддог. Тийм биз? Хэрвээ та нар надад итгэхгүй бол гэртээ хариад туршиж үзээрэй. Нам тайван суугаад тархи толгойгоо тавхан минут хоослох гээд үз. Чадаж байвал та

нар миний багш гэсэн үг. Учир нь үүнийг хийхэд үнэхээр хэцүү. Бие нь нэгэн хайрцаганд суувч оюун ухаан эмх замбараагүй элдэв зүйлийг бодно. Энэ бол бясалгалын арга биш. Эзэн Бурхан, Бурханаас ирэх илгээлтийг сонсох ч арга биш. Үүнээс илүү сайн нэгэн арга байдаг бөгөөд энэ бол бид Эзэн Бурхан, өөрийн дотоодын бурхан чанарт даатгах, өөрийн нигүүлсэнгүй, энэрэнгүй чанар, Хятад хүмүүсийн хэлдгээр “мөн чанар угаас сайн” хэмээдэг дотоод чанартаа чин сэтгэлээсээ даатгах явдал юм.

“Хүний мөн чанар угаас сайн” гэсэн хятадын үг бий. Хэрвээ бид Эзэн Бурханд итгэвэл Эзэн Бурханд даатгана. Бурхан Багшид итгэвэл Бурхан Багшид даатгана. “Угаас ариун мөн чанар”-таа итгэвэл дотоод мөн чанартаа даатгана. Хаана ч байсан үргэлж хамгийн дээд их хүчинд даатгаж, хамгийн дээд Эзэн Бурхан, хамгийн дээд Бурханаас залбиран гуйна. Харин жижиг сахиуснуудад даатгаж болохгүй. Жишээ нь, Хятад хүмүүсийн хэлдэг сахиус, чөтгөр, та нарын нэрлэдэг газрын эзэн эр лус, эм лус гэх мэт. Тэд бол газар орны чанартай сахиуснууд тул хүч нь хязгаарлагдмал. Тиймээс бид заавал хамгийн дээд, хамгийн их хүчинд даатган залбирсанаар хамгийн дээд, хамгийн их хүчийг олж авна. Ойлгов уу? Бидний даатгал заавал сайн сайхан зүйл байх ёстой.

Хүн алахын төлөө, банк дээрэмдэхийн төлөө Эзэн Бурханаас тусламж гуйж болно гэж би хэлээгүй. Үгүй, үгүй. Ийм биш. Энэ бол тун тусгүй явдал. Миний санаа бол та бүхэн хүн төрөлхтний энэрэнгүй өршөөнгүй сэтгэлийн үүднээс бусдын аж амьдрал амар амгалан байхад тустай, учир зүй логикт нийцсэн даатгал хийх хэрэгтэй. Та энэрэл нигүүлсэл, энх тайвны төлөө даатгаж, хамгийн дээд их хүч биднийг удирдан чиглүүлж, өөрийн болоод өрөөлийн аж амьдрал, нийт улс орныхоо цэцэглэн хөгжилтийн төлөө даатгаарай. Мөн бүх дэлхийн энх тайвны төлөө, хүмүүс

билиг ухаантай байгаасай хэмээн залбирвал Эзэн Бурхан, Бурхан Багш хэрхэн яаж ажиллахыг чинь өдөр бүр чамд заах болно. Ингэвэл ажил төрөлд чинь маш хурдан өөрчлөлт гарч, улам сайжран урагштай болно. Өмнөхөөсөө илүү сайн ажиллаж, шийдвэр хурдан гаргаж, их билиг ухаантай болох бөгөөд тэр үед Эзэн Бурхан таныг цаг үргэлж удирдан чиглүүлж байдгийг сайн ойлгоно.

Хэрвээ та бясалгалаасаа энэ бүх ач тусыг хүртэж чадаагүй бол би танд Эзэн Бурханыг таних, Бүтээгчийн, Бурханы хайрыг мэдрэхэд тань туслах өөр нэг арга зааж өгье. Цэцгийн дэлбээ, цэцгийн дохиур бүгд л маш үзэсгэлэнтэй, тун сайхан үнэртэй байдаг. Яагаад ийм сайхан цэцгүүд байдаг вэ? Учир нь Эзэн Бурхан, Бурхан Багш, Их мөр, Аллах бидэнд маш их хайртай. Тэд та биднийг баясгахын тулд ийм сайхан цэцгүүдийг бүтээж, бидний амьдралыг улам гэрэл гэгээтэй, хүлээцтэй тайван, тав тухтай болгодог. Хүүхдийн нүдийг харахад хурц ухаан, хайр энэрэлээр бялхаж, юм бүхний учрыг олохыг хүссэн хүслээр дүүрэн төдийгүй, гэр бүлийнхэндээ халуун дулаан сайхан уур амьсгалыг бэлэглэж байдаг. Энэ бол Эзэн Бурхан, Бурхан Багшаас бидэнд зориулсан энэрэл хайрын илрэл юм. Хэрвээ хүүхдийн хайр, цэцэг, үзэсгэлэнт тэнгэр огторгуй, од мичид, нар, сар үгүй бол бидний амьдрал тун уйтгартай, ядмаг байх байсан.

Иймээс бид Эзэн Бурхан, Бурхан Багш үнэхээр оршин байдаг эсэхийг сайн мэдэхгүй ч ямар нэгэн нөхцөл болзолгүй хайр үргэлж оршдогийг хэдийнээ мэдэрсэн байдаг. Түүний хаанаас ирснийг мэдэхгүй ч хүн бүхнийг, энэ дэлхийн бүхий л зүйлийг хайрладаг болохыг нь мэднэ. Эзэн Бурхан хүн төрөлхтнийг төдийгүй, ан амьтдыг ч хайрлана. Бурхан Багш биднийг, орчлонгийн түмэн бодисыг харж хамгаалж байдаг. Тиймээс Тэр үхэр малд идэх өвсийг нь, эр тахианд эмэгчнийг, зөгийнд цэцгийн балыг бүтээсэн байна.



Христийн шашны Библийн сударт: “Эзэн Бурхан бүхий л төрөлтөнд зориулан хэрэгтэй зүйлсийг нь бүтээв” гэж байдаг. Буддын шашны сударт Бурхан Багш: “Бурхан бодьсадва нар хамаг төрөлтөнд үйлчлэн тэдэнд туслахын тулд ан амьтан, шувууд, цэцэг, уух ус болон хувирдаг” гэж тайлбарлажээ. Эдгээр нь өөр өөр хэлээр адил бус хэлбэрээр бичигдсэн ч санаа нь ижил. Эзэн Бурхан, Буддагийн хайр энэрлийг ойлгохыг хүсвэл эргэн тойрныхоо бүхий л зүйлд тун хүндэтгэлтэй хандаж, илүү их анхаарал тавьж, илүү их сэтгэл гаргаж, өөрт байгаа бүхий л зүйлдээ талархалтай байх хэрэгтэй. Эс бөгөөс Бид талархахаа амархан мартдаг. Хэдийгээр Эзэн Бурхан, Буддагийн хувьд бидний талархах эсэх нь чухал биш боловч хэрвээ бид талархах сэтгэлгүй бол өөрийн аугаа чанараа мэдрэхгүй, нэгэн хосгүй их хүч бүхнийг зохицуулж байдгийг мартаж, тун их ганцаардаж, цөхөрч, шанална.

Бид гадна талдаа бүхий л зүйлд талархаж, дотооддоо цаг зав гарган бясалгаж, Бурхан бидний дотоодод байдгийг ойлгож, дотоодын дуу аялгуу, тэр нам жим аялгуу, Буддагийн дуу хоолой, Эзэн Бурханы дуу аялгууг сонсоно. Хэрвээ бид өдөр бүр ингэж хийвэл маш их ялгааг олж харах болно. Жишээ нь, амьдралын өдөр тутмын асуудлуудыг шийдэх, билиг ухааны талд, аливаа хэрэг явдалд хандах хандлага бүгд өөрчлөгдөнө. Энэ бол миний “бясалган суухуй” юм.

Хэрвээ бид зөвхөн нам гүм бясалгавал Эзэн Бурханы дуу хоолойг сонсож нэн их ач тусыг хүртэж чадна гэх нь дэндүү хялбарчилсан хэрэг юм. Үүнээс гадна өөр нэг багахан нөхцөл байдгийг бид анхааралдаа авах хэрэгтэй. Энэ тухай миний номд бий. Үнэндээ миний ч ном биш, шавь нарын бичиж тэмдэглэсэн тэмдэглэл. Би ямар ч ном гаргаагүй, хятадаар ч бичиж чадахгүй. Бүгдээрээ миний шавь нарын гарамгай бүтээлүүд. Би зөвхөн ярьдаг. Тэд яриаг минь бичиж аваад нэрийг минь тавиад хэвлэж тараасан. Үүнээс болоод

би ихэд нэрд гарав. Нэрд гарснаас болоод их ч саадтай тулгарсан.

Эхлээд би өөрийн номын талаар ярьж. Формосад амьдарч байсан эхний таван жил надад ямар ч саад бэрхшээлгүй тун амар байсан. Хаа ч явсан хүмүүс хайрлан хүндэлж, хооллож хувцаслан мөнгө төгрөг өгч, байгаа бүхнээ хуваалцдаг байв. Учир нь би нэрд гараагүй нэгэн гэлэнмаа байсан болохоор ямар ч төвөг бэрхшээл байсангүй. Хожим нь Формосагийн хэсэг бясалгагчид намайг гаргаж ирсэн. Тэд надаас зарим зүйлийн талаарх үзэл бодлоо илэрхийлэхийг хүссэн юм. Мөн Арьяабалын бясалгалын аргыг зааж өгөхийг гуйсан билээ. Би тэдэнд зааж өгсөн. Дараа нь тэд миний заасан зүйлсийг тэмдэглэн авчээ. Тухайн үед би зөвхөн тэдэнд л зориулан ярьсан юм. Хүмүүсийн зэрэг дэс адилгүй тул зарим зүйлийг зөвхөн тухайн хүнд л зориулан ярьдаг. Бусдад хүнд ярьж болохгүй. Тийм байдаг биз дээ? Гэтэл тэд ямар ч сонголт хийлгүйгээр бүгдийг нь хэвлээд нийтэд ил болгосон. Ингээд би ч нэрд гарсан, яршиг төвөг ч ихэссэн. Та нар энэ талаар бараг мэдэх байх. Гэсэн ч би энэ бүхнийг тоохгүй. Хүмүүст жаахан ч гэсэн ач тустай бол хамаагүй. Иймэрхүү саад бол үнэндээ өчүүхэн явдал. Тиймээс дахин учирч болох ямар ч саад бэрхшээлийг би тоохгүй. Шавь нарын өөрсдийн хүртсэн ач тусыг бусадтай хуваалцах гэсэн сайн санаа, сайхан сэтгэлийг зогсоох аргагүй байсан. Хэрвээ зогсоовол тэдэн шиг хайрын сэтгэл надад байхгүй байна гэсэн үг. Тиймээс бусдад тустай гэж бодсон зүйлээ хийхийг нь зөвшөөрсөн юм.

Гадуур түгээж байгаа хятад, англи хэлээрх “Агшин зуур гэгээрэхийн түлхүүр” номд бясалгалдаа хэрхэн яаж ахиж дэвших талаар шавь нартаа зориулан ярьсан миний ярианууд байдаг. Үүнд өдөр бүр яг Бурхан шиг нүдээ аниад завилан сууж, бусдад их бясалгагч хүн шиг харагдах нь хангалттай биш, бид бясалгалаа аж амьдралтай холбох

хэрэгтэй. Жишээ нь, бид бясалгаад Эзэн Бурхан, Буддагийн хүчтэй холбогдоно. Дараа нь бид уулзсан хүмүүстээ, хийсэн өдөр тутмын ажил үйлдээ энэ хүчийг тодруулан гаргах хэрэгтэй. Бид өмнөхөөсөө улам илүү хайрлангуй болох ёстой. Энэ бүхэн нь бидний дэвшиж дээшилснийг батална.

Хайрлах сэтгэлээ улам тэлснийг баталъя гэвэл илүү их сайн үйл хийж, ядуучуудад тусалж, эцэг, эхдээ элбэрэл журамтай байж, өндөр настан, өнчин, бэлбэсэн хүмүүст чадлаараа тусалж, өөрийн биед хэт их жаргал цэнгэл эдлүүлэхийг хязгаарлах хэрэгтэй. Бусдын зовлонг өөрийн мэт ойлгож, амьтдын алагдаж байгааг хараад даган баясаж, махыг нь идэхгүй байх хэрэгтэй. Энэ бол бид яагаад мах иддэггүйн гол шалтгаан. Хэрвээ та нар ажил бизнесээсээ болоод эсвэл зүгээр л төвөгшөөгөөд эхнэр, нөхөр ургамал хоол хийж өгөхгүй, иймээс..., тиймээс... гэх үй олон шалтаг шалтгаанаас болоод ургамал хоол идэх хүсэлгүй байгаа бол бас өөр нэгэн сонголт бий. Жишээ нь, Бурхан Багш анх хэдэн гэлэнг өөрийн шавь болгоход тэд мах иддэг зуршилтай байжээ. Тэр хэдэн гэлэн төдийгүй, гэртээ байгаа бүх хүн мах идэж байв. Тэдний улс оронд жимс ногоо ургадаггүй тул Бурхан Багш тэднийг мах идэхээ аажмаар багасгаж, ургамал хоолтон болохыг зөвшөөрчээ. Тиймээс би ч бас Бурхан Багшийн энэ аргаар та нарт өөр нэгэн сонголтыг бий болгосон юм. Жишээ нь, боломжийнхоо хэрээр ургамал хоол идэж, аль болохоор ийм хоол идэх шалтаг шалтгаан хайна. Харин мах идэх шалтаг хайхгүй. Энэ бол аажим аажмаар энэрэнгүй нигүүлсэнгүйн зүг хандаж, хайрын хүчээ тэлж, бүхий л төрөлтөнд хандах хандлагаа болгоорой гэх миний арга болно. Ямар ч шашин шүтлэг бидэнд хүн төрөлхтөн, хамаг төрөлтийг сэтгэлдээ багтаадаг болтол хайр энэрлээ тэлэхийг сургадаг. Иймээс ямар шашин шүтдэг эсэх нь хамаагүй, бид өөрсдийн угийн ариун мөн чанартаа итгэж, дотоодод угаас байдаг энэрэнгүй, өгөөмөр сайхан сэтгэлдээ

итгэх хэрэгтэй. Иймээс та нар боломжийнхоо хэрээр илүү олон амь насыг авраарай! Гэхдээ ганц зүсэм мах идэхээ болилоо гээд маш олон зүйл өөрчлөгдөнө гэсэн үг биш. Энэ бол зөвхөн нэг зүйлийн зарчим. Бид өөрсдийн сэтгэл зүрхээ аажмаар энэрэнгүй, өгөөмөр байхад дадуулан сургана. Ойлгов уу? Өөрийн энэрэнгүй нигүүлсэнгүй чанараа улам өнгөлөн тодруулах нь хамгийн чухал зорилго байх ёстой. Түүнийгээ хэрхэвч бөхөөж болохгүй!

Зарим нэг бясалгалын бүлгэм ургамал хоол идэх хэцүү гээд иддэггүй. Тэд өдөр бүр маш олон хүнтэй уулзаж, дайлага цайллаганд уригдан найзалж нөхөрлөж, ажил бизнес эрхлэх тул ургамал хоол идэхэд асуудал бэрхшээлтэй гээд сард ганц хоёрхон өдөр иднэ. Ийм маягаар идэх махныхаа хэмжээг багасгаж, хамаг амьтныг хайрлах энэрэнгүй сэтгэлийн бэлгэ тэмдэг болгоно. Зарим бүлэг нь долоо хоногийн тав дахь өдөр ургамал хоол иднэ. Зарим шашны бүлэг жилд нэг сар ургамал хоол иддэг гэж сонссон. Энэ бүхэн нь бүгд маш эртний уламжлалт зан заншлаас үлдсэн зүйл. Буддын шашинтны дунд ургамал хоол идэх олон хэлбэр байдаг. Үүнд, нэг насаараа ургамал хоолтон байх, сард хоёр өдөр, дөрвөн өдөр, өдөр бүр идэх гэх мэт. Энэ бүхэн цөм хүмүүсийг мацаг хоол идэх зуршилтай болгох арга юм. Энэ нь миний бодлоор та нарт нилээд төвөгтэй. Жишээ нь, манай дорно дахины буддын шашинтнууд мацаглах маш нарийн цаг тооны бичигтэй. Билгийн тооллын шинийн нэгэн, арван таван, сарын хамгийн сүүлийн өдрүүдэд мацагладаг.

Хэрвээ та завгүй ажилтай бизнес хийдэг, хэвлэл мэдээллийн ажилтан бол байнга үүний дагуу мацаглаад байж чадахгүй. Бас одооны зарим цаг тооны бичигт билгийн тооллыг оруулаагүй байдаг. Иймээс нилээд бэрхшээлтэй. Тийм болохоор амь амьдралыг хайрлан энэрэх сэтгэлээ илэрхийлж, өдөр судар харалгүй хүссэн үедээ хагас, эсвэл бүтэн ургамал хоол идэж заншаарай. Ингэж чадвал хэдийнээ

тун сайн явдал болно гэдгийг би та бүхэнд хэлмээр байна. Ингэж чадах уу? (Чадна хэмээн бүгд хариулав) Баярлалаа! Үүнийг дадуулж чадвал санаа сэтгэл, оюун ухаан чинь дарамтгүй хөнгөн байна. Яагаад вэ? Учир нь мах идэхэд амьтдын үхэх үеийн зовуурь шаналал, үзэн ядалт, занал хорсол, хүчинд автсан уур хилэн энэ бүхэн нь бидний далд ухамсарт ул мөрөө үлдээх нь тодорхой. Улмаар бидний дотоод сэтгэл тайван бус, тогтворгүй болж, шөнө хар дарж зүүдлэнэ. Амьтад биднийг хармагцаа айн зугтана. Өвчин тусвал мөд эдгэхгүй байдаг зэрэг нь бүгд л идсэн маханд чинь шингэсэн айдас хүйдэс, уур хилэн, хорсол гомдлын эрчимээс болжээ. Тиймээс бид хэр удаан мацаг хоол иднэ, нүгэл хилэнцэт сэтгэл төдий чинээ багасаж, сэтгэл санаа амар амгалан болно. Далд ухамсарт үлдэж хоцрох муу нөлөөлөл улам багасаж, шөнө тайван унтаж, хар дарахаа болино. Тиймээс та бүхэн чадахын хэрээр ургамал хоол идээрэй. Тэгвэл та бүхний оюун санаа, сэтгэл зүрх, эрүүл мэнд бүгдэд тустай.

Та нартай адил өдөр бүр сонин сэтгүүл уншаад байх зав надад байхгүй. Онгоцоор явах үед л зав гарч, арав, хорь, гучин цаг зүгээр суух болдог тул их унтахгүй, удаан бясалгаагүй бол сонин, сэтгүүл уншдаг. Тэр болгонд үзээд сонирхоод уншмаар юмгүйг хараад хүмүүс яагаад: “Юу ч мэдээгүй байх нь хамгийн сайн мэдээ” гэдгийг ойлгодог. Нэг удаа Хонгконгоос Формоса хүрэх замд уншсан шинэ мэдээний сэтгүүл гай гамшиг, далайн хар салхи, үймээн самуун, онгоцны осол, аллага таллага, өвчин зовлонгийн мэдээгээр дүүрэн байв. Зарим нь урд нь ерөөс сонсож байгаагүй өвчин байв. Жишээ нь, ойрын үед гарсан нэг зүйлийн хорхойтох өвчин нь эдгэшгүй бөгөөд хазсан газраараа дамжин хүний биед үржээд биеэр нь тархаж, улмаар энд тэндээс нь нэвтрэн гарч ирэх, эсвэл бие дотуур нь хаа сайгүй гүйж байна гээд төсөөлөөд үз дээ? Эмч нар

энэ өвчнийг эмчлэх ямар ч аргагүй байна. Би үүнийг уншаад дотор муухайрч, бөөлжмөөр болсон. Тэр аймшигтай байдлыг төсөөлснөөс биш, харин ийм өвчин туссан хүмүүсийг өрөвдсөнөөс болсон юм. Жирийн үед ч бидний гэдэс ходоодонд өт хорхой байвал ямар их зовуурьтай байх билээ. Гэтэл бүх биеэр нь хорхой дүүрч, бас дуртай цагтаа нүхлэн гарч ирдэг, жишээ нь, чи судас, махан дотуураа дүүрэн өт хорхой гүйлдэж байхыг харвал энэ чинь ямар маягийн амьдрал байх вэ? гэдгийг төсөөлөөд үз. Тиймээс бид бие махбод эрүүл саруул, аж амьдрал элбэг хангалуун байхыг хүсвэл Эзэн Бурханаас иймэрхүү нөхцөл байдалд намайг бүү оруулаарай гэж гуйх хэрэгтэй. Бас өөрөө өөрийгөө бэлтгэж, бие, хэл, сэтгэлээ улам ариусгавал Эзэн Бурханы хамгаалалтыг бүрэн хүлээж авах төдийгүй, ийм өрөвдөлтэй байдалд хэзээ ч орохгүй. Дамаар амь хороохоос зайлсхийх нь хамгийн сайн арга. Хэрэв бид мах идэхгүй бол амь хороох хүн байхгүй билээ. Яг л Бурханы сударт: “Үйлийн үрийн хууль үсний ширхэгнээс нарийн” гэж айлдсантай ижил. Бусдад хийсэн бүхэн өөрт ямар нэгэн хэлбэрээр заавал буцаж ирдэг. Үүнийг буддын шашин, христийн шашны аль алинд нь: “Чи юу тарина, түүнийгээ хураана” гэж тодорхой заасан.

Хэрвээ та сайтар анзаарвал бусад бүх шашинд үйлийн үрийн талаар дэлгэрэнгүй тайлбарлаж: “Таны хийсэн бүхний чинь үр дүн танд эргэж ирнэ” гэж сургадаг. Күнз: “Өөрийн хүсээгүйг өрөөлд бүү тулгагтун” гэж сургаж байв. Үйлийн үрийн хууль нь юу хийнэ, тийм үр дүнг эдэлнэ, сайн, муу аль ч ялгаагүй. Хэрвээ чи муу үр дүн хүсэхгүй бол сайн үйл хийж эхэл, ингэвээс сайн үрийг хүртэнэ гэдгийг Тэр ч бас мэднэ. Би энд диваажин, тамын талаар их зүйл ярих бодолгүй байна. Харин амьдрал дээр хэрэгжүүлэх бүрэн боломжтой бодитой зүйлийг ярья. Хэрвээ бид бие эрүүл, сэтгэл саруул, ухаан тунгалаг, нинжин сайхан сэтгэлтэй,

гүн нойрсож сайхан амрахыг хүсвэл бусдад, амьтдад илүү энэрэнгүй хандвал зохино. Тэгвэл үүнийхээ хариуд сайн үйлийн үрийг эдэлнэ. Та бид бусдад амар амгалан, аюул осолгүй нөхцөл байдлыг бэлэглэвэл өөрөө ч бас тэр бүхнээр хангагдана. Би багаасаа л амьтныг хайрлан энэрч, өчүүхэн жаахан шоргоолж, хорхой шавж, бяцхан шувуудыг ч алж хороож, бэртээж гэмтээж зүрхэлдэггүй, мөн бусдын хийж буй тийм үйлдлийг харах дургүй байлаа. Хэдийгээр Ау Лакт гай гамшиг, дайн дажин болж, үхэл хагацал, зовлон бэрхшээл учирч байсан ч би ямар ч аюулд өртөж байгаагүй. Надад усан онгоцоор тэнүүлчлэх зовлон байсангүй, бас элдэв аюул осол ер тохиолдоогүй. Яагаад вэ? Учир нь би амьдралдаа бусдыг зовоон тарчлаасан, алж хороосон муу муухай үйл хийгээгүй болохоор тийм сайхан нөхцөл бүрдсэн юм. Тиймээс би өөрт тохиолдсон бодит байдал, туршлага дээрээ үндэслээд бусдад хийсэн сайн үйл бүхэн чинь өөрт буцаж ирдгийг сануулан хэлье. Одоо би гэлэнмаа, эсвэл Арьяабалын аргаар бясалгах болсноос энэ бүхнийг хэлж байгаа биш. Тийм биш!

Бусдад энэрэл хайраар хандсаныхаа үр шимийг өмнө нь аль хэдийнээ би олж харсан. Жишээ нь, Ау Лакт хүүхдүүд шувууны үүрнээс дэгдээхэйг нь булаана, эсвэл иднэ. Би ийм хэрэгт ер оролцдоггүй, харин ч буруутгаж, тэдний үйлдлийг зогсоохыг оролддог байв. Бэртэж гэмтсэн шувуудыг харах бүртээ тэднийг гэртээ авчирч асарч тэжээгээд эдгэснийх нь дараа тавьж явуулна. Магадгүй үүнээс болоод амьтан бүхэн надад хайраар ханддаг байсан байх. Германд байхдаа нэгэн өдөр би маани тоолж дуусаад гадаалтал нэг жижиг шувуу нисэн ирж миний өмнө суув. Би түүнээс: “Чамд юу хэрэгтэй вэ?” гэж асуухад миний өмнө удаан сууж бараг хагас цаг орчим надтай шулганан ярилцав. Миний санааг тэр ойлгосон эсэхийг мэдэхгүй ч харин би түүнийг сайн ойлгосон. Үнэхээр бид тасралтгүй ярилцсаар байсан бөгөөд

хүн, шувуу хоёрын харилцан ярих энэ байдлыг зурсан бол сэтгэл хөдөлгөм сайхан зураг болох байсан. Тухайн үед хүн, шувуу хоёрын харилцан ярилцахыг хараад хүмүүс шохоорхон бүчсэн. Учир нь бид тун ойрхон, яг л ийм зайд (Багш мөрний хэмжээтэй зайг дүрслэн үзүүлэв) бяцхан шувуухай ер холдохгүй, ер бусын энэ байдлыг сонирхсон хүмүүс тойрон хүрээлэхэд шувуухай олон хүнээс айгаад нисэн одсон. Учир нь тэр надаас биш, хүмүүсээс айсан юм.

Энэтхэгт, Хималайн нуруунд байхдаа тийм ч сайн сууцтай байгаагүй. Чулуун дээвэртэй шавар байшин байсан бөгөөд чулуунууд нь хэдийд ч хамаагүй нуран унана. Өрлөг нь сайнгүй тул шавар хана үй олон цоорхойтой. Түүгээр нь салхи үлээж, гэрэл тусан хорхой шавж шурган орж ирээд надтай найзлан сууна. Өглөө бүхэн бясалгахаар суухад таван хилэнцэт хорхой намайг тойрон хамт бясалгадаг байв. Хилэнц хорхойг мэдэх үү? Түүнд хазуулбал тун их зовно. Тэр том амтай урт нарийн сүүлтэй. Хазуулсан л бол өнгөрлөө гэсэн үг. Хилэнц хорхойнууд, могойнууд өдөр бүр миний дэргэд ирж бясалгана. Бясалгал дуусаад босоход тойрон суугаа найз нараа хараад энэ ч тийм таатай орчин биш аж гэж бодогдоно. Хэрвээ нэг л болгоомжгүй алхвал тэднийг гишгэж болзошгүй. Тиймээс би том төмөр лааз бэлдэж, өдөр бүр тэднийг аятайхан гадагшлуулаад том чулуун дээр тавьчихна. Тэд тэгээд л явчихдаг байв. Би амьтдад хүндэтгэлтэй хандаж, хайрлан харилцдаг байсан тул тэд тийм сайн ханддаг байсан байх. Амьтад хүнтэй хамтдаа ийм эв зохиролтой, найртай сайхан байхыг төсөөлөөд үз. Хэрвээ бид хүмүүстэй бас ийм сайхан эв найртай, бусад бүх төрөлтөнтэй ая зохиролтой байвал энэ дэлхий дайн дажингүй, амар амгалан байна. Тиймээс бүгдээрээ өнөөдрөөс, маргаашаас өөрсдийн энх тайван амьдралын хэв маягийг эхлүүлцгээе. Хүн бүхэн энх тайвны тухай ярьдаг ч муу хүн биеэ гурав зарахын үлгэрээр төд удалгүй зоогийн газрын том ширээний ард өнөөх зүйлээ



ярьсан ч үг хэлээр л хийхээс үйлдэл болгохгүй бол үр дүнгүй. Бид заавал үйлдлээрээ харуулах хэрэгтэй. Амьтдыг хөнөөх явдлыг үндсээр нь зогсоох, бүхий л амь амьдралыг хайрлан хамгаалахаас эхэлье! Энх тайвныг бид өөрөөсөө эхлүүлье! Энэ бүхэн надаас, танаас эхэлвэл дэлхий бүхэлдээ амар амгалан болно. Та бид энд зүгээр хүлээгээд сууж болохгүй. Тэр ерөнхийлөгч, энэ энх тайвныг цогцлоогч ирж, энх тайвны талаар ярихыг хүлээх хэрэггүй. Бид өөрсдөө шийдвэрээ гаргах хэрэгтэй. Миний бодлоор хэрвээ бид бясалгаж, идэх махаа хамгийн бага хэмжээнд хүртэл багасгаж чадвал сэтгэл зүрх харьцангуй амар амгалан болно. Бид амар амгалан байвал эргэн тойрондоо яг тийм үл үзэгдэх амар амгалан уур амьсгалыг түгээж, хүн бүхэнд аяндаа нөлөөлнө. Тэгэхээр хэлж ярихаас илүүтэйгээр, бодит үйлдлээр энх тайвныг цогцлооё! Ингэвэл бид энх тайвны тухай ярихгүй байсан ч энх тайван өөрөө аяндаа тогтох юм. Та нар үүнийг зөвшөөрч байна уу? (Бүгд зөвшөөрч байна гэж хариулав) Тийм үү? За баярлалаа!

Хэрвээ бид өөрөө ариусахын зэрэгцээ Эзэн Бурхан, Бурхан бодьсадва, өөрийн итгэдэг аливаа их хүчинд итгэвэл Эзэн Бурхан, Бурхан бодьсадва, бусад их хүчинд нилээн ойртоно. Энэ бол зайлшгүй. Би хэдийнэ туршсан тул та нарт ойлгуулахын тулд ярьж байна. Би шинэ мэдээ дуулгаад байгаа биш, угаасаа та нарын мэддэг байсан зүйл. Би зөвхөн сануулсан төдий.

Дотоодын Бурхан чанараа бүү март, Эзэн Бурхан бидний дотоодод байдгийг бүү март, Бурхан сэтгэлд буйг мартаж болохгүй. Бидний дотоодод Эзэн Бурхан, Бурхан чанар байгааг бүр ч мартаж үл болно. Бид өөрсдөө энэ хүчийг хайж олоод нээн илрүүлэх хэрэгтэй, Түүнийг туслуулахаар дуудан сэрээх хэрэгтэй. Тэгвэл бид түүний тусийг нь ч авна, адислалыг нь ч хүртэнэ. Та бүхэн бүгдээрээ адислагдах болтугай!

## **ВЕГАН ХООЛНЫ АЧ ТУС**

Насан турш веган (ногоон) хоолтон байх буюу ургамал хоол хэрэглэх нь Арьяабалын Бясалгалын (Quan Yin Method) авшиг хүртэх тэргүүн нөхцөл юм. Ургамлын гаралтай зүйлсийг хүнсэнд хэрэглэж болох ч өндөг болон амьтны гаралтай аливаа хоол хүнсийг идэж болохгүй. Үүнд олон шалтгаан байдаг ч хамгийн чухал нь амьтны амь хороож болохгүй гэсэн нэгдүгээр сахил буюу амьтан бүү хөнөө гэдгээс үүдэлтэй.

Амь хороохгүй байх, бусад амьд биест хор хүргэхгүй байх нь тэдгээр амьтанд ач тустай нь яриангүй. Бусдад хор хөнөөл учруулахгүй байх нь бидэнд ач тустай болох нь тэр бүр илт харагддаггүй. Энэ нь “ямар үйл хийнэ, тийм үр байна” гэсэн үйлийн үрийн хуулиар зохицуулагддагаас тэр юм. Мах идэх шунал хүслээ хангахын тулд амьтны амь хөнөөх, эсвэл бусдаар амьтны амь хороолговол та амь насны төлөөсөнд унаж, хэзээ нэгэн цагт заавал төлөх ёстой болно.

Веган хоол идэх нь үнэндээ бидний өөртөө барьж буй бэлэг юм. Ингэснээр бид хураасан асар их үйлийн үрээ нимгэлж, амьдралын чанараа сайжруулан, өөрийгөө улам чөлөөтэй сайхнаар мэдрэх төдийгүй, дотооддоо нэвтэрч диваажингийн нууцлаг, шинэ содон зүйлсийг ч мэдрэх болно. Энэ бүхнийг та веган хоол идсэнээрээ хүртэж буй хэрэг. Зарим хүн сүнслэг үзэл бодлоор махнаас татгалзуулдаг нотолгоонд нь итгэдэг ч веган хоолтон байхыг хөхиүлэн дэмждэг өөр олон зайлшгүй учир шалтгаан бий. Эдгээр нь хүний эрүүл мэнд, хоол хүнсний шим тэжээл, байгаль экологи, ёс суртахуун, амьтдын зовлон, дэлхийн өлсгөлөн зэрэг асуудалтай холбоотой юм.

## ЭРҮҮЛ МЭНД БА ХООЛ ХҮНС

Хүн төрөлхтний хувьслын түүхээс үзвэл манай өвөг дээдэс төрөлхийн цагаан хоолтон байжээ. Хүний бие махбодын бүтэц нь мах идэхэд зохицоогүй. Колумбын их сургуулийн доктор Г.С.Хантинген хүний биеийн бүтэц зүйн харьцуулсан судалгааны өгүүллээрээ үүнийг нотолсон байна. Тэрээр махчин амьтны нарийн, бүдүүн гэдэс нь богино байдгийг анзаарчээ. Махчин амьтны бүдүүн гэдэс шулуун бөгөөд гөлгөр байдаг. Харин мах иддэггүй амьтны нарийн, бүдүүн гэдэсний аль аль нь урт байдаг. Махан дахь эслэгийн агууламж бага, уургийн нягтрал ихээс шим тэжээлийг шингээхэд урт хугацаа шаардагддаггүй тул махчин амьтны гэдэс богино байдаг аж.

Төрөлхийн ургамлаар хооллогч бусад амьтны нэгэн адил хүн төрөлтний бүдүүн, нарийн гэдэс нь урт байдаг. Бидний гэдэсний нийт урт барагцаалбал 8.5 метр (28 фут), олон нугалаатай, хана нь хуниастай, гулгамтгай биш, махчин амьтны нарийн гэдэснээс урт тул идсэн мах гэдсэнд удаж ялзран хорт бодис ялгаруулдаг. Энэ нь шулуун гэдэсний хорт хавдар үүсэхтэй холбоотой төдийгүй элэгний ачааллыг ихэсгэж, элэгний хатуурал, элэгний хорт хавдар үүсэхэд хүргэнэ. Маханд ихээр агуулагддаг урокинез уураг, шээсний хүчил нь бөөрний ачааллыг ихэсгэж, үйл ажиллагааг нь алдагдуулдаг. Хагас килограмм шарсан үхрийн маханд 14 грамм урокинез уураг агуулагддаг. Амьд эсийг шингэн урокинез дотор хийхэд бодисын солилцоо нь алдагддаг байна. Маханд эслэг эд, ширхэглэг бодис бага байдаг бөгөөд эслэг бодис дутагдвал өтгөн амархан хатдаг. Өтгөн хатах нь шамбарам болон бүдүүн гэдэсний хорт хавдрыг үүсгэдэг.

Махан дахь холестерин, ханасан өөх нь зүрх судасны өвчин үүсгэдэг. Зүрх судасны өвчин нь америкчуудын нас баралтын шалтгааныг тэргүүлдэг бөгөөд өнөө үед Тайваньд

ч мөн адил болжээ.

Хорт хавдар нь үхэлд хүргэж буй хоёр дахь том шалтгаан юм. Махыг шарж хайрахад метилхолантрен хэмээх химийн бодис үүсдэг. Энэ нь маш хүчтэй хорт хавдар үүсгэгч болохыг туршилтаар нотолжээ. Нядалгааны газрууд мэргэжлийн байгууллагын хяналтад байдаг тул махны эрүүл ахуй асуудалгүй гэж ихэнх хүн үздэг. Үнэн хэрэгтээ нядалгааны газарт өдөр бүр маш олон үхэр, гахай, тахиа, нугас зэргийг алж худалддаг. Тэр бүхний хорт хавдартай эсэхийг нь нэг бүрчлэн шалгах бололцоогүй. Амьтан нэг бүрийг бүү хэл зүсэм махан дахь хавдрын эсийг нягтлах нь туйлын бэрхшээлтэй. Орчин үеийн махны үйлдвэрүүдэд амьтны толгой нь сэжигтэй бол толгойг нь, хөл нь өвчтэй бол хөлийг нь хаях маягаар өвчтэй хэсгийг салгаж бусдыг нь худалдаж байна. Ногоон хоолтон эмч, нэрт доктор Ж.Х.Келлог: “Бид веган хоол идвэл хоол хүнс маань ямар өвчнөөр үхсэн бол гэж санаа зовохгүй, айдасгүй амар тайван хооллоно!” гэжээ.

Өөр нэгэн санаа зовоож буй зүйл бол бордоо тэжээл, антибиотик болон өсөлт хурдасгах даавар, стеройд зэргийг агуулсан эм бэлдмэлийг амьтны тэжээлд холих буюу биед нь шууд тарьдаг явдал. Ийм мах идвэл эдгээр бодисууд хүний биед шингэдэг болохыг нийтэд мэдээлсэн байна. Махан дахь антибиотик нь хүмүүсийн эмчилгээнд хэрэглэж буй антибиотикийн үйлчилгээг бууруулах магадлалтай.

Зарим хүн веган хоол идэхэд шим тэжээл дутагдана гэж үздэг. Америкийн гэмтэл согогийн эмнэлгийн мэргэжилтэн, доктор Миллер Тайваньд дөч гаруй жил ажилласан бөгөөд эмнэлгийн ажилтан, өвчтөн цөмөөрөө веган хоол иддэг эмнэлэг байгуулсан байна. Тэрээр: “Орчин үеийн шинжлэх ухааны ачаар эм, эмнэлгийн шинжлэх ухаанд их дэвшил гарсан ч эм нь зөвхөн өвчнийг л анагаана. Харин хоол хүнс бол эрүүл мэндийг тэтгэнэ” гэжээ. Мөн тэрээр: “Ургамлаас

авч буй шим тэжээл нь махныхыг бодвол бидэнд шууд хүрнэ. Учир нь амьтад ургамлаас шим тэжээлээ авдаг. Ихэнх амьтан нас богинотой, хүнд байдаг ихэнх өвчнийг тээдэг. Иймээс хүн төрөлтний өвчин эмгэгийн ихэнх нь өвчтэй малын мах идсэнээс үүсэлтэй байх магадлал тун өндөр. Хүн яагаад шим тэжээлээ ургамлаас шууд авдаггүй юм бэ?” гэжээ. “Үр тариа, буурцагт ургамал, хүнсний ногооноос хангалттай шим тэжээлээ авч эрүүл саруул байх бүрэн боломжтой” гэж Доктор Миллер үзсэн байна.

Амьтны уураг төгс, ургамлынх төгс бус учраас амьтны уураг ургамлынхаас илүү гэж олон хүн үздэг. Үнэндээ зарим ургамал төгс уурагтай. Хүнсний бүтээгдэхүүнүүдийг хооронд нь зөв харьцаагаар хольж төгс уураг үүсгэж болно.

Америкийн Хоол Судлалын холбооноос 1988 оны гуравдугаар сард “Шим тэжээлт чанарыг нь зохистой тохируулж чадвал веган хоол нь эрүүл мэндэд ашигтай, хангалттай шим тэжээлтэй” гэж зарлажээ.

Мах иддэг хүмүүс веган хоолтнуудаас хүч чадалтай байдаг гэсэн төөрөгдөл түгээмэл байдаг. Йелийн их сургуулийн профессор Ирвинг Фишер 32 веган хоолтон, 15 махан хоолтон оролцсон туршилт хийхэд веган хоолтнууд нь илүү тэсвэр хатуужилтай байжээ. Туршилтад оролцогсдыг удаан хугацаагаар гарыг нь өргүүлэхэд үр дүн нь тун тодорхой байв. Мах иддэг 15 хүний 2 нь л арван таваас гучин минут өргөсөн бол веган хоолтон 32 хүний 22 нь арван таваас гучин минут, 15 нь хагас цаг, 9 нь нэг цагаас дээш, 4 нь хоёр цагаас дээш, нэг нь гурван цагаас дээш хугацаагаар өргөсөн байна.

Марафон гүйлтийн тамирчид тэмцээний өмнө веган болон цагаан хоол иддэг байна. Цагаан хоолоор эмчлэх мэргэжилтэн, эмч Барбара Море 200-гаад км зайг 27 цаг 30 минутад туулжээ. Тавин зургаан настай энэ эмэгтэй залуучуудын тогтоосон дээд амжилтыг эвдсэн байна.

Тэрээр: “Веган хоолтон хүн эрүүл чийрэг, ухаан саруул, цэвэр ариун амьдралтай байдгийг харуулах жишээ байхыг би хүссэн юм” гэжээ.

Веган хоолтон хоол хүнснээсээ хангалттай хэмжээний уураг авч чаддаг уу? Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөснөөр бид өдөр тутам авах илчлэгийнхээ 4,5 хувийг нь уургаас авч болно. Буудайн 17%, ногоон цэцэгт байцайны 45%, цагаан будааны 8%-ийн илчлэгийн эх үүсвэр нь уураг юм. Иймээс мах хэрэглэхгүй веган хоол идвэл хоол хүнснээсээ хангалттай уургийг амархан авч болно. Хүртэж болох өөр ач тус гэвэл өөх тос хэтрүүлснээс үүсдэг зүрх судасны өвчин, хорт хавдар зэргээс зайлсхийж чадна. Иймээс веган хоол идэх нь хамгийн зөв сонголт гэдэг нь илэрхий байна.

Зүрх судасны өвчин, хөхний болон шулуун гэдэсний хавдар, тархины саа өвчнөөр өвчлөх нь ханасан өөх тос ихээр агуулдаг мал амьтны гаралтай хүнсний хэт их хэрэглээтэй холбоотой нь батлагдаад байна. Тос багатай веган хоол идсэнээр бөөрний чулуу, булчирхайн хавдар, чихрийн шижин, арван хоёр нугалаа гэдэсний шархлаа, цөсний чулуу, ходоодны архаг үрэвсэл, үе мөчний үрэвсэл, буйлны өвчин, батга, нойр булчирхайн хавдар, ходоодны хавдар, цусан дахь чихрийн хэмжээ багасах, өтгөн хатах, дивертикулит, цусны даралт ихсэх, яс сийрэгжих, өндгөвчний хавдар, шамбарам, хэт таргалалт, багтраа зэрэг өвчнөөс урьдчилан сэргийлж, явцыг нь сааруулж тэр ч байтугай эмчилж болно

Тамхийг эс тооцвол хүний эрүүл мэндийг мах шиг хохироож байгаа зүйл байхгүй байна.

## **ЭКОЛОГИ БА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН**

Мах идэхийн тулд мал амьтан тэжээх нь дараах хор уршигтай. Үүнд: ширэнгэн ойг сүйтгэх, дэлхийн дулаарал, усны бохирдол, усны нөөц хомсдол, цөлжилт, эрчим хүчний гарздал болон дэлхийг хамарсан өлсгөлөн зэрэг болно. Газар, ус, эрчим хүч, хүний нөөцийг мах боловсруулахад ашиглаж байгаа нь дэлхийн нөөц баялгийг үр ашиггүй зарцуулж байгаа хэрэг юм.

1960-аад оноос Төв Америкт үхрийн бэлчээрт зориулан халуун бүсийн ойн 25 орчим хувийг шатааж устгасан байна. Тооцоолсноос үзэхэд шатааж устгасан 5 метр квадрат ой тутмаас 115 грамм бургерын мах үйлдвэрлэжээ. Үүнээс гадна үхэр тэжээхэд ихээр ялгардаг гурван төрлийн хорт хий нь дэлхийн дулаарлыг ихэсгэдэг. Мөн 450 грамм үхрийн мах үйлдвэрлэхэд 9117 литр ус зарцуулдаг нь үнэхээр почирдмоор. Гэтэл 450 грамм улаан лооль ургуулахад ердөө 107 литр ус, тийм хэмжээний цагаан талх үйлдвэрлэхэд 514 литр ус хэрэглэдэг. АНУ хэрэглээний усныхаа тэн хагасыг тэжээл бордоо тарих, үхэр тэжээх болон бусад мал амьтны хэрэгцээнд зарцуулж байна.

Үхэр бордоход хэрэглэж байгаа нөөц баялгаар үр тариа үйлдвэрлэж, дэлхийн хүн амыг хангавал маш олон хүн идэх хоолтой болох сон. Хэрэв нэг акр газарт овъёос тарьж малд биш хүмүүсийн хүнсэнд хэрэглэвэл махныхаас 8 дахин их уураг, 25 дахин их илчлэг өгнө. Нэг акр газарт тарьсан ногоон цэцэгт байцаа (брокколи) нь ийм хэмжээний газраас гаргаж авсан үхрийн махнаас 10 дахин их уураг, илчлэг, ниацин өгдөг. Иймэрхүү тоо баримт маш их. Мал амьтан тэжээж буй газарт хүнсний таримал таривал дэлхийн нөөц баялаг илүү үр ашигтайгаар зарцуулагдана.

Веган хоол танд энэ гараг дээр “өр төлөөсгүй амгалан амьдрах” боломж олгоно. Зайлшгүй чухал зүйлээ хэрэглээд,

амь хороохоо багасгаж, хоолноос минь болж амьтны амь сүйдээгүй гэж бодохоор таны сэтгэл амар байх болно.

## **ДЭЛХИЙН ӨЛСГӨЛӨН**

Дэлхийн бөмбөрцөг дээр нэг тэрбум орчим хүн өлсгөлөн, хоол тэжээлийн дутагдлаас шаналан зовж байна. Жилд 40 сая хүн өлсөж үхэж байгаагийн ихэнх нь хүүхэд юм. Гэтэл үүнийг үл харгалзан дэлхийн үр тарианы гуравны нэгийг хүмүүсийн хоол хүнсэнд бус, мал аж ахуйн хэрэгцээнд зориулж байна. АНУ-д үйлдвэрлэсэн үр тарианыхаа 70%-ийг малын тэжээлд хэрэглэж байна. Хэрвээ бид энэ үр тариагаар хүмүүсийг хоолловол хэн ч өлсөхгүй.

## **АМЬТНЫ ЗОВЛОН ЗҮДҮҮР**

Америкийн Нэгдсэн Улсад өдөр бүр 100 гаруй мянган үхэр нядалдгийг та бүхэн харсан уу? Өрнөдийн орнуудад ихэнх мал амьтныг “үйлдвэржсэн аж ахуй”-д тэжээж байна. Эдгээр фермүүд бага зардлаар олон мал амьтдыг нядлахаар тооцоолж баригдсан байдаг. Мал амьтныг зайгүй чихэлдсэн тун хэцүү орчинд байлгаж, тэдэнд, тэжээлийн мах бэлтгэдэг машин мэтээр хандаж байна. Бидний ихэнх нь бодит байдлын үнэн төрхийг өөрийн нүдээр хэзээ ч олж хараагүй. “Чи нядалгааны газар нэг л очвол насаараа веган хоолтон болно” гэсэн үг байдаг.

Лев Толстой: “Нядалгааны газар байгаа цагт дайны талбар байсаар байх болно. Цагаан хоол бол хүнлэг энэрэнгүй чанарын өндөр шалгуур юм” гэжээ. Бидний ихэнх нь амьтны амийг санаатайгаар хөнөөдөггүй ч нийгмийн зуршлаа дагаад байнга мах иддэг дадалтай болсон бөгөөд идсэн амьтанд ямар хор хөнөөл учруулснаа үнэндээ ойлгодоггүй.



## ГЭГЭЭНТНҮҮД БА ҮЙЛС НЭГТНҮҮД

Хүн төрөлхтний тэмдэглэж үлдээсэн эртний түүхээс үзэхэд ургамал нь хүн төрөлхтний байгалиас заяасан хоол хүнс байжээ. Эрт үеийн Грек болон Еврейн домог үлгэрт хүмүүс анхнаасаа жимс жимсгэнэ иддэг байсныг өгүүлдэг. Эртний Египетийн билиг ухаант хуврагууд хэзээ ч мах иддэггүй байв. Грекийн агуу их философичид жишээ нь, Платон, Диоген, Сократ нар цагаан хоол идэхийг шийдвэртэй дэмждэг байв.

Энэтхэгт Шагжамуни Будда “Ахимса” буюу аливаа амьтанд хор хөнөөл учруулахгүй байхыг чухалчлан тэмдэглэж, амьтдыг айдаст автуулахгүйн тулд мах идэхгүй байхыг шавь нартаа дахин дахин анхааруулж байв. Будда: “Мах идэх нь ердөө л олдмол зуршил төдий. Бид мах идэх хүсэлтэй төрөөгүй. Мах идвэл их нигүүлслийн үр тасарна. Мах идэгчид бие биеэ алж иддэг. Энэ төрөлд би чамайг, дараа төрөлд чи намайг иднэ гэхчлэн хэзээ ч таслах аргагүй. Ийм хүн яаж гурван ертөнцийг гэтлэх вэ?” гэж өгүүлжээ.

Эрт үеийн Дао, Христ, Еврейн шашны олон лам хуврагууд цагаан хоолтон байжээ. Энэ талаар Библид тун тодорхой тэмдэглэсэн байна. Эзэн Бурхан: “Би та нарыг идэг гэж элдэв зүйлийн жимс, төрөл төрлийн үр тариа өгөв. Харин хээрийн амьтад болон бүх шувуудын хоол тэжээл болгож, өвс ногоо, навчит ургамлыг өглөө” гэж (Genesis, 1:29) Ариун Библид өгүүлжээ. Библид мах идэхийг цээрлэсэн өөр нэг жишээ нь гэвэл: “Амьтны мах, цусыг идэх ёсгүй. Цус амьтай” гэсэн үг юм. (Genesis, 9:4) Эзэн Бурхан: Хэн та нарыг энэ эр үхэр, эм ямааг алж, надад тахил өргө гэсэн юм бэ? Намайг мөргөл залбирлаа сонсоосой гэж байгаа бол гэмгүй амьтны цуснаас өөрийгөө цэвэрлэгтүн. Тэгэхгүй бол би та нараас нүүр буруулна. Яагаад гэвэл та нарын гар нэлдээ цустай байна. Надаар өршөөж уучлуулахын тулд гэм

нүглээ наманчил.” (Isaiah1: 11-16) гэж хэлжээ. Есүсийн шавь нарын нэг Гэгээн Павел Ромчуудад илгээсэн захидалдаа: “Мах идэхгүй, дарс уухгүй байх нь аль аль нь сайн хэрэг” гэсэн байдаг. (Ромчуудад илгээсэн захидал, 14:21).

Саяхан түүхчид Есүсийн амьдрал болон сургаалыг шинээр тодруулсан олон эртний судар ном олж илрүүлсэн байна. Есүс: “Амьтны мах иддэг хүмүүс өөрсдийнхөө булш нь болдог. Та нарт үнэнээр нь хэлэх юм бол алж хөнөөж байгаа хүн өөрөө алагдах болно. Амьд амьтныг хөнөөж, махыг нь идэж буй хүн бол хүний үхдэл хүүрийн мах идэж байгаа хэрэг юм.” гэжээ.

Энэтхэгийн шашнууд ч бас мах идэхийг цээрлэдэг. Энэ нь “Хүн амьд амьтныг хөнөөхгүйгээр махыг нь идэж чадахгүй. Амьд амьтныг зовоож тарчлааж буй хүнийг Эзэн Бурхан хэзээ ч адислахгүй. Тийм учраас мах идэхийг цээрлэ!” (Энэтхэг шашны сахил).

Исламын Ариун судар Коранд: Үхсэн амьтны мах, цусыг идэхийг хориглосон байдаг.

Хятадын агуу их Зэн Багш Хань Шань-Зу мах идэхийг эрс эсэргүүцсэн найраглал туурвиж: “Эхнэр хүүхдээ тэжээхээр зах зээлээс мах, загасхан худалдан авах гэж яарах хэрэг юун. Таны амьдралыг тэжээж тэтгэхийн төлөөнөө эдний амь тасрах заавал албатай юу? Ингэхийн утга учир алга. Энэ нь таныг диваажинд хүргэхгүй, харин тамын хог новш болгоно!” хэмээжээ.

Маш олон алдарт зохиолч, урлаачид, эрдэмтэн, гүн ухаантан, гарамгай хүмүүс цагаан хоолтон байжээ. Үүнээс жишээ болгон цөөхнийг дурдвал: Шагжамуни Будда, Есүс Христ, Вергилий, Гораций, Платон, Овидий, Петрарка, Пифагор, Сократ, У.Шекспир, Вольтер, И.Ньютон, Леонардо Да Винчи, Чарльз Дарвин, Бенжамин Франклин, Ральф Уолд Эмерсон, Хенри Дэвид Торо, Эмиль Золя, Бертран Рассель, Ричард Вагнер, П.Б.Шелли, Х.Ж.Уэллс, Алберт Эйнштейн,

Рабиндранат Тагүүр, Лев Толстой, Жорж Бернард Шоу, Махатма Ганди, Алберт Швейцер болон орчин үеийнхнээс цөөхнийг дурдах юм бол Пол Ньюмен, Мадонна, Диана гүнж, Линдсей Вагнер, Пол Маккартни, Кандис Берген нар цагаан хоол идэх ёсыг зориг төгс сайшаан дагаж байв.

Алберт Эйнштейн хэлэхдээ: “Миний бодлоор бол цагаан хоолны улмаас хүний зан чанарт гардаг өөрчлөлт, ариусгах нөлөө нь хүн төрөлхтөнд ихээхэн ашигтай. Иймээс хүмүүс цагаан хоол идэхийг сонгох нь буян хишигтэй болоод амар амгалан хоёр талтай юм” гэжээ. Энэ бол хүн төрөлхтний түүхэн дэх сод гарамгай, сэцэн мэргэн олон хүний номлосоор ирсэн сургаал билээ.

## АВШИГ ХҮРТЭХҮЙ- АРЬЯАБАЛЫН БЯСАЛГАЛЫН АРГА

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Үнэнийг таньж мэдэхийг чин сэтгэлээсээ эрмэлзэн тэмүүлж буй хүмүүст Арьяабалын бясалгалын аргыг авшгаар дамжуулан уламжилна. “Аялгуу ажих” гэдэг нь Хятадаар амарлин сууж аялгууны хэлбэлзлийг ажиглах гэсэн утгатай. Энэхүү бясалгалын аргад дотоодын “Гэрэл” болон “Аялгуу”-г ажих багтана. Эртнээс нааш дэлхийн шашнуудын болон бясалгалын ном сударт дотоодын ийм ахуй ойлголтыг олонтоо дурдсан байдаг. Тухайлбал, Христийн шашны “Библи”-д: “Түмэн бодис аялгуунаас үүссэн. Энэ аялгуу Эзэн Бурхантай хамт байсан. Аялгуу өөрөө Эзэн Бурхан байсан” гэжээ. (Иохан 1-р бүлгийн 1-р хэсэг) Энэхүү аялгуугаар дотоодын аялгууг заажээ. Мөн “Бурханы хэл”, “Шабд”, “Дао”, “Аялгууны урсгал”, “Ум”, “Тэнгэрийн хөгжим” гэж бас нэрлэдэг. Их Багш Чин Хай: “Тэрээр түмэн бодисын дотор хэлбэлзэн, бүхий л орчлон ертөнцийг тэжээн тэтгэдэг. Энэхүү дотоодын хэмнэл нь аливаа шархыг эмнэн, бүхий л хүсэл эрмэлзлэлийг хангаж, эгэл ертөнцийн элдэв дур хүслийг намжаана. Тэрээр бүхнийг чадагч бөгөөд хайраар бялхаж байдаг. Бид энэхүү аялгуунаас үүссэн болохоор түүнтэй холбогдвол сэтгэл ханаж амарлина. Энэхүү аялгууг сонссоноор бид бүхэлдээ хувирч, амь амьдралын тухай үзэл бодол маань үндсээрээ өөрчлөгддөг.” гэжээ.

“Билиг нээгдэх” гэдгээр дотоодын гэрэл - “Эзэн Бурханы гэрэл”-ийг хэлж байна. Гэрлийн хүч нь өчүүхэн багаас авахуулаад тоо томшгүй олон нарны гэрэл мэт хурц тод. Бид Бурханыг дотоодын гэрэл, аялгуугаар л таньж мэддэг.

Арьяабалын аргаар сүнслэг дадал бясалгал хийх, авшиг хүртэх нь ямар нэг нууц ёслол үйлдэж буй, эсвэл

шинэ шашинд орж буй хэрэг биш. Авшиг хүртэх үеэр гэрэл болон аялгуу ажихад онцгойлон анхаарах зүйлсийг зааж өгдөг. Хамгийн анхны ариун ахуй ойлголт чимээ аниргүйд бууж ирнэ.

Арьяабалын бясалгалын аргын хамгийн чухал хэсэг нь авшиг уламжлах юм. Таны билгийн үүдийг нээхэд Их Багш Чин Хай өөрийн биеэр морилох шаардлагагүй. Гэхдээ Их Багшийн адислалгүй бол бясалгалын арга ач тусаа өгөхгүй. Авшиг хүртэх үед та тэр даруйдаа дотоодын аялгууг сонсож, дотоодын гэрлийг харна. Үүнийг “Агшнаа гэгээрэх” юм уу “Агшин зуур билиг нээгдэх” гэдэг.

Их Багш Чин Хай шашин шүтлэг, соёл уламжлалын ялгааг үл харгалзан авшиг хүртээдэг. Та шүтэж буй шашин, сүсэг бишрэлээ өөрчлөх шаардлагагүй. Таныг ямар нэгэн байгууллагад элсэхийг, эсвэл таны амьдралын одоогийн хэв маягт тохирохгүй аливаа үйл ажиллагаанд оролцохыг шаардахгүй.

Авшиг хүртэх нь ямар ч үнэ төлбөргүй.

Насаараа веган хоолтон байх нь авшиг хүртэх зайлшгүй нөхцөл болно.

Арьяабалын бясалгалын аргаар өдөр бүр бясалгах, таван сахил сахих нь авшиг хүртсэний дараах цорын ганц шаардлага юм.

Сахил нь өөртөө болон өрөөлд хор хүргэхгүй байхад туслах хэм хэмжээ бөгөөд үүнийг сахиж бясалгавал авшгаар нээгдсэн билиг ухаанаа улам тэлсээр эцэст нь хамгийн дээд ухамсрыг олж Будда болно. Хэрэв өдөр бүр бясалгахгүй бол билиг нээгдсэнээ мартаж, ердийн ухамсрын түвшинд эргэж очдог.

Өөрөө бясалгал хийж төгс гэгээрэлд хүрэхийг бидэнд зааж сургах нь Их Багш Чин Хайн зорилго билээ. Иймээс Түүний зааж буй бясалгалын аргаар хэн ч бясалгаж болдог. Нэмэлт тусламжид түшиглэхгүйгээр өөрөө бясалган

дадуулж болно. Тэрээр сүсэгтэн, бишрэн шүтэгч, шавь эрдэггүй, гишүүнчлэлтэй байгууллага байгуулж хугацаат татвар хураадаггүй. Их Багш Чин Хай сөгдөж мөргөхийг зөвшөөрөхгүй, мөнгө төгрөг, бэлэг сэлт хүлээж авахгүй учир өргөл барьц хэрэггүй. Тэр зөвхөн таны өдөр тутмын амьдрал болоод бясалгал дадалдаа өөрийгөө дэвшүүлэн богд гэгээнтэн болохыг хүсэх тэрхүү чин сэтгэлийг чинь л хүлээж авна.

## ТАВАН САХИЛ

- 1.Аливаа амьтанд хор хөнөөл учруулахыг цээрлэнэ;\*
- 2.Үнэн бус зүйл ярихыг цээрлэнэ;
- 3.Өөрийн бус юмыг авахыг цээрлэнэ;
- 4.Бэлгийн зүй бус харилцааг цээрлэнэ;
- 5.Согтууруулах, мансууруулах бодис, хорт зүйл хэрэглэхийг цээрлэнэ;\*\*

\* Энэ сахил нь веган хоолны дэглэмийг хатуу мөрдөхийг шаардана. Мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, загас, шувууны мах, өндөг (өндөгтэй болон сүүтэй боов, чихэр, бялуу, жигнэмэг, зайрмаг гэх мэт) амьтны гаралтай аливаа хүнсийг хэрэглэж болохгүй.

\*\* Энэ сахилд бүх төрлийн хорт бодис, тухайлбал: архи уух, тамхи, хар тамхи татах, мөрийтэй тоглоом тоглох, садар самуун, хүчирхийлэлтэй кино, зураг үзэх, ном, сэтгүүл унших, компьютер тоглоом тоглох зэрэг аливаа хортой зүйлээс зайлсхийх багтана.

## **ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН НОМ ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ**

### **Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр**

*Англи (1-5), Ау Лак (1-15), Герман (1-2), Индонез (1-5), Испани (1-3), Монгол (1-7), Польш (1-2), Солонгос (1-11), Португал (1-2), Тай (1-6), Төвөд (1), Унгар (1), Фин(1), Франц (1-2), Хятад (1-10), Швед (1), Япон (1-4)*

### **Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр - Асуулт Хариулт**

*Англи (1-2), Ау Лак (1-4), Болгар (1), Герман (1), Индонез (1-3), Монгол (1-2), Орос (1), Польш (1), Португал (1), Солонгос (1-4), Унгар (1), Франц (1), Хятад (1-3), Чех (1), Япон (1)*

### **Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр - Багш шавийн хоорондын захиа**

*Англи (1), Ау Лак (1-2), Испани (1), Хятад (1-3)*

### **Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр - Багштайгаа өнгөрүүлсэн гайхамшигт мөчүүд**

*Ау Лак (1-2), Хятад (1-2)*

### **1992 онд Сан Ди Мун-д болсон 7 хоногийн даяан бясалгал / тусгай хэвлэл**

*Англи (1), Ау Лак (1)*

### **Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн 1993 онд Дэлхий даяар ном дэлгэрүүлсэн аялал**

*Англи (1-6), Хятад (1-6)*

### **Их Багшийн ярьсан үлгэр түүх**

*Англи (1), Ау Лак (1), Испани (1), Монгол (1), Солонгос (1), Тай (1), Хятад (1), Япон (1)*

### **Эзэн Бурхантай шууд холбогдох - Энх тайванд хүрэх зам**

*Англи, Ау Лак, Хятад*



**Эзэн Бурхан ба хүн төрөлхтний үлгэр - Библийн  
үлгэрүүдийг ухаарахуй**

*Англи, Ау Лак, Хятад*

**Амьдралаа солонгоруулья**

*Англи, Ау Лак, Монгол, Хятад*

**Эрүүл мэндээ ухаарахуй Жам ёсны зөв амьдралын хэв  
маягт эргэн орохуй**

*Англи, Ау Лак, Монгол, Хятад*

**Оюун санааны дадал бясалгалын нууц хялбар аргууд**

*Англи, Ау Лак, Монгол, Хятад*

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдсан билиг  
ухааны зурагт үлгэрүүд- Бурхан бүхнийг зохицуулдаг**

*Англи, Ау Лак, Монгол, Солонгос, Хятад, Франц, Япон*

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Гэгээрүүлэгч  
хошигнол - Таны гэрлэн бүрхүүл дэндүү давчуу байна!**

*Англи/Хятад (ном + CD)*

**Онч мэргэн үгс (1)**

*Англи (1), Хятад (1), Испани/Португал, Франц/Герман,*

*Англи/Солонгос, Англи/Япон*

**Онч мэргэн үгс (2)**

*Англи (1), Хятад (1)*

**Тэнгэрлэг зоог - Олон улсын цагаан хоолны гал тогоо**

*Англи/Хятад, Ау Лак, Япон*

**Тэнгэрлэг зоог – Гэрийн хоолны амтат сонголт**

*Англи/Хятад*

**Диваажингийн урлаг**

*Англи, Ау Лак, Хятад, Монгол*

**Жинхэнэ хайр**

*Англи, Хятад, DVD, MP4*

**Ая эгшгээр амгалан дэлхийг бүтээхүй (тусгай хэвлэл)**

*Англи/Ау Лак/ Хятад*

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн урлагийн бүтээлийн цоморлог**

*Англи/Ау Лак/Хятад*

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн урлагийн бүтээлийн цоморлог - Уран зургийн цувралууд**

*Англи (1), Хятад (1)*

**Тэнгэрийн хувцас**

*Англи/Хятад*

**Шувууд миний амьдралд**

*Англи, Ау Лак, Араб, Герман, Индонез, Монгол, Солонгос, Орос, Франц, Хятад*

**Эрхэм ариун амьтад**

*Англи, Ау Лак, Герман, Монгол, Солонгос, Франц, Хятад*

**Аниргүй нулимс**

*Англи, Ау Лак, Хятад, Герман, Франц, Испани, Португал, Солонгос, Монгол, Филиппин*

**Вуузуу шүлгүүд**

*Англи, Ау Лак, Хятад*

**Мартагдсан дурсамж**

*Англи, Ау Лак, Хятад*

**Хайрга ба Алт**

*Англи, Ау Лак, Хятад*

## **Эрвээхэйн мөрөөдөл**

*Англи, Ау Лак, Хятад*

## **Өмнөх амьдралын зам мөр**

*Англи, Ау Лак, Хятад*

## **Хуучин цаг**

*Англи, Ау Лак, Хятад*

## **Эрин зууны хайр**

*Англи, Ау Лак, Хятад, Монгол*

## **Аниргүйхэн нулимсыг хайрлахуй**

*Англи, Хятад, CD, DVD, MP4*

## **Амьдрал болоод ухамсрын тухай бодрол:**

### **Доктор Жанезын бичсэн ном**

*Хятад хэл дээр*

## **Хямралаас энх тайванд: Шийдэл нь Органик веган хүнс**

<http://crisis2peace.org> хаягаар олон хэл дээр үнэ төлбөргүй унших болон татаж авна уу.

Дээрх номууд үргэлжлэн хэвлэгдсээр байна.

Бусад айлдварууд болон дууны DVD, MP3, MP4, CD-ны цувралууд Араб, Армен, Ау Лак, Болгар, Камбож, Кантон, Хятад, Хорват, Чех, Дани, Голланд, Болгар, Англи, Фин, Франц, Герман, Грек, Еврей, Унгар, Индонез, Итали, Япон, Солонгос, Малай, Монгол, Непал, Норвег, Перс, Филиппин, Польш, Португал, Румын, Орос, Шри Ланк, Словени, Испани, Швед, Тай, Турк, Зулу хэл дээр хэвлэгджээ.

## БИДЭНТЭЙ ХЭРХЭН ХОЛБОГДОХ ВЭ?

Шуудангийн хайрцаг 9, Шихү, Миаоли, Формоса,  
БНХАУ (36899)

Шуудангийн хайрцаг 730247, Сан Хосе,  
Калифорни 95173-0247, АНУ

Суприм Мастер Телевиз

И-мэйл: Peace@SupremeMasterTV.com

Утас: 1-626-444-4385

Факс: 1-626-444-4386

### **Ном орчуулгын групп:**

И-мэйл: divine@godsdirectcontact.org

(Та Их Багшийн номыг олон хэл дээр орчуулах ажилд оролцож болно.)

### **Мэдээний групп:**

И-мэйл: lovenews@godsdirectcontact.org

S.M. Celestial Co., Ltd:

И-мэйл: smclothes123@gmail.com;

Vegann@@hotmail.com

Утас: 886-3-4601391

Факс: 886-3-4602857

Веб сайт: <http://www.smcelestial.com>

<http://www.sm-celestial.com>

Асуулт хариултын баг:

И-мэйл: lovewish@godsdirectcontact.org

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн  
Хэвлэлийн ХХК

И-мэйл: smchbooks@godsdirectcontact.org

Утас: 886-2-23759688 Факс: 886-2-23757689

<http://www.smchbooks.com>

### **Онлайн дэлгүүр**

Celestial Shop: <http://www.theCelestialShop.com> (Англи)

Eden: <http://www.EdenRules.com/> (Англи, Хятад)

Цэвэр веган бүтээгдэхүүний онлайн дэлгүүр

<http://www.lovingfood.com.tw>

**“Loving Hut” Олон Улсын Веган Хоолны Сүлжээ  
ресторан**

И-мэйл: [service@lovinghut.com](mailto:service@lovinghut.com)

Утас: 886-3-4683345

Факс: 886-3-4681581

Веб сайт: <http://www.lovinghut.com/tw/>

**Гуань Инь веб сайтууд:**

Бурхантай шууд холбогдох- Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн интернэт хаяг:

<http://www.godsdirectcontact.org.tw/eng/links/links.htm>

Энэхүү хаягаар дэлхийн олон хэл дээрх Гуань Инь вэб хаягуудыг олж авахаас гадна 24 цагийн интернэт телевиз болох Суприм Мастер Телевиз болон Урлагийн Ертөнцөөр Аялахуй нэвтрүүлгийг үзэх боломжтой.

Мөн олон орны хэл дээр “Агшин зуур гэгээрэхийн түлхүүр” үлгэр дэвтрийг татаж авч болно. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн мэдээ сэтгүүлийг цахим хэлбэрээр татаж авах болон унших боломжтой.

**Суприм Мастер Телевиз**

Суприм Мастер Телевиз нь бүтээлч хөтөлбөрүүдийг нэвтрүүлдэг суваг бөгөөд танд сүнслэг дэвшлийг авчирч, амьдралд тань цоо шинэ өнгө төрхийг бэлэглэх болно.

Суприм Мастер Телевизийг 24 цагийн турш онлайнгаар үзэх хаяг: <http://suprememastertv.com/mn1/>

Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр (үлгэр дэвтэр)-г олон хэл дээр үнэ төлбөргүй татаж авах хаяг (80 орны хэл дээр)

<http://sb.godsdirectcontact.net>

## Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр-6

Зохиогч: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Хэвлэсэн газар: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Олон  
Улсын Нийгэмлэгийн Хэвлэлийн ХХК

Хаяг: Тайпэй хот, Жүнзэн дүүргийн баруун замын 1 дүгээр  
хэсэг, 72-8-16

Утас: 886-2-23759688

Факс: 886-2-23757689

И-мэйл : [smchbooks@Godsdirectcontact.org](mailto:smchbooks@Godsdirectcontact.org) <http://www.smch-books.com>

Шуудангийн дугаар: 19259438

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай © 1987~2019

Зохиогчийн эрх: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Энэхүү номын агуулгыг хэвлэлийн компаниас зөвшөөрөл  
авсны дараа хуулбарлаж болно.

Анхны хэвлэл: 1991 оны 1 дүгээр сар

Хоёр дахь хэвлэл: 1993 оны 2 дугаар сар

Гурав дахь хэвлэл: 1994 оны 4 дүгээр сар

Дөрөв дэх хэвлэл: 1997 оны 11 дүгээр сар

Тав дахь хэвлэл: 2001 оны 3 дугаар сар

Зургаа дахь хэвлэл: 2006 оны 9 дүгээр сар

Долоо дахь хэвлэл: 2011 оны 8 дугаар сар

Энэ хувилбарыг монгол хэлнээ орчуулсан

2021 оны 1 дүгээр сар

Цахим хувилбар: <http://www.gegeerel.mn/>

Та бүхэн номын талаархи санал сэтгэгдлээ

[Mon.nomiinbag@gmail.com](mailto:Mon.nomiinbag@gmail.com) хаягаар ирүүлнэ үү.

Энэ дэлхийд залран буй Төгс гэгээрсэн Их багштай учрахад хэцүү, жинхэнэ дээд номыг хүртэхэд бэрх гэдгийг үнэнийг эрж хайсан бидний бэрхшээлт аяллууд гүнзгий ухааруулсан юм. Арьяабалын бясалгалын арга нь эртний жинхэнэ багш нараас уламжлагдан ирсэн охь дээд номын дамжлага мөн учраас хүмүүний мөн чанарын билиг билгүүнийг сэрээж, үнэн номыг ухааруулж чадна. Энэхүү номын ёсоор бясалгаад бид хэмжээлшгүй их ач тусыг хүртсэн тул бидний багш Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн дэлхийн олон оронд айлдсан дээдийн номын айлдваруудыг эмхтгэж, энэ төрөлдөө сансрын хүрднээс ангижрахыг хүссэн, жинхэнэ үнэн номыг хайсан, үхэж төрөх, бясалгал, гэгээрэл, үнэн мэдлэгийн тухай асуултууддаа хариулт эрж буй хүмүүст туслахыг зорин энэхүү номыг өргөн барьж байна.